



БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives.
Resilient nations.

Science Tech Gate LLC



**“ТОВИЙН БҮСИЙН НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАН СУДЛАХ,
ХАМГААЛАХ ТӨВ” БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН
ЗАСГИЙН УРЬДЧИЛСАН СУДАЛГАА, ҮНДЭСЛЭЛ
БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ
ЗАХУЙ, ЗАРМАНГЫН ГОВЬ**

(ENSURE 22/22)

(Эцсийн тайлан)

2023 оны 03 дугаар сарын 21

Сайнс Тэч Гэйт ХХК

52-р байр, 25 тоот, Содномын Гудамж

8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

И-майл : sciencetechgate LLC@gmail.com

Харилцах утас: 1. 976-96688196 2. 976-88131248

Улаанбаатар 2023

Зөвлөх багийн ахлагч: **С. Цогт**
“Сайнс тэч гэйт” ХХК Амьтны мэргэжлийн
байгууллагын ТУЗ-ын дарга
ХААИС –ийн Агроэкологийн сургууль
Экологийн тэнхимийн баги,
Биологич: Экологич

Багийн гишүүд: **Дэд проф. Др. З.Ядмаа**
ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургууль
Санхүүгийн тэнхимийн эрхлэгч
Эдийн засагч: Санхүүч

Дэд проф. Др С. Соёлжин
МУИС-ийн ШУС, БУС, Гадаад хэлний төв
Хэл шинжээч, орчуулагч

Х. Мөнхтүвшин
ХААИС –ийн Агроэкологийн сургууль
Таримал судлал, ой, ландшафт, архитектурын тэнхимийн баги
Интерьер дизайн; Архитектурч

Н. Нямсүрэн
Утга зохиол нийгмийн ажилтны дээд сургууль
Нийгмийн ажил арга зүйн тэнхимийн эрхлэгч
Нийгмийн ажилтан; Социологич

Н. Мягмарсүрэн
ХААИС –ийн Агроэкологийн сургууль
Экологийн тэнхимийн баги,
Үйлдвэрийн экологич

Б. Батдэмбэрэл
“Сайнс тэч гэйт” ХХК Амьтны мэргэжлийн
байгууллагын ТУЗ-н гишүүн
Биологич: Экологич

Н. Ариунтуяа
“Сайнс тэч гэйт” ХХК Амьтны мэргэжлийн
байгууллагын ТУЗ-н гишүүн, захирал
МУИС, ШУС, БУС, Физикийн тэнхим
Биофизикч

АГУУЛГА

(Эцсийн тайлан)	i
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ, ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР	3
БҮЛЭГ НЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ	5
1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
1.2. НЭН ХОВОР, ХОВОР АМЬТНЫГ СУДЛАХ ХАМГААЛАХ ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ	6
1.3. АМЬТНЫ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ	11
1.4. ЗЭРЛЭГ АМЬТАН АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	12
1.5. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	26
1.6. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	27
БҮЛЭГ ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	29
2.1. ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛ, ГАЗРЫН ТОГТОЦ	29
2.2. УУР АМЬСГАЛ	31
2.3. УС ЗҮЙ	37
2.4. ХӨРС	39
2.5. УРГАМАЛ	41
2.6. АМЬТАН	42
БҮЛЭГ ГУРАВ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХҮН АМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ	43
3.1. ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ	43
3.2. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ	46
3.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	46
3.4. ЭРҮҮЛ МЭНД	47
3.5. БОЛОВСРОЛ	47
3.6. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ	48
3.7. АЖ ҮЙЛДВЭР	48
3.8. ТӨСӨВ	48
3.9. ХӨДӨӨ АЖ АХУЙ	49
БҮЛЭГ ДӨРӨВ. “ТОВИЙН БҮСИЙН НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВ” БАЙГУУЛАХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИЙДЛҮҮД	50
4.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ЦАР ХҮРЭЭ	50
4.2. ЗОХИОМОЛ ОРЧИНД БАЙГАЛЬ ХАМГААЛАХ СТРАТЕГИ	51
4.3. НЭН ХОВОР, ХОВОР АМЬТНЫ ТОО ТОЛГОЙГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ БОДЛОГО ..	54
4.4. АМЬТАНТАЙ ХАРЬЦАХ АЖИЛТНУУДЫН ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ ҮНДСЭН МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДАЛ	60

4.5. АМЬТАН СУДЛАХ, АСРАХ, ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СТАНДАРТЧИЛЛЫН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ.....	62
4.6. ЗЭРЛЭГ АМЬТНЫ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТ....	65
4.7. ЗЭРЛЭГ АМЬТДАД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ.....	68
4.8. АМЬТНЫ МАЛЛАГАА, АСАРГААНЫ ҮЕД АНХААРАХ ЗҮЙЛСИЙН ТУХАЙ.....	73
4.9. АМЬТАН ХАМГААЛАХ БАЙРАНД ӨВЧИН ТАРХАХААС СЭРГИЙЛЖ, ХАМГААЛАХ НЬ	79
4.10. АМЬТНЫ АМЬ ХОРООХ ТУХАЙД	79
4.11. МЭДЭЭ АЛДУУЛАЛТ.....	80
4.12. УСТГАЛ	80
4.13. АЮУЛТАЙ АМЬТАНТАЙ ХАРЬЦАХАД АНХААРАХ ЗҮЙЛС.....	81
БҮЛЭГ ТАВ. ГОВИЙН БҮСИЙН НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ АРГАЧЛАЛ.....	82
5.1. БАРИХ, ЗӨӨВӨРЛӨХ АРГАЧЛАЛ.....	82
5.2. ХАШААНЫ ХИЙЦ, БҮТЭЦ, ТОНОГЛОХ АРГАЧЛАЛ.....	83
5.3. БАЙР ОРОМЖИЙН ХИЙЦ, БҮТЭЦ, ТОНОГЛОХ АРГАЧЛАЛ.....	92
5.4. ТЭЖЭЭХ УСЛАХ, ТОРДОХ АРГАЧЛАЛ	99
5.5. АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ БАЙРНЫ АРИУТГАЛ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АРГАЧЛАЛ	101
5.6. ГОВИЙН БҮСИЙН НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВИЙН ОФИССЫН БАЙРНЫ ТӨЛӨВЛӨЛТ	102
5.7. АМЬТАН СУДЛАХ ХАМГААЛАХ ТӨВД БУЙ ХӨХТӨН АМЬТАДТАЙ ХАРЬЦАХ АРГАЧЛАЛ.....	108
5.8. АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВД БУЙ ХӨХТӨН АМЬТДЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ	109
5.9. АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВД БУЙ ХӨХТӨН АМЬТДЫГ ТЭМДЭГЛЭХ АРГАЧЛАЛ.....	109
5.10. АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВӨӨС БАЙГАЛЬД ТАВИХ АРГАЧЛАЛ	109
5.11. ШААРДЛАГАТАЙ ҮЕД АМЬТНЫ АМЬ ХОРООХ АРГАЧЛАЛ.....	111
5.12. ГОВИЙН НЭН ХОВОР, ХОВОР ХӨХТӨН АМЬТДЫН БИОЛОГИЙН ОНЦЛОГ, ТЭДГЭЭРИЙГ СУДЛАХ, АВРАН ХАМГААЛАХ АРГАЧЛАЛ.....	112
ТАХЬ АДУУ (<i>Equus ferus przewalskii</i>)	112
ХУЛАН АДУУ (<i>Equus hemionus</i>)	112
ХАВТГАЙ ТЭМЭЭ (<i>Camelus ferus</i>)	113
АРГАЛЬ ХОНЬ (<i>Ovis ammon</i>).....	113
ЯНГИР ЯМАА (<i>Capra sibirica</i>).....	114
МОНГОЛ БӨХӨН (<i>Saiga borealis</i>).....	115
ХАР СҮҮЛИТ ЗЭЭР (<i>Gazella subgutturosa</i>).....	116

5.13. ХӨХТӨН АМЬТДЫН ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ.....	116
БҮЛЭГ ЗУРГАА. “ГОВИЙН БҮСИЙН НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ” ТӨВ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ТООЦОО	119
6.1. ТӨСЛИЙН САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО.....	120s
6.2. ТӨСЛИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ТООЦООЛОЛ	131
6.3. ТӨСЛИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ.....	135
6.4. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ	140
ДҮГНЭЛТ	142
ЗӨВЛӨМЖ.....	143
УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	145
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ	147
ХАВСРАЛТ.....	148

ЗУРГИЙН ТАЙЛБАР

Зураг 2.1. Монгол орны физик газар зүйн мужлал.....	29
Зураг 2.2. Төсөл хэрэгжих нутгийн харагдах байдал	30
Зураг 2.3. Жилийн дундаж агаарын температурын газарзүйн тархалт (1991-2020)	34
Зураг 2.4. Жилийн нийлбэр хур тунадасны газарзүйн тархац эх үүсвэр: www.climate-source.com	35
Зураг 2.5. Дэвсгэр гадаргын жилийн нийлбэр ууршиц	36
Зураг 2.6. Шороон шуурганы тархалт /1960-2008/	36
Зураг 2.7. Гол, мөрний ай сав, ус судлалын харуул	37
Зураг 2.8. Шар усны үерийн урсац (мм)	38
Зураг 2.9. Монгол орны хөрсний органик бодисын зураг (Монгол улсын үндэсний атлас, 2009)	40
Зураг 2.10. Монгол орны ургамалжилын тойрог	41
Зураг 4.1. Төсөл хэрэгжих газар нутаг	50
Зураг 4.2. Төслийн талбай орчмын үзэгдэх байдал	51
Зураг 5.1. Хязгаарлалтын хашааны план зураг	85
Зураг 5.2. Торон хашааны дээгүүр өргөст тор татах ба хашааны ёроолоор төмөр тор байрлуулна.	86
Зураг 5.3. Төвийн ерөнхий харагдах байдал (дээрээс)	87
Зураг 5.4. Төвийн ерөнхий харагдах байдал (урдаас)	87
Зураг 5.5. Төвийн ерөнхий харагдах байдал (баруун талаас)	88
Зураг 5.6. Төвийн ерөнхий харагдах байдал (хойноос)	88
Зураг 5.7. Төвийн ерөнхий харагдах байдал (зүүнээс)	89
Зураг 5.8. Амьтны хашааны гадна талаас харсан байдал	89
Зураг 5.9. Амьтны хашааны гадна талаас харсан байдал	90
Зураг 5.10. Амьтны хашаан дотроос харсан байдал	90
Зураг 5.12. Амьтан хамгаалах байр	92
Зураг 5.13. Амьтан хамгаалах байрны зүүн урд талаас	93
Зураг 5.14. Амьтан хамгаалах байрны зүүн талаас	93
Зураг 5.15. Амьтан хамгаалах байрны зүүн хойноос	94
Зураг 5.16. Амьтан хамгаалах байрны хойд талаас	94
Зураг 5.17. Амьтан хамгаалах байрны баруун хойд талаас	95
Зураг 5.18. Амьтан хамгаалах байрны баруун талаас	96
Зураг 5.19. Амьтан хамгаалах байрны хойно байрлах тэжээлийн хадгалах хэсэг	96
Зураг 5.20. Амьтан хамгаалах байрны дотор талд амьтан тусгаарлах өрөө, эмчлэх өрөөний байрлал	97
Зураг 5.21. Амьтан хамгаалах байрны дотор тал	97
Зураг 5.22. Амьтан хамгаалах байрны дотор тал	98
Зураг 5.23. Амьтан услах онгоц	100
Зураг 5.24. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилга	102
Зураг 5.25. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (баруун хойно)	103
Зураг 5.26. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (хойноос)	103
Зураг 5.27. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (зүүн хойноос)	104
Зураг 5.28. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (зүүн өмнөөс)	104

Зураг 5.29. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (өмнөөс).....	105
Зураг 5.30. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын 1 давхарын план зураг	106
Зураг 5.31. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын 1 давхарын план зураг	107

ХҮСНЭГТИЙН ТАЙЛБАР

Хүснэгт 1.1. Байгаль орчин, Хөдөлмөр хамгаалал, Эрүүл мэндийн талаар Монгол улсын үндэсний стандартууд	22
Хүснэгт 1.2. Хийх ажлын ерөнхий төлөвлөгөө	27
Хүснэгт. 3.1. Хүн амын тоо, сумаар, хүйсээр, байршлаар, 2021 он	45
Хүснэгт. 3.2. Хүн амын тоо, багаар, 2021 он	45
Хүснэгт 3.3. Хүн амын тоо, сумаар насны бүлгээр, 2021 он	46
Хүснэгт 4.1. Төслийн талбайн байршил	51
Хүснэгт 5.1. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-д байршуулах амьтны тоо, зардлын тооцоо	83
Хүснэгт 5.2. Амьтны тэжээлийн норм	99
Хүснэгт 5.3. Амьтан судлах хамгаалах төвийн амьтны усалгаанд өдөр болон жилд хэрэглэх усны хэмжээ, амьтан услах онгоцны зардал	100
Хүснэгт 5.4. Амьтны байрны цэвэрлэгээний журналын загвар	101
Хүснэгт 6.1. Төслийн анхны хөрөнгө оруулалт	120
Хүснэгт 6.2. Амьтны байр	121
Хүснэгт 6.3. Оффисийн барилга байгууламж	121
Хүснэгт 6.4. Амьтны хамгаалалтын хашаа	122
Хүснэгт 6.5. Хашааны суурийн өртөг	122
Хүснэгт 6.6. Хязгаарлалтын хашаа	123
Хүснэгт 6.7. Явган зам	123
Хүснэгт 6.8. Авто зогсоол	123
Хүснэгт 6.9. Жорлон /Ариун цэврийн байр/	124
Хүснэгт 6.10. Харуулын буюу ажиглалтын байр	124
Хүснэгт 6.11. Хамгаалалтын ойн зурвас	125
Хүснэгт 6.12. Тээврийн хэрэгсэл болон түүнтэй холбоотой багаж хэрэгсэл /тоног төхөрөмж 1/	125
Хүснэгт 6.13. Амьтан барихтай холбоотой багаж хэрэгсэл /тоног төхөрөмж 2/	125
Хүснэгт 6.14. Мэс засал болон үзлэгийн багаж хэрэгсэл /тоног төхөрөмж 3/	126
Хүснэгт 6.15. Харуул хамгаалалт,ажилчдын, тэжээл боловсруулах өрөөний багаж хэрэгсэл /тоног төхөрөмж 4/	127
Хүснэгт 6.16. Амьтан маллагчийн хамгаалах багаж хэрэгсэл /тоног төхөрөмж 5/	128
Хүснэгт 6.17. Дотоод тохижилтын эд хогшил	129
Хүснэгт 6.18. Төслийн бэлтгэл ажлын зардал	130
Хүснэгт 6.19. Барилгын материалын тээврийн зардал	130
Хүснэгт 6.20. Амьтан барих зардал	131
Хүснэгт 6.21. Ажиллагсдын цалин хөлсний зардал	131
Хүснэгт 6.22. Байгалийн нөөц ашигласны зардал	132
Хүснэгт 6.23. Амьтны тэжээлийн зардал	132
Хүснэгт 6.24. Шатахууны зардал	133
Хүснэгт 6.25. Эм урвалж, ариутгалын зардал	133
Хүснэгт 6.26. Хөдөлмөр хамгааллын зардал	134
Хүснэгт 6.27. Үндсэн хөрөнгийн элэгдэл, засварын зардал	134
Хүснэгт 6.28. Хоол, хүнсний зардал	135
Хүснэгт 6.29. Бусад зардал	135
Хүснэгт 6.30. Төслийн шууд орлогын тооцоолол	136
Хүснэгт 6.31. Төслийн үйл ажиллагааны нэгдсэн зардлын тооцоолол	136
Хүснэгт 6.32. Төслийн орлого үр дүнгийн тайлан /шууд орлогоор тооцсон/	137
Хүснэгт 6.33. Төслийн орлого үр дүнгийн тайлан /шууд орлогоор тооцсон/	137

Хүснэгт 6.34. Төслийн орлого үр дүнгийн тайлан /экологи эдийн засгийн орлогоор тооцсон/	139
Хүснэгт 6.35. Төслийн PP8-, EBIDTA, IE /экологи эдийн засгийн орлогоор тооцсон/	139
Хүснэгт 6.36. Эрдлийн хугарлын цэгийн шинжилгээ	141

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

№	Нэр	Тайлбар
1	Төслийн нэр	“Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээ
2	Төслийн зорилго	“Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах, үүгээр дамжуулан судалгаа шинжилгээний ажил хийх, бэртэж, гэмтсэн амьтдыг асран хамгаалах, байгаль хамгаалах экологийн боловсролыг түгээх, судлаачид, зочид жуулчдыг татах говь цөлийн бүсийг төлөөлөх аялал жуулчлал, судалгаа шинжилгээний түшиц газар болох зорилготой.
3	Төслийн байршил	Говь-Алтай аймаг Цогт сум, Баянтоорой багаас баруун урагш 30 км, Цагаан бургасны амны адаг, Хүйс толгой орчмын нутаг дэвсгэр
4	Төслийн хамрах хүрээ	Захуй, Зармангийн говийн төлөөлөл газар нутаг
5	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2024-2026 он \3 жил\
6	Төсөл Хэрэгжүүлэх үе шат 1-р үе шат Төслийн эхний жил 2024	<ol style="list-style-type: none"> 1. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах газрын хатуу цэгийг ашиглах зөвшөөрөл авах 2. Ус ашиглах гэрээ хийх 3. Төвийн барилга, хашаа байгууламж бариулах тендерийг зарлах, шалгаруулах 4. Гүний худаг гаргах 5. Хязгаарлалтын хашааг барих, хүлээн авах 6. Хамгаалалтын хашааг барих, хүлээн авах 7. Төвийн оффисын байр барих, хүлээн авах 8. Байршуулан гаршуулах зүйлийг барих тендер зарлах 9. Хар сүүлт зээр барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх 10. Хавтгай тэмээ барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх 11. Амьтны эм, эмнэлгийн багаж хэрэгслээр хангах 12. Мал эмнэлэг, ариун цэврийн үйлчилгээг аргачлалын дагуу хийх 13. Амьтны идэш тэжээл бэлтгэх 14. Ажилчдын байр амьдрах орчны нөхцөлөөр хангах тохижилт хийх 15. Оффисийн байрыг тохижуулах, техник хэрэгсэлээр хангах 16. Амьтны маллагаа, арчилгааг тогтворжуулах 17. Жилийн ажлын тайлан гаргах 18. Жилийн ажлын төлөвлөгөөг гаргах
	2-р үе шат Төслийн 2 дахь жил 2025	<ol style="list-style-type: none"> 1. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулахтай холбоотой тендерүүдийг зарлах 2. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн байрыг барьж хүлээлгэн өгөх 3. Хар сүүлт зээр барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх 4. Хавтгай тэмээ барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх 5. Монгол бөхөн барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх 6. Янгир барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх 7. Аргаль барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх 8. Хулан адуу барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх 9. Тахь адуу барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх 10. Халиун буга барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх

		<ul style="list-style-type: none"> 11. Амьтны эм, эмнэлгийн багаж хэрэгслээр хангах 12. Мал эмнэлэг, ариун цэврийн үйлчилгээг аргачлалын дагуу хийх 13. Амьтны идэш тэжээл бэлтгэх 14. Оффисийн байрыг тохижуулах, техник хэрэгслээр хангах 15. Амьтны маллагаа, арчилгааг тогтворжуулах 16. Жилийн ажлын тайлан гаргах 17. Жилийн ажлын төлөвлөгөөг гаргах
	3-р үе шат Төслийн 3 дахь жил 2026	<ul style="list-style-type: none"> 1. Мал эмнэлэг, ариун цэврийн үйлчилгээг аргачлалын дагуу хийх 2. Амьтны идэш тэжээл бэлтгэх 3. Амьтны маллагаа, арчилгааг тогтворжуулах 4. Жилийн ажлын тайлан гаргах 5. Жилийн ажлын төлөвлөгөөг гаргах 6. Төвийн үйл ажиллагаа жигдэрэх 7. Бие дааж амьдрах чадвартай болсон бодгалиудыг байгаль суллан тавих менежмент боловсруулах
7	Төслийн санхүүжилт	<p>Барилга байгууламж , тоног төхөөрөмжийн зардал: 1,368,207,528</p> <p>Эргэлтийн хөрөнгийн зардал: 813,483,181</p> <p>НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: (813,483,181+1,368,207,528) = 2,181,690,709</p> <p>Үйл ажиллагааны зардал: 144,083,360</p> <p>ТӨСЛИЙН НИЙТ САНХҮҮЖИЛТ: (2,181,690,709+144,083,360) = 2,325,774,069</p>
8	Төслийн үр дүн	<ul style="list-style-type: none"> 1. Говь цөлийн нэн ховор, ховор амьтдыг судлах, хамгаалах төв байгуулагдана. 2. Нэн ховор, ховор амьтдын талаархи судалгааны ажил сайжирч олон улсад эргэлтэнд орсноор илүү их судалгааны төсөл хөтөлбөр хэрэгжих суурь болно. 3. Нэн ховор, ховор зүйл амьтны тоо толгойг өсгөж, тогтвортой популяцийг бий болгоно. 4. Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах Монгол улсдаа жишиг газар байгуулагдана. 5. Говь-Алтай аймгийн нэг томоохон байгалийн аялал жуулчлалын үзмэр болж гадаад дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ. 6. Тус төвийг дагаж аялал жуулчлалын баазууд хөгжих, орон нутгийн хөгжлийг түргэсгэнэ. 7. Монгол улсын болон орон нутгийн иргэд, оюутан, сурагчдын экологийн боловсрол олгох нэг томоохон түшиц газар болно. 8. Орон нутагт ажлын байр нэмэгдэнэ. 9. Дээрх бүхний үр дүнд говь, цөл, түүний биологийн олон янз байдлыг хайрлан хамгаалах ажил өргөжин тэлнэ.

ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ, ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

БОАЖЯамны Төрийн нарийн бичгийн дарга болон Сайнс тэч гэйт ХХК амьтны мэргэжлийн байгууллагын хооронд төслийн зорилтот нутаг болох Зармангийн говь болон Улаан шалын хоолойд “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээний 22/22 тоот гэрээг 2020 оны 6-р сарын 16-ны өдөр байгуулав.

Гэрээний анхны хүчин төгөлдөр хугацаа 2022-оны 6-р сарын 10-ны өдрөөс 2022 оны 12-р сарын 10 өдөр хүртэл 6 сарын хугацаанд үргэлжлэхээр тогтсон. Гэрээгээр дараах үүргийг хүлээсэн болно. Үүнд:

- Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах техник эдийн засгийн урьдчилсан суурь судалгаа
 - Тухайн бүс нутгийн нөхцөл байдлын шинжилгээ
 - Эдийн засгийн өнөөгийн байдал
 - Хүн ам зүйн судалгаа
 - Төсөл хэрэгжих салбар болон орон нутгийн өнөөгийн байдлын шинжилгээ
 - Хууль эрх зүйн орчны өнөөгийн байдлын шинжилгээ
 - Төслийн онцлогоос хамаарсан нэмэлт судалгааны ажлууд буюу нэн ховор, ховор амьтдыг нутагшуулах боломжийг тодорхойлох
- “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник эдийн засгийн үндэслэлийн төсөл
 - Ерөнхий мэдээлэл
 - Бүтээгдэхүүний мэдээлэл
 - Байгаль орчин
 - Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ
 - Барилгын үйл явц, хөтөлбөрийн судалгаа
 - Төсөвт өртгийн тооцооллыг тусгасан байна.

Гэрээний дагуу дээрх үүргийг гүйцэтгэснээр дараах хэд хэдэн гол үр дүнг хүлээлгэн өгнө. Үүнд:

- “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах техник эдийн засгийн урьдчилсан суурь судалгаа
- “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах газрын нийгэм, эдийн засгийн судалгааг хийх
- Төсөл хэрэгжих газрыг байршлыг тодорхойлох
- Төсөл хэрэгжихэд хууль эрх зүйн орчны шинжилгээ хийх
- Төслийн төвд хамгаалах, гаршуулах, нутагшуулах боломжтой нэн ховор, ховор амьтдыг тодорхойлох
- “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник эдийн засгийн үндэслэлийн төсөл
- Төсөлд шаардагдах түүхий эд, бүтээгдэхүүний мэдээлэл
- Эдийн засаг, санхүүгийн үнэлгээ хийх
- Барилгын зураг, төсөл, төлөвлөлт, барилгын үйл явц, материалыг урсгал зардалын тооцоо хийх
- Төсөвт өртгийн тооцоолол зэрэг болно.

ГЭРЭЭТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Төслийн зорилтот бүс нутаг болох Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр, Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Цогт сумдын нутагт орших Зармангийн говь, Баянхонгор аймгийн Баацагаан, Баянцагаан сумд, Говь-Алтай аймгийн Чандмань сумдын нутагт орших Улаан шалын хоолойд “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх зөвлөх баг нь “Сайнс тэч гэйт” ХХК амьтны мэргэжлийн байгууллага, ХААИС, Утга зохиол нийгмийн ажилтны дээд сургууль, Говь-Алтай аймгийн БОАЖГ-ын төлөөллөөс бүрдсэн баг бөгөөд манай оронд нэн ховор, ховор амьтдыг шинээр болон сэргээн нутагшуулах, судалгааны газар нутаг, байршил сонгох, нийгэм эдийн засгийн судалгаа хийх, ландшафт архитектурын ажил хийх, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах чиглэлээр олон жил ажиллаж байгаа туршлагатай баг юм.

БҮЛЭГ НЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

1.1. ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оршил

Амьтныг судлах, хамгаалах үйл ажиллагаа нь тусламж шаардлагатай байгаа нэн ховор, ховор, элбэг амьтныг тархалт, элбэгшил, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийг судлах, эдгээрийн талаар олон нийтэд таниулах, мэдээллэх, тусламж шаардлагатай амьтдыг барих, тээвэрлэх, хамгаалах байранд байршуулах, эмчлэх, сувилан тэнхрүүлэх, байгальд нь буцаан суллан тавих болон уг үйл ажиллагааг санхүүжүүлэх, удирдан зохион байгуулах зэрэг олон янзын үйл ажиллагааг багтаасан, олон талын оролцоонд тулгуурласан цогц ойлголт юм.

Монгол улсын Их хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолоор баталсан үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.7-д “Ховор амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлж, ашиглалтын нөөц бий болгоно” гэж тусгагдсан болон Говь-Алтай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төслийн зорилтот газар нутгийн говийн бүсэд зэрлэг амьтан хамгаалах, судалгааны төв байгуулах суурь судалгаа болон техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг төлөвлөсөн юм.

Энэхүү “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулагдсанаар говийн бүсэд ховор тааралдах зэрлэг амьтан буюу хар сүүлт, хавтгай, бөхөн, хулан зэрэг амьтад болон говийн бүсийн уур амьсгалын өөрчлөлт, экосистемийн суурин судалгааг тогтмол хийж болох чухал ач холбогдолтой юм.

Иймд төслийн зорилтот нутаг болох Зармангийн говь болон Улаан шалын хоолойд “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах шаардлага тулгарч байна.

Энэхүү тайланд хүний тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай болсон зэрлэг амьтдын амьдрах орчин, тухайн нутгийн нийгэм эдийн засгийн онцлог болон тухайн нэн ховор, ховор амьтдын биологи, экологийн онцлогийг судлах, барих, зөөж тээвэрлэх, анхны тусламж үйлчилгээ үзүүлж, эмчлэх, асран тордох үеийн орон байрны нөхцөл, үзлэг оношилгоо, хооллож тэжээх, сувилан тэнхрүүлэх, амьтантай зүй зохистой харьцах, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах, байгальд нь буцаан тавих талаар тодорхой мэдлэг, ур чадвар, арга барил олгохуйц байдлаар говийн онцлог, нөхцөл байдалтай уялдуулж, олон салбарын эрдэмтэн, судлаачид хамтран боловсруулсан байна.

Мөн ажлын нэгээхэн том зорилтын нэг болох “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах үүднээс судлах, хамгаалах төвийн сууринг бүтээн байгуулалт, түүнд шаардлагатай бараа материал, ажиллах хүч, тээвэр, дэд бүтэц, үйл ажиллагааны зардал зэрэг зарлагууд болон энэхүү төвөөс орох боломжтой орлогын хэмжээг тооцоолж гаргалаа.

1.2. НЭН ХОВОР, ХОВОР АМЬТНЫГ СУДЛАХ ХАМГААЛАХ ТУХАЙ ҮНДСЭН

ОЙЛГОЛТ

Сая сая жилийн турш хөгжиж өнөөгийн өнгө төрхөө олсон байгалийн тогтолцоо, амьд биес хүний үйл ажиллагааны нөлөөгөөр сөнөж мөхөж байгааг дэлхийн аль ч өнцөгт харж бодохоор болжээ. Хүний үйл ажиллагааны шууд нөлөөгөөр өөрчлөгдсөн байгалийн тогтоцын нийт тоо хэмжээг гаргах аваас нэн урт жагсаалт байхаар болсон байна. Олон тооны амьтан, ургамал, бичил биетний тухайд хэт агнасан, амьдрах орчныг нь өөрчилж устгасан, аль эсвэл бусад өрсөлдөгч зүйлийн нөлөөгөөр заримынх нь тоо толгой хэт хурдан цөөрч байна. Амьдралын түүхийн хугацааны турш ийм олон тооны зүйл ингэж ахар богино хугацаанд устах аюулд нэрвэгдэж байсан нь урьд өмнө огтхон ч тохиолдож байсангүй. Биологийн олон янз байдалд нүүрлэж байгаа энэхүү аюул асар хурдацтайгаар өсөн нэмэгдэж байгаа хүн амын тоо, хүний хэрэглээний өсөлтөөс шалтгаалж улам давшингуй шинж чанартай болж байна. Биологийн олон янз байдалд учирч байгаа аюулын олонхи нь харилцан бие бие нөхцөлдүүж байдаг. Байгаль орчныг эрүүл хэвийн байлгахын тулд түүнийг бүрдүүлэгч экосистем, бүлгэмдэл, зүйл, генетик олон янз байдлын хэвийн зохистой нөхцлийг чандлан сахих шаардлагатай. Учир нь байгаль орчны бүрдэл хэсгийн аль нэгэнд нүүрлэсэн аюул яваандаа орчныг бүхэлд нь сүйрүүлэхэд хүргэдэг. Бүлгэмдэл доройтож, үгүйрэх, түүний экосистемд гүйцэтгэх үүрэг алдагдсаар яваандаа устаж болзошгүй байдаг. Гэсэн ч бүлгэмдлийг бүрдүүлэгч зүйлүүд амьд оршин байгаа тохиолдолд бүлгэмдэл нөхөн сэргэх боломжтой. Үүнтэй адилаар, популяцийн хэмжээ буурснаас зүйлийн доторх генетик олон янз байдал хомсдож удамшлын төвөгтэй асуудал бий болж зүйл хямралд ордог. Гэвч мутаци, байгалийн шалгарал, эвцэлдүүлэг болон хамгаалалтын үйл ажиллагааны дүнд генетик олон янз байдал нөхөн сэргэх боломжтой. Нэгэнт зүйлүүд мөхөж алга болсон нөхцөлд популяци дахин сэргэхгүй бөгөөд тухайн бүлгэмдлийн бүтэц хувьсаж өөрчлөгдөнө.

Тодорхой зүйлийн амьтан устаж үгүй болох, тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь хорогдох зэргээр амьтны аймаг доройтоход хүргэж буй байгалийн болон хүний хүчин зүйлээс улбаатай маш олон нөхцөл, шалтгаан байх ба энэ хирээр зэрлэг амьтдыг хамгаалах арга, аргачлал ч мөн төдий хэмжээгээр баяжин боловсронгуй болж байна. Зэрлэг амьтдыг аврах, хамгаалах үйлчилгээ бол тэдгээр арга, аргачлалын нэг чухал хэлбэр нь юм.

Тооны хувьд цөөрч байгаа болон мөхөх аюулд өртөөд байгаа зүйлийг хамгаалах арга замыг эрэлхийлэх явдал бол байгаль хамгаалах ажлын нэг үндсэн зорилго юм. Хүний үйл ажиллагаа зүйлийн ховордолд ноцтой нөлөөлдөг. Ховордож байгаа зүйлийг амжилттай хамгаалахын тулд тодорхой нөхцлийн дор популяцийн тогтвортой байдлыг үнэн зөв тодорхойлох ёстой. Хэрэв аль нэг зүйл ховордож байвал түүнийг устахаас сэргийлэх тусгай арга хэмжээ авах ёстой юу? Эсвэл аль нэг ховордсон зүйлийн популяци тогтворжоод, тэр ч бүү хэл хамгаалалттай газар нутагт олшроод ирвэл яах вэ?

Үндэсний бэлэг тэмдэг, жуулчдын үзмэр болох магадлал ихтэй арслан, бар, баавгай гэх мэт сэтгэл татам амьтны зүйлийг хамгаалах зорилгоор олон тооны байгалийн цогцолбор газар, зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах бусад төрлийн хамгаалалттай газрыг байгуулсан байдаг. Гэхдээ тухайн зүйлийн амьдрах газрыг байгуулаад, түүнийгээ дархан цаазат газар хэмээгээд, тэр ч бүү хэл тэдгээрийг хуулиар хамгаалаад ч тэрхүү зүйлийг ховордох, мөхөх аюулаас хэлтрүүлэх асуудал бүрэн шийдэгдэхгүй юм. Аливаа зүйлийн хувьд ихэнх популяци амьдрах орчноо алдсан, эсвэл амьдрах орчин нь эвдэрч сүйрсэн, хэсэгчлэн хуваагдсан, аль эсвэл идэш тэжээл хомс зэрэг шалтгаанаар тоо толгой хэт

цөөрсөн хойно нь тусгай хамгаалалттай газар байгуулж, хамгаалах ажлыг эхлүүлдэг. Ийм нөхцөлд тухайн зүйлийн мөхөл их ойрхон байдаг нь ойлгомжтой.

Түүнчлэн хамгаалалттай газар нутгийн гадна байгаа хэсэг нь хамгаалалтгүй орхигддог бөгөөд тэдний мөхлийн эрсдэл их байна. Ховордсон зүйлийг хамгаалах, өсгөн үржүүдэхийн тулд байгаль хамгааллын төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй. Үүний тулд популяцийн байгальд байгаа төлөв байдал, амьдрах орчны өөрчлөлтөнд зохицох чадвар болон тухайн зүйлийн биологи, экологийн талаар хангалттай ойлголттой байх шаардлагатай. Байгаль хамгааллын биологичид зүйлийг хамгаалах болон өсгөн үржүүлэхэд популяцийн түвшний аргыг хэрэглэдэг.

Ховордсон зүйлийг хамгаалахад чиглэсэн байгаль хамгааллын төлөвлөгөөг боловсруулахдаа "хамгийн боломжит өргөн уудам орон зай бүхий хамгаалагдсан газар нутагт аль болох олон тооны бодгалийг хамгаалалтанд авах" ерөнхий зарчмыг баримтлана. Зүйл оршин тогтноход шаардлагатай нутаг орны хэмжээ, орон зайн тухай нарийн судалгаагүйгээр байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулах нь асуудлыг улам ч хүндрүүлнэ. Түүнчлэн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа газар нутгийн нөөц бололцоо, хязгаарлагдмал байдалтай эвлэрэн, зохицох шаардлагатай болдог.

Устах аюул нүүрлэсэн амьтан зүйлийг идэвхгүйгээр ажиглаж суухын оронд тэдгээр зүйлийг аврах арга замыг боловсруулах ажлыг эхлүүлдэг байна. Ингэснээр, устах аюул нүүрлэсэн ба ховордсон зүйлийн зэрлэг, хагас зэрлэг популяцийг шинээр бий болгох, нэгэнт байгаа популяцийн тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилготой зарим шинэ арга боловсруулжээ. Эдгээр туршилтын үр дүнд одоогоор зөвхөн зохиомол орчинд амьдарч байгаа амьтад өөрсдийн байгалийн биологийн бүлгэмдэлд дасаж экологийн үйлчилгээ үзүүлэх, хувиран өөрчлөх үүргээ биелүүлж чадна гэдгийг харуулж байна. Зэрлэгээр амьдарч буй популяци гаршуулсан популяцийг бодвол халдварт өвчин, хүний зүгээс үүссэн аливаа гамшгийн золиос болох магадлал багатай байдаг. Тэдгээрийн тоо хэмжээг ихэсгэх нь устаж алга болох магадлалыг бууруулахад тустай болох нь ойлгомжтой.

Зэрлэг популяцийг хорогдож, цөөрөхөд хүргэж буй хүчин зүйлийг зөв тогтоох, шалтгааныг арилгах, ядаж хяналт, ажиглалт хийхгүйгээр зүйлийг шинээр нутагшуулах хөтөлбөр дорвитой үр дүнд хүрч чадахгүй.

Амьтан шинэ популяци бий болгоход, одоогоор үндсэн 3 арга замыг ашиглаж байна.

Сэргээн нутагшуулах хөтөлбөрт: зохиомол орчинд өсгөж үржүүлсэн, аль эсвэл байгалиас цуглуулсан амьтан, ургамлын зүйлийн тодорхой тооны бодгалийг тэдгээрийн амьдарч байсан түүхэн нутагт нь тавьж нутагшуулах арга хэмжээ хамрагдана. Популяцийг сэргээн нутагшуулах талаархи нэр томъёо тодорхой болоогүй байгаа бөгөөд энэ хөтөлбөрийг заримдаа "дахин бий болгох", "дахин сэргээх" буюу "тараан байрлуулах" гэх мэтээр нэрлэх нь бий. Сэргээн нутагшуулах хөтөлбөрийн гол зорилго урьд амьдарч байсан түүхэн нутагт шинэ популяци бий болгоход оршино. Зарим тохиолдолд хамгаалалттай газар нутаг шинээр байгуулагдсан, эсвэл оршин буй бүлгэмдэлд шинээр аюул нүүрлэж тэр газартаа амьдрах нөхцөлгүй болсон, эсвэл тэдний чөлөөтэй шилжин явах замд нь зохиомлоор, эсвэл байгалийн саад тотгор үүссэн тохиолдолд сонгож авсан амьтдыг ерөнхийдөө тэдний тархац нутгийн өөр хэсэгт тараан суллаж тавина.

Тоо толгойг дэмжих хөтөлбөр: бол оршин байгаа популяцийн тоо хэмжээ, генийн санг баяжуулах зорилгоор сонгож авсан бодгалиудыг тухайн популяцид нийлүүлэн тавих арга юм. Эдгээр бодгалиудыг хаа нэгтээ газраас барьсан буюу цуглуулсан, эсвэл гаршуулж тэжээсэн байж болно. Ийм хөтөлбөрийн нэг онцгой жишээ бол "нялхаас нь

эхлэх” аргачлал бөгөөд тэнгисийн яст мэлхийн үр төлийн нялх байх, хамгийн их хорогдолтой үед нь тусгай газар өсгөөд тэнгист нь буцааж тавьсан явдал юм.

Шинээр нутагшуулах хөтөлбөр: амьтны зүйлийг өмнө нь амьдарч байгаагүй газар нутагт суурьшуулж шинээр популяци бий болгох үйл ажиллагаа юм. Зарим зүйл амьтан өөрийн идээшил газар нутагтаа амьдрах нөхцөлгүй болтол орчин нь муудсан, эсвэл тэдний тоо толгой улам бүр цөөрөх хүчин зүйл хэвээр байгаагаас дахин нутагшуулах боломжгүй байгаа нөхцөлд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь тохиромжтой. Шинээр нутагшуулахаар сонгон авсан тодорхой нэг зүйлийг шинэ газар нутагшуулахын өмнө тэд шинэ экосистемд буюу тэнд оршин буй устгах аюулд нэрвэгдээд байгаа аливаа зүйл амьтны ямарваа хор хохирол учруулахгүй байх үүднээс нарийн судалгаа хийх ёстой. Мөн суллаж тавих зүйл нь зохиомол орчинд байх үедээ, зэрлэг популяцид нөлөөлж тэднийг устгахуйц өвчний халдвар аваагүй байхад онцгой анхаарах хэрэгтэй.

Шинээр популяци бий болгох үйл ажиллагаа ихэвчлэн өртөг өндөртэй, бэрхшээл ихтэй байдаг бөгөөд ул үндэс сайтай, урт хугацааны хүчин чармайлтыг шаардана. Урт насалдаг амьтдын тухайд хөтөлбөрийн үр дүнг үзэхийн тулд бүр ч олон жил хүлээх шаардлагатай болно. Ийм хөтөлбөрийг мөнгөний гарз ("Хэдхэн муу шувууны төлөө их мөнгө доллар үрж байна!"), ямар ч шаардлага байхгүй ("Өөр газар өчнөөн олон байхад бид энд амьтдаар яах юм бэ"), муу арчилж байна ("Үржүүлгийн газар өвчнөөр үхсэн энэ олон амьтныг харцгаа!"), эсвэл ёс суртахуунгүй байна ("Яагаад сүүлчийн хэдэн амьтан хүртэл баригдаж, амьтны хүрээлэнд очилгүй өөрийн зоргоор тайван амьдарч байгаад үхэж болдоггүй юм бэ") гэх зэрэг шүүмжлэл ихээхэн гарна. Энэ бүх шүүмжлэлд өгөх хамгийн зөв хариу бол сайн зохион байгуулж, зөв төлөвлөсөн гаршуулах үржүүлэг, сэргээн нутагшуулах хөтөлбөр бөгөөд эдгээрийг хэрэгжүүлснээр байгаль дээр устгах аюулд нэрвэгдсэн буюу маш цөөрсөн зүйл амьтдыг хамгаалах итгэл, үнэмшлийг төрүүлэх явдал юм.

Нэн ховор, ховор амьтныг хамгаалах, судлах үйл ажиллагааны зорилго, хэрэгцээг орон нутгийн хүмүүст тайлбарлаж, ойлгуулах; тэдний дэмжлэгийг авах, итгэл үнэмшил, бахархлыг төрүүлэх, үгүй ядаж эсэргүүцэхгүй байлгах зэрэг олон нийтийн харилцаан дахь хүчин чармайлт бол олонхи хөтөлбөрийн хамгийн чухал бөгөөд байнга анхаарал тавьж байх ёстой бүрэлдэхүүн хэсэг юм. Орон нутгийн хүмүүсийг шагнаж, урамшуулах ажлыг хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн нэг хэсэг байхаар зохион байгуулах нь ямар нэг хууль дүрэм, хориг тавьснаас илүү үр дүнтэй байна.

Байгальд суллаж тавих үед эсвэл дараахан нь тэдгээр амьтдад онцгой анхаарал халамж, тусламж шаардлагатай байдаг бөгөөд энэ үе шатыг "зөөлөн суллах" хэмээн нэрийддэг байна. Тухайн амьтныг өөрөө бие дааж амьдрах чадвартай болтол нь нутагшуулах орчинд нь байлгаж тэжээх, эсвэл суллах газарт нь түр оромж барьж, хамгаалах шаардлага гарч болох бөгөөд ингэх нь тэднийг аажмаар орчиндоо дасч зохицоход тустай. Бүл амьтдыг гэнэт суллаж тавихад ("хатуу суллах") өөр өөр зүгт тарж бутраад, хамгаалалттай газрын нутаг дэвсгэрээс гарах, холдох магадлал ихтэй байх бөгөөд ингэвэл үр дүн муу болох нь ойлгомжтой. Ган гачиг, хоол тэжээлийн хомсдлоос болоод тухайн амьтан бие дааж амьдарч чадахгүй нөхцөл бүрэлдвэл тэдэнд туслах нь зайлшгүй. Ийм нөхцөлд тэдгээр амьтанд дасан зохицох хүртэл нь үе үе тусламж, дэмжлэг үзүүлэх үү; эсвэл зоргоор нь биеийг нь даалгах уу гэдгийг харьцуулж үзээд шийдвэр гаргах ёстой болно. Ер нь сэргээн нутагшуулах ажил бол олон арван жил үргэлжлэх, урт удаан хугацааны хүчин чармайлтын үр дүн байдаг юм.

Сэргээн нутагшуулах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нь мөн боловсролын талаасаа ихээхэн ач холбогдолтой.

Агнуурын ач холбогдол бүхий амьтдыг сэргээн нутагшуулах хөтөлбөр олон газарт хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь устаж байгаа болон устах аюул нүүрлэсэн амьтныг хамгаалах, дахин нутагшуулах шинэ хөтөлбөрийг боловсруулахад мэдээллийн асар их ач холбогдолтой юм. Шинээр нутагшуулж байгаа популяцийн хувьд илүү амжилттай байж болох хэд хэдэн нөхцөл байна. Үүнд:

- Устаж буй, устах аюул нүүрлэсэн, эмзэг зүйл амьтадтай (44%) харьцуулахад агнуурын ач холбогдол бүхий амьтдын хувьд маш сайн (86%)
- Амьдрах орчны чанар доройтсон газарт суллаж тавьснаас (38%), нөхцөл сайтай орчинд суллаж тавих нь (84%) илүү үр дүнтэй
- Түүхэн тархац нутгийн захад буюу гадна нутагшуулсанаас (48%), түүхэн тархац нутгийн цөм хэсэгт тавих нь (78%) илүү үр дүнтэй
- Зохиомол орчинд өсгөн үржүүлж, бойжуулсан амьтадтай (38%) харьцуулахад зэрлэгээр нь барьж сулласан амьтдын хувьд (75%) илүү үр дүнтэй
- Махчин амьтадтай (48%) харьцуулахад ургамал идэштнийг (77%) дахин нутагшуулах нь илүү үр дүнтэй байна.

Дээр дурьдсан судалгаанд хамрагдсан шувуу, хөхтөн амьтдын хувьд 100 хүртэлх тоогоор суллаж тавихад шинэ популяци үүсгэх магадлал өсч байсан бол 100-гаас илүү тоогоор суллаж тавихад амжилт буурч байгаа нь ажиглагдсан байна.

Сэргээн нутагшуулах, тоо толгойг өсгөх, шинээр нутагшуулах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд суллан тавьж буй амьтдын бүлийн зохион байгуулалт болоод зан авирыг чухалчлан авч үзэх шаардлагатай. Бүлсэг амьтад байгальд өсч үржихдээ өөрсдийн амьдрах орчин ба бүлийн дотоод харилцааны талаар өөрийн зүйлийн бие гүйцсэн амьтдаас байнга суралцдаг байна. Гаршиж өссөн амьтад байгалийн зэрлэг орчинд зохицож амьдрахад туршлага, чадвар дутагдаж болно. Хамтарч идэш хоолоо олох, учрах аюулыг мэдрэх, үржлийн хосоо олох, үр зулзагаа өсгөх зэрэг бүлсэг амьдралд зайлшгүй хэрэгтэй чадвар, дадал үүнд юуны түрүүнд хамаарна. Энэ бүх бэрхшээлийг даван туулахын тулд суллаж тавихын өмнө удаан хугацааны дадлага сургуулилт хийх шаардлагатай. Гаршуулсан амьтдад том дууриамал амьтны дүрс үзүүлэх замаар томоохон араатнаас айдаг болгож сургадаг туршлага бий. Гаршуулсан хөхтөн болон шувуудыг өөр амьтадтай харилцаж сургах нь хамгийн хэцүү асуудал байдаг. Учир нь ихэнх зүйл амьтны бүлийн харилцааны нарийн ширийн одоогоор бүрэн тодорхой болоогүй байна. Гэхдээ гаршуулсан хөхтнийг бүлийн харилцаанд амжилттай сургасан олон тохиолдол бий. Зарим тохиолдолд хүн, зэрлэг амьтны зан авир гадаад төрхийг дууриаж үзүүлдэг. Энэ арга нь ялангуяа нялх амьтдын тухайд бусад тэжээвэр амьтан болоод хүнтэй харьцахаас илүү өөрийн адил зүйлийн амьтантай харьцаж, тэднийгээ ялгаж, танихад маш чухал.

Хулгайн анчдаас болгоомжлуулж сургахын тулд хүний нөлөөнөөс аль болох ангид байлгаж хооллохдоо тусгайлсан давууны цаана зогсож тэжээдэг туршлага байна.

Зарим тохиолдолд зэрлэг амьтныг түүний ижил зүйлийн тэжээвэр амьтанд “зааварлагч”-аар ашигладаг. Гаршуулсан амьтдыг байгальд суллан тавьсны дараа зэрлэг амьтадтай байнга бүлийн харьцаанд байх нь тэдний амьдралд маш чухал ач холбогдолтой байж болзошгүй.

Монгол орон зах зээлийн эдийн засагт шилжиж, байгалийн нөөц баялгийг ашиглах эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж, нийгмийн амьдрал, байгаль орчны унаган төлөв байдал

өөрчлөгдөхийн хирээр зэрлэг амьтдын хэвийн амьдралд байгалийн болон хүний зүгээс үзүүлэх сөрөг нөлөө улам ихсэж байгаа боловч гэмтсэн, шархадсан, өнчирсөн амьтдын тоо толгойн талаар тоймтой мэдээ баримт байхгүй төдийгүй тэдгээрийг хамгаалах, нөхөн сэргээх үүрэг бүхий албан ёсны байгууллага, хүмүүс ч байхгүй байна. Тиймээс ган, зуд, түймэр, үер, газар хөдлөлт, салхи шуурга зэрэг байгалийн олон үзэгдлүүдийн нөлөөгөөр эрсдэлд орж буй амьтдыг аварч, асран хамгаалан эрүүлжүүлээд байгалийн амьдрах орчинд нь буцаан тавих ажлыг эхлүүлэх шаардлага тулгарч байна. Нөгөө талаас, манай улсад эдгээр эрсэдсэн зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах стандартын шаардлага хангасан төрийн ба төрийн бус байгууллага, асран хамгаалах төв зэрэг амьтны эрүүл мэнд, эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа олон улсын жишгээс хоцорч байна.

Иймээс нэн ховор, ховор амьтдыг судлах хамгаалах төв байгуулах ажлыг НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төслөөс санаачлан төв байгуулах техник, эдийн засгийн урьдчилсан үндэслэл боловсруулах ажил хийгдэж байна. Эдгээр үйл ажиллагааг олон улсын жишиг, Монгол Улсын стандарт, арга аргачлалд нийцүүлэн хэрэгжүүлэхэд туслах зорилгоор энэхүү урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулав.

Нэн ховор, ховор амьтдыг хамгаална гэдэг нь янз бүрийн шалтгааны улмаас тоо толгой цөөрч, тархац нутаг хумигдсан хүний тусламж шаардлагатай болсон тодорхой зүйлийн бодгаль биесийг байгалиас олж илрүүлэн, судлах, хамгаалах, эмчлэн илаарьшуулж, асран тордож тэнхрүүлээд байгальд нь буцаан нутагшуулах цогц үйл ажиллагаа юм. Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны үндсэн зорилго нь тухайн бүс нутгийн зэрлэг амьтдыг хамгаалах, амьдрах орчныг сайжруулах, амьтдын байгалийн жам ёсны эрхийг хүндэтгэн сахих, асран хамгаалахад ард, иргэд, төрийн ба иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог бүтээлчээр хангах явдал болно.

Амьтан хамгаалах үйл ажиллагаа бол нэг ёсондоо хүний зүгээс тухайн амьтанд үзүүлж буй олон төрлийн үйлчилгээний цогц нийлэмж юм. Энэ цогц ажиллагаанд бодгаль биесийг цаг алдалгүй олж, осол аюулгүй барих, тээвэрлэхээс эхлээд үзлэг, оношилгоо хийх, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, эмчлэх, асран сувилж тордох, адуулан маллаж тэжээх, зохиомол амьдрах орчныг бүрдүүлэн хяналт тавих, сайжруулах, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэм сахих, эдгэрч, тэнхэрсний дараа байгальд буцаан тавьж нутагшуулах зэрэг олон төрлийн үйлчилгээ багтана. Амьтдын ангилал зүйн бүлгээс хамаарч эдгээр үйл ажиллагаа өөр өөрийн онцлогтой байдаг.

Дараах нөхцөлүүдээс нэг нь эсвэл хэд хэд нь илэрч байгаа амьтныг хүний тусламжтайгаар аварч, асран хамгаалах шаардлагатай гэж үзнэ. Үүнд:

Төрөл бүрийн байдлаар гэмтэж бэртсэн, шархадсан, түлэгдсэн амьтан: Амьтад байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн нөлөөгөөр гэмтэж, бэртэх нь байгальд үлэмж элбэг.

Хүнд өвчтэй амьтан. Байгальд буй өвчилж, шаналсан амьтдыг зөвхөн хүний зүгээс тусалж дэмжин, эмчилж, эдгэрүүлэх боломжтой, эс тэгвээс ийнхүү өвчилсөн амьтдыг ихэвчлэн үхэл мөхлийн хувь заяа л хүлээж байдаг. Өвчилсөн амьтдыг байгалиас олж эмчлэх нь зөвхөн тухайн бодгаль төдийгүй, тухайн байгалийн популяцийг өвчин эмгэгээс сэргийлэхэд нэн өндөр ач холбогдолтой. Өвчилсөн амьтдын хувьд ямар нэг халдварт өвчин туссан эсэхэд онцгой анхаарах ёстой.

Хаягдсан, төөрсөн, бие даах чадваргүй нялх төл амьтан. Тэгэхдээ тухайн нялх амьтан үнэхээр эх, эцгээс хаягдан төөрч, бие даах чадваргүй болсон эсэхийг сайтар нягтална. Осол, аюул тохиолдсон үед олон зүйлийн амьтан үр төлөө хаа нэгтээ нуун

далдалж, өөрсдөө тухайн газраас алслан холдох аргаар үр төлөө авран хамгаалах төрөлх зан араншин хөгжсөн байдгийг анхаарах шаардлагатай. Үр төлийг аврах гээд санамсаргүйгээр эх, үрийг хагацуулах үйлдэл хийж огт болохгүй.

Ган, зуд, үер, аянга цахилгаан, түймэр болон байгалийн бусад гэнэтийн бэрхшээлд өртсөн амьтан. Байгалийн эдгээр хүчин зүйлд өртсөн амьтад ихэнх тохиолдолд бэртэж, гэмтсэн байдаг. Идэш тэжээл, унд усны хомсдолын улмаас турж эцэн, хүч тамир нь барагдсан амьтан.

Энэ үйл ажиллагааны явцад амьтдыг зохиомол орчин, хүнд дасан зохицож, байгальд бие даан амьдрах чадвар, боломжоо алдахаас ямагт сэргийлэх шаардлагатай. Үүний тулд амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг аль болох богино хугацаанд хийж гүйцэтгэх ёстой.

1.3. АМЬТНЫ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ

Энэхүү тунхаглалыг 1977 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Лондон хотноо Олон улсын амьтны эрхийн холбооноос баталж, 1978 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ЮНЕСКО-оос дэлхий дахинд тунхаглан зарлажээ. Уг тунхаглалыг Олон улсын амьтны эрхийн лигээс 1989 онд шинэчлэн найруулж, 1990 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий захиралд өргөн барьснаар тухайн ондоо олон нийтийн хүртээл болсон байна.

Амьтны эрхийн түгээмэл тунхаглал бол хүн төрөлхтний зүгээс манай дэлхийн амьтны аймагт хандах хандлага, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээг өндөр дээд түвшинд тодорхойлон тунхагласан, дэлхий дахинаар даган мөрдөх Олон улсын эрх зүйн үндсэн баримт бичиг юм.

Амьтны эрхийн түгээмэл тунхаглалын оршилд:

- Манай дэлхийн амьдрал, бүх амьд бие махбод бол нэг гарал үүсэлтэй нэгдмэл тогтолцоо бөгөөд түүхэн хөгжлийн явцад тэдгээрийн олон янз байдал бүрэлдэн бий болсныг;
- Бүх амьд бие махбод байгалиас заяасан жам ёсны эрхтэй, мөн мэдрэлийн системтэй аливаа амьтан бусдаасаа онцлох эрхтэйг; Эдгээр байгалийн жам ёсны эрхийг үл хүндэтгэх, бүр энгийнээр үл тоомсорлох нь байгальд асар их хор хохирол учруулж, амьтдын эсрэг гэмт хэрэг үйлдэхэд хүргэж байгааг харгалзан үзэхийг;
- Хүн төрөлхтөн зэрэгцэн оршин тогтнодгийнхоо хувьд бусад амьтдын амьдрах эрхийг хүлээн зөвшөөрөхөд анхаарлаа хандуулахыг;
- Хүмүүс амьтдыг хүндлэх нь хүн хүнээ хүндлэхтэй утга нэг болохыг тус тус хүн төрөлхтөнд хандан сонордуулсан билээ.

Олон улсын эрх зүйн энэ баримт бичигт нийт хүн төрөлхтөн, улс үндэстэнд хандан амьтны эрхийн талаар дор дурдсан 10 зүйлийг тунхаглан зарласан байна. Тэдгээрийн үндсэн агуулгыг толилуулав. Үүнд:

Нэгдүгээр зүйл: Бүх амьтад биологийн тогтвортой нөхцөлд оршин тогтнох тэгш эрхтэй. Эдгээр эрхийн тэгш байдал нь төрөл зүйл ба бодгаль биеийн хоорондын ялгааг харгалзахгүйгээр хэвээр хадгалагдана.

Хоёрдугаар зүйл: Бүх амьтдын амьдрал нь хүндэтгэл хүлээх эрхтэй.

Гуравдугаар зүйл: 1. Амьтадтай зүй бус харьцаж, түрэмгий үйлдэл гаргаж болохгүй. 2. Зайлшгүй шаардлагаар амьтны амь хороох үйл ажиллагааг агшин зуур,

өвдөлтгүйгээр гүйцэтгэх бөгөөд урьдчилан сэтгэлзүйн болон бие махбодын ямар нэгэн зовлон шаналал учруулахгүй байх ёстой. 3. Үхсэн амьтдад ёс зүйтэй хандах ёстой.

Дөрөвдүгээр зүйл: 1. Зэрлэг амьтад байгалийн хүрээлэн буй орчин, нөхцөлд эрх чөлөөтэй амьдарч, өсөн үржих эрхтэй. 2. Зэрлэг амьтдыг удаан хугацаагаар хорих, зугаа цэнгэлийн зорилгоор агнах, 3. загасчлах, түүнчлэн зайлшгүй амин чухал бус шалтгаанаар зэрлэг амьтдыг ашиглах нь энэхүү үндсэн эрхэд харш болно.

Тавдугаар зүйл: 1. Хүмүүсээс хамааралтай орчинд амьдарч буй аливаа амьтан зохих ёсоор анхаарал халамж хүртэх эрхтэй. 2. Ямар ч тохиолдолд амьтныг хаях юм уу үндэслэлгүйгээр алж болохгүй. 3. Амьтдыг үржүүлэх, ашиглах бүхий л тохиолдолд тухайн зүйлийн физиологи, байгалийн зан төрхийг хүндэтгэх ёстой. 4. Амьтдыг оролцуулсан үзэсгэлэн, сурталчилгаа, кино нь тэдний эрхийг хүндэтгэсэн байх ёстой бөгөөд хүчирхийлэл огт агуулагдах ёсгүй.

Зургаадугаар зүйл: 1. Амьтанд бие махбодын болон сэтгэхүйн дарамт учруулах аливаа туршилт хийх нь амьтны эрхийг зөрчсөн үйлдэл мөн. 2. Амьтдын тоо толгойг өсгөн олшруулах нь системтэй хөгжүүлсэн үр дүнтэй аргад үндэслэх ёстой.

Долоодугаар зүйл: Амьтныг үндэслэлгүй үхэлд хүргэх аливаа үйлдэл, ийм үйлдэл хийхэд хүргэх шийдвэр нь амьдралын эсрэг гэмт хэрэг мөн.

Наймдугаар зүйл: 1. Зэрлэг амьтдын оршин амьдрахад аюул заналхийлж буй аливаа үйлдэл, ийм үйлдэл хийхэд хүргэх аливаа шийдвэр нь хоморголон устгах (геноцид) буюу төрөл зүйлийн эсрэг гэмт хэрэг үйлдэхтэй адил хэмээн үзнэ. 2. Зэрлэг амьтдыг алах, биосферийг бохирдуулж, сүйтгэх нь хоморголон устгаж буй (геноцид) үйлдэл мөн.

Есдүгээр зүйл: 1. Амьтны эрх зүйн байдал, түүний эрхийг хуулиар хүлээн зөвшөөрөх ёстой. 2. Амьтдын хамгаалал, аюулгүй байдлын асуудлыг Засгийн газар (төрийн байгууллага)-ын түвшинд авч үзэх ёстой.

Аравдугаар зүйл: Боловсролын байгууллагууд амьтдыг ажиглах, ойлгох, хүндлэх боловсролыг иргэдэд бага наснаас нь гүн гүнзгий эзэмшүүлэх ёстой.

1.4. ЗЭРЛЭГ АМЬТАН АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хүн төрөлхтний соёл иргэншлийн өндөр түвшин, байнга өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээний улмаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн цар хүрээ, үр дагавар урд өмнө байгаагүй шинэ шатанд гарчээ. Дэлхийн хуурай газрын үлэмж талбайг хот, суурин, хөдөө аж ахуйн эдэлбэр газар, уул уурхайн үйлдвэрлэл, дэд бүтцийн байгууламжууд эзлэх болсноор зэрлэг амьтад унаган байгалийн орчин нөхцөлдөө идээшин амьдрах орон зай улам бүр хумигдаж, тархац нутаг, тоо толгой нь эрс хорогдсоны зэрэгцээ, олон зүйлийн амьтан эргэлт буцалтгүйгээр устан сөнөж буй харамсалтай дүр зураг газар сайгүй гарч байна.

Тодорхой зүйлийн амьтан устаж үгүй болох, тархац нутаг нь хумигдаж, тоо толгой нь хорогдох зэргээр амьтны аймаг доройтоход хүргэж буй байгалийн болон хүний хүчин зүйлээс улбаатай маш олон нөхцөл, шалтгаан байх ба энэ хирээр зэрлэг амьтдыг хамгаалах арга, аргачлал ч мөн төдий хэмжээгээр баяжин боловсронгуй болж байна. Зэрлэг амьтдыг хамгаалах үйлчилгээ бол тэдгээр арга, аргачлалын нэг чухал хэлбэр нь юм.

Амьтан судлах, хамгаалах үйл ажиллагааг тусламж шаардлагатай байгаа нэн ховор, ховор амьтны талаар мэдээллэх, барих, тээвэрлэх, хамгаалах байранд байршуулах, эмчлэх, асран хамгаалах, байгальд буцаан суллах, уг үйл ажиллагааг санхүүжүүлэх, удирдан

зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг цогцоор нь агуулсан ойлголт хэмээн үзэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, амьтан судлах, хамгаалах үйл ажиллагаа нь тухайн тоо толгой, тархац нутаг нь хомсдсон зүйлийг дэмжих, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагад мэдээллэхээс эхлээд тухайн амьтныг барих, тээвэрлэх, аврах, хамгаалах байранд байршуулж, эмчлэх, сувилян тэнхрүүлэх, буцаан байгальд нь тавих зэрэг үйл ажиллагааг багтаасан цогц ойлголт юм.

Энэхүү цогц үйл ажиллагаа, үүнтэй холбоотой харилцааг зохицуулсан, оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлж, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх хууль, эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хуулиас эхтэй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долоодугаар зүйлийн 2-т *"Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн"* хэмээн заасан байдаг. Ийнхүү Монголын төр амьтныг хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг болохыг Үндсэн хуульдаа тодорхой зааж өгсөн байдаг.

Нэн ховор, ховор амьтныг хамгаалахад анхаарах гол шаардлага, нөхцлийг тодорхойлж, амьтан судлах, хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулсан гол хууль нь Амьтны тухай хууль болно. Монгол Улсын Үндсэн хуулиар амьтан хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг байхаар тодорхойлж, үндэс суурийг тогтоож өгсөн бол Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн амьтан судлах, хамгаалах үйл ажиллагаанд оролцох эрх, үүргийг тодорхойлж, тэдгээртэй холбоотой нийтлэг харилцааг зохицуулсан байна.

Амьтныг хамгаалах үйл ажиллагаа бол Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтад зааснаар амьтан хамгаалах нэг хэлбэр юм. Амьтны тухай хуульд заасан амьтан хамгаалах үйл ажиллагааг явуулахад шаардлагатай зөвшөөрөл, зөвшөөрлийн төлбөр, хураамжийн хувь хэмжээ, тэдгээрийг хөнгөлөх, чөлөөлөх, зөвшөөрлийн төлбөрөөс эргээд амьтан хамгаалах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг тогтоохтой холбоотой харилцааг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар зохицуулдаг. Энэхүү хууль нь амьтан хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх гол эх үүсвэр, хөрөнгийн хувь хэмжээг тодорхойлсноороо чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулиар амьтан хамгаалах үйл ажиллагаанд засаг захиргааны нэгж дэх төрийн болон нутгийн өөрийн удирдлагын байгууллагын чиг үүрэг, оролцоог тодорхойлж, үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой харилцааг зохицуулж өгсөн бол амьтан хамгаалах үүргийг хуулийн дагуу хэрэгжүүлээгүй тохиолдолд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэхээр заасан байна.

Амьтан хамгаалах үйл ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг дараах хуулиудаар зохицуулна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)
- Амьтны тухай хууль (Шинэчилсэн найруулга 2012)
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль (2017)
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль (2003)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (Шинэчилсэн найруулга 2012)
- Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга 2015)
- Зөрчлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга 2017)
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль (Шинэчилсэн найруулга 2012)

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006; 2020)
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (Шинэчилсэн найруулга 2019)
- Гамшгаас хамгаалах тухай хууль (2017)
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019) зэрэг болно.

Иймд амьтан аврах, асран хамгаалахад чиглэсэн аливаа үйл ажиллагааг Монгол Улсын дээр дурьдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулах нь зүйтэй.

Амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг, оролцоо

Амьтан хамгаалах үйл ажиллагааг дараах үйлдэл, үйл ажиллагааны цогц хэмээн ойлгох нь зүйтэй. Үүнд:

- Тусламж шаардлагатай байгаа нэн ховор, ховор, элбэг амьтны талаар мэдээллэх, олж тогтоох
- Шаардлагатай зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авах
- Барих, тээвэрлэх
- Хамгаалах төвд байршуулах, эмчлэх, асрах
- Тэдгээр амьтдыг байгальд суллан тавих
- Санхүүжүүлэх
- Удирдлага зохион байгуулалт, хяналт зэрэг болно.

Дээрх хууль тогтоомжид нэн ховор, ховор амьтан авран хамгаалах үйл ажиллагааг явуулахад оролцогч талууд (төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэд)-ын гүйцэтгэх чиг үүрэг, эрхийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Амьтны жам ёсны эрх

Монгол Улсын Амьтны тухай хуульд “Амьтны жам ёсны эрх гэж амьтад идэш тэжээлээ олох, амьдрах идээшил, тархац нутгаа сонгох, үржил хөөцөлдөөнд орж, үр төлөө үлдээх, бүл сүрэгтэй дасан ижилсэх, айдас цочрол, хоморголон устгагдахаас ангид байх”-ыг ойлгоно гэж заажээ (Амьтны тухай хууль, 2012). Энэ нь төрөөс "Амьтны эрхийн түгээмэл тунхаглал"-ын үзэл санааг хүлээн зөвшөөрч, хуульчлан баталгаажуулсан хэрэг мөн.

Түүнчлэн Амьтны тухай хуулийн “Амьтан хамгаалах” тухай 2 дугаар бүлгийн “Амьтныг хамгаалах хэлбэр” хэмээх 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтад “өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах” нь амьтан хамгаалах үндсэн нэг хэлбэр мөн болохыг, мөн зүйлийн 6.2 дахь хэсэгт уг үйл ажиллагааг “байгаль орчны мэргэжлийн байгууллага, иргэн, хуулийн этгээд хэрэгжүүлнэ” хэмээн тус тус хуульчилсан байна. Уг хуулийн 5 дугаар бүлгийн 34 дүгээр зүйлд “Амьтны жам ёсны эрхийг хүндэтгэж, энэрэнгүй хандах”, “Амьтныг агнах, барих, тавих, арчилж тордох, ачиж тээвэрлэхдээ эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан арга технологи, багаж хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын тоногдсон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг ажиллуулна” гэж заажээ. Байгалийн нэг чухал нөөц баялаг болсон зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг

хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн үзэл санаа, хууль, эрх зүйн үндэслэлийг ийнхүү хуульчилсан байна.

Мэдээллэх

Монгол Улсын Үндсэн хууль. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долоодугаар зүйлийн 2-т *“Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”* гэж амьтан хамгаалах, мэдээллэх нь Монгол Улс иргэн бүрийн журамт үүрэг байдлаар Үндсэн хуульдаа эх үндсийг тавьж өгсөн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт иргэн байгаль орчныг хамгаалах талаар *“байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх”*-ээр зааж, үүрэг болгосон байдаг. Түүчлэн нэн ховор, ховор, элбэг амьтныг хууль бусаар агнасан, барьсан талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээд нь цагдаагийн байгууллагад мэдээллэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуульд зааснаар хууль бус үйл ажиллагаа буюу гэмт хэргийн талаар гомдол мэдээллийг цагдаагийн байгууллагад мэдээллэх үүрэгтэй болохыг заасан байна. Харин иргэнд амьтан аврах, асран хамгаалах, туслах, мэдээллэх шаардлагатай болохыг тусгайлан хуульчилж өгөөгүй боловч дээрх заалтын агуулгад хамааруулан ойлгож болохоор байна. Тодруулж хэлбэл, Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу иргэн нь тусламж шаардлагатай байгаа амьтны талаар мэдээллэх үүрэг бүхий этгээд юм.

Амьтны тухай хууль. Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *“Амьтныг дор дурьдсан хэлбэрээр хамгаална”*. Үүнд: мөн зүйлийн 6.1.9-д *“өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах”*, 6.2-т *“энэ хуулийн 6.1.1-6.1.6, 6.1.10, 6.1.11-д заасан үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага, 6.1.4, 6.1.6-6.1.9-д заасан үйл ажиллагааг байгаль орчны мэргэжлийн байгууллага, 6.1.7-6.1.9-д заасан үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд тус тус хэрэгжүүлнэ”* хэмээн заасан байна. Иймд иргэн өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэл, хууль бус үйлдэлд өртсөн болон бусад шалтгаанаар тусламж шаардлагатай болсон амьтныг аврах, асран хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэхийг тусгайлан үүрэгтэй байхаар заагаагүй боловч хэрэгжүүлэх субъектийг тодорхойлон заах байдлаар үүрэгжүүлсэн байна.

Тусламж шаардлагатай амьтныг барих, тээвэрлэх болон шаардлагатай зөвшөөрөл

Амьтны тухай хууль болон Эрүүгийн хууль. Тусламж шаардлагатай байгаа амьтныг хамгаалах үйл ажиллагааны үед тухайн амьтныг барих, тээвэрлэх шаардлага зайлшгүй гарна. Харин амьтныг барих, тээвэрлэхэд тухайн амьтны ховордлын зэргээс шалтгаалан хуульд заасан зөвшөөрлийг холбогдох байгууллагаас нэн яаралтай авах шаардлага гарна. Өөрөөр хэлбэл, тухайн амьтан нь нэн ховор, ховор, элбэг тархацтай амьтны аль нь болохоос шалтгаалан тухайн зүйл амьтныг барих, тээвэрлэх зөвшөөрлийг ямар байгууллагаас авах, эсэх нь тодорхойлогдох юм. Үүнийг одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд дараах байдлаар тайлбарлаж болохоор байна.

Монгол орны амьтны аймгийг ховордлын зэргээр нь нэн ховор, ховор, элбэг тархацтай гэж ангилдаг бөгөөд Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нийт

31 зүйл, салбар зүйл амьтныг нэн ховор, Засгийн газрын "Ховор амьтны жагсаалт батлах тухай" 2012 оны 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан 76 зүйл амьтныг ховор амьтан, бусад амьтдыг элбэг тархацтай амьтан хэмээн тус тус ойлгоно.

Энэхүү ховордлын зэргээс нь хамааран нэн ховор, ховор, элбэг амьтдыг ямар зориулалтаар агнаж, барьж болохыг Амьтны тухай хуульд тусгайлан зааж өгсөн байдаг. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т нэн ховор амьтныг зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болохоор заасан бөгөөд бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж, барихыг хориглосон байна.

Нэн ховор амьтныг эрдэм шинжилгээнээс бусад зориулалтаар барих, агнах, эсхүл тусгай зөвшөөрөлгүй тухайн амьтан агнасан, барьсан, эд эрхтнийг тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан бол Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн 2-т заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан болно.

Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн 2-т *“Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”* гэж заасан байдаг.

Засгийн газрын “Журам батлах тухай” 2013 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан “Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох тухай” журмын 2.1-д *“эрдэм шинжилгээ гэдэгт амьтны биеийн бүтцийг судлах, эд, эрхтэнд нь гэмтэл учруулалгүйгээр судалгааны багаж, тэмдэг зүүх, хэмжилт хийх, эд эрхтнээс сорьц авах”* хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, нэн ховор амьтныг зөвхөн тухайн амьтны биеийн бүтцийг судлах, тэмдэг зүүх, хэмжилт хийх, сорьц авах зорилгоор барьж, агнаж болно.

Ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээ болон тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор агнаж, барьж болохоос гадна, олзворын ангийн зориулалтаар зөвхөн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр агнаж, барьж болохоор хуулийн зохицуулалттай байдаг.

Тусламж шаардлагатай байгаа нэн ховор, ховор амьтныг барих, асран хамгаалах, шаардлагатай нөхцөлд тэдгээрийг барих, тээвэрлэх зохицуулалтыг хуульд тусгайлан зааж өгөөгүй байна. Гэвч Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэг, Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийг харгалзан авран хамгаалах шаардлагатай нэн ховор, ховор амьтныг барих, тээвэрлэхдээ төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг заавал авах нь зүйтэй болно.

Тусламж шаардлагатай байгаа элбэг тархацтай амьтныг барих, тээвэрлэх зөвшөөрлийг ямар субьектээс авах нь тодорхой зохицуулалтгүй байгаа боловч иргэн нь байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагчид энэ талаар мэдэгдэж, зөвшөөрөл, заавар зөвлөгөөг авах нь зүйтэй болно. Элбэг амьтныг барих, тээвэрлэх үйл ажиллагааг орон нутгийн байгаль орчныг хамгаалах газар, тэдгээрийн ажил үүргээ гүйцэтгэж буй албан хаагч нар (байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч г.м) зөвшөөрөл шаардлагагүйгээр гүйцэтгэж болно.

Амьтны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн дагуу тусламж шаардлагатай байгаа амьтныг барьж, тээвэрлэж байгаа байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, орон нутгийн биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн нар нь

амьтны жам ёсны эрхийг хүндэтгэж, барих, тээвэрлэх, асран хамгаалахдаа эрүүл ахуй, осол аюулгүйн шаардлагыг хангасан технологи, арга хэрэгсэл, байр сав, тохиромжтой цаг хугацаа, зориулалтын дагуу тоноглогсон тээврийн хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хүмүүсийг оролцуулах ёстой. Өөрөөр хэлбэл, амьтан барих, тээвэрлэх, асран хамгаалах үйл ажиллагаанд заавал амьтны мэргэжлийн байгууллагыг оролцуулах үүрэгтэй болно.

Амьтныг хамгаалах үйл ажиллагаа

Амьтны тухай хууль. Аймгийн байгаль орчны газар нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.3-д заасны дагуу ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ёстой. Үүнээс үзвэл, нэн ховор, ховор амьтан хамгаалах үйл ажиллагаанд хэрхэн оролцох талаар эрх зүйн тодорхой зохицуулалт байхгүй ч тухайн байгууллага нь аймаг, орон нутгийн байгаль орчныг хамгаалах мэргэжлийн байгууллага болох нь тодорхой юм.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.2-т амьтан болон агнуурын нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх талаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар заасан нь амьтан асрах, буцааж байгальд нь тавих үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн дагуу хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх эрх зүйн үндэстэй байна. Энэ бүгдээс үзвэл, аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага нь амьтныг авран хамгаалах, тээвэрлэх, асран тэтгэх ажлыг хэрэгжүүлж, мэргэжлийн арга зүйгээр хангах үндсэн байгууллага болно. Харин шаардлагатай тохиолдолд дээрх ажлыг Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу мэргэжлийн байгууллага (мэргэжлийн байгууллагын эрхтэй)-аар гүйцэтгүүлж болно.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д *“Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь улсын хэмжээнд мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэнэ”* хэмээн заажээ. Ийнхүү амьтан хамгаалах, тэдэнд шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллага, сум, дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж голлон гүйцэтгэхээр хуульчилсан байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл бүхий малын эмчтэй, стандартын шаардлага хангасан байр, тоног төхөөрөмжтэй, мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т зааснаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгж үйлчилгээний хүрээнээс хамаарч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

1. Бүх төрлийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ эрхлэх бол ерөнхий мэргэжлийн тусламж, үйлчилгээний;

2. Тодорхой төрлийн мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, халдварт өвчинтэй тэмцэх, тухайн төрлийн мал, амьтны гаралтай түүхий эдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ эрхлэх бол төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний;

3. Мал эмнэлгийн тодорхой мэргэшлээр дагнан явуулын болон суурин үйлчилгээ үзүүлэх бол тусгай мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр тус тус заасан байна.

Дээрх үйл ажиллагааг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4-д зааснаар итгэмжлэлтэй малын эмч дангаараа эсхүл итгэмжлэлтэй малын эмчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан хуулийн этгээд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж байгуулж, харьяалах аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлснээр хэрэгжүүлнэ. Энэ нэгж нь тусламж шаардлагатай байгаа амьтанд эмнэлгийн тусламжийг үзүүлэх, эмчлэх гол үүрэг бүхий субъект юм.

Амьтан эмчлэх үйл ажиллагааг төрийн байгууллагаас гадна, мэргэшсэн, итгэмжлэгдсэн хуулийн этгээд эрхлэн явуулж болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д *“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрхзүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн”*, энэ зүйлийн 3.2-т *“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх замаар зохион байгуулах”*-аар тус тус заасан байдаг.

Цагдаагийн байгууллага нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах үйл ажиллагаанд голлон оролцохоос гадна, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу хязгаарлалтын болон бэлэн байдлын дэглэмийг хэрэгжүүлэхэд нийтийн хэв журмыг хамгаалах чиглэлд оролцох юм.

Гамшгаас хамгаалах тухай хууль. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д *“гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг*, 4.1.2-д *“аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавьж, мэрэгч тархах зэргийг*, 4.1.3-д *“осол” гэж уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг* ойлгохоор тодорхойлж өгсөн бөгөөд гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед онцгой байдлын байгууллага нь асран хамгаалах, хязгаарлалтын болон бэлэн байдлын дэглэмийг сахиулах, гамшиг, осол, аюулт үзэгдэлд өртсөн амьтныг хамгаалах, холбогдох байгууллагад асруулах, эмчлүүлэхээр шилжүүлэх үйл ажиллагаанд голлон оролцогч байгууллага болно.

Санхүүжилт

Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн дагуу шаардлагатай санхүүжилт, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах зэрэг бүрэн эрхийн хүрээнд төрийн захиргааны төв байгууллага энэхүү амьтан хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэн оролцоно.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь амьтан хамгаалахад шаардлагатай төсвийг Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.2 дахь амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгахаар заасны дагуу бодлогын баримт бичиг, батлагдсан аймгийн хэмжээний нэн ховор, ховор амьтан хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд шаардлагатай төсөв, хөрөнгийг баталж санхүүжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, аврах, асран хамгаалах шаардлагатай нэн ховор, ховор, элбэг амьтанд зориулсан байр бариулах, асаргааны санхүүжилт, албан хаагчдын томилолт, тээвэрлэхэд зориулсан санхүүжилт зэргийг аймгийн төсөвт тогтмол суулган баталж байх ёстойг дээрх хууль тогтоомжуудаар баталгаажуулсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсэгт ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50-аас доошгүй хувийг амьтныг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар заажээ. Ийнхүү тус заалтын дагуу нэн ховор, ховор, элбэг амьтныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний нэг хэсэг болох амьтан хамгаалах арга хэмжээнд зарцуулах санхүүжилтийн асуудлыг зохицуулах хууль, эрх зүйн бүрэн үндэстэй.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 болон 34.3-т мал, амьтныг эрүүлжүүлэх, эмчлэхэд шаардлагатай төсвийг аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, сум, дүүргийн төсвийг сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал тус тус хэлэлцэн баталж, мал, амьтны эрүүл мэндийн хөтөлбөрт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын санхүүжилтэд зарцуулахаар зохицуулжээ. Үүнээс үзвэл, зөвхөн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсөв хөрөнгөөс гадна, амьтныг хамгаалах ажилд шаардлагатай төсвийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн дагуу мал, амьтан эмчлэх зардлаас санхүүжүүлж болохоор байна. Тухайлбал, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3.1-д дуудлагын дагуу анхны онош тогтоох үйл ажиллагааны тээвэр, шатахууны зардал, халдварт өвчин гарсан үед хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах халдваргүйтгэлийн бэлдмэлийн үнэ гэх мэтийн зардлыг сум, дүүргийн энэ төрлийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэх эрх зүйн үндсийг тогтоож өгсөн байна.

Амьтан хамгаалах үйл ажиллагааг олон улсын байгууллага, Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуй нэгж байгууллага, иргэний хандив тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлж болно. Энэ тохиолдолд аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хандив, тусламжийг олгож, баталгаажуулахаас гадна, тухайн үйл ажиллагаанд хамтран оролцох байдлаар санхүүжүүлэн ажиллаж болохоор байна.

Харин гамшиг, осол, аюулт үзэгдлийн үед амьтныг хамгаалах, гамшиг ослын хор хохирлыг арилгахад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаа, гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэх боломжтой болно. Түүнчлэн тухайн аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах, гамшгийн хор аюулыг арилгах хөрөнгөөс тодорхой хэмжээгээр амьтныг асран хамгаалах харгалзан дэмжих үйл ажиллагааг зөвхөн гамшиг ослын үед, эсхүл гамшгийн аюулыг бууруулах, хор хохирлыг арилгахад санхүүжүүлэх боломжтой юм.

Удирдлага зохион байгуулалт, хяналт

Төрийн захиргааны төв байгууллага нь Амьтны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2; 7.5 дахь заалтууд болон Ховор амьтан агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журам зэргийн хүрээнд амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааны зөвшөөрлийг олгоно. Ийнхүү энэ үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг олгож оролцохоос гадна, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1-д *“амьтан хамгаалах, нутагшуулах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага зохицуулалт, арга зүйн зөвлөгөөгөөр хангах”*, 5.3.5-д *“агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар технологи, норм, нормативыг батлах”*, 5.3.8-д *“амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийг тайлагнах”*, түүнчлэн Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн заалтын дагуу шаардлагатай санхүүжилт, нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Амьтны тухай хууль. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу *“Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”* үүргийг төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хэрэгжүүлнэ.

Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1-д *“амьтан хамгаалах, нутагшуулах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага зохицуулалт, арга зүйн зөвлөгөөгөөр хангах”*, 5.3.5-д *“агнуурын нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэх талаар технологи, норм, нормативыг батлах”* зэрэг бүрэн эрхийг төрийн захиргааны төв байгууллага буюу Байгаль орчин, аялал жуулчлалын яам хэрэгжүүлэхээр заасан байдаг. Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны төв байгууллага тусламж шаардлагатай байгаа амьтан (нэн ховор, ховор болон элбэг амьтад)-ыг барих, тээвэрлэх асран хамгаалах зөвшөөрлийг олгох чиг үүргээс гадна, голлон амьтан хамгаалах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлага, зөвлөмжөөр хангаж, норм, норматив, технологийг батлах, үйл ажиллагааг санхүүжүүлэх үндсэн чиг үүрэгтэй байна.

Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.4 дэх *“Харьяалах нутаг дэвсгэртээ нэн ховор, ховор амьтан хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг баталж, биелэлтэд нь хяналт тавих”*, 5.4.6 дахь *“Амьтны аймгийн хамгаалалт, ашиглалтын талаар Засаг даргын мэдээлэл, тайланг хэлэлцэх”*, 5.4.9 дэх *“Харьяалах нутаг дэвсгэртээ байршидаг амьтан хамгаалах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах хөтөлбөртөө тусган хэрэгжүүлэх”* зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлж, амьтныг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөр, тайланг батлан, шаардлагатай санхүүжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, батлах зэрэг үндсэн чиг үүрэгтэй болно. Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.4-д заасны дагуу нутаг дэвсгэртээ байршдаг амьтдыг хамгаалах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах хөтөлбөртөө тусган хэрэгжүүлнэ.

Аймгийн Засаг дарга нь Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх *“Амьтан хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, түүний хэрэгжилттэй холбогдуулан гаргасан Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах”*, 5.5.2 дахь *“Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8-д биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх”*, 6.1.9 дэх *“өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах”*, 6.1.11

дэх “Иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтан хамгаалах үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах” арга хэмжээг нутаг дэвсгэртээ тус тус авч хэрэгжүүлэх чиг үүрэгтэй болно.

Дээрх чиг үүргээс үзвэл, аймаг, нийслэлийн Засаг дарга нь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын боловсруулсан амьтан хамгаалах үйл ажиллагааг тусгасан амьтан хамгаалах хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, аймгийн хэмжээнд зохион байгуулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. Энэ хөтөлбөрт тусламж шаардлагатай байгаа амьтныг хамгаалах үйл ажиллагааг төлөвлөж, санхүүжилтийн хамтаар тусгасан байх ёстой болно.

Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх өвчилсөн, гамшигт, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, хамгаалах, энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2 болон бусад хууль тогтоомжийн дагуу удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжүүлэхээр заажээ. Ийнхүү тухайн аймгийн Засаг дарга бол харьяалах нутаг дэвсгэртээ амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг бусад төрийн байгууллагуудын хамтын уялдааг хангах замаар удирдан зохион байгуулах үндсэн удирдлага болохыг хуульчлан баталгаажуулсан байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т зааснаар Мэргэжлийн хяналтын байгууллага нь мэргэжлийн хяналтын төв байгууллага, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, хилийн мэргэжлийн хяналтын алба, сумын мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас бүрдэнэ. Мэргэжлийн хяналтын байгууллагын байгаль орчны чиглэлийн хяналт нь "Байгаль орчныг хамгаалах хууль", "Амьтны тухай хууль" болон бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, зөрчилд хариуцлага оногдуулах, биелэлтийг хангуулах эрх, үүрэгтэй байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын Зооноз халдварт өвчин судлалын төв нь Зоонозын болон гоц аюулт халдварт өвчний байгалийн голомтын тандалтыг зохион байгуулж, хөдлөл зүйг тогтоох, эрсдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх, халдвар тархахаас сэргийлэх, халдварын голомтыг цомхотгон дарах, зэрлэг амьтан, мал, тэжээвэр амьтдаас хүнд халдварлах Зоонозын болон гоц аюулт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, мал, амьтны гоц халдварт өвчний үед голлон ажиллах үүрэг, оролцоотой байгууллага юм.

Сүүлийн жилүүдэд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь дээр дурдсанчлан амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, холбогдох талуудын эрх, үүргийг тодорхойлж, тэдгээрийн оролцоог хангах зохион байгуулалтын загвар, хувилбарыг бий болгох талаар нэлээд чармайн ажилласны үр дүнд баруун бүсийн Ховд, Баян-Өлгий, Увс аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газрын Зооноз халдварт өвчин судлалын төв, тусгай хамгаалалттай газар нутгуудын Хамгаалалтын захиргаад, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар болон тэдгээрийн сум, орон нутгийн салбар нэгжүүдээс санал авч, Хууль зүй, дотоод хэргийн яамны санал зөвлөмжийн дагуу тухайн аймгуудын Засаг даргын захирамжаар дээр нэр дурьдсан байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, түүнчлэн энэ ажлын хэсгийн ажиллах нийтлэг журмыг боловсруулж, тэдгээр аймгуудад загвар байдлаар хэрэгжүүлж байна.

Энэхүү аймгийн Засаг даргын захирамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, түүний ажиллах нийтлэг журмын загварыг энэ гарын авлагат хавсралтаар оруулж өгсөн бөгөөд нэгэнт амьтан судлах, хамгаалах төв юм уу мэргэжлийн нэгж байхгүй өнөөгийн нөхцөлд энэ зохион байгуулалтын хэлбэрээр ажиллах нь холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, талуудын хамтын ажиллагааг уялдуулах, сайжруулах, нөгөө талаас тус үйл ажиллагаанд оролцогч талуудын албан хаагчид болон хуулийн этгээдийг хууль бусаар амьтан барьж, зөөж тээвэрлэсэн, гаршуулан тэжээсэн гэх гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зэрэг олон талын ач холбогдолтой тул бусад аймгууд ч гэсэн иймэрхүү бүрэлдэхүүн, зохион байгуулалтаар ажиллаж болох юм.

Монгол улсын үндэсний стандарт

Говийн бүсийн нэн ховор, ховор амьтныг судлах, хамгаалах төвийг байгуулах урьдчилсан Техник эдийн засгийн үндэслэлийг хэрэгжүүлэх явцад баримталж ажиллах байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар болон байгалийн гамшиг, эрсдэл осол гарах үед хүн ам, байгаль орчныг хамгаалах чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагын хүлээх үүргийг тодорхойлсон одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа стандартыг мөрдөж ажиллана.

Төслийг хэрэгжүүлэхэд Байгаль орчин, Хөдөлмөр хамгаалал, Эрүүл мэндийн талаар Монгол улсын үндэсний стандартууд даган мөрдөх үүрэгтэй.

Хүснэгт 1.1. Байгаль орчин, Хөдөлмөр хамгаалал, Эрүүл мэндийн талаар Монгол улсын үндэсний стандартууд

Стандартын дугаар	Стандартын нэр
MNS 12.0.002:1987	Хөдөлмөр хамгааллын стандартын систем нэр томьёо, тодорхойлолт
MNS 12.0.005:1988	Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Хөдөлмөрийн нөхцөл, түүний хүчин зүйлийн ангилал.
MNS 12.0.003:81	Хөдөлмөр хамгаалал. Үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлүүд. Ангилал.
MNS 12.1.009:85	Хөдөлмөр хамгаалал. Шуугиан Орон сууц, иргэний барилгын шуугианы байж болох түвшин.
MNS 12.1.016 - 88	Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Хэт өндөр дуу. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
MNS 12.1.017:88	Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Хэт өндөр дуу Ажлын байранд дууны даралтыг хэмжих арга
MNS 12.3.004:83	Хөдөлмөр хамгаалал. Автомашины техникийн үйлчилгээ, засвар. Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
MNS 12.3.006 : 84	Хөдөлмөр хамгаалал. Будгийн ажил, Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
MNS 12.4.005:85	Хөдөлмөр хамгаалал. Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд. Ангилал
MNS 12.4.015:88	Хөдөлмөр хамгааллын тандартын систем. Цахилгаан хүчдэлийн тэмдэг. Хэлбэр хэмжээ. Техникийн шаардлага
MNS 12.099 - 91	Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийг ажиллуулахыг хориглох ажлын байрны нөхцөл.
MNS 12.104-94	Хөдөлмөр хамгааллын стандартын систем
MNS 17.1.1.10 - 79	Байгаль орчны хамгаалал, Ус. Ус ашиглалт , хамгаалалт . Нэр томьёо, тодорхойлолт
MNS 17.2.0.07 - 79	Байгаль орчныг хамгаалах. Агаарыг бохирдуулах хаягдал. Ангилал
MNS 17.2.1.01 - 78	Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах агаар мандлыг бохирдуулах хорт бодис. Нэр томьёо, тодорхойлолт
MNS 359 - 89	Усны аж ахуй, гидротехник, урсгал усны нэр томьёо, тодорхойлолт
MNS 0899:92	Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба

	эрүүл ахуйн шаардлага
MNS-0900-2005	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдал. Ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
MNS 3297:91	Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ.
MNS 3342:1982	Байгаль орчны хамгаалал, усан мандал, Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага
MNS 3382:82	Гидрогеологийн нэр томъёо. Тодорхойлолт
MNS 3597 - 83	Байгаль орчны хамгаалал. Усан мандал. Гадаргуугийн ба газрын доорхи усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
MNS 3870:1986	Эх газрын ус судлал. Нэр томъёо, тодорхойлолт
MNS 3985 - 87	Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтүүдийн нэр төрөл
MNS 4047-88	Байгаль орчныг хамгаалах, Усан мандал Гадаргын усны чанарыг хянах журам
MNS 4078 - 88	Усны аж ахуй. Усны мелиораци нэр томъёо, тодорхойлолт
MNS 4079 - 88	Усны аж ахуй. Усны чанар нэр томъёо, тодорхойлолт
MNS 4191-93	Байгаль орчныг хамгаалах стандартын систем. Монгол орны уур амьсгал үндсэн үзүүлэлт
MNS 4219-94	Байгаль орчны хамгаалал Аж ахуй нэгжийн экологийн паспорт. Үндсэн дүрэм
MNS 4244:1994	Хөдөлмөр хамгаалалын систем, Галын аюулгүй байдал
MNS 4288:95	Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага
MNS 4585 :2007	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
MNS 4586 : 1998	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
MNS 4660-98	Цахилгаан тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн хамгаалалтын багаж, хэрэгсэл ажлын хувцас
MNS 4943 : 2011	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
MNS 4967:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Нэр томъёо, тодорхойлолт
MNS 4968:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага.
MNS 4969 : 2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм
MNS 4990 : 2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.
MNS 4992 : 2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
MNS 4994 : 2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Доргионы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
MNS 4995 : 2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
MNS-5002:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
MNS-5003:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
MNS 5010 : 2001	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага
MNS 5029 : 2011	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг
MNS 5078 : 2001	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага
MNS 5079 : 2001	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрийн эрүүл ахуй. Ачих, буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
MNS 5080 : 2001	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ

MNS 5105: 2001	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага
MNS 5106 : 2001	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн физиологи. Мэдрэл сэтгэхүйн ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм, тодорхойлох арга
MNS 5151:2002	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Нэр томьёо, тодорхойлолт
MNS 5247:2003	Барилга байгууламжийн гал унтраах ус түгээгүүрийн цогцолбор. Техникийн шаардлага
MNS 5282:2003	Газрын тосны бүтээгдэхүүний галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
MNS 5390 : 2004	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.
MNS-5566-2005	Гал түймрээс хамгаалах. Аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжинд гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага норм
MNS 5850 : 2008	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
MNS 5885 : 2008	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
MNS 5914 : 2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
MNS 5916 : 2008	Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт
MNS 5918 : 2008	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
MNS 6010: 2009	Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги
MNS-ISO 14001:2005	Байгаль орчны удирдлагын тогтолцоо-Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар
MNS ISO 4225 : 2001	Байгаль орчин. Агаарын чанар. Нийтлэг үндэслэл. Тайлбар толь
MNS ISO 4226:2000	Агаарын чанар. Ерөнхий ухагдахуун. Хэмжих нэгж
MNS ISO 5667-5: 2001	Байгаль орчин. Усны чанар.
MNS ISO 5667-6: 2001	Байгаль орчин. Усны чанар. Дээжлэлт. 6-р хэсэг: Гол, горхины уснаас дээж авах заавар
MNS ISO 5667-8 :2000	Усны чанар - Дээж авах, 8-р бүлэг : нойтон хур тунадасны дээж авах заавар
MNS ISO 5667-10:2001	Байгаль орчин. Усны чанар. Дээжлэлт. 10-р хэсэг: Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж
MNS ISO 5667-11:2000	Усны чанар-Дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж
MNS ISO 5667-13 :2000	Усны чанар - Дээж авах: 13-р бүлэг. Бохир ус болон цэвэрлэх байгууламжийн лагаас дээж авах заавар
MNS ISO 5667-14:2000	Усны чанар-Дээж авах: 14-р бүлэг. Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж
MNS ISO 6107-1:2002	Усны чанар. Тайлбар толь
MNS ISO 6107-2:2000	Усны чанар. Үгсийн сан. 2-р хэсэг
MNS ISO 6107-3:2000	Усны чанар. Тайлбар толь. 3-р хэсэг
MNS ISO 6107-4:2000	Усны чанар. Тайлбар толь. 4-р хэсэг
MNS ISO 6107-5:2000	Усны чанар. Тайлбар толь. 5-р хэсэг
MNS ISO 6107-7:2002	Усны чанар. Тайлбар толь
MNS ISO 6107-8:2000	Усны чанар. Тайлбар толь. 8-р хэсэг
MNS-ISO-8421-3:2000	Галын аюулаас хамгаалах-Тайлбар толь 3-р хэсэг: Галыг илрүүлэх ба дохиолох
MNS-ISO-8421-5:2000	Галын аюулаас хамгаалах-Тайлбар толь. 5-р хэсэг Утааны хяналт
MNS ISO 11074-1 : 2001	Байгаль орчин. Хөрсний чанар. Тайлбар толь. 1-р хэсэг: Хөрс хамгаалах бохирдлоос сэргийлэхтэй холбогдох нэр томьёо тодорхойлолт
MNS ISO 11074-2 : 2001	Байгаль орчин. Хөрсний чанар. Тайлбар толь. 2-р хэсэг: Дээж авахтай холбогдох нэр томьёо ба тодорхойлолт
MNS-ISO-11091:2007	Барилгын зураг-Ландшафтын зураг боловсруулах
MNS-ISO-14004:2005	Байгаль орчны удирдлагын тогтолцоо. Зарчим, тогтолцоо, дэмжих аргачлалын заавар
MNS ISO 14015 : 2002	Байгаль орчны удирдлага (менежмент)–Байрласан газар ба байгууллагын талаархи

	байгаль орчны үнэлгээ (БББОУ)
MNS-ISO-14020:2004	Эко тэмдэг ба мэдэгдэл –Ерөнхий зарчим
MNS-ISO-14021:2001	Байгаль орчны эко тэмдэг ба мэдэгдэл. Өөрийн зарласан мэдүүлэг (Байгаль орчны эко тэмдэг хэрэглэх II дахь загвар)
MNS ISO 14031: 2001	Байгаль орчны удирдлага - Байгаль орчинд нөлөөлөх байдлын гүйцэтгэлийн үнэлгээ – Арга зүйн заавар
MNS ISO 14040 : 2001	Байгаль орчны удирдлага(менежмент). “Амьдрал”–ын мөчлөгийн үнэлгээ. Зарчим ба бүтэц.
MNS ISO 14050:2003	Байгаль орчны менежмент (удирдлага)- Тайлбар толь
MNS-ISO-14064-1:2011	Хүлэмжийн хий Хэсэг 1: Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгаралт ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж
MNS-ISO-14064-2:2011	Хүлэмжийн хий Хэсэг 2: Төслийн түвшинд хүлэмжийн хийн ялгаралтын бууралт ба шингээлтийн өсөлтийг тооцоолох
MNS-ISO-GUIDE 64:2011	Мониторинг хийх, тайлагнах тухайн зааварчилсан удирдамж
MNS ISO/TR 14025:2001	Байгаль орчны эко-тэмдэг ба мэдэгдэл- Байгаль орчны мэдэгдэл - III загвар. Техникийн Тайлан
MNS ISO/TS 14048:2004	Байгаль орчны удирдлага - Амьдралын мөчлөгийн үнэлгээ - Өгөгдлийн баримт бичгийн хэлбэр
MNS 5546 : 2005	Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага
MNS 5851 : 2008	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг, тэмдэглэгээ, дүрэмт хувцас. Ерөнхий шаардлага
MNS ISO 4227:2002	Хүрээлэн буй орчны агаарын чанар хяналтын төлөвлөгөө
MNS ISO 5667-1:2002	Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар
MNS ISO 5667-7:2002	Усны чанар. Дээж авах. 7 дугаар хэсэг: Уурын зуухны ус болон уураас дээж авах заавар

Олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдсэн байдал.

Монгол Улсын Засгийн газар дараах олон улсын Конвенцуудад нэгдсэн байна.

Үүнд:

- Дэлхийн хөдөө аж ахуйн болон байгалийн өв хамгаалах тухай Конвенц (1990 он)
- Уур амьсгалын өөрчлөлтийн нэгдсэн үндэсний тогтолцооны Конвенц (1992 онд гэрээнд гарын үсэг зурж, 1993 онд хүлээн зөвшөөрч, 1994 онд нэгдсэн)
- Биологийн төрөл зүйлийн Конвенц (1992 онд гэрээнд гарын үсэг зурж, 1993 онд хүлээн зөвшөөрч, нэгдсэн)
- Озоны давхаргын цоорхой үүсгэгч бодисын талаарх Монреалын протокол, 1996 он
- Озоны давхаргыг хамгаалах Венийн Конвенц, 1996 он
- Биологийн ховордсон төрөл зүйлийг худалдаалах олон улсын Конвенц, 1996 он
- Цөлжилттэй тэмцэх олон улсын Конвенц, 1994 он
- Аюултай хог хаягдлыг хил дамжуулах тээвэрлэхэд хяналт тавих тухай Базелийн Конвенц, 1997 онд нэгдсэн
- Олон улсын ач холбогдол бүхий гол нуурууд ялангуяа усны шувууд, усны амьтдыг хамгаалах Рамсарын Конвенц, 1998 он
- Нүүдэллэдэг зэрлэг ан амьтдыг хамгаалах Боннийн Конвенц, 1999 он
- Байгаль орчны хүчин зүйлүүдийг тогтоох, энергийн үр ашгийн Энергийн тунхаг бичгийн протокол (1999 онд хүлээн зөвшөөрч, 2000 онд нэгдэн орсон)
- Энергийн тунхаг бичгийн олон улсын гэрээ хэлэлцээр

- Озоны давхаргын цоорхой үүсгэгч бодисын талаархи Монреалийн протокол \засварласан\, 2002 он
- Биологийн төрөл зүйлийн Конвенцоор биологийн аюулгүй байдлын Картагенийн протокол, 2003 он
- Олон улсын химийн хорт бодисын худалдаанд хяналт тавих тухай Роттердамын Конвенци (1998 онд гарын үсэг зурж, 2001 онд хүлээн зөвшөөрч, 2004 онд нэгдэн орсон)
- Органик бохирдуулагч бодисуудын тухай Стокгольмийн Конвенци, (1999 онд зөвшөөрч, 2005 нэгдэн орсон)
- Уур амьсгалын өөрчлөлтийн нэгдсэн үндэсний тогтолцооны Киотогийн протокол (1999 онд зөвшөөрч, 2005 онд нэгдэн орсон)

1.5. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Төслийн зорилтот нутаг болох Зармангийн говь болон Улаан шалын хоолойд “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах ажлыг багцалж үзэж дунд хугацааны буюу 3 жилийн ажлын төлөвлөгөөг гаргаж төсөл хэрэгжүүлэх хугацааг онуудаар тооцож үзүүлээ.

1.6. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1.2. Хийх ажлын ерөнхий төлөвлөгөө


№	Хийгдэх ажил	Өмнөх жил	Эхний жил				Хоёрдугаар жил				Гуравдугаар жил			
		IV улирал	I улирал	II улирал	III улирал	IV улирал	I улирал	II улирал	III улирал	IV улирал	I улирал	II улирал	III улирал	IV улирал
1	“Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах газар ашиглах хүсэлт гаргах													
2	“Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулахтай холбоотой тендерүүдийг зарлах													
3	“Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” -ийн газрыг хүлээн авч хатуу цэгийг тогтоох													
4	Хүн, амьтны ундны усаар хангах гүний худаг гаргах													
5	Хязгаарлалтын хашааг барих, хүлээлгэн өгөх													
6	Хамгаалах төвийн хашааг барих, хүлээлгэн өгөх													
7	Амьтдыг байршуулах байрыг барьж ашиглалтанд оруулах													
8	“Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн байрыг барьж хүлээлгэн өгөх													
9	Хар сүүлт зээр барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх													
10	Хавтгай тэмээ барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх													
11	Монгол бөхөн барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх													
12	Янгир барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх													
13	Аргаль барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх													
14	Хулан адуу барьж, амьтан судлах													

	хамгаалах төвд хүлээлгэн өгөх												
15	Тахь адуу барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх												
16	Халиун буга барьж, амьтан судлах хамгаалах төвд хүлээлгэн өгөх												
17	Амьтны эм, эмнэлгийн багаж хэрэгслээр хангах												
18	Мал эмнэлэг, ариун цэврийн үйлчилгээг аргачлалын дагуу хийх												
19	Амьтны идэш тэжээл бэлтгэх												
20	Ажилчдын байр амьдрах орчны нөхцөлөөр хангах тохижилт хийх												
21	Оффисийн байрыг тохижуулах, техник хэрэгсэлээр хангах												
22	Амьтны маллагаа, арчилгааг тогтворжуулах												
23	Бие дааж амьдрах чадвартай болсон бодгалиудыг байгаль суллан тавих менежмент боловсруулах												
24	Жилийн ажлын тайлан гаргах												
25	Жилийн ажлын төлөвлөгөөг гаргах												

БҮЛЭГ ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. ГАЗАР ЗҮЙН БАЙРЛАЛ, ГАЗРЫН ТОГТООЦ

Төсөл хэрэгжих нутаг нь Алтайн өвөр говийн биеэ даасан мужийг төлөөлөх жинхэнэ цөлийн бүсэд орших нутаг юм. Физик газар зүйн мужлалаар Алтайн өвөр говийн муж, Алтайн өвөр говийн тойрогт хамаарна.



Зураг 2.1. Монгол орны физик газар зүйн мужлал

Говийн их дархан цаазат газар болон Ээж хайрханы дурсгалт газрын хооронд байрлана.

Цөлийн бүсийн байгалийн хам бүрдлүүд, цөлийн экосистемийн зооценозын оргил болсон туурайтан амьтдыг хамгаалах эталон нутаг бөгөөд хэт гандуу жинхэнэ цөлийн өргөрөгийн бүсийн 2 судал, өмнө зүгт Говь-Тянь-Шань, хойт хэсэгт Говийн Алтайн нурууны хүрээнд хуурай хээр, цөлийн өндрийн бүслүүрийг төлөөлсөн, экологийн хувьд ижил нөхцөлтэй 11 байгалийн районд хуваагддаг. Үүнд: Шивээт-Уул (142.9 мян.га), Отгон-Ус (204.6 мян.га), Эдрэнгийн нуруу (115.6 мян.га), Буурын хяр (973.0 мян.га), Номингийн говь-Цэнхэрийн хоолой (726.3 мян.га), Шаргын говь (331.5 мян.га), Атас-Чингис (139.3 мян.га), Төв Говь-Тянь-Шань (780.8 мян.га), Цагаан Богд (191.5 мян.га), Эхийн гол (489.9 мян.га), Бейшаны өмнөд хэсэг (323.6 мян.га).

Тус бүс нутгийн газрын гадарга нь Төв Азийн бусад нутаг дэвсгэрийн нэгэн адил Мезозойн эриний эхэн үеэс одоо хүртэл үргэлжилж байгаа эх газрын геологийн хөгжлийн

урт удаан хугацааны хөгжлийн явцад үүссэн нам уулс, цав толгод, өндөрлөг тал хосолсон нилээд нарийн төвөгтэй, өвөрмөц тогтоцтой.



Зураг 2.2. Төсөл хэрэгжих нутгийн харагдах байдал

Кембрээс өмнөх үед баруун-өмнөд Монголын нийт дэвсгэр тектоник идэвх харьцангуй багатай, тогтвортой эх газрын нөхцлөөр хөгжиж байсан байна. Палеозойн эхэн үед дархан газрын нутаг дэвсгэр нь доош сууж далай болсон бөгөөд Девоны сүүл үед аажмаар өргөгдөж, палеозойн төгсгөл үед Алтайн өвөр говийн ихэнх нутаг дэвсгэрт далайн тэнгис ширгэж том жижиг нуур зонхилох болсон байна. Палеозойн хурдас чулуулаг нь ихэвчлэн 5-6 мянган метр хүртэл зузаан далай тэнгисийн гаралтай байдаг.

Мезозойн эринээс эхэлж эх газрын байдлаар хөгжиж эхэлсэн бөгөөд одоогийн газрын гадаргын хэлбэр дүрс энэ үеэс эхэлсэн гэж үздэг. Юрийн галавын үед уул ихсэх хөдөлгөөн эрчимжсэн бөгөөд Цэрдийн үед томоохон нуурууд үүссэн байна. Дээд Юр, доод Цэрдийн хурдас нь ихэвчлэн нуур, аллювийн гаралтай байдаг. Кайнозойн эхэн үед уур амьсгал огцом өөрчлөгдөж хуурайшилт эрчимжиж, цөлжих үйл явц эхэлсэн гэж үздэг. Газрын гадаргын ерөнхий өргөгдөл нь хуурайшилт цөлжилтийн үйл явцыг улам түргэсгэсэн байна. Альпийн уул үүсэх хөдөлгөөний үед Алтай, Тянь-Шанийн уул нурууд үүссэн бөгөөд түүний дараагийн денудацийн үйл явцаар элэгдэл эвдрэлд орж одоогийн газрын гадаргын дүр төрх бий болжээ. Шарга, Номингийн говийн урд хэсэг, Атаc богд, Чингэс уулсын хойд хэсгээр тектоникийн хагаралтай. Газар хөдлөлийн мужлалтаар 7-9 балл (Рихтерийн шаталбараар) буюу сейсмотектоникийн идэвхтэй бүсэд хамаарагдана. Ялангуяа Атаc, Чингэс, Цагаан богд уул орчмын нутаг нь 9 балл хүртэл газар хөдлөлтийн хүчтэй бүсэд орно.

Геологийн нарийвчилсан хайгуул шинжилгээний ажил хийгдээгүй, одоогоор үйлдвэрлэлийн түвшинд ашиглах боломжтой томоохон ашигт малтмалын орд газар байхгүй гэж хэлж болно.

Дээр үед Хятадууд болон орон нутгийнхан малтан ашиглаж байсан алтны ордны олон ухам нүх Эдрэнгийн нурууны Хярын гүний худаг, Хадат гүн худаг, Онгон улаан, Талын мэлтэс, Хатан суудал, Хар хайрхан зэрэг газруудад байдаг юм. Сүүлийн жилүүдэд хууль бусаар алт олборлогчдын нөлөөгөөр Нарийн хөх, Хүрэн аараг, Буурын хяр, Мянган тоорой зэрэг газруудад шинээр нүх бий болгосон. Мөн цахиур, мана, гартаам, хаш, чүнчигноров гэх мэт гоёл чимэглэлийн чулуутай газар цөөнгүй. Үхэр улааны зүүн суга Шал тойромд гөлтгөнө ихтэй. Ер нь дархан газарт гөлтгөнө их байдаг бөгөөд борзон, шүү гэх мэт идээлэх, шүүдэх хужир хийгээд давс, буулттай газар цөөнгүй бий. Онгон улаан, Ногоон цав, Шар хулсны нуруу, Зам билгэх, Чулуут билгэхийн нуруу, Зараа хайрхан зэрэг боржин, асмалжин, толболжин, харлагжин (габбро) гэх мэт гүний чулуулгаас цогцлон тогтсон хадат уулсын өвөр хуурмагт, толь горт, могой эрдэст чулуулгийн судалд болор, мана, гартаам зэрэг хагас эрдэнийн чулуу байх магдалалтай. Хөх өндөрт сайн чанартай нарийн билүү, гуранз тохиолддог. Тус дархан газартай хил залгаа Хятадын Шинжаан Уйгурын нутагт ихээхэн хэмжээний нефтийн ордууд байдаг бөгөөд геологийн тогтоцын хувьд төстэй Номингийн говь, Шаргын говь зэрэг хотос хотгор газруудаар газрын тос, шатдаг хийн (нефтийн) ордууд байх боломжтой.

Эрт галавын амьтан, ургамлын чулуужсан үлдэц багагүй тохиолдоно. Сэгс цагаан богдын баруун суга, Эдрэнгийн явар цонжоор гуравдагч галавын үеийн зүйл бүрийн амьтан, ургамлын чулуужсан үлдэц ястай. Ногоон цав ба Атас богдын баруун ба баруун хойд цөл говийн Сүм толгой, Шар тээг зэрэг газраар Цэрдийн болон гуравдагч галавын амьтны чулуужсан яс бий. Түүх дурсгалын үлдэгдэл багагүй байдаг бөгөөд эртний баян бүрд, элс манхан, шал тойром, булаг ус зэрэг газруудаар хуучин чулуун зэвсгийн үеийн болон шинэ чулуун зэвсгийн үеийн чулуун зэвсэг олддог. Энэ газар нь алслагдмал нутаг учраас археологи, палеонтологийн чиглэлийн судалгаа бараг хийгдээгүй гэж хэлж болно.

2.2. УУР АМЬСГАЛ

Монгол орон дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын сэрүүн бүсэд гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан Евразийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалын хэмжигдэхүүний хуваарилагдалд өргөрөгийн болон өндрийн бүслүүр тодорхой илэрдэг явдал юм.

Цагаан бургас орчим нь Монгол орны хамгийн халуун хуурай хур тунадас багатай нутгийн нэгэнд зүй ёсоор тооцогдоно. Ази тивийн төв хэсэгт орших бөгөөд далай тэнгисээс хэт алслагдсан, томоохон уул нуруудаар тусгаарлагдсан, харыдангуй өндөр, хотгор гүдгэр нь ихээхэн хэрчигдсэн зэрэг газарзүйн онцлог нь уур амьсгалд тусгалаа олсон байна. Алтайн өвөр говийн уур амьсгалын онцлог шинжүүдийг эрс тэс хуурай, зөвхөн зуны улиралд хур тундастай, хавар салхи шуургатай, өвөл дулаан, зунд халуун зэргээр тодорхойлж болно.

Нарны цацраг

Төсөл хэрэгжих бүс нутаг далайн мандлаас их өргөгдсөний дээр үүлшил болон агаарын булингаршил багатай учраас нарны туяат эрчим хүчээр туйлын баялаг юм. Энэ чанараараа байгалийн гэрэлтүүлэг болон ургамал ургахад шаардагдах гэрэл, дулааны

хангамж дутагдах нь тун ховор юм. Үүнтэй холбогдуулан Б.Жамбаажамц (1989) нарын судалгаагаар 45 дугаар өргөрөгт нийлмэл цацрагийн хэмжээ 125 ккал/см^2 буюу 5238 мЖ/м^2 хүрдэг нь ургамлын өсөлт ба хөгжилтийн аль алинд нь чухал хэрэгцээ бүхий гэрлийн хүч хангалттай гэсэн байна.

Шууд цацраг. Нарны шууд цацрагийг түүний туяанд эгц \перпендикуляр\ гадаргад тусаж байгаагаар нь хэмжиж, газрын гадарга \хэвтээ\ дээр тусаж байгааг нь тооцоолж гаргадаг. Газрын хэвтээ гадарга дээр тусаж байгаа нарны шууд цацрагийг жилийн нийлбэрээр авч үзвэл тухайн нутгийн өмнөд хэсгээр (хойд өргөрөгийн 45° -аас урагш) $85-90 \text{ ккал/см}^2$ ($3560-3800 \text{ мЖ/м}^2$) хэмжээтэй байна. Өвөл Азийн эсрэг циклоны нөлөөгөөр ихэвчлэн цэлмэг, салхи болон шороон шуурга ховор, агаар тунгалаг байдаг. Нарны өндөр нэмэгдэх тутам хэвтээ гадаргад тусах шууд цацраг аажим нэмэгдэн 6 дугаар сард хамгийн их хэмжээндээ хүрч, өвлийнхөөсөө 3-7 дахин өснө. Баянтоорой орчимд хэвтээ гадаргад ирэх шууд цацрагийн жилийн агууриг (6 ба 12 дугаар сарын цацрагийн харьцаа) бага байна. Зуны улиралд хэвтээ гадаргад ирэх шууд цацрагийн хэмжээ үүлшлийн хэмжээнээс ихээхэн хамаардаг ба 6 дугаар сард 10 ккал/см^2 (419 мЖ/м^2)-аас их байна.

Сарнимал цацраг. Энэхүү цацраг нь нийлмэл цацрагийн дотор 30-40 орчим хувийг эзлэх ба жилийн нийлбэрээр тус оронд $40-50 \text{ ккал/см}^2$ ($1875-2090 \text{ мЖ/м}^2$) хэмжээнд хүрнэ. Сарнимал цацраг өвлийн улиралд бага 1-3 ккал/см^2 ($41.9-125.5 \text{ мЖ/м}^2$), зун нь 4-9 ккал/см^2 ($187-376 \text{ мЖ/м}^2$) болно. Иймээс сарнимал цацраг газрын гадарга болон түүний орчны агаарын дулааны горимд багагүй үүрэг гүйцэтгэнэ. Нийлбэр цацрагийн дотор сарнимал цацрагийн эзлэх хувийг тооцоолж говь нутгаар өвөл нь 30-35%, зун нь 35-38% байна. Энэхүү зүй тогтол нь сарнимал цацрагийн хэмжээг нийлбэр цацрагт харьцуулан хоног, сар, жилийн хуваарилалтын байдлаас тодорхой харагддаг. Тухайлбал, 4 дүгээр сарын дунд үеэс 9 дүгээр сар хүртэлх хугацаанд өглөөний 8 цагаас 16 цаг хүртэлх хугацаанд сарнимал цацраг нийлбэр цацрагийн 40%-ийг эзэлж байдаг буюу шулуун цацраг давамгайлдаг байна. Хоногийн бусад хугацаанд ялангуяа оройн 16 цагаас хойш өглөөний 4 цаг хүртэлх хугацаанд бараг жилийн турш сарнимал цацраг давамгайлах болдог байна.

Нийлбэр цацраг. Энэхүү цацрагийг нарны цацраг судлалын салбаруудад шууд хэмждэг бөгөөд гол төлөв онол практикийн шаардлагаар хэрэглэдэг. Нийлбэр цацрагийг шууд болон сарнимал цацрагийг хэмжээд, тэдгээрийн нийлбэрээр тодорхойлж ч болно. Нийлбэр цацраг 12 дугаар сард хамгийн бага буюу 4.5 ккал/см^2 (188 мЖ/м^2) -аас их, хамгийн их нь 6 дугаар сард байх бөгөөд $16.0-16.9 \text{ ккал/см}^2$ ($669-710.0 \text{ мЖ/м}^2$) хүрнэ.

Ойсон цацраг. Газрын гадаргад тусаж байгаа нарны нийлбэр цацрагийн зарим хэсэг түүнд шингэж дулааны эрчим хүчинд шилжилгүй буцан ойж байдаг. Үүнийг ойсон цацраг гэх бөгөөд газрын гадаргын ойц буюу цацрагийг ойлгох чадвараас хамаарна. Үүнийг альбедо гэж нэрлэдэг. Ойсон цацрагийн жилийн нийлбэр тус нутагт $30-35 \text{ ккал/см}^2$ байна. Ойсон цацраг хөрсний гадаргын альбедо, өөрөөр хэлбэл, газрын өнгө, чийгшил, ургамалшил, түүний өнгө, цасан бүрхүүлийн байдал зэргээс шалгаална. Цасан бүрхүүлийн альбедо 40-60% байна. Харин өвс ургамал ногоон өнгөтэй байх үедээ 17-22% ойцтой байдаг.

Газрын гадаргын цацрагийн тэнцэл. Газрын гадаргад тусаж байгаа сарын дундаж богино долгионы нийлбэр цацраг мөн гадаргаас алдагдаж байгаа урт долгионы цацрагийн туяарал хоёрын ялгаврыг цацрагийн тэнцэл гэнэ. Цацрагийн тэнцлийг нарны цацраг судлалын салбаруудад балансомерээр хэмжиж гаргадаг. Цацрагийн туяарал нь газрын гадаргын алдаж буй ба агаар мандлын эсрэг туяаруулал хоёрын ялгавар бөгөөд жилийн туршид хэмжээний хувьд төдий л их өөрчлөгддөггүй, үндсэндээ $2.2-4.3 \text{ ккал/см}^2$ -ын

хооронд байна. Цацрагийн тэнцэл нарны өндөр, үүлшил, агаарын тунгалагшил, газрын гадаргын шинж байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаарах боловч түүний орон зай, цаг хугацааны хуваарилалт ихээхэн нарийн төвөгтэй байдаг. Цацрагийн тэнцэл өргөрөг багасах тутам ихсэх ерөнхий зүй тогтолтой боловч манай орны хувьд орон зайн тархацын хувьд төдий л тод ялгаа илрэхгүй байна. Цацрагийн тэнцэл жилдээ 45 орчим ккал/см² (1885 мЖ/м²) байна. Цацрагийн тэнцэл 11 дүгээр сараас 4 дүгээр сард сөрөг тэмдэгтэй, 12 ба 1 дүгээр сард хамгийн бага 0.2-1.4 ккал/см² байх ажээ.

Газрын гадаргын дулааны тэнцэл. Монгол орны газрын гадаргын дулааны тэнцэл, түүнийг бүрдүүлэгч хүчин зүйлсийн зарим үзүүлэлтийг Л.Бадарч (1973) анх түрүүн тооцоолж гаргасан юм. Үүний тулд газрын гадаргын цацрагийн тэнцэл, ууршил, ууршиц, газрын гадарга орчмын дулааны солилцоо зэрэг голлох үзүүлэлтүүдийг тодорхойлж, цацрагийн тэнцэл болон ууршихад зарцуулагдах дулаан хоёрын ялгавраар дулааны тэнцлийг тооцоолжээ. Уг судалгаанаас үзвэл газрын гадаргын дулааны тэнцэл жилийн хуваарилалтын хувьд 12 дугаар сард хамгийн бага (-0.6-1.6 ккал/см²), 6 дугаар сард хамгийн их (3.4-5.7 ккал/см²) байна. Дулааны тэнцэл жилийн нийлбэрээрээ говийн нутгаар 30.1-32.6 ккал/см² хүрэх бөгөөд энэ нь тэнд бараг жилийн туршид үүл бага байдагтай холбоотой.

Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа. Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа тухайн орон нутгийн өргөрөг, тэнгэрийн хаяаны хаагдал, үүлшил зэргээс ихээхэн шалтгаална.

Манай оронд жилийн 230-260 хоног нь цэлмэг байдгаас нарны гийгүүллийн үргэлжлэх хугацаа урт байх бөгөөд жилд 2600-3300 цаг гийгүүлнэ. Энэ нь манай нутагт нар гийгүүлэх боломжит хугацааны бараг 75%-д хүрч байгаа юм. Нарны гийгүүллийн үргэлжлэх хугацааны орон зайн хуваарилалт үүлшлээс ихээхэн шалтгаалж өргөрөгийн дагуу биш, уулзүйн байрлалтай аль нэг хэмжээний уялдаатай гардаг байна.

Өвлийн улиралд нарны өндөр бага байхаас шалтгаалж гийгүүллийн үргэлжлэх хугацаа богино байна. Нарны гийгүүллийн үргэлжлэлийн хамгийн бага нь 12 дугаар сард тохиолдох бөгөөд 130-200 цаг гийгүүлнэ.

Агаар мандлын орчил урсгал

Орчил урсгалын явц, нарны цацрагийн ба газрын гадаргын онцлог зүй тогтолтой уялдан Төв Азид өвөрмөц чанарын агаарын цул бүрэлдэн тогтоно. Өвөл манай оронд дундад өргөрөгийн эх газрын агаарын цул ноёлно. Эсрэг циклоны нөлөөгөөр агаар тухайн газраа удаан хугацаагаар байршин цацрагийн туяарлын замаар улам их хөрч газрын гадарга орчинд температурын тонгоруу үе давхарга буй болох нөхцөл бүрдүүлнэ. Мөн өвөл орчил урсгалын уртраглаг явцын улмаас туйлын хүйтэн агаарын цөмрөлт болж их хүйтрэх нь цөөнгүй.

4 дүгээр сарын дундаас эхлэн цөлийн нутагт эрчимтэй дулаарснаас шалтгаалан эндэхийн агаар бараг эх газрын дулаан бүсийн агаарын цулын шинжтэй болсон байх нь элбэг.

Дэвсгэр гадаргын хүчин зүйлийн нөлөө. Тухайн газар орны уур амьсгалын онцлог өвөрмөц шинжүүдийг бүрдүүлэх хүчин зүйлсийн дотроос хамгийн чухал бөгөөд олон талтай, нарийн төвөгтэй нь газрын гадарга янз бүр байх явдал юм. Өөрөөр хэлбэл дэлхийн гадарга, хуурай газар, далай тэнгис, гол мөрөн, нуур цөөрөм, нүцгэн буюу өвс ургамалтай гадарга, уул нуруу, хотгор, тэгш тал мэтчилэн нэг төрлийн биш байх нь нутаг бүрийн уур амьсгалын онцгой шинжийг бүрдүүлэх үндсэн эх шалтгаан нь болно.


Төслийн бүс нутаг нь Төв Азийн хойд, уулархаг хэсгийг эзэлж, дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын дундад өргөрөгт багтах бөгөөд уур амьсгалын ерөнхий ангиллын хувьд “сэрүүн бүс”-д хамаарна. Тухайн газрын гадарга нэгэн жигд биш янз бүрийн хэлбэр дүрс, байрлал бүхий өндөр уулс, тэгш тал газар, өргөн хөндий, том нуур, гол мөрөн, өвс ургамалтай ба ургамалгүй нүцгэн гадарга алаглан оршдог явдал тус орны байгаль, уур амьсгалын байдлыг нэн олон янз болгоно.

Байгаль, уур амьсгалын том хэмжээст нөхцөл байдлын энэ бүх онцлогийг бүрдүүлдэг газарзүйн нөлөөллийн гурван үндсэн шалтгаан байгааг дурьдах нь чухал. Үүнд:

1. Гадаад далай, тэнгисээс алслагдсан байдал.
2. Далайн түвшнээс дээш их өндөр өргөгдсөн байдал.
3. Тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн байдал зэрэг болно.

Уур амьсгалын хэмжигдэхүүний горим

Агаарын дулаан хүйтэн. Жилийн дундаж агаарын температур Монгол орны өндөр уулын бүс, тэдгээрийн хоорондын хөндий, хоолой, томоохон голын хөндийгөөр -6°C -аас -8°C хүртэл хүйтэн байдаг бол өмнийн говь, цөл нутагт 6°C -аас дулаан байна. Цаг уурын ажиглалтын мэдээгээр жилийн дундаж агаарын температурын утгын хамгийн их нь Алтайн цаад говьд 8.5°C байдаг бол Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур говь цөлийн бүсээр -15°C -аас -20°C байдаг. Цөлийн бүсэд хоногийн дундаж агаарын температур 10°C -аас их байх үеийн үргэлжлэх хугацаа 150 хоногоос их юм.




Зураг 2.3. Жилийн дундаж агаарын температурын газарзүйн тархалт (1991-2020)

Чийгишлийн горим. Монгол орон ерөнхийдөө хуурай, хуурайвтар уур амьсгалын бүсэд орших тул хур тунадас ерөнхийдөө бага. Говь цөлийн бүсэд 50-150 мм орчим хур тунадас унана. Захуйн говийн өргөн уудам нутагтай, газрын тогтоц, хотгор гүдгэрийн байдал, газар зүйн онцлог нөхцөл байдлаас шалтгаалан хур тунадасны тархац ихээхэн өвөрмөц.


Жилийн хүйтэн улиралд ордог хур тунадасны хэмжээ говь нутагт 10 мм-ээс төдий л хэтэрдэггүй байна. Цасан бүрхүүлийн зузаан их биш уулархаг нутагт дунджаар 5 см, цөлөрхөг хээрийн бүсэд дунджаар 2-5 см байна.

PRISM 1961 - 1990 Mean Annual Precipitation, Mongolia




Зураг 2.4. Жилийн нийлбэр хур тунадасны газарзүйн тархац эх үүсвэр: www.climatesource.com

Масштаб 1:8,000,000



Зураг 2.5. Дэвсгэр гадаргын жилийн нийлбэр ууршиц

Салхины горим. Монголын тал хээр, говь цөлийн бүс салхи ихтэй. Жилийн дундаж салхины хурд энэ бүс нутагт 4-6 м/с. Салхины хурдны жилийн явцыг үзвэл өвөл нь салхины хурд бага, хавар, намар их болно. Өөрөөр хэлбэл, өвөл газрын гадарга ерөнхийдөө цасаар хучигдаж жигд хөрсөн байдгаас гадна эсрэг циклоны нөлөөлөл их тул салхины хурд бага байдаг. Харин дулаан улиралд газрын гадарга харилцан адилгүй халах, хөрөх \ялангуяа, хавар, намар\ мөн циклонлог цаг агаарын нөхцөл ноёрхох зэргээс шалтгаалж салхины хурд их байдаг ажээ. Монгол орны нутгийн 43%-ийг эзлэх говь-цөлийн бүсэд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтоо тохиолдоно. Шороон шуургатай өдрийн тоо Алтайн өвөр говь орчимд 90 өдрөөс давдаг байна. Шороон шуурганы 80% нь өдрийн гэрэлтэй цагт тохиолдоно. Олон жилийн ажиглалтаар Монголын говь цөлийн бүсэд жилдээ 300-600 цаг шороо хийсдэг ажээ.




Зураг 2.6. Шороон шуурганы тархалт /1960-2008/

Агаар мандлын гаралтай гамшигт үзэгдлийн давтамж. Дэлхийн уур амьсгалын эрчимтэй өөрчлөлтийн явцад агаар мандлын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэн, учруулах хор хохирол нь улам бүр өсөх хандлагатай байгаа тул тэдгээрээс улс орны тогтвортой хөгжил, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах асуудал хурцаар тавигдаж байна. Манай улсад улс орны нийгэм-эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг 10 гаруй төрлийн байгалийн гамшигт үзэгдэл тохиолддог бөгөөд тэдгээрийн гол нь агаар мандлын гаралтай үзэгдлүүд бөгөөд нийгэм-эдийн засгийн эрсдлээр нь эрэмбэлбэл ган, зуд, цасан шуурга, үер, эрс хүйтрэлт зэрэг нь голлох гамшигт үзэгдлийн тоонд ордог. Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, их цас, бороо, цочир хүйтрэл, хүйтэн бороо, нойтон цас зэрэг үзэгдлүүд их хэмжээний газар нутгийг хамарч харьцангуй удаан хугацаагаар үргэлжилдэг тул хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд ихээхэн хохирол учруулдаг ба жилд болдог АМГ гамшигт үзэгдлийн 39%-г эзэлдэг байна.

2.3. УС ЗҮЙ

Гадаргын ус.

Монгол орны нутаг дэвсгэр, гол мөрний сав газар Хойт мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсацгүй ай савд бүхэлдээ багтана. Онон, Улз, Галын гол, Хэрлэн, Монголын Дорнод талын умард ба өмнөд хэсгийн гол, горхи, нуурууд, Халх голын сав газар Номхон далайн ай савд, Енисей морний эх Шишхэд, Шар гэр, Сэлэнгэ морон, Хар-Эрчис морний эх Елт голын сав газар Хойт мөсөн далайн ай савд, Сийлхэм, Шапшал, Чехачевын нуруу, Монгол Алтай нуруунаас усжих Ховд, Тагна нурууны өврөөс усжих голууд, мөн нурууны өвөр ба Булнай нурууны араас усжих Тэс, Монгол Алтай нурууны салбар уулсаас усжих Хархираа, Түргэн, Намир, Цэнхэр, Зүйл, Шарга, Монгол Алтай нурууны өврийн Булган, Үенч, Бодонч, Биж, Хулд, Барлаг, Байтаг Богд уулын араас усжих Баруун Харгайт гол, Тахийн Шар нуруу, Хөх-Ондөр, Хавтаг нурууны арын гол, горхи, Хангай нурууны, баруун ба өврөөс усжих Завхан, Онги, Ар-Агуйт, Таац, Байдраг, Нарийн, Цагаан, Түйн гол, Алтан элснээс усжих Нарийн, Бор Хярын элснээс усжих Хүнгүй, Ханхөхий нуруунаас усжих Баруунтуруун, Чигж, Хангай нурууны арын тэгш өндөрлөг, Говь-Алтай нурууны ар, Алтайн өвөр говь, Умард говь, Халхын дундад тал, Дарьгангын тэгш өндөрлөг, Говийн гол, сайр, нуур, тойрмын сав газар Төв Азийн гадагш урсацгүй ай савд тус тус багтана.



Зураг 2.7. Гол, мөрний ай сав, ус судлалын харуул


Төсөл хэрэгжих Цагаан бургас орчим нь Монгол орны нутаг дэвсгэрийн 63.8 хувийг эзлэх Төв Азийн гадагш урсацгүй ай савд хамрагдана. Голын сүлжээний нягтшилаар 0.01 км/км^2 бага, гол мөрний нийлбэр урсацаар 0.5 л/с км^2 , хур борооны үерийн хамгийн урсацаар 10мм ба түүнээс доош, шар усны урсацын хамгийн их урсац

4мм –ээс багатай хуурай бүс нутагт оршино. Голын усны горимоор зуны хур борооны усаар сайр, садаргууд үерлэнэ. 5-10 сарын гадаргын усны ууршилт 900-1000 мм хүрнэ.

Монгол орны уулсад орсон хур тунадасны үлэмж хэсэг нь голын урсац болох ба говь, хээрийн бүсийн нуурын хөндий, хонхор хотгорын усны тэжээл болно. Нуурын хөндийн хур борооны ус бараг бүгдээрээ уурших процесст зарцуулагдана. Ийм хоёр өөр нөхцөл нь Монгол орны газар нутгийг урсац бүрдэх, шилжих, сарних хэмээх үндсэн бүсэд хуваах боломжийг олгож байна.

Монгол орны гол мөрөнд шар усны үер, хур борооны үер, зун ба өвлийн гачиг үе гэсэн усны горимын үе тод ялгарна.

Шар усны үер Говь-Алтай нуруу, Монгол Алтай нурууны өврөөс усжих хийгээд ус хурах талбайн дундаж өндөр 2500м, 2800м орчим байх Булган, Бодонч, Үенч болон бусад голуудад дунджаар 4 дүгээр сарын эхээр (4 дүгээр сарын 8), 4 дүгээр сарын 24-нд тус тус эхэлж, 5 дугаар сарын 29 ба 27-нд тус тус хамгийн их хэмжээндээ хүрч, 6 дугаар сарын 30 ба 15-н орчимд дуусна.



Зураг 2.8. Шар усны үерийн урсац (мм)

Усны дулааны ба мөсний горим. Цэнгэг усны гайхамшигтай нэгэн шинж чанар бол түүний температур 4°C байхад хамгийн их нягттай байдагт оршино. Үүнээс доош ба дээш дулаантай болоход усны эзлэхүүн тэлж хөнгөн болно. Иймээс мөс ёроолд живэхгүй байж, усан орчин, ёроолын ургамал, амьтанд таатай орчин бүрдүүлнэ. Усны физик, химийн чанар харьцангуй бага хувьсах учир амьтан, ургамлын амьдралын таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

Усан орчин, түүний экосистемд нарны цацрагийн баланс, усны дулааны горим чухал үүрэгтэй. Хүйтэн усанд дасан зохицсон хоовгон, зарим хос далавчтан зэрэг олон зүйлийн амьтан, ургамал бий. Халуун, бүлээн усанд зохицсон амьдралын хэвшил бүхий амьтан, ургамал байна. Усны температур эрс нэмэгдэхэд амьтан, ургамлын төрөл, зүйлийн

тоо цөөрнө. Жишээ нь: ногоон ургамал усны температур 38°C , цахиур замаг 45°C , хөх ногоон замаг 60°C , бактери 77°C градус хүрэхэд үгүй болно. Хүрд хорхой, дугариг хорхой, хавч хэлбэртэн, шавж, зөөлөн биетэн амьтад 40°C градусаас дээш температурт үгүй болно. Хуурай бүсийн нуур үе үе ширгэх учир түүнд амьдрах амьтан, ургамал бүр 10-15 жил хатсаны дараа ч цутгал гол, түүний орчмын экосистемийн үйлчлэлээр эргэн сэргэх нь бий.

Усны температур, дулааны балансад нөлөөлөх хүчин зүйлсийг 4 бүлэгт хувааж болно. Үүнд: 1. Уур амьсгал, 2. Газарзүй (уулзүй, дүрсзүй), 3. Усны баланс, 4. Хурдас чулуулаг зэрэг болно.

Монгол Алтай нуруу бусад мужаас харьцангуй өндөр өргөгдсөн, хур цас, мөсөөр хучигдсан, их хэмжээгээр хэрчигдсэн агаад тачир ургамалтай, адрашил багатайгаас салхи өндрөөсөө үлэмж ихэддэг онцлогтой. Эл мужид далайн түвшнээс 2000 м дээш өргөгдсөн нутаг багтах бөгөөд нэн сэрүүн уур амьсгалтай, жилд дунджаар хөрсний гадаргын температур 2200 м өндөрт -1.4°C , 2840 м өндөр -4.3°C хүрч, цаашид улам хүйтэрнэ. Энд дунджилсан салхины хурд 4.3 м/с, дулаан улирлын хоногийн дундаж дутагдал чийгийн нийлбэр, дунджаар 588 гПа, ууршил 432 мм байна. Ууршлын хэмжээ хамгийн бага байгаа нь нэн сэрүүн учир дутагдал чийгшил харьцангуй бага байдагт оршино. Ууршилд нөлөөлөх гол хүчин зүйл нь салхины хурд байна. Ууршлын 70-75 хувь салхины, 25-30 хувь нь дутагдал чийгшлийн нөлөөгөөр явагдана.

Газрын доорхи ус

Газрын доорх ус нь дэлхийн хамгийн өргөн тархалттай эрдэс билээ. Манай орны хот суурингийн хүн ам унд ахуйн усныхаа хэрэглээг үндсэндээ 100 хувь газрын доорх уснаас авдаг. Хээр тал, говийн малчид, мал жилийн 4 улирлын турш худаг тойрон амьдрахаас өөр арга зам одоогоор байхгүй байна. Газрын доорх усыг эрж олж ашиглаж хэрэглэх нь үе үеийн монголчуудын үйл ажиллагааны салшгүй хэсэг болж ирсэн түүхтэй.


Монгол орны гидрогеологийн срөнхий нөхцлийг тодорхойлохдоо дөрөвдөгч, неогени, палеогени, дээд, доод цэрд настай тунамал гаралтай, нүх сүвэрхэг хэсэгтээ газрын доорх ус агуулсан хурдсуудыг үе, үе давхарга; юра, триас, пермийн настай, нүх сүв-ан цавлаг хэсэгтээ ус агуулсан хурдас, чулуулгийг давхраадаст-ан цавлаг давхарга; пермээс өмнөх насны тунамал чулуулаг болон геологийн наснаас үл хамааруулан түрмэл, бялхмал, хувирмал, карбонат чулуулаг дахь ус агуулсан хэсгийг ус агуулагч ан цавлаг бүсүүд гэж нэрлэн тус бүрээр нь ялгажээ.

2.4. ХӨРС

Хөрсөн бүрхэвч нь байгаль орчны үндсэн суурь дэвсгэр болох бөгөөд шинж чанар төлөв байдал нь харьцангуй тогтвортой удаан хадгалагддаг боловч нөхөн сэргэх нь удаан, хэдэн зуун жил шаардагддаг байгалийн нөөц баялаг болно.

Алтайн өвөр говьд цөлийн бор саарал болон хэт хуурай цөлийн борзон хөрс зонхилно. Аж богд, Атас, Чингэс, Цагаанбогд, Эдрэнгийн нуруу зэрэг уулархаг газраар хөрсний босоо бүслүүрийн гандуу хуурай хэв шинж тодорхой хэмжээгээр илэрнэ.

Аж богдын нурууны доод, дунд биеэр цөлөрхөг хээрийн бор, цайвар хүрэн хөрс тархахаас гадна оройд нь өндөр уулын нугат хээрийн хөрс тохиолдоно. Бусад уул нуруудаар нимгэн чулуурхаг цөлөрхөг хээрийн бор хөрс голлон тархана. Цөлийн гөлтгөнөт бор саарал, хэт цөлийн чулуурхаг бор саарал хөрс хотгоруудаар түгээмэл бөгөөд эндэхийн хөрс голдуу хөнгөн шавранцар, механик бүрэлдэхүүнтэй байна. Зарим хотгор хонхорын ёроолд шал болон шалархаг хөрстэй.



Зураг 2.9. Монгол орны хөрсний органик бодисын зураг (Монгол улсын үндэсний атлас, 2009)

Цөлийн бор саарал болон хэт хуурай цөлийн борзон хөрс нь гадарга дээрээ хайрга чулуун хучаастай. хайрга чулууны гадарга нь нарны хэт халалтаас шалтгаалж хар бараан өнгөтэй болсон байдаг. Гадарга дээрээ хатуу нягтавтарт, өнгөр бактери үүсгэсэн байдаг. Энэ өнгөн давхарга нь хөрсний доод хэсгийг хэт халалт, хуурайшилтаас хамгаалдаг. Ялзмагийн хэмжээ бага 0.4-0,17%, шүлтлэг орчин хэт давамгайлна. Хэт халалтаас шалтгаалж хөрсөнд гөлтгөнийн давсны хуримтлал ажиглагдана. Хөрсний дунд хэсэгт гол төлөв гөлтгөнийн хуримтлалтай байхаас гадна, өнгөн хэсгээс гөлтгөнөтэй хөрс тохиолдоно.

Цөлийн бүсэд ус чийг туйлын хомс, хур тунадас бага унадаг. өвөл хүйтэн, улирлын хөлдөлт 4 сар гаруй хугацаагаар үргэлжилдэг учраас хөрсөн дэх биологийн үйл явц маш хязгаарлагдмал. Зуны хур борооны үед хөрсний дээд нимгэн үе чийглэгдэхэд биологийн үйл явц эрчимтэй явагдах нөхцөл бүрдэх боловч түүний үргэлжлэх хугацаа богино. Хэт халах, хөрөх, хуурайших, түр зуур чийг авч норох үзэгдэл олон зууны турш ээлжлэн цөлийн хөрсний өвөрмөц содон шинж төрх бүрэлдэн бий болох нөхцлийг хангажээ.

Номингийн говь, Хар сайрын хөндий, Баруун шаргын хоолой зэрэг газруудад ургамал бүрхэвч бараг үгүй болж хүрэн хар өнгийн сайр чулуугаар хучигдмал гадарга үүссэн байдаг. Баянбүрдүүдэд хужир мараат хөрс зонхилох ба булаг шанд хатаж ширгэхийн хирээр талбай нь нэмэгддэг. Цөлийн бүсэд хужир. шал тойром, мараа, гөлтгөнөт хөрс багагүй тархсан.


Сүүлийн жилүүдэд хуурайшилт ихэссэнтэй холбоотой хөрсний давсжилт ихэсч байна. Эхийн голын баянбүрдийн нутагт 1977, 2001, 2012 онд явуулсан мониторинг судалгаагаар хөрсний дээд давхаргын (0-10 см) давсжилтын хэмжээ нэмэгдэж өнгөн үед давс хуримтлагдах үйл явц идэвхжиж байна. Хөрсний гарал үүсэл, морфологийн тогтоц, физик-химийн шинж чанар болон ул хөрсний усны түвшний хэлбэлзлээс хамаарч хөрсний хэв шинж бүрт давсжилт харилцан адилгүй (2-20) дахин хэмжээтэй нэмэгдсэн байна.

Нугын болон бага хужирлаг нугат-намгийн хөрстэй газрын ул хөрсний усны түвшний бууралт, халиа үүсэх талбайн хэмжээ багассан зэргээс энэ төрлийн хөрс хатаж хуурайшин давсжилт нь илт ихсэж байна. Үүнтэй уялдаж нугын хөрсний органик бодисын

хуримтлал багассанаас ялзмагийн хэмжээ судалгааны өмнөх үеийнхтэй харьцуулахад дээд давхаргад 1,7-3,3 дахин буурсан нь ялзмагших эрчимшлийг сааруулж улмаар хөрсний үржил шимийг алдагдахад хургэж байна. Баянбүрдийн ихэнх талбайд тархсан чийгт гарлын хужир хөрсний давжилт 1977-2012 оны хугацаанд эрс нэмэгдээгүй байгаа нь хөрсний дээд давхарга дахь давсны агууламж жигд биш тархсантай холбоотой бөгөөд цаашид нарийвчлан судлах шаардлагатайг харуулж байна.

2.5. УРГАМАЛ

Алтайн өвөр говьд чийг хур тундасны дутагдлаас шалтгаалж маш сийрэг ургамлан бүрхэвчтэй болсон. Монгол өвст, монгол өвс-хазаар өвст, монгол өвс-таанат, монгол өвс-бударганат, монгол өвс-агьт цөлөрхөг хээр зонхилно. Цөлийн ургамалшлаас зүйл бүрийн бударгана, дэрс, шар мод, буйлс, харгана, заг голлохоос гадна булаг, шанд, баянбүрд зэрэг газраа тоорой, жигд сухай, хармаг, гоёо, таана, боролзой, зээргэнэ, шаваг, шарилж, ортууз зэрэг элдэв модлог, бутлаг, өвслөг ургамлаар нилээд баялаг. Шал тойром, хуурай хөндий зэрэг огт ургамалгүй газар ч түгээмэл тохиолдоно.



1. Хөвсгөлийн уулын тайгын тойрог, 2. Хэнтийн уулын тайгын тойрог, 3. Хангайн уулын ойт хээрийн тойрог, 4. Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрог, 5. Хянганы уулын нугат хээрийн тойрог, 6. Ховдын уулын цөлжсөн хээрийн тойрог, 7. Монгол Алтайн уулын хээрийн тойрог, 8. Дундад Халхын хуурай хээрийн тойрог, 9. Дорнод Монголын хээрийн тойрог, 10. Их нууруудын хотгорын цөлөрхөг хээрийн тойрог, 11. Олон нуурын хөндийн цөлөрхөг хээрийн тойрог, 12. Дорнод говийн цөлөрхөг хээрийн тойрог, 13. Говь Алтайн уулын цөлөрхөг хээрийн тойрог, 14. Зүүнгарын говийн (цөлийн) тойрог, 15. Алтайн өвөр говийн (цөлийн) тойрог, 16. Алашаа говийн (цөл) тойрог

Зураг 2. 10. Монгол орны ургамалжилын тойрог

Тус бүс нутагт эрдэмтдийн судалгаагаар 79 овог, 195 төрөлд хамаарах 266 зүйл ургамал тэмдэглэгджээ. Байгаль цаг агаарын эрс тэс уур амьсгал, халуун уур амьсгалтай холбогдолтойгоор ургамлын аймгийн зүйлийн бүрдэл ядмаг боловч цөлийн амьдралын

үндсэн хэлбэрийг агуулсан модлог, бутлаг, сөөглөг 1 наст, олон настай ургамлууд цөм тохиолдоно.

Ашигт ховор ургамал. Төвд, Монголын ардын эмнэлгийн эмийн түүхий эдэд ашиглагддаг 40 орчим зүйл, Монгол улсын улаан номонд орсон 13 зүйлийн ургамал тус дархан газрын нутагт ургадаг юм. Ургамлын аймгийн зүйлийн ядмаг байдлыг байнгын эрс тэс уур амьсгал, халуун хуурай нөхцөлтэй холбон тайлбарлаж болох бөгөөд эдгээр хүчин зүйлүүдийн улмаас урьд өмнө энд ургаж байсан ургамлуудаас хүнд хуурай нөхцөлд дасан зохицсон цөөн зүйлийн ургамал амьд үлдэж бусад нь устаж үгүй болжээ.

2.6. АМЬТАН

Монгол Улсын амьтны аймгийн тухай хуулиар нэн ховор амьтны бүртгэлд орсон 13 зүйл хөхтөн амьтдын 5 зүйл (38.5%), Засгийн газрын 1995 оны 152-р тогтоолоор баталсан ховор амьтны бүртгэлд орсон 12 зүйл хөхтөн амьтдын 8 зүйл (66.6%), Монгол Улсын улаан номонд /2013/ устаж, ховордож буй амьтны ангиллаар бүртгэгдсэн 33 зүйл хөхтний 17 зүйл (51.6%), 35 зүйл шувуудын 7 зүйл (20%), 6 зүйл мөлхөгчдөөс 4 зүйл (66,6%), 4 зүйл хоёр нутагтнаас 1 зүйл (25%), Олон улсын улаан номонд бүртгэгдсэн Монгол орны 8 зүйл хөхтний 6 зүйл (75%), “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай” олон улсын конвенц /CITES/-ийн 1-р хавсралтанд бүртгэгдсэн манай орны 12 зүйл хөхтөн амьтны 4 зүйл (33.3%), 2-р хавсралтанд бүртгэгдсэн 6 зүйл хөхтөн, 11 зүйл шувуу, 1 зүйл мөлхөгч нийт 17 зүйл амьтан, “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай” олон улсын конвенц (CMS)-ийн I хавсралтад орсон 2 зүйл, II хавсралтад орсон 2 зүйл тус дархан газрын нутагт тархан амьдарч байна.

Тус нутагт Дэлхий дахинд ховордсон олон зүйл сээр нуруутан байдгийн олонхи нь Төв Азийн эндемик байгаа нь амьтны аймгийн хувьд ихээхэн сонирхол татдаг.

Байгаль, байгалийн нөөцийг хамгаалах олон улсын холбоо (IUCN) -ноос дэлхийд ховордсон амьтдын жагсаалт (Red list)-ыг гаргадаг бөгөөд хамгийн сүүлчийн хувилбарт Монгол улсын нутагт тохиолддог 69 зүйлийн амьтан бичигджээ. Үүний 6 зүйл нь тус газарт бий. Энэ хэсэгхэн нутагт манай орны хөхтөн амьтны овгийн 65%, төрлийн 43%, зүйлийн 34% нь нутаглаж байна.

Тухайн орчинд зарим ховор, нэн ховор амьтдын тоо толгойг судлаачид тогтоосон байна. Шавьж идэштэн 2, гар далавчтан 5, туулай хэлбэртэн 2, мэрэгч 21, туурайтэн 1, туруутан 3, саарьтан 1, махчтан 13 нийт 48 зүйл хөхтөн бүртгэгдсэн. Алтайн өвөр говийн шувуудын зүйлийн бүрдлийг А.Болд, Ш.Болдбаатар, Н.Цэвээнмядаг (2002) нарын хэвлүүлсэн “Монгол орны шувууны зүйлийн бүрдлийн жагсаалт” зарчмыг баримтлан гаргаж үзвэл энэ нутагт 15 багийн 36 овог, 94 төрлийн 177 зүйл шувуу тохиолдоно. Эдгээр шувуудын дундаас Podicipediformes (2 зүйл), Ciconiformes (2 зүйл), Anseriformes (14 зүйл) зэрэг жинхэнэ ус чийгтэй газар бараадан амьдардаг шувууд бүхий багуудын төлөөлөгчид энд байгаа нь тус нутаг хэдийгээр Монголын говь, цөлөрхөг орчин боловч баян бүрд нуур, задгай ус, тойромтой бүс, дотоод бүслүүрүүд олонтой болохыг харуулж байна.

БҮЛЭГ ГУРАВ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХҮН АМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1. ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТ, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн амын тоо, өсөлт

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат хүн амыг хамруулна.

Аливаа улс орны хүн амын өсөлтөд төрөлт, нас баралт, гадаад шилжих хөдөлгөөн гэсэн гурван үндсэн хүн ам зүйн үзүүлэлт шууд нөлөөлдөг. Хүн амын тооны өөрчлөлт нь улс орны тухайн үеийн нийгэм, эдийн засгийн хөгжил, ард түмний аж байдлын түвшин, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж зэрэг олон хүчин зүйлтэй уялддаг.

Хүн амын тоо 1921 онд жилд дунджаар 0.1 хувийн өсөлттэй буюу 649.9 мянга байжээ. Хорьдугаар зууны эхэн үед Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил нэн дорой, хүн амын эрүүлийг хамгаалах систем бүрэлдэн тогтож чадаагүй байснаас нас баралт, ялангуяа нялхсын эндэгдэл их байжээ. Түүнчлэн хүн амын дунд элдэв халдварт өвчин ихээхэн дэлгэрсэн, бага насны хүүхдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаггүй байсан зэрэг нь хүүхдийн эндэгдэл өндөр байхад нөлөөлсөн.

Монгол Улсад эрүүлийг хамгаалах систем 1921 оны Ардын хувьсгалын дараагаар үүсжээ. Манай улсын хүн амын нас баралтын голлох шалтгааны нэг нь гоц халдварт өвчин байсан. Нийгмийн гоц халдварт өвчинтэй тэмцэх ажлын хүрээнд бүх хүн амд 1934-1935 онд цэцгийн тариа хийж, цагаан бурхан өвчнийг устгасан нь хүн амын өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байна. Хүн амын тоо 1945 онд 759.3 мянгад хүрсэн бөгөөд 1936 оноос жилд дунджаар 0.3 хувиар өссөн нь тухайн цаг үед тохиолдсон хэлмэгдүүлэлтийн үр дагавар, Халх голын дайн зэрэгтэй холбоотойгоор хүн амын өсөлт зогсонги байдалд орсон байв.

Хүн амын ердийн хөдөлгөөнийг албан ёсоор бүртгэх хууль 1950 онд гарч, 1951 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн нь цаашид хүн амын тоог жил бүр тооцох бололцоог бий болгожээ.

Монгол Улсын хүн амын тоо 1958 оны эхэнд 884.8 мянга болж, 1945 оноос 125.4 мянган хүнээр өссөн нь жилд дунджаар 1.4 хувийн өсөлттэй байлаа. Энэ хугацаанд эх орны болон чөлөөлөх дайн дуусаж, тайван замаар нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх нөхцөл, боломж бүрэлдэж эхэлсэн үе бөгөөд энэ нь хүн амын өсөлтөд эерэгээр нөлөөлсөн юм. Хүн амын өсөлтөд эерэгээр нөлөөлөх чухал арга хэмжээнүүдээс 1957-1959 онд улсын нийт хүн амын 82.9-95.8 хувийг хамарсан арьс өнгө, сүрьеэ өвчтэй хүнийг илрүүлэн эмчлэх өргөн хүрээтэй арга хэмжээг хэрэгжүүлж, ард иргэдийг эрүүлжүүлсэн нь хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх суурь нөхцөлийн нэг болсон.

Хүн амын тоо 1958-1980 онд 797.2 мянгаар, жилд дунджаар 34.7 мянгаар буюу 3.9 хувиар өссөн нь ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах чиглэлээр төр, засгаас авч хэрэгжүүлсэн дэс дараатай арга хэмжээний үр дүн байв.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил 1980-аад оны эхэн үеэс сайжирсны дотор хүн амын боловсролын түвшин дээшилж, үйлдвэр, аж ахуйн олон газар шинээр байгуулагдан түүнд ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэн гаргаж, улмаар ажил эрхэлдэг хүний тоо эрс өсөж байлаа.

Монгол Улсын Хүн ам, орон сууцны 1989 оны тооллогоор 2044.0 мянган хүн тоологдсон нь 1979 оныхоос 449.0 мянган хүнээр нэмэгдэж жилд дунджаар 44.9 мянгаар буюу 2.5 хувь өссөн байна. Хэдийгээр хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь өмнөх 10 жилийн дунджаас 0.4 нэгж хувиар буурсан ч бодит өсөлтийн хэмжээ нь 5.2 мянган хүнээр

илүү байгаа юм. Харин 2000 оны тооллогоор тус улсын хүн амын тоо 2373.5 мянга болсон нь өмнөх тооллогын дүнгээс 329.5 мянган хүнээр, жилд дунджаар 30.0 орчим буюу 1.4 хувиар өссөн байна. Мөн 2010 оны тооллогын дүнгээр манай улсын хүн ам 2754.7 буюу 381.2 мянган хүнээр нэмэгдэж жилд дунджаар 38.0 орчим буюу жилд 1.5 хувиар өссөн байна. Өсөлтийн энэ хувь өмнөх тооллого хоорондынхоос 0.1 нэгж хувиар өссөн байна. Тооллого хоорондын хүн амын өсөлт нь тухайн үеийн улс төр, нийгэм, хүн ам зүйн хөгжлөөс ихээхэн хамаардаг. Тиймдээ ч 1956-1989 онд хүн амын тоо тогтвортой өсөлттэй байсан нь ард түмний аж амьдрал үүний дотор, хүн амын эрүүл мэндийн түвшин дээшилж, төрөлт нэмэгдэхийн зэрэгцээгээр нас баралт буурч, гадаад шилжих хөдөлгөөн бараг байхгүй байсантай холбоотой юм. Харин сүүлийн жилүүдэд гадаад шилжих хөдөлгөөн нээлттэй болсон, төрөлт буурсан зэргээс шалтгаалан тухайн тооллогын онуудын хүн амын өсөлтийн хувиас буурах хандлагатай байна. Энэ нь 1990 оны эхнээс нийгэм, эдийн засгийн хөгжилд гарсан өөрчлөлт, ард түмний аж байдлын доройтол, ажилгүйдэл газар авч, эрүүл мэндийн үйлчилгээг зах зээлийн зарчмын дагуу явуулж эхэлсний сөрөг үр дагаврын нэг илрэл гэж тайлбарлаж болох юм. Мөн 1990-ээд оны эхээр манай улсад ажиллаж байсан ЗХУ-ын (хуучин нэрээр) 50.0 мянга орчим иргэн нутаг буцахын зэрэгцээгээр 1990-ээд оны дундуур манай улсын 50.0 мянга гаруй иргэн Бүгд Найрамдах Казахстан Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явж, тэд бараг бүхэлдээ тэндхийн иргэн болсон зэрэг шилжих хөдөлгөөний нөлөө их байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Улсын хэмжээнд 2021 оны байдлаар 72.4 мянган эх амаржиж, 73.3 мянган хүүхэд төрж, 20.9 мянган нас баралт бүртгэгдэж Монгол Улсын харьяат хүн амын тоо 3409.9 болж өмнөх оноос 52.4 (1.6) мянгаар өссөн байна.

Улсын хэмжээнд 2021 онд төрөлтийн ерөнхий коэффициент 21.6 буюу 1000 хүн тутам 21-22 төрөлтөөр нэмэгдсэн бол нас баралтын ерөнхий коэффициент 6.2 буюу 1000 хүн тутамд 6 хүн нас барсан байгааг илэрхийлж байна.

Төсөл хэрэгжих Говь-Алтай аймагт хүн амын тоо 2021 онд 58735 байгаа нь өмнөх оноос 392 (0.7%) хүнээр нэмэгдсэн бол Цогт суманд 3568 хүн тоологджээ.

Хүн амын нас, хүйсийн бүтэц

Хүн амын насны бүтцийг судлах нь тухайн улсын хүн ам зүйн түүхэн замналыг харах, одоогийн үйл явцыг үнэлж дүгнэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох бололцоо олгодгоороо ихээхэн ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн чиг хандлагыг харгалзан улс орныхоо нийгэм, эдийн засгийн урт, богино хугацааны бодлого хөтөлбөр боловсруулах үндэслэл болдог. Хүн амын төрөлт, нас баралтын түвшнээс хамааран тухайн улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдөж байдаг. Хүн амын хэдэн хувь нь хүүхэд залуучууд, идэр насныхан эсвэл хөгшчүүд байгаагаас хамааран нийгэм, эдийн засгийн хөгжлийн хандлагад нөлөөлдөг.

Улсын хэмжээнд 2021 онд хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 96.4 болжээ. Говь-Алтай аймгийн хэмжээнд хүйсийн харьцаа нь 100 эмэгтэйд ноогдох эрэгтэйчүүдийн тоо 100 буюу хүйсийн харьцаа тэнцвэртэй байна.

Улсын хэмжээнд 2021 оны нийт хүн амын 32.1 хувь нь 15 хүртэлх насны хүүхэд, 63.4 хувь нь 15-64 насны хүмүүс, 4.5 хувь нь 65, түүнээс дээш насны өндөр настан байгаа бол Говь-Алтай аймгийн хэмжээнд 2021 оны хүн амыг насны бүлгээр нь авч үзэхэд 18187 (31.0%) нь 15 хүртэлх насны хүүхэд, 37965 (64.6%) нь 15-64 насны хүмүүс, 2583 (4.4%) нь 65, түүнээс дээш насны өндөр настан байна.

Хүн амыг насны бүтцийн хувьд таллан хувааж байгаа зааг насыг “Голч нас” гэдэг. Өөрөөр хэлбэл, 2021 онд голч нас 28.1 болсон нь хүн амын тэн хагас нь 28-аас доош, үлдсэн 50.0 хувь нь түүнээс дээш насныхан байна гэсэн үг юм.

Говь-Алтай аймагт оршин суугаа хүн амын 17.5 мянган (29.8%) нь аймгийн төвд, 1.5 мянган (2.6%) нь тосгонд буюу нийт суурин газарт 19.0 мянган хүн амьдарч байна.

Улсын хэмжээнд 2021 оны төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь 71.0 болжээ. Дундаж наслалтыг хүйсээр авч үзвэл эрэгтэй 67.1 жил, эмэгтэй хүн 76.5 жил байна.

Аймгийн хэмжээнд 2021 оны төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь 71.14 болжээ. Дундаж наслалтыг хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийнх 75.77, эрэгтэйчүүдийнх 66.04 болж, эрэгтэй эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү 9.73 болжээ.

Өрх гэдэг нь ганц бие болон нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ.

Говь-алтай аймгийн хувьд нийт 16521 өрхтэй, үүнээс өрхийн тэргүүлэгчдийг хүйсээр авч үзвэл 13047 (79%) эрчүүд, 3474 (21%) эмэгтэйчүүд өрх толгойлж байна. Нийт өрхийн 29,7 % аймгийн төвд, 2.8 % тосгонд, 20.5 % сумын төвд, 47 % хөдөө амьдарч байна. Айл өрхийг ам бүлийн тоогоор ангилж үзвэл 32.2% нь 1-2 ам бүлтэй, 54.2% нь 3-5 ам бүлтэй, 13.6 % 6-аас дээш ам бүлтэй өрхөд хамаарч байна. Цогт суманд 1044 өрх байна.

Хүснэгт. 3.1. Хүн амын тоо, сумаар, хүйсээр, байршлаар, 2021 он

Сум		Бүгд	Цогт сум
Бүх хүн ам	Бүгд	58735	3568
	Эрэгтэй	29372	1775
	Эмэгтэй	29363	1793
Аймгийн төвд	Бүгд	17514	0
	Эрэгтэй	8576	0
	Эмэгтэй	8938	0
Тосгонд	Бүгд	1503	781
	Эрэгтэй	736	391
	Эмэгтэй	767	390
Сумын төвд	Бүгд	11926	677
	Эрэгтэй	5965	337
	Эмэгтэй	5961	340
Хөдөөд	Бүгд	27792	2110
	Эрэгтэй	14095	1047
	Эмэгтэй	13697	1063

Хүснэгт. 3.2. Хүн амын тоо, багаар, 2021 он

Сум	Баг	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Өрхийн тоо
Цогт сум	1-р баг, Рашаант	376	186	190	104
Цогт сум	2-р баг, Далан	342	180	162	98
Цогт сум	3-р баг, Гэгээт	317	158	159	93
Цогт сум	4-р баг, Төгрөг	704	353	351	193
Цогт сум	5-р баг, Баян-Өндөр	674	329	345	193
Цогт сум	6-р баг, Баян-Улаан	374	178	196	112
Цогт сум	7-р баг, Баян тоорой	781	391	390	251
Цогт сум	СУМЫН ДҮН	3568	1775	1793	1044

Хүснэгт 3.3. Хүн амын тоо, сумаар насны бүлгээр, 2021 он

СУМ	НИЙТ	Насны ангилал										
		0-4	4-9	10-14	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54
Цогт сум	3 568	393	383	347	287	286	233	279	265	239	202	204
Нийт	58 735	6614	5939	5634	4663	4978	4209	4114	4291	4087	3796	3 364

3.2. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Аймгийн хэмжээнд 2021 онд 1082 өнчин хүүхэд байгаагийн 54 (5.0%) нь бүтэн өнчин хүүхэд, 1028 (95.0%) нь хагас өнчин хүүхэд байна.

Нийт өнчин хүүхдийн 132 (12.2%) нь 0-4 насны, 269 (24.9%) нь 5-9 насны, 421 (38.9%) нь 10-14 насны, 85 (7.9%) нь 15 насны, 97 (9.0 %) нь 16 насны, 77 (7.1%) нь 17 насны хүүхэд байна. Үүнээс Цогт суманд бүтэн өнчин 1, хагас өнчин 51 хүүхэд бүртгэгджээ.

Өрх толгойлсон эх 2021 онд 1593 болж өмнөх оноос 110 (6.5%)-аар, өрх толгойлсон эцэг 282 болж өмнөх оноос 24 (7.8%)-иар тус тус буурчээ. Цогт суманд өрх толгойлсон эмэгтэй 102 байна.

Өрх толгойлсон эхчүүдийн 794 (49.8%) нь 3 хүртэлх, 690 (43.3%) нь 3-5 хүртэлх, 109 (6.8%) нь 6, түүнээс дээш гишүүнтэй өрхийг толгойлж байна.

18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 1003 болж, өмнөх оноос 46 (4.4%)-аар буурсан байна. Нийт 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш өрхийн 779 (77.7%) нь 4 хүртэлх, 156 (15.6%) нь 5 хүртэлх, 55 (5.5%) нь 6 хүртэлх, 13 (1.3%) нь 7, түүнээс дээш хүүхэдтэй өрх байна.

Ганц биеэрээ амьдарч буй ахмад настай хүний тоо 2021 оны эцэст 1528 болж, өмнөх оноос 65 (4.4%)-өөр өссөн байна. Ганц биеэрээ амьдарч буй өндөр настай нийт хүний 295 (19.3%) нь 60, түүнээс дээш настай эрэгтэйчүүд, 1233 (80.7%) нь 55, түүнээс дээш настай эмэгтэйчүүд байна. Цогт суманд 60, түүнээс дээш настай эрэгтэйчүүд 17, 55, түүнээс дээш настай эмэгтэйчүүд 79 байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн 2021 оны эцэст 2970 болж, өмнөх оны мөн үеэс 146 (4.7%)-аар буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 20.2 хувь нь хөдөлгөөний согогтой, 7.8 хувь нь сонсгол, 3.0 хувь нь хэл ярианы согогтой, 4.8 хувь нь хавсарсан согогтой, 11.7 хувь нь харах эрхтний өөрчлөлттэй, 36.7 хувь нь бусад, 15.8 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй хүн байна. Эдгээрээс Цогт суманд 153 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

3.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2021 оны 12 дугаар сарын эцэст 915 байгаагаас 493 (53.9%) ажил хөдөлмөр эрхлээгүй бүртгэлтэй иргэн, 422 (46.1%) одоо ажил хөдөлмөр эрхэлж байгаа ч бүртгэлтэй иргэн байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 81 (8.1%) хүнээр, өмнөх сараас 213 (30.3%) хүнээр тус тус буурч, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 433 (47.3%) нь эмэгтэйчүүд байна.

Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 17 (1.9%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаагаас 7 (41.2%) эмэгтэйчүүд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 52.4 хувийг бүрэн дунд, 29.9 хувийг дипломын болон бакалаврын дээд, 6.4 хувийг техник мэргэжлийн, 4.0 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.4 хувийг суурь, 1.7 хувийг бага, 1.1 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.

Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 50.8 хувийг 15-34 насны залуучууд, 43.4 хувийг 35-54 насныхан, 5.8 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна.

3.4. ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2021 оны эхний 12 сарын байдлаар 1289 эх амаржиж, 1296 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 106 (7.6%)-аар, амьд төрсөн хүүхэд 110 (7.8)-аар тус тус буурсан байна.

Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 12 сард 23 гарч, 1000 амьд төрөлтөнд нялхсын эндэгдэл 17.7 ноогдож байна

Нас баралтын 319 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 37 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.

Нас барсан хүний 60.5 хувь нь эрэгтэй, 39.5 хувь нь эмэгтэй байна. Нийт нас баралтын 31.0 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд 17.2 хувь нь хоног болоогүй байна.

Нийт нас баралтын 80 буюу 25.1 хувийг хорт хавдрын, 54 буюу 16.9 хувь нь осол гэмтлийн шалтгаантай байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 13220 болж, өмнөх оны мөн үеэс 12915 өсөхөд ковид-19 халдварт өвчнөөр өвчлөгчид 13084 нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5. БОЛОВСРОЛ

Ерөнхий боловсролын сургуульд 2021-2022 оны хичээлийн жилд 11816 суралцагчид байгаагийн 5881 (49.8%) нь эмэгтэй суралцагчид байна. Нийт суралцагчдын 5739 (48.6%) нь 1-5-р ангид, 4111 (34.8%) нь 6-9-р ангид, 1966 (16.6%) нь 10-12-р ангид суралцаж байна. Энэ хичээлийн жилд 1-р ангид 1095 суралцагчид элсэн орсны 555 (50.7%) эмэгтэй суралцагчид байна. Мөн 12-р ангид 619 суралцагчид байгаагийн 366 (59.1%) нь эмэгтэй суралцагчид байна.

Энэ хичээлийн жилд 542 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 21.8 суралцагч ногдож байна. 1 багшид ногдох суралцагчийн тоо 15 байна. Нийт ажиллагсдын 793 (53.8%) үндсэн багш байна. Үндсэн багшийн 652 (82.2%) нь эмэгтэй багш нар байна. Дотуур байранд 1065 сурагч амьдарч байна.

2021-2022 оны хичээлийн жилд 137 бүлэгт 3.2 мянган хүүхэд хүмүүжиж байгаагийн 1.5 (46.9%) мянга нь эмэгтэй хүүхэд байна.

Нийт хүмүүжиж байгаа хүүхдийн 2.6 (80.7%) мянга нь үндсэн цэцэрлэгт, 0.6 (19.3%) мянга нь хувилбарт сургалтанд хамрагджээ. Нийт ажиллагсдын 164 (47.4%) нь үндсэн багш байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2021-2022 оны хичээлийн жилд нийт 2.5 жилийн сургалттай 9 мэргэжлийн ангид 351, нэг жилийн сургалттай 9 мэргэжлийн ангид 142, нийт 493 суралцагч суралцаж байгаагийн 230 (46.6%) нь эмэгтэй суралцагчид байна.

Суралцагчдын 142 (28.8%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр нэг жилийн хугацаатай суралцаж байгаа бөгөөд 351 (71.2%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр 2.5 жилийн хугацаатай суралцаж байна. Суралцагчдын 53 (10.7%) барилгын засал, чимэглэлч, 45 (9.1%) оёмол бүтээгдэхүүний оёдолчин, 33 (6.6%) авто машины засварчин, 31 (6.2%) Цахим тоног төхөөрөмж, үйлчилгээний ажилтан, 29 (5.8%) барилгын цахилгаанчин, 29 (5.8%) үсчин гэх мэт мэргэжлээр сурч байгаа нь олонх байна.

Төгсөгчдийн 21 (12.2%) барилгын засал чимэглэлч, 18 (10.4%) мэргэшсэн жолооч, 16 (9.3%) хүнд машин механизмын операторч, 15 (8.7%) үсчин, 15 (8.7%) оёмол бүтээгдэхүүний оёдолчин, 14 (8.1%) гоо засалч зэрэг мэргэжил ихэнх нь эзэмшиж төгсчээ.

3.6. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 12 сард 46.5 тэрбум төгрөг, сангийн зарлага 46.5 тэрбум төгрөг болсон.

Харин тэтгэмжийн даатгалын сангийн орлого 39.7 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн 1.8 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 3.5 тэрбум төгрөг, ҮОМШӨ–ний даатгалын сангийн орлого 0.7 тэрбум төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 0.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийгмийн халамжийн сангаас 2021 оны 12 дугаар сард 29.5 мянган иргэнд 6 тэрбум 598.6 сая төгрөг олгосон бол үүнээс нийгмийн халамжийн үйлчилгээний зардалд 2 тэрбум 925.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7. АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн борлуулалтыг сүүлийн 11 жилээр харахад нэмэгдсэн хандлагатай харагдаж байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлтийн борлуулалт 2021 оны 12 дугаар сарын байдлаар 16 тэрбум 498.6 сая төгрөгт хүрчээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 34.1 (0.2%) сая төгрөг, 2010 оны мөн үеэс 9 тэрбум 735.5 (144%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Аж үйлдвэрийн борлуулалтыг салбараар нь харахад 2021 онд 13.8 тэрбум төгрөг буюу 83.9 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл, 1.8 тэрбум төгрөг буюу 10.8 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 0.9 тэрбум төгрөг буюу 5.4 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар тус тус эзэлж байна.

3.8. ТӨСӨВ

Орон нутгийн төсөвт нийт 74.6 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 101.8 хувиар биелүүлсэн байна. Үүнээс улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 14.0 тэрбум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 40.4 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 10.0 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 10.1 тэрбум төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 113.9 хувиар, хөрөнгийн 75.2 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 132.9 хувь, татварын бус орлого 1.0 тэрбум төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 123.8 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх 2.4 тэрбум төгрөг, татварын орлого 9.0 тэрбум төгрөгийн орлогыг тус тус оруулсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтийн 88.4 хувийг санхүүжүүлсэн байна. Үүнд бараа, ажил үйлчилгээний зардлын 96.2%, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 98.2%, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 95.6%, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 97.7%, хангамж, бараа материалын зардлын 96.1%, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын 98.1%, эд хогшил, урсгал засварын зардлын 92.3%, томилолт, зочны зардлын 69.5%, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн 72.0%, бараа үйлчилгээний бусад зардлын 95.2%, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасны 100.0%, урсгал шилжүүлгийн 99.6 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

3.9. ХӨДӨӨ АЖ АХУЙ

Говь-Алтай аймагт 2021 оны жилийн эцсийн мал тооллогоор 2990.5 мянган толгой мал тоологдсоны дотор адуу 115.5 (3.9%) мянга, үхэр 69.6 (2.3%) мянга, тэмээ 43.7 (1.5%) мянга, хонь 885.9 (29.6%) мянга, ямаа 1875.7 (62.7%) мянга тус тус эзэлж байна.

Улсад нийт малын тоогоор 14 дүгээр байрт орсон бол тэмээгээр 3 дугаар байрт ямааны тоогоор 4 дүгээр байрт тус тус орсон байна.

Малтай 10.9 мянган өрх байгаагийн 8.2 (74.7%) мянга нь малчин өрх байна. Мөн энэ онд 1000 түүнээс дээш малтай өрхийн тоо 252 болж 2020 оноос 72 өрхөөр (22.4%)-иар, 2018 оноос 494 өрхөөр 3 дахин буурчээ.

Хээлтэгч мал: Хээлтэгч мал нь жилийн эцсийн нийт малын (47.8%)-ийг эзэлж, өмнөх оноос 47.5 (3.5%) мянга өссөн байна. 2020 оноос жилийн эцсийн хээлтэгч гүү 1552 (3.1%), үнээ 422 (1.4%), ингэ 832 (5.4%), эм хонь 19501 (4.8%), эм ямаа 26140 (2.9%)-иар төрөл тус бүр дээр өссөн байна. Нийт хээлтэгчээс гүү (3.1%), үнээ (2.2%), ингэ (1.1%), эм хонь (29.7%), эм ямаа (63.9%)-ийг тус тус эзэлж байна.

Нийт төллөх насны хээлтэгчийн (53.8%) нь төллөж, үүнээс гүүний (49.2%), үнээний (57.8%), ингэний (45.4%), эм хонины (62.0%), эм ямааны (50.2%) нь тус тус төллөсөн байна. Мөн тайлант онд 86.7 мянган хээлтэгч мал хээл хаяж, 524.7 мянган хээлтэгч мал сувайрсан байна.

Малын хорогдол: 2020 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 30.5 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон бол 2021 онд 278.1 мянган толгой болж 9 дахин өссөн байна. Малын төрлөөр нь авч үзвэл хонь 74881 (26.9%), ямаа 190576 (68.5%), адуу 5983 (2.2%), үхэр 5945 (2.1%), тэмээ 736 (0.3%)-ийг эзэлж байна.


Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 5983 (2.2%), үхэр 5945 (2.1%), тэмээ 736 (0.3%), хонь 74881 (26.9%), ямаа 190576 (68.5%) толгой байна. Нийт хорогдлын (26.3%)-ийг хонь, (65.9%)-ийг ямаа эзэлж байна.

2021 оны байдлаар үр тариа 338.8 га, төмс 60.4 га, хүнсний ногоо 66.8 га, тэжээлийн ургамал 756.3 га-д тус тус тариалалт хийсэн. Үүнээс үр тариа 702.1 тн, төмс 340.4 тн, хүнсний ногоо 439.3 тн, тэжээлийн ургамал 2156.0 тонныг тус тус хурааж аваад байна. Мөн иргэд 7821.3 тн хадлан, 401.2 тн гар тэжээл, 2669.5 тн хужир шүү тус тус бэлтгэсэн байна.

БҮЛЭГ ДӨРӨВ. “ГОВИЙН БҮСИЙН НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВ” БАЙГУУЛАХ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИЙДЛҮҮД

4.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ЦАР ХҮРЭЭ

Төслийн ажлын даалгаварт тусгаснаар төслийн зорилтот нутаг болох Зармангийн говь болон Улаан шалын хоолойд “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хийхээр тусгасан бөгөөд тухайн орон нутагт нөхцөл байдал, материаллаг бааз, амьтдын уугуул нутаг, аялал жуулчлал хөгжүүлэх боломж зэргийг үндэслэн Говь-Алтай аймгийн Цогт сумын 7-р баг, Баян тоорой тосгоноос Баруун урагш 30 км, Ээж хайрхан уулнаас 36 км, Цагаан бургасны баянбүрд (ундарга 200 л/цаг)-ээс 5 км зайд орших Цагаан бургасны амны төгсгөл, Хүйс толгой орчмын газарт (N44⁰45'12" E96⁰36'45" alt; 1521m) 60 га талбайг хамран оршино.



Зураг 4.1. Төсөл хэрэгжих газар нутаг

Энэ нутаг нь ухаа толгод бүхий, элсэрхэг, чулуурхаг гадаргатай, говь цөлийн ургамал тачир сийрэг нутаг юм.



Зураг 4.2. Төслийн талбай орчмын үзэгдэх байдал

Хүснэгт 4.1. Төслийн талбайн байршил

№	Байршил	Уртраг	Өргөрөг	Өндөршил (м)
1	Зүүн урд	44 ⁰ 45'08''	96 ⁰ 37'25''	1361
2	Зүүн хойд	44 ⁰ 45'35''	96 ⁰ 37'24''	1334
3	Баруун урд	44 ⁰ 45'07''	96 ⁰ 36'52''	1356
4	Баруун хойд	44 ⁰ 45'35''	96 ⁰ 36'52''	1326

4.2. ЗОХИОМОЛ ОРЧИНД БАЙГАЛЬ ХАМГААЛАХ СТРАТЕГИ

Биологийн олон янз байдлыг улаан хугацаагаар хамгаалах хамгийн сайн арга бол байгалийн бүлгэмдэл болон популяцийг байгальд нь зэрлэг байдлаар нь хамгаалах арга бөгөөд үүнийг байгалийн нөхцөлд хамгаалах арга хэмээн нэрлэдэг. Зөвхөн байгалийн нөхцөлд амьдарч байгаа зүйл түүхэн хөгжлийнхөө явцад амьдрах орчны элдэв өөрчлөлтөнд дасан зохицох боломжтой байдаг. Гэвч олон янзын ховор зүйлийн хувьд байгалийн нөхцөлд хамгаалах арга нь байнга өсөн нэмэгдэж буй хүний нөлөө, хөнөөл сүйтгэлээс бүрэн хамгаалах нөхцөл болж чаддаггүй. Тухайлбал, нэн ховордсон тодорхой нэг зүйлийн үлдмэл популяцийн хэмжээ цаашид оршин тогтноход хэт бага бол, эсвэл үлдэж хоцорсон бодгалиуд нь тусгай хамгаалалттай газар нутгийн гадна оршиж байгаа тохиолдолд байгалийн нөхцөлд хамгаалах арга нь үр дүнтэй байх боломжгүй юм. Ийм нөхцөлд зүйлийг устаж, мөхөхөөс аврах хамгийн боломжтой нэг арга бол тухайн зүйлийн бодгалиудыг хүний асрамжин доор зохиомол орчинд хамгаалах явдал юм. Бидний хэрэгжүүлэх говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв нь энэхүү

зохиомол орчныг бүрдүүлж хамгаалах үйл ажиллагаатай ижил зорилгод нэгтгэж байгаа юм. Энэ аргыг зүйлийг хамгаалах байгалиас тусгаар буюу зохиомол орчинд хамгаалах арга хэмээн нэрлэдэг. Олон зүйл нэгэнт байгалиас устаж үгүй болсон боловч зохиомол орчинд амьд үлдсэн байх нь цөөнгүй. Ховордож мөхлийн ирмэгт хүрсэн зүйлийг зохиомол орчинд хамгаалах арга хэмжээний эцсийн зорилго нь ийм орчинд хамгаалан, өсгөж үржүүлсэн тодорхой нэгэн зүйлийн бодгалиудын тоо толгой хангалттай хэмжээнд хүрч, тохиромжтой байгалийн орчин бүрдсэн нөхцөлд түүнийг байгальд нь сэргээн нутагшуулж, шинэ популяцийг үүсгэхэд оршино.

Устаж ховордож буй амьтдыг хамгаалах зохиомол орчинд амьтны хүрээлэн, хашаалсан эдэлбэр нутаг, аквариум болон үржүүлгийн газар орно. Байгалийн нөхцөлд болон зохиомол орчинд зүйлийг хамгаалах аргын дундаж хэлбэр буюу тэдгээрийн аль алиных нь арга хэлбэр, нөхцлийг давхар агуулсан арга бол устаж, ховордож буй зүйлийн популяцийг жижиг хэмжээний тусгай хамгаалалттай газар нутагт хамгаалж, популяцийн зохицуулалт болон хяналт хийх явдал юм. Ийм нөхцөлд хамгаалж буй популяци харьцангуй зэрлэг шинжтэй байх бөгөөд түүнд үзүүлэх хүний үйл ажиллагаа нь тухайн популяцийг устаж мөхөхөөс аврахад чиглэгддэг.

Зохиомол орчны хамгааллын арга хэмжээ нь устаж, ховордож буй зүйлийг хамгаалах нэгдмэл стратегийн чухал хэсэг юм. Байгалийн болон зохиомол орчинд зүйлийг хамгаалах арга хэмжээ нь харилцан уялдаатай нэгдмэл үйл ажиллагаа байдаг. Зохиомол орчинд өсгөж үржүүлсэн амьтан, ургамлын популяцийн зарим бодгалиудыг байгальд нь эргүүлэн тавьж, байгалийн нөхцөлд, тусгай хамгаалалттай газар нутагт үргэлжлүүлэн хамгаалж, өсгөн үржүүлнэ. Зохиомол орчинд хамгаалж буй популяцийг судалснаар тухайн зүйлийн биологийн талаархи чухал мэдээллийг хуримтлуулахаас гадна, түүнийг байгалийн нөхцөлд хамгаалах шинэ дэвшилтэт арга зүй, стратегийг боловсруулах нөхцөл бүрэлдэнэ. Зохиомол орчинд амьдарч буй, өөрөө өөрийнхөө тоо толгойг нөхөн зохицуулах чадвартай популяци нь судалгааны болон үзүүлэн таниулах сургалтын зорилгоор ашиглаж болох тохиромжтой объект бөгөөд ингэснээр дээрх зорилгоор байгалиас амьтан, ургамлын цуглуулга хийх шаардлага багасна. Түүнчлэн устаж, ховордож буй зүйлийг олон нийтэд үзүүлж, ухуулга сурталчилгаа хийснээр тэдэнд ховордсон амьтан, ургамлын зүйлийг хамгаалах шаардлага болон байгаль дахь бусад зүйлийг хамгаалах талаар тодорхой ойлголт өгөхөд тус дөхөм болно. Түүнчлэн зохиомол орчинд зүйлийг өсгөн, үржүүлж, хамгаалах нь ихээхэн өндөр өртөгтэй. Тухайлбал, Африкийн заан болон хар хирсийг амьтны хүрээлэнд өсгөн үржүүлж, хамгаалахад гарах зардал эдгээр зүйлийг (адил тооны амьтдыг) Зүүн Африкийн дархан газруудад хадгалан, хамгаалах зардлаас даруй 50 дахин их өртөгтэй байдаг ажээ. Зөвхөн АНУ-ын нийт амьтны хүрээлэнгийн жилийн төсөв 1 тэрбум орчим долларт хүрдэг байна. Майкл Соулийн хэлсэнчлэн "Ямар нэгэн боломжгүй юмуу найдваргүй болсон зүйл гэж байдаггүй бөгөөд зөвхөн найдваргүй хүн, өртөг ихтэй зүйл гэж байдаг".

Зохиомол амьдрах орчны нэг болох амьтны хүрээлэн Засгийн газрын харьяа байгаль хамгаалах газар, бусад байгаль хамгаалах байгууллага, их сургууль зэрэг байгууллагыг түшиглэн ажилдаг бөгөөд тэдгээрт өнөөгийн байдлаар хөхтөн амьтад, шувуу, хоёр нутагтан, мөлхөгчдийн 3000 зүйлийн 700000 бодгаль амьдарч байна (WCMV, 1992). Гэвч эдгээр амьтдын тоог мал юмуу бусад гэрийн тэжээмэл амьтад, тухайлбал хүмүүсийн хувийн сонирхолоороо тэжээдэг нохой, муур, аквариумын загасны тоотой харьцуулбал өчүүхэн бага юм. Амьтны хүрээлэн ихэвчлэн хүмүүсийн дур сонирхлыг татам өвөрмөц сүрлэг амьтад, тухайлбал хулсны баавгай, анааш, заан зэрэг амьтад

илүүтэй анхаарч, харин олноороо нэн ховордож, устаж буй шавьж болон бусад нугаламгүй амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх асуудлыг орхигдуулсан байдаг. Ихэнх томоохон амьтны хүрээлэнгийн өнөөгийн зорилго нь ховор болон устаж буй амьтдын үржлийн популяцийг буй болгоход оршиж байна. Дэлхийн олон амьтны хүрээлэнд амьдарч буй ховор зүйлийн хөхтөн амьтдын зөвхөн маш бага хувь нь тэдгээрийн генетик хувьсамжийг хадгалахуйн хэмжээнд хүрсэн тоо толгойтой болжээ. Энэ нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд амьтны хүрээлэн болон байгаль хамгаалах байгууллага ирвэс, хүн дүрст бич орангутан зэрэг ховордсон болон устаж буй амьтдын үржлийн сүргийг буй болгох орчинг бүрдүүлж, түүнд хэрэглэгдэх технологийг боловсруулах, зүйлийг байгальд сэргээн нутагшуулах шинэ арга, хөтөлбөрийг боловсруулахад ихээхэн анхаарч байна. Тэдгээр арга хэмжээний зарим нь ихээхэн төрөлжиж, зөвхөн тодорхой нэг зүйлийг хамгаалахад чиглэгдсэн байна.

Зохиомол орчинд зүйлийг хамгаалах үйл ажиллагаа сүүлийн үед ховор болон устаж буй зүйлийг хамгаалах асуудалд мөн чиглэгдэж байна. Зохиомол орчинд зүйлийг хамгаалж байгаа өөр нэг хэлбэр бол гэрийн тэжээмэл амьтдыг үржүүлж байгаа үйл ажиллагаа бөгөөд түүн дээр тулгуурлан хүн өөрийн өдөр тутмын хэрэглээ болох хүнс тэжээл, үс ноос, арьс шир гэх мэт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, мөн аж ахуйн үйл ажиллагааны олон хэлбэр явагдаж байна. Ховор болон устаж буй зүйлийг хамгаалах, үржүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэд хэдэн чиглэлээр гүнзгийрүүлэн хийж байгаа бөгөөд тэдгээрийг гүйцэтгэдэг байгууллага нь ховор болон устаж буй зүйлийн талаархи мэдээллийг цуглуулж, хуримтлуулан, түүнийгээ олон нийтэд түгээн дэлгэрүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Олон улсын Байгаль хамгаалах Холбоо (ОУБХХ)-ны нэг салбар болох Зүйлийг хамгаалан үржүүлэх мэргэжилтний бүлэг болон бусад олон нийтийн байгууллага, тухайлбал Америкийн Амьтны хүрээлэн ба Аквариумын Холбоо зэрэг нь амьтны хүрээлэнд тодорхой зүйлийг гаршуулах, тэжээх, тэжээлийн орц хэмжээ, амьдрах орчны тохиромжтой нөхцөл, эмчлэн сувилах арга зүй, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэх мэтийн асуудалд мэдээлэл, зөвлөлгөө өгч байдаг. Ховор ба устаж буй амьтдын үржлийн бүртгэл, судалгааны мэдээлэл нь ойр цусан төрлийн бодгалиудыг хооронд нь эвцэлдүүлэхгүй байх болон цус ойртолтоос болж тэдгээрийн генетик бүтэц алдагдахгүй байх нөхилийг хангахад чиглэгдэнэ. Ийм мэдээллийн сангийн хамгийн чухал хэсэг бол Зүйлийн бүртгэлийн олон улсын систем (ISIS) бөгөөд энэхүү мэдээллийн сан нь дэлхийн 39 орны 395 амьтан судлалын хүрээлэнгээс 4,200 орчим зүйлийн амьтдын талаар мэдээлэл авч, хуримтлуулж байдаг ажээ. Ховор ба устаж буй амьтдын үржил, нөхөн төлжилтийн эрчмийг нэмэгдүүлэхийн тулд олон төрлийн шинэлэг технологийг боловсруулж байна. Тэдгээрийн зарим арга нь хүн эмнэлэг ба мал эмнэлгийн ухааны чиглэлээр хөгжсөн байдаг бол бусад арга зүй зөвхөн тодорхой нэг зүйлд зориулж боловсруулсан шинэлэг арга зүй байдаг. Ийм арга зүйд:

- авахуулах арга -ховор зүйлийн амьтны нялх төлийг өөр элбэг зүйл амьтанд авахуулан дасгаж, хөхүүлэн тэжээх;
- зохиомол хээлтүүлэг хийх арга - энэ нь эр, эм хүйсийн амьтад эвцэлдээнд орох сонирхолгүй байх юмуу эсвэл хоёр өөр газар амьдарч байгаа тохиолдолд хэрэглэдэг арга;
- зохиомол инкубац хийх арга - үр тогтсон өндгөн эсийг умайн орчинтой адил нөхцөлд бойжуулах;

- хөврөл шилжүүлэн суулгах арга -ховор зүйлийн үр тогтсон өндгөн эсийг элбэг тохиолдох өөр зүйлийн эх организмд шилжүүлэн суулгаж бойжуулах зэрэг арга орно.

Сүүлийн үед боловсруулж буй нэгэн шинэ оролдлого бол устаж, мөхөхийн ирмэгт тулсан амьтдын өндөг, хөврөл болон эд, эсийн хэсгийг гүн хөлдөөж хадгалах арга бөгөөд түүнийг "хөлдүү амьтны хүрээлэн" хэмээн нэрлэдэг. Түүнчлэн ирээдүйд, устаж мөхсөн амьтдын арьс үс, яс гэх мэт биеийн аль нэгэн эрхтний эд, эсийг хувилах (колониийн арга) аргаар амилуулан өсгөвөрлөх асуудал цаашид шийдвэрлэгдвэл, тэдгээр устаж мөхсөн зүйлийг дахин амьдруулж болох юм хэмээн найдаж байгаа билээ.

Эрдэмтэд ховордож буй зүйлийг хамгаалахын тулд дээрх хэдэн аргыг хэрэглэхээр шийдвэрлэвэл тэдэнд хэд хэдэн ёс зүйн асуудал тулгарна. Тухайлбал, нэгдүгээрт эдгээр арга нь тодорхой нэг зүйлийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай юу?, Энэ аргыг хэрэглэснээр хэр үр дүнтэй байх вэ? Устаж буй тодорхой нэг зүйлийн үлдсэн цөөн хэдэн бодгалийг зохиомол орчинд тэжээж өсгөсөн ч тэдгээр бодгалиуд нь эргэж байгалийнхаа зэрлэг байдалд дасан зохицох боломжгүй бол тэр чигээр нь байгальд нь байлгасан нь дээргүй юу? Хоёрдугаарт, зохиомол орчинд өсгөн үржүүлсэн ховор амьтны популяци байгалийн зэрлэг амьдралын орчны талаар ямар нэгэн төсөөлөлгүй бол цаашид бие даан амьдрах чадвартай юу? Гуравдугаарт, зохиомол орчинд үржүүлэг явуулж буй нь тухайн зүйлийг хамгаалахад чиглэгдэж байна уу? эсвэл амьтны хүрээлэнгийн эрх ашгийн төлөө хийгдэж байна уу? г. м. асуудал тулгарна.

Хэдийгээр дээрх асуултуудын хариулт зохиомол орчинд зүйлийг хамгаалах менежмент нь зөв, оновчтой болохыг баталдаг ч ховор амьтдыг зохиомол орчинд үржүүлэх асуудал тэр бүр биелэгддэггүй. Учир нь аливаа нэг зүйл хүний нөлөөнөөс гадна үржлийн эрчим багатай байдгаас шалтгаалан тоо толгойн хувьд хэт цөөрч, улмаар цус ойртолт хүчтэй явагдсан байж болох юм. Түүнчлэн зарим амьтад, тухайлбал далайн хөхтөн амьтдын биеийн хэмжээ нүсэр том байхын зэрэгцээ тэдгээрийг өсгөж, үржүүлэх амьдралын орчинг бэлтгэхэд маш их өртөг, зардал шаардагдана. Мөн олонхи нугаламгүйтэн амьдралын нийлмэл эргэлтэй байдаг бөгөөд тэд хөгжлийн нэг шатнаас нөгөөд шилжихэд идэш тэжээлийн горим нь өөрчлөгдөж, амьдралын орчин нь солигдож байдаг. Ийм зүйлийг өнөөгийн нөхцөлд өсгөн, үржүүлэх боломжгүй байгаа юм. Дээрхээс гадна зарим нэг зүйлийн амьтад эрдэмтэд судлаачдын зүтгэл, хөдөлмөрөөс үл хамааран үржүүлж өсгөхөд ихээхэн бэрхшээлтэй байдаг. Энэ тухай хоёрхон жишээ өгүүлэхэд Аварга панда буюу хулсны баавгай, мөн Суматрын хирс зэрэг зүйлийн амьтад байгаль дээр үржлийн эрчим багатай бөгөөд мөн зохиомол орчинд ч төдийлөн үржилд орж үр төл өгдөггүй ажээ.

4.3. НЭН ХОВОР, ХОВОР АМЬТНЫ ТОО ТОЛГОЙГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ

БОДЛОГО

Хүрээлэн буй орчныг хамгаалах, зөв удирдах /менежмент хийх/ асуудлын ард буй Дэлхийн байгаль хамгаалах холбоо болон бусад олон байгууллагын гол философи нь „Caring for the Earth“ болон „Global Biodiversity Strategy“ зэрэг гол баримт бичигт тусгагдсан байна. Эдгээр бичиг баримтанд аливаа асуудалд байгалийн нөөцийн тогтвортой хамгаалалд оролцож буй, амьдрах орчны чанарыг тэтгэх чиглэлээр тал бүрийн санаачлагатай, экосистем хамгаалах, шаардлагатай тохиолдолд нөхөн сэргээх зэрэгт орон нутгийн хүмүүсийн оролцооны ач холбогдлын талаарх өргөн сэдвийг хөндөнө. Экосистемийг нөхөн сэргээхэд тухайн нутагт дутагдаж байгаа нэг зүйл зэрлэг амьтныг

сэргээн нутагшуулах нь нэг өвөрмөц тохиол юм. Нэг экосистемийн дотор ургамал, амьтны олон зүйлийг сэргээн нутагшуулсан туршлага ховор юм. Ургамал, амьтны тодорхой нэг зүйлийг сэргээн нутагшуулах ажил улам өргөн дэлгэр болж байна.

Зарим нэг нь амжилт олж байгаа ч, ихэнх нь үр дүнгүй болж байна. Экологийн менежментийн энэ хэлбэр эрчтэй өсөн нэмэгдэх тутам Дэлхийн Байгаль хамгаалах холбооны сэргээн нутагшуулах асуудал эрхэлсэн мэргэжлийн хэсгийн гол үүрэг бол сэргээн нутагшуулах ажлыг үр дүнтэй болох баталгааг хангах, аливаа санаачлага үр дүнтэй болсон эсэхээс үл хамааран түүнээс гарах байгаль хамгааллын үр дагаварыг суралцах үүднээс сайн журам боловсруулах ажил юм. Тодорхой судалгаа, олон салбар дундын мэргэжлийн зөвлөмжинд тулгуурлан асуудлыг тал бүрээс нь хөндсөн энэхүү удирдамж хэдийгээр сэргээн нутагшуулахаар сонгох амьтны зүйл, ажиллах орон зайн нөхцөл харилцан адилгүй боловч хөтөлбөрийн үзэл баримтлал, ажлын зураг, хэрэгжүүлэх боломжийн судалгаа, хэрэгжүүлэх үе шат бүхэнд анхаарвал зохих олон санаа авах байх гэдэгт найдна. Анхаарал хандуулсан гол чиглэл бол сэргээн нутагшуулах хөтөлбөр боловсруулдаг, зөвшөөрдөг, хэрэгжүүлдэг бүх талын хүмүүст практик зөвлөмж болохуйц удирдамж боловсруулахад оршино. Энэ удирдамжийг хэрэгжүүлэх анхаарал хандуулах зорилтот бүлэг бол практик ажилтнууд /хэрэг дээрээ менежерүүд, эрдэмтэд/ бөгөөд засаг, захиргааны шийдвэр гаргагчид бага хамаарна. Засаг захиргааны байгууллагад хандсан удирдамжинд бол эрхзүйн болон улс төрийн агуулгыг илүү гүнзгий тусгах хэрэгтэй болно.

Үндсэн ойлголт

Re-introduction /сэргээн нутагшуулах: Түүхэн тархац нутагт хамаарах боловч янз бүрийн шалтгаанаар устаж, мөхсөн газар нутагт ямар нэг зүйлийг буцаан тавих туршилт.

Re-establishment / сэргээн нутагшуулах: дээрхийн ижил утгатай үг боловч сэргээн нутагшуулах ажил үр дүнтэй болсон байна.

Translocation / шилжүүлэн тавих: Зэрлэгээр амьдарч байгаа бодгаль ба популяцийг тархац нутгийн аль нэг хэсгээс нөгөө хэсэгт тодорхой зорилгоор зориуд шилжүүлэн тавих үйл ажиллагаа

Re-inforcement / Supplementation / сэлбэх нутагшуулалт: Нэгэн зүйлийн бодгалийг тухайн зүйлийн өөр нэг популяцид шилжүүлэн тавих

Conservation/Benign Introduction / хадгалах нутагшуулалт: Ямар нэг зүйлийг хамгаалах шаардлагын үүднээс түүхэн тархац нутгийн гадна, гэхдээ тохиромжтой амьдрах орчин, экологи-газарзүйн бүс нутагт шилжүүлэн тавих үйл ажиллагаа. Энэ арга хэмжээг тухайн зүйлийн түүхэн тархалтын хүрээнд амьдрах тохиромжтой газар үгүй болсон нөхцөлд л хэрэгжүүлнэ.

Сэргээн нутагшуулах хөтөлбөрийн зорилго ба зорилтууд

Зорилго: Сэргээн нутагшуулах аливаа хөтөлбөр нь дэлхий дахинаа болон орон нутгийн хэмжээнд устсан ямар нэг зүйл, салбар зүйл, хэлбэрийн амьдрах чадвартай, бие даан чөлөөтэй амьдардаг популяци үүсгэх зорилготой. Шинээр үүсгэх популяци нь зүйлийн түүхэн тархац нутаг, анхдагч бөгөөд байгалийн аясаараа байгаа амьдрах орчинд хийгдэх бөгөөд аажимдаа менежемент хамгийн бага шаардана.

Зорилтууд: Сэргээн нутагшуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтуудад:

- зүйл урт хугацаанд оршин тогтнох нөхцлийг сайжруулах,
- экосистемд түлхүүр зүйлийг /экологийн болон соёлын үүднээс/ буцаан оруулах,
- байгалийн биологийн олон янз байдлыг хадгалах, нөхөн баяжуулах,
- Орон нутгийн болон үндэсний эдийн засагт урт хугацаандаа ашиг тустай байх,

- Байгаль хамгаалах ухамсарыг дэмжих,
- Аль эсвэл дээрхийн бүх хоршил

Салбар дундын хандлага

Сэргээн нутагшуулах хөтөлбөрт олон салбарын хамтын ажиллагаа шаардлагатай бөгөөд янз бүрийн салбарын хүмүүсээс бүрдсэн холимог багийн нягт хамтын ажиллагааг шаардана. Орон нутгийн өөрийн удирдлагын байгууллагын холбогдох хүмүүсийн зэрэгцээ байгаль, хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлийн төрийн байгууллага, ТББ, элдэв сан, их сургуулиуд, мал эмнэлэг, амьтны хүрээлэн, ботаник цэцэрлэг, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаад зэрэг олон байгууллагын төлөөлөл ажлын хэсэгт ажиллана. Ажлын хэсгийн ахлагч талуудын оролцоог зохицуулж, олон нийтийн болон ухуулга, сурталчилгааны ажлыг хариуцна.

Бэлтгэл ажил

Биологийн арга хэмжээ

1. хэрэгжүүлэх боломжийн судалгаа ба үүдэн гарах үр дагавар

Сэргээн нутагшуулахаар сонгож байгаа бодгалийн ангилалзүйн статусыг тодорхойлох шаардлагатай. Сэргээн нутагшуулах газарт амьдарч байгаад устсан салбар зүйл, растай /хэлбэртэй/ нэгэн ижил ангилалд хамаарах амьтдыг сонгох учиртай. Сэргээн нутагшуулах нутагт амьдарч байсан популяцийн талаар түүхэн мэдээлэлд тулгуурласан судалгаа хийх, популяцийн доторх болон популяци хоорондын генетик хувьслын судалгаа хийнэ.

Сэргээн нутагшуулах газарт тухайн зүйл устаж алга болоод урт хугацаа өнгөрсөн бол дээрх судалгаанд онцгой анхаарах ёстой. Зүйлийн экологийн хэрэгцээ шаардлагаг таньж мэдэхийн тулд байгальд чөлөөтэй амьдарч байгаа популяци дээр нарийвчилсан судалгаа хийнэ. Амьтан нутагшуулахад: амьдрах орчны бичиглэл, зүйлийн доторх хувьсал ба орон нутгийн тодорхой нөхцөлд зохицох байдал, социаль зан төрх, бүлийн зохион байгуулалт, эзэмшил нутгийн хэмжээ, зугатах зай, идэш тэжээлийн хэрэгцээ, идэш тэжээлээ олох зан төрх, хооллолт, дайсан амьтад, өвчин эмгэг зэрэг асуудал хамаарна.

Нутагшуулахаар зорьж байгаа амьтан алга болсноор экосистемд гүйцэтгэх үүргийг нөхөх өөр амьтан бий болсон бол түүнийг тогтоох ёстой. Энэ нь нутагшуулах ажлын амжилтанд шууд хамаатай.

Шинээр бий болж байгаа популяцийн өсөлт/хөгжлийг янз бүрийн нөхцөлд загварчилж, жил бүр нэмж тавих амьтны тоо, улмаар амьдрах чадвартай популяци үүсэхэд хэдэн жил шаардлагатай болохыг урьдчилан тооцоолох

Популяци болон түүний амьдрах орчны амьдрах чадварын шинжилгээ [Population and Habitat Viability Analysis, PHVA] хийж, хүрээлэн буй орчин болон популяцийн баталгаат хувьсагчийн тогтоож, тэдгээрийн боломжит харилцан хамаарлыг үнэлэх замаар популяцийн менежментийг урт хугацаанд удирдан чиглүүлэх боломжтой болно

2. Урьд өмнө явагдсан сэргээн нутагшуулах хөтөлбөр

Сэргээн нутагшуулах хөтөлбөр эхлэхээс өмнө болон зэрэг хэрэгжиж байгаа ижил болон ойролцоо зүйлийн сэргээн нутагшуулах арга хэмжээг сайтар судалж, холбогдох мэргэжилтэн нартай холбоо тогтоож, ажлын арга туршлагаа баяжуулах

3. Амьтан сэргээн нутагшуулах газрыг сонгох ба түүний гол шинж чанар

Сэргээн нутагшуулах газар нутаг тухайн амьтны түүхэн тархац нутагт хамаарсан байна. Популяцийг сэлбэх зорилгоор амьтан нэмж тавих тохиолдолд цөөн тооны бодгаль тухайн нутагт амьдардаг байна. Харин сэргээн нутагшуулах тохиолдолд тухайн нутагт амьтан үлдээгүй байна. Ийм тохиолдолд аливаа өвчин эмгэг дэлгэрэх, социаль бүтэц

алдагдах, харь генийн тархалтаас сэргийлэх ёстой. Сүргийг сэлбэх, аль эсвэл сэргээн нутагшуулах тохиолдолд тухайн зүйлийн түүхэн тархалтын дотор хашаалж тусгаарласан, аль эсвэл өөр аргаар тархалтыг хязгарласан талбайд амьтнаа тавина.

Хадгалан үлдээх, эсвэл “сайн үйлийн” зорилготой нутагшуулалт нь тухайн зүйлийн түүхэн тархалт, тархац нутгийн хүрээнд хийх боломжгүй болсон, нөгөө талаар тухайн зүйлийг хадгалан үлдээхэд зайлшгүй хувь нэмэр болох нөхцөлд л хийгдэнэ.

Шинээр сэргээн нутагшуулж байгаа газар нутаг урт хугацаанд баталгаатай хамгаалагдсан байх /албан болон албан бус байдлаар/

4. Сэргээн нутагшуулах газрыг үнэлэх

Амьдрах орчны тохиромжтой нөхцөл хүрэлцээтэй байх: Сэргээн нутагшуулах ажил тухайн зүйлийн ландшафтын болон амьдрах орчны өвөрмөц шаардлага хангагдсан бөгөөд цаашдаа ч нөхцөл нь хангагдахаар газар хийгдэнэ. Тухайн зүйл устсанаас хойш байгалийн амьдрах орчинд гарсан байж болох өөрчлөлтийг анхааран үзэх хэрэгтэй. Түүнчлэн энэ зүйл устаж алга болсон үеэс хойш гарсан хууль эрх зүй, улс төрийн болон соёлын хүрээний өөрчлөлтийг шинжлэх, ажилд хязгаарлалт үүсгэж болох нөлөөг үнэлэн илрүүлэх ёстой. Сэргээн нутагшуулалтанд сонгон авсан газар нутаг амьдрах чадвартай популяци урт хугацаанд тогтвортой амьдрах хэмжээний экологийн даацтай байх шаардлагатай. Өвчлөл, хэт агналт, хэт ашиглалт, орчны бохирдол, хордолт, өрсөлдөөн, харь зүйлийн дарамт, амьдрах орчны хомсдол, өмнөх судалгаа болон менежментийн хөтөлбөрийн сөрөг нөлөө, гэрийн амьтдын улирлын чанартай өрсөлдөөн зэрэг тухайн зүйл энэ нутгаас алга болоход хүргэсэн шалтгааныг илрүүлэх, түүнийг арилгах, боломжтой хэмжээнд хязгаарлах бодлого хэрэгжүүлэх. Сэргээн нутагшуулахаар сонгон авсан нутаг хүний нөлөөнд хэт автагдсан аваас амьтнаа суллан тавихаас өмнө амьдрах орчныг сэргээн сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай.

5. Сэргээн нутагшуулахад шаардлагатай амьтны хүрэлцээ

Сэргээн нутагшуулах амьтан байгалийн зэрлэг популяциас үүдэлтэй бол маш зохимжтой. Сэргээн нутагшуулах амьтдын сүргийг зэрлэг популяциас авах өргөн сонголт байгаа бол тухайн амьтад сэргээн нутагшуулалт хийхээр сонгосон газар амьдарч байсан уугуул популяцитай удам төрлийн хувьд аль болох ойр, экологийн нөхцөлөөрөө ч ойролцоо /морфолог, физиологи, зан төрх, амьдрах орчны шаардлага/ хэсгээс сонголт хийнэ.

Сэргээн нутагшуулахаар амьтад авах нь хүний асрамжинд байгаа болон байгальд зэрлэгээрээ байгаа популяцийг доройтуулахад хүргэж үл болно. Амьтан барьж байгаа популяци нь урт хугацаанд төслийн хэрэгцээг хангах хэмжээний баталгаатай эх үүсвэртэй байна.

Сэргээн нутагшуулах зорилгоор амьтан барих зэрлэг популяциас амьтан авах нь ямар нэг сөрөг нөлөөгүй болохыг тогтоосны дараа тухайн популяциас амьтан барина. Хүний асрамжинд үржүүлж байгаа, эсвэл зохиомлоор олшруулсан сүргээс амьтан авах нөхцөлд орчин үед амьтан үржүүлэх биологийн заавар журмыг демографийн болон генетикийн хувьд яг таг мөрдөн ажилласан сүргээс авна.

Хүний асрамжинд байгаа сүргээс илүүдэл болсон амьтдыг адгуулах нэг арга хэрэгсэл болгож амьтан сэргээн нутагшуулах ажил хийж болохгүй. Сэргээн нутагшуулах амьтад, түүний дотор засгийн газрын шугамаар илгээх бэлэгийн амьтдыг тээвэрлэхээс өмнө уугуул нутагт нь мал эмнэлэгийн шинжилгээ хийсэн байна. Халдвартай амьтан илэрсэн, эсвэл эндемик биш болон халдвартай үүсгэгчид эерэг үзүүлэлттэй амьтад шинэ популяцид нөлөө үзүүлэх учир тээвэрлэлтээс хасна. Халдваргүй болон сөрөг үзүүлэлт

бүхий амьтдыг дараагийн тест хүртэл тодорхой хугацаанд карангийн байлгана. Давтан шинжилгээ сөрөг гарвал амьтдыг тээвэрлэж болно.

Аюултай халдвар тээвэрлэх явцад, ялангуяа далайн чанадад хийх тээвэрлэлтийн явцад үүсч болзошгүй тул халдвар гарах эрсдлийг багасгахын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай.

Тээвэрлэх сүрэг хүлээн авагч орны мал эмнэлэгийн байгууллагын холбогдох заавар, журамд бүрэн нийцсэн байх ёстой бөгөөд шаардлагатай нөхцөлд карангийн сэргийлэх арга хэмжээ авч болно.

6. Хүний асрамжинд байгаа сүргээс амьтан зэрлэгшүүлэн тавих

Хөхтөн амьтан болон шувуудын олон зүйлийн амьдрах чадвар хувийн туршлага болон залуу насандаа сурсан зүйлээс ихээхэн хамааралтай байдаг. Ийм амьтдыг зэрлэг байгальд дасгахын тулд тусгай дасгал сургуулилтаар дамжуулан байгальдаа дасан амьдрахад тус дэм болох /хамаатай/ мэдээллийг гаршуулсан нөхцөлд олгохыг эрмэлзэх учиртай. Хүний асрамжинд өссөн амьтны амьдрах чадвар түүний зэрлэг удмынхтай дүйцэхүйж байж сая амжилтанд хүрнэ.

Хүний анхаарал халамжинд төрж, өсөн бойжсон бөгөөд аюултай байж болзошгүй амьтад /ж: том махчин амьтад болон сармагчин/ өнөө үед орон нутгийн хүмүүс болон тэдний гэрийн мал, амьтанд эрсдэл үүсгэх учир анхааруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай

Нийгэм-эдийн засгийн болон эрхзүйн шаардлага

Сэргээн нутагшуулах ажил ихэнх тохиолдолд урт хугацаанд үргэлжлэх хөтөлбөр байдаг тул санхүүгийн болон улс төрийн урт хугацааны дэмжлэг шаардана.

Сэргээн нутагшуулах хөтөлбөр нутгийн иргэдэд үзүүлэх нөлөө, зардал, үр ашгийг үнэлэхийн тулд нийгэм-эдийн засгийн судалгаа явуулах шаардлагатай.

Төлөвлөж байгаа сэргээн нутагшуулах төсөл нутгийн иргэдийн хандлагыг анхааралтай үнэлэх нь шинээр бий болох популяцийн хамгааллыг баталгаатай болгох, ялангуяа тухайн амьтны устахад хүний нөлөө /хэт агналт, хэт ашиглалт, амьдрах орчны хомсдол, доройтол/ голлох үүрэг гүйцэтгэсэн бол нэн шаардлагатай. Хөтөлбөрийг нутгийн иргэд ойлгож, хүлээн зөвшөөрч, дэмжих шаардлагатай.

Сэргээн нутагшуулсан популяци хүний үйл ажиллагааны нөлөөнд өртөгдөх эрсдэлтэй газар нутагт энэхүү эрсдэлийг багасгах арга хэмжээ авах шаардлагатай. Энэхүү арга хэмжээ үр дүнгүй бол сэргээн нутагшуулах ажиллагааг зогсоох, боломжтой өөр газар эрэлхийлэх хэрэгтэй болно.

Сэргээн нутагшуулах хөтөлбөр болон сэргээн нутагшуулж байгаа зүйлийн талаарх улс төрийн хандлагыг үнэлэх шаардлагатай. Үүнд олон улсын, үндэсний болон бүс нутгийн хууль, дүрэм журам, түүнчлэн шинээр төлөвлөх арга хэмжээ, шаардлагатай зөвшөөрлийг нягтлан үзэх шаардлагатай.

Сэргээн нутагшуулах хөтөлбөрийг хүлээн авагч болон нийлүүлэгч орны холбогдох талуудын хамтын оролцоо, зөвшөөрөл бүрэн гүйцэт байгаа нөхцөлд л сая ажил хэрэг болгох боломжтой болно. Хөтөлбөр хил залгаа нутагт, хэд хэдэн улс хамтарсан, сэргээн нутагшуулсан популяци өөр улс, муж, газар нутагт дамжих боломжтой бол энэ арга хэмжээ бүр ч чухал болно.

Хэрвээ нутагшуулж байгаа зүйл тухайн нутгийн амьдрал болон өмчийн хэлбэрт болзошгүй эрсдэл үүсгэхээр бол түүнийг багасгах, хохирлын нөхөн төлбөрийг баталгаатай болгох хариу арга хэмжээ төлөвлөх хэрэгтэй. Хэрвээ зохистой шийдэлд хүрэх аливаа оролдлого талаар болбол нутагшуулсан амьтнаа зайлуулах, устгах арга замыг анхааралдаа

авна. Хэрвээ нүүдэллэдэг зүйл аваас олон улсын хил дамнасан арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай.

Төлөвлөлт, бэлтгэл ба нутагшуулах үе шатууд

Харьяалах засаг захиргааны байгууллага болон өмчлөгчийн зөвшөөрөл, үндэсний болон олон улсын байгаль хамгаалах байгууллага хоорондын уялдаа зохицуулалт хийх,

Олон салбарын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулж, нутагшуулах ажлын бүх үе шатны турш мэргэжлийн зөвлөлгөө өгч байх,

Богино хугацааны болон урт хугацааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тогтоосон зорилго, үйл ажиллагааны явцаас хамааруулан хөтөлбөрийн үргэлжлэх хугацааг таамаглах

Хөтөлбөрийн бүх үе шатны туршид хангалттай хүрэлцэх санхүүжилтыг баталгаажуулах,

Сэргээн нутагшуулах ажил нь шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон мэдээллийг шалгах боломжтой туршилт болох учир амьтнаа суллан тавихаас өмнө болон дараа хэрэгжүүлэх мониторингийн хөтөлбөр боловсруулна. Хамгийн чухал нь бодгаль бүрийн эрүүл мэнд, амьдрах чадварыг тогтмол хянах шаардлагатай. Хэрвээ нөхцөл байдал төсөөлж байснаас илүү эерэг хөгжих нөхцөлд ямар нэг оролцоо шаардлагатай болно.

Сэргээн нутагшуулж байгаа, түүний дотор засгийн газрын шугамаар бэлэглэж байгаа амьтдын эрүүл мэнд, генетик төлөвийг сайтар шалгана. Сэргээн нутагшуулж байгаа нутагт байгаа удам төрлийн хувьд ойролцоо зүйлийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих шаардлагатай.

Нутагшуулж байгаа амьтад зэрлэг популяциас гаралтай бол дараах зүйлийг баталгаажуулах: а/ амьтад нь зөөвөрлөхөөс өмнө халдварт болон цусаар дамжих элдэв эмгэг, паразитаар халдварлагдаагүй болохыг тогтоох, б/ сэргээн нутагшуулж байгаа амьтад уугуул нутагт нь байж болох элдэв өвчин дамжуулагчийн завсрын эзэн байхгүй болохыг батлах, нөгөө талаар олдмол дархлаа үүсээгүй гэдгийг батлах шаардлагатай.

Сэргээн нутагшуулах амьтан авах нутгийн зэрлэг болон гэрийн амьтдад орон нутгийн чанартай эндемик болон халдварт өвчний эсрэг тарилга хийх бол бэлтгэл үе шатанд хийнэ. Ингэснээр дархлаа үүсгэхэд хангалттай цаг хугацаа баталгаатай болно.

Хөтөлбөр хэрэгжүүлэх явцад нутагшуулах амьтдын эрүүл мэндийг баталгаатай хангахын тулд мал эмнэлгийн болон цэцэрлэгжүүлэлтийн арга хэмжээг шаардлагын дагуу авна. Ялангуяа эх сүрэг нутагшуулах газар хүртлээ алс газар зөөвөрлөгдөх, эсвэл олон улсын хил нэвтрэх бол карантиний зааврыг анхааран үзэх шаардлагатай.

Амьтнаа нутагшуулах газар, оронд хүргэхийн тулд тээвэрлэх төлөвлөлтөө сайн хийх шаардлагатай. Энэ тохиолдолд тээвэрлэх явцад учирч болох стрессийг багасгах боломжийг хангахад илүү анхаарна.

Нутагшуулах стратегийг боловсруулах /нутагшуулах газар амьтнаа тавих, ан хийх болон хооллох зан төрхийн сургалт, сүргийн бүтэц, амьтны тоо хэмжээ, нутагшуулах болон нутагшуулах техникийн явц, цаг хугацааны төлөвлөлт/

Интервенц /хөндлөнгийн оролцоо/хийх явцыг төлөвлөх

Урт хугацааны дэмжлэг олохын тулд хүрээлэн буй орчны боловсролын хөтөлбөр боловсруулах, нутагшуулах урт хугацааны хөтөлбөрт оролцох хүмүүсээ сайтар мэргэшүүлэх; олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан нийтийн дунд мэдээлэл хүргэх, боломжтой бүх үе шатанд орон нутгийн хүмүүсийг хөтөлбөртөө оруулах,

Сэргээн нутагшуулах бүх үе шатны туршид суллан тавьж байгаа амьтдын тав тухыг хангахад дээд зэргээр анхаарах,

Нутагшуулалтын дараа хийх арга хэмжээ

Нутагшуулсны дараа бүх амьтнаа /эсвэл зарим хэсгийг/ хянаж байх нь нэн чухал. Энэ арга хэмжээг шууд /амьтнаа тэмдэглэх, телеметр/, эсвэл шууд бусаар /амьтны ул мөрийг бүртгэх, мэдээлэгчээр дамжуулах/ хийж болно.

Нутагшуулсан амьтны демографи, экологи, зан төрхийн судалгааг хийх,

Бодгаль болон популяцийн аажим дасан зохицох үйл явцыг судлах,

Үхэл хорогдлын талаар мэдээлэл цуглуулах, судлах

Шаардлагатай бол нэмэлт арга ажиллагаа /Интервенц /хийх (ж: нэмэлт тэжээл, мал эмнэлгийн тусламж, цэцэрлэгжүүлэлтийн арга хэмжээ)

Цаг хугацааны шинэ төлөвлөлт хөгжүүлэх, шаардлагатай бол хөтөлбөрийг зогсоох,

Шаардлагатай бол амьдрах орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэх,

Тал бүрийн мэргэжлийн оролцоотой тайлбар хийх зэргээр олон нийтийн дунд зохиох ажлыг үргэлжлүүлэх,

Сэргээн нутагшуулах техникийн амжилт болон зардлын үр ашгийг үнэлэх,

Шинжлэх ухааны болон танин мэдэхүйн ном гарын авлага тогтмол хэвлүүлэх, зэрэг болно.

4.4. АМЬТАНТАЙ ХАРЬЦАХ АЖИЛТНУУДЫН ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ ҮНДСЭН

МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДАЛ

Зэрлэг амьтадтай харьцах ажилтнуудын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар.

Зэрлэг амьтдыг хамгаалах үйл ажиллагааны үр дүн, амжилт нь хэдийгээр олон хүчин зүйлээс хамаарах ч хамгийн чухал нь тэнд ажиллагсдын суурь мэдлэг, мэргэжлийн ур чадвар, эрхэлсэн ажилдаа хандах хандлагаас ихээхэн хамааралтай. Ер нь амьтан судлах, хамгаалах үйл ажиллагаа бол ёс зүй, амьтан судлал, байгаль хамгааллын биологи, экологи, этологи, мал эмнэлэг, эм зүй, халдвар судлал гэх зэрэг олон шинжлэх ухааны суурь мэдлэг, ур чадвар шаардцаг нарийн нийлмэл үйл явц юм. Ямар ч тохиолдолд амьтдын анатоми, морфологи, амьтны аймгийн ангилал зүй, биологи, экологи, зан төрх, зэрлэг амьтантай харьцах, амьтдыг аврах, асран сувилах, эмчлэх талаарх зохих түвшний суурь мэдлэг, чадвар дадал эзэмших нь тухайн хүнд амьтан бүрийг илүү сайн асарч хамгаалах боломжийг нээдэг.

Ийнхүү суурь мэдлэг эзэмшин зэрлэг амьтдыг судлах, асрах, хамгаалах үйл ажиллагааг ойлгож ухаарна гэдэг бол зөвхөн хувь хүнд төдийгүй ерөөс энэ үйл ажиллагааг үр дүнтэй эрхлэн явуулахад чиглэсэн маш ухаалаг хөрөнгө оруулалт юм. Энэ нь дараа дараагийн мэдлэг, чадварыг хөгжүүлэх суурь нөхцөл болох ба амьтан аврагчдыг зэрлэг амьтдад маш чанартай асаргаа, үйлчилгээ үзүүлэхэд чадавхжуулах үндсэн хүчин зүйл болно.

Эзэмшсэн мэдлэг, чадвар нь шинжлэх ухааны үндэстэй байхын зэрэгцээ амьтан асрах, хамгаалах ажил үйлчилгээнд хэрэгжиж үр дүнтэй нь нотлогдсон байх нь чухал. Амьтан асрах, хамгаалахад шаардлагатай мэдлэг, чадварыг мэргэжлийн сургалтаас гадна, ажлын байрны сургалт, мэргэжлийн семинар зөвлөгөөн, мэргэшүүлэх сургалт, ижил төрлийн ажил, үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран ажиллаж, туршлага судлах зэрэг олон арга, хэлбэрээр эзэмших боломжтой. Эцсийн дүндээ тухайн хүн амьтан асрах, хамгаалахад хэрэгтэй мэдлэг, чадварыг эзэмшихийн тулд ажилдаа чин сэтгэлээсээ хандан, өөрийн нөөц бололцоогоо бүрэн дайчилж ажиллах чадвартай байх ёстой. Амьтан судлах, асрах,

хамгаалах үйл ажиллагааг эрхлэн явуулахад тухайн хүн дараах чиглэлээр зохих түвшний мэдлэг, чадварыг зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай. Үүнд:

Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах тухай ерөнхий мэдлэг. Амьтан асрах, хамгаалах гэж юу болох, ямар тохиолдолд амьтдыг энэ үйл ажиллагаанд хамруулдаг, уг үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэх арга, аргачлал, баримтлах зарчмын талаар анхан шатны мэдлэг, чадвар эзэмшсэн байна.

Хууль, эрх зүйн мэдлэг. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай зэрэг хуулиуд болон мал, амьтны эмчилгээ, оношилгоо, асаргаа, ариун цэвэр, хорио цээр, халдваргүйжүүлэлтийн талаарх дүрэм, журам, заавар, стандарт зэрэг зэрлэг амьтдыг асрах, хамгаалахад шууд хамааралтай эрх зүйн баримт бичгүүдийн үзэл, санаа, агуулгыг эзэмшиж үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлэх чадвартай байна.

Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах ёс зүй. Амьтны жам ёсны эрхийг хүндэтгэн, хангах шаардлагад нийцсэн ёс зүйн үндсэн зарчмыг бүрэн эзэмшсэн, түүнийгээ амьтан асрах, хамгаалах ажил үйлчилгээний үе шат бүхэнд чанд сахин мөрдөх чадвартай байна. Ер нь төрөл бүрийн шалтгааны улмаас өвчилсөн, өнчирсөн, зовж шаналж буй амьтдыг асран сувилж, тэдэнд амь, амьдрал бэлэглэнэ гэдэг бол тухайн хүнээс ихээхэн тэвчээр, сэтгэлийн хат, энэрэнгүй нинжин сэтгэл, хичээл зүтгэл шаардсан нарийн чимхлүүр ажил гэдгийг ухаарсан байх ёстой.

Амьтны аймгийн талаарх суурь мэдлэг, чадвар. Тухайлбал, амьтны аймгийн ангилал зүй, анатоми, морфологи, физиологи, биологи, экологи, зан төрх зэрэг биологийн суурь болон хавсарга ухааны мэдлэг, чадвар эзэмшсэн байна гэсэн үг. Хүний тусламж шаардлагатай амьтад ямар төрөл зүйлд хамаарах, түүний зан төрхийн онцлогт үндэслэн тухайн амьтны хэрэгцээ, шаардлагад нийсэн ямар байр оромжид байршуулах, хоол тэжээлийн орц, найрлага, тэжээх, цочролоос урьдчилан сэргийлэх арга техник гэх мэт тулгамдсан олон асуудлыг оновчтой шийдвэрлэн, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авч хэрэгжүүлэхэд энэ талын мэдлэг, чадвар үлэмж тус дэм болно.

Эмчилгээ, үйлчилгээ, сувилгааны талаарх мэдлэг, чадвар. Зэрлэг амьтдыг стрессээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэднийг осол аюулгүй барих, тээвэрлэх, үзлэг хийж биеийн ерөнхий байдал, бэртэл гэмтлийг тодорхойлох анхан шатны арга барил эзэмшсэн байна. Малын эмч, мэргэжилтний заавар зөвлөмжийн дагуу амьтдыг эмчлэх, асран сувилах талаар зохих мэдлэгтэй, тэдгээрийг гардан гүйцэтгэх чадвартай байна. Ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг хэрхэн хангах, ариутгал, устгалын ач холбогдол, тэдгээрийг хэрхэн гүйцэтгэх арга барилд суралцсан байна. Ялангуяа,

- Амьтны зан төрхийн онцлог, түүний өөрчлөлт, саатлыг илтгэх шинж тэмдгийн тухай
- Амьтанд шаардлагатай хоол тэжээл, усны хэмжээ, шаардлагын тухай
- Өвчнийг таних шинж, ялангуяа халдварт өвчний тухай
- Эрүүл бус байдлыг илтгэх шинж тэмдэг, түүний эсрэг авах арга хэмжээний тухай
- Барих, тээвэрлэх, зөөх үед амьтанд ээлтэй арга барил хэрэглэх
- Амьтан хамгаалах шаардлагад нийцсэн барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн тухай

- Амьтанд ээлтэй аргаар амьтныг суллан тавихтай холбогдсон мэдлэг, зэргийг зохих түвшинд зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай.

Зэрлэг амьтан судлах, асрах, хамгаалах чиглэлээр ажиллагсдыг мэргэшүүлэх боломж. Биологи, экологи, байгаль хамгаалал, мал эмнэлэг зэрэг мэргэжлийн сургалтын хөтөлбөрт амьтан аврах, асран хамгаалахад шаардлагатай суурь хичээлүүдийг тодорхой түвшинд судалдаг. Иймд дээрх чиглэлээр суралцаж, мэдлэг, чадвар эзэмшсэн хүмүүсийг мэргэшүүлэх сургалтад хамруулах замаар амьтан судлах, асрах, хамгаалах чиглэлээр мэргэшсэн ажиллагсдыг бэлтгэх бүрэн боломжтой.

Дэлхийн олон улс орнуудын туршлагаас үзвэл, зэрлэг амьтан асрах, хамгаалах тусгай мэдлэг, ур чадварыг олгоходоо тухайн хувь хүний амьтны төлөөх хүсэл, сонирхол, эзэмшсэн суурь боловсрол, мэдлэг, туршлагад нь тулгуурлан богино хугацааны сургалт, семинар, зөвлөгөөн зохион байгуулах, харилцан туршлага судлах зэрэг хэлбэрүүдийг өргөнөөр ашигладаг байна. Тухайлбал:

- Зэрлэг амьтан асран хамгаалж, дахин нутагшуулахтай холбоотой ном, сэтгүүл, судалгааны материалуудыг бие даан уншиж, судлах
- Олон улсын болон үндэсний хэмжээд баримтлах стандартуудын талаар семинар зохион байгуулах
- Мэргэжлийн байгууллагуудаас эрхлэн зохион байгуулж буй сургалт, семинар, зөвлөгөөнд хамруулах
- Байгаль, амьтан хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон олон улсын төрийн ба иргэний нийгмийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй амьтан хамгаалах төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан бүс нутгийн амьтны төрөл зүйл хийгээд ховордсон биологийн төрөл зүйлүүдийг аврах, асран хамгаалах арга барилд сургах
- Тэдгээр төрөл зүйлүүдийн талаарх зарим мэдээллийг мэргэжлийн хүмүүсийн тусламжтайгаар сурч мэдэх, тэдгээрийг асран хамгаалахад шаардагдах мэдээллийг цуглуулах, олсон мэдээллүүдийг боловсруулан эмхэтгэх зэргийг дурдаж болно.

4.5. АМЬТАН СУДЛАХ, АСРАХ, ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СТАНДАРТЧИЛЛЫН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ

Стандарт бол ямар нэгэн үйл ажиллагааны бүтээмж болон үр дүнг сайжруулахад чиглэсэн, амьдралд үр дүнтэй болох нь батлагдаж, шалгарсан аргын нэг юм. Аливаа стандартыг чандлан мөрдөх нь тухайн байгууллагад үйл ажиллагааныхаа үзүүлэлтүүдийг дээшлүүлэх, эрсдэлээ бууруулах, тогтвортой байдлыг хангах, байгаль орчны аюулгүй байдлыг хангах, хүнсний аюулгүй байдал болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зэргээр ач тус үзүүлдэг. Ямар ч үйл ажиллагаа эрхэлж байгаа жижиг том, төрийн болон төрийн бус, хувийн хэвшил, сайн дурын бүх байгууллага өрсөлдөх чадвараа дээшлүүлэх зорилгоор стандартыг хэрэгжүүлдэг. Энгийн үгээр тайлбарлавал, стандарт гэдгийг аливаа үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, алдаа эндэгдэлгүй ажиллах арга зам гэж ойлгож болно.

Манай улсад стандарт болон түүнтэй холбоотой бүхий л харилцаа “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” хуулиар зохицуулагддаг. Энэ хуульд “стандарт гэж тодорхой хүрээнд хэм хэмжээ бий болгоход чиглэсэн ерөнхий зарчим, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж

баталсан, сонгон хэрэглэх баримт бичиг” хэмээн тодорхойлсон байдаг. Үүнээс үзвэл, стандарт гэдэг нь аливаа үйлчилгээ, үйл ажиллагааны хангавал зохих наад захын жишиг хэм хэмжээ, шаардлагыг тогтоосон баримт бичиг юм. Үндэсний стандартыг боловсруулахдаа шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололт амжилт, практикийн үр дүн, олон улсад мөрдөж буй стандартын шаардлага, хэм хэмжээг суурь болгох зарчим баримталдаг.

Зэрлэг амьтдыг асрах үйл ажиллагаа нь анх шархадсан эсвэл өнчирсөн зэрлэг амьтдыг эмчилж, тэнхрүүлээд байгальд нь буцааж тавьдаг энэрэнгүй сайхан сэтгэлтэй хүмүүсийн ач буянаар, сайн дурын үүсгэл санаачилгын хүрээнд эхэлсэн байдаг. Энэ үйл ажиллагаа нэг хэв маягаар олон жил үргэлжилж, арвин баян мэдээ баримт, туршлага хуримтлуулснаар зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалахад чиглэсэн мэдлэгийн санг бүтээсэн байна. Хүн төрөлхтний ийнхүү танин мэдэж бүтээсэн мэдлэг, чадвар, туршлагад үндэслэн зэрлэг амьтдыг асрах, хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй эрхлэн явуулах, уг үйл ажиллагааг тодорхой стандартын дагуу гүйцэтгэх, амьтны жам ёсны эрхийг хангах зэрэг олон шаардлага амьдралаас урган гарчээ.

Зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалахад дагаж мөрдөх хамгийн бага (наад захын) стандартыг анх 1980-аад оны дундуур АНУ-д төвтэй Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах Олон улсын зөвлөл (International Wildlife Rehabilitation Council) болон Зэрлэг амьтан аврах, асран хамгаалагчдын үндэсний холбоо (National Wildlife Rehabilitators Association) санаачилж хамтран боловсруулсныг өдгөө Дэлхийн олон улс оронд жишиг болгон мөрдөж байна. Өнгөрсөн 40 шахам жилийн хугацаанд уг стандартыг 4 удаа шинэчлэн сайжруулж, олны хүртээл болгосон байдаг.

Монгол Улсын тухайд хүн амын төвлөрөл, суурьшил, хотжилт хүрээгээ тэлж, дэд бүтцийн барилга байгууламж, уул уурхайн үйлдвэрлэл өсөн нэмэгдэж, цас зуд, ган гачиг, үер ус, ой, тал хээрийн гал түймэр зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас хамаарч байгалийн зэрлэг амьтдад үзүүлэх тусламж үйлчилгээний хэрэгцээ, шаардлага, энэ ажлын цар хүрээ байнга нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, суурин болон зөөврийн амьтны хүрээлэн, минж үржүүлэх төв, тарвага, буга болон бусад амьтдыг сэргээн нутагшуулах, бэртэж гэмтсэн хөхтөн, шувуудыг авран хамгаалах, урт богино хугацаагаар тэжээн тэнхрүүлэх, зөөж тээвэрлэх, байгальд суллан тавих ажил тодорхой түвшинд хийгдэж эхлээд байна. Үүний нэг жишээ бол нийслэлийн Байгаль орчны газраас санаачлан 2017 оны 11 дүгээр сард байгуулсан "Зэрлэг амьтан асрах төв" юм. Үүнийг одоогоор манай улсад амьтан аврах, асран хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй цорын ганц байгууламж хэмээн үзэж болно.

Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүсэд газар олгож, нийслэл маань хаяа тэлэхийн хэрээр хотын ногоон бүсийн зэрлэг амьтдын тархац нутаг хумигдаж зэрлэгшсэн нохойд хөөгдөх, торон хашаанд сүлбэгдэх, идэш тэжээл хайн хот руу тэнүүлчлэн орж ирэх, иргэд хууль бусаар амьтдыг барин тэжээж байгаад гэмтээх юм уу алдах, машинд дайруулах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх, элдэв өвчинд нэрвэгдэх, шувуудын үр төл унаж бэртэх тохиолдол жил ирэх тусам нэмэгдэж, ард иргэдээс мэдээлэх, дуудлага өгөх үйл явц эрчимжсэнтэй уялдан энэхүү төвийг байгуулах зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүсжээ. Өнгөрсөн 3 жил гаруйн хугацаанд дээрх төв нийтдээ 112 амьтны холбоотой дуудлага, мэдээлэл хүлээн авснаас 47 бодгаль амьтныг "Зэрлэг амьтан асрах төв"-д эмчлэн, асарснаас 30-ийг нь байгальд буцаан тавьж, 17 нь аргагүй шалтгааны улмаас хорогджээ. Харин 65 амьтанд газар дээр нь тусламж, үйлчилгээ үзүүлээд суллан тавьсан байна. Энэ ажлыг эрхлэн гүйцэтгэх явцад цаашид анхаарч шийдвэрлэх шаардлагатай олон

асуудал тулгарчээ. Тухайлбал, уурга, сачок, могойн уурга, нойрсуулагч буу, амьтан барих тор зэрэг зэрлэг амьтан барих, зөөвөрлөх зэрэгт шаардлагатай наад захын багаж хэрэгсэл байхгүйгээс барих явцдаа амьтнаа гэмтээж бэртээх, зөөвөрлөх үед алдах эрсдэл үүссэн байна. Мөн гэмтсэн амьтдыг уг төвд эмчлэн, асрахад шаардлагатай эм бэлдмэл, идэш тэжээлийн хүрэлцээ муу, батлагдсан төсөв байхгүй зэрэг санхүүгийн хүндрэл ч багагүй тохиолджээ. Түүнчлэн амьтан асрах төвд байлгаж эмчлэн, сувилах шаардлагатай амьтдын байр оромжийн хүрэлцээ, зохистой хэмжээ, ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг хэрхэн сахих, унд, тэжээлийн орц, найрлага, тэжээх хэмжээ, давтамж, хүн нэг бүрийн хамгаалах хувцас, хэрэгсэл, амьтан тээвэрлэх тээврийн хэрэгсэл гэх зэрэг олон тулгамдсан асуудлуудтай нүүр тулжээ. Нөгөө талаас ажиллагсад маань хэдий сэтгэл зүтгэл гарган хоёргүй сэтгэлээр хичээж байгаа ч байгалийн зэрлэг амьтдыг аврах, эмчлэх, асран сувилах арга, туршлага дутах тал ч бас гарч байна.

Эдгээр болон бусад нөхцөл байдлын улмаас амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах хууль эрх зүй, аж ахуйн зохион байгуулалт, эмнэлгийн үйлчилгээ, тэжээллэг, санхүүжилт, хяналтын ажлыг цаг алдаж хойшлуулалгүй эхлэх, улмаар олон улсын жишигт ойртуулах бодит хэрэгцээ шаардлага нэгэнт бий болсон байна.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санаачилга, санхүүжилтээр зохион байгуулсан “Амьтан авран хамгаалах бүсийн хэмжээний төв байгуулах үндэслэл, шаардлага” хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж болон Алтай Соёны бүс нутагт “Амьтан авран хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж нөхцлийг судалж, зөвлөмж боловсруулах” ажлын үр дүн, зөвлөмж, дэлхийн олон улс орнуудын сайн туршлагыг тус тус үндэслэн Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага, Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хөхтөн амьтдад тавих тусгай шаардлага, Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Шувуу аврах, асран хамгаалах тусгай шаардлага, Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хоёр нутагтан, мөлхөгчдөд тавих тусгай шаардлага гэсэн багц стандартууд боловсруулсан байна.

Дээрх стандартууд бол амьтан авран хамгаалагчид нь юуг хийж болох, юуг хийж болохгүй, өвдөж зовж шаналсан, өнчирч хагацсан амьтдыг өөрсдийн үүрэг хариуцлагын хүрээнд чанарын өндөр түвшинд асран халамжлахын тулд юу юу хийж хэрэгжүүлэх шаардлагатай, техник, технологийн нэн хурдацтай хөгжил, дэвшлийн эрин үед зайлшгүй хийгдэх алхмууд гэх мэт зүйлүүдийг багтаасан үйл ажиллагааны цогц удирдамж юм. Эдгээр багц стандартын үндсэн үзэл санаа, агуулгыг дор товч авч үзлээ.

Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага.

Энэ стандартын үндсэн зорилго нь Монгол орны нутаг дэвсгэрт идээшин амьдарч буй хүний тусламж, дэмжлэг шаардлагатай болсон зэрлэг амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааны үндсэн чиглэл, байр, оромжид тавих ерөнхий шаардлагыг тодорхойлж, тэдгээр амьтдыг эмчилж, асран тэнхрүүлж, бие даан амьдрах чадвартай болсон үед байгальд нь буцаан тавих замаар зэрлэг амьтдыг хамгаалах, тэдгээрт учирч буй эрсдлийг бууруулах явдал болно.

Тус стандартыг зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, хяналт шалгалтын болон экологи, байгаль хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагууд үйл ажиллагаандаа чиглэл, мөрдлөг болгон хэрэглэнэ.

Уг стандартаар амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа эрхлэхэд тавих ерөнхий шаардлагыг тодорхойлсон байна. Мөн амьтдын байр оромжийн экологийн нөхцөл, уг үйл ажиллагааг эрхлэгчдийн мөрдөх нийтлэг хэм хэмжээ, амьтны эмчилгээ, маллагаа, асаргаанд тавих үндсэн шаардлагуудыг тус тус тодорхойлжээ.

Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хөхтөн амьтдад тавих тусгай шаардлага. Стандартын үндсэн зорилго нь өвдсөн, гэмтсэн, шархадсан, өнчирсөн, эхээсээ салсан нялх төл зэрэг олон янзын шалтгааны улмаас хүний тусламж, оролцоо зайлшгүй шаардлагатай болсон зэрлэг хөхтөн амьтдыг аврах, түр асрах, байгальд суллан тавих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх, энэ үйл ажиллагаанд төрийн ба төрийн бус байгууллага, иргэдийн оролцооны хэм хэмжээг тогтооход оршино.

Зэрлэг хөхтөн амьтдыг аврах, асран хамгаалахад ашиглах байр оромж, хайрцаг, сав, тор, хашаанд тавих үндсэн шаардлага, тэдгээрт амьтдыг хэрхэн байршуулах, тэжээх, арчлан маллах, эмчлэх, зөөж тээвэрлэхтэй холбогдсон хэм хэмжээг ангилал зүйн болон экологийн адил төстэй байдлыг харгалзан (1) шавж идэштэн, гар далавчтан, (2) туулай хэлбэртэн, мэрэгчид, (3) мах идэштэн, (4) туруутан, туурайтан, тавхайтан гэсэн 4 үндсэн бүлгээр авч үзсэн байна.

Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Шувуу аврах, асран хамгаалах тусгай шаардлага. Хүний тусламж, оролцоо зайлшгүй шаардлагатай болсон шувуудыг аврах, асрах, тоо толгойг өсгөн олшруулах, энэ үйл ажиллагаанд төрийн ба төрийн бус байгууллага, иргэдийн оролцооны хэм хэмжээг энэ стандартаар тодорхойлсон байна.

Шувууг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд тэдний бусдаас ялгарах зарим өвөрмөц онцлогуудыг харгалзан үзэх зайлшгүй шаардлагын үүднээс уг үйл ажиллагаанд ашиглах байр оромж, хайрцаг, сав, тор, хашааны хэмжээ, тэдгээрийн экологийн нөхцөл, тэнд шувуудыг хэрхэн байршуулах, тэжээх, арчлан маллах, эмчлэх, зөөж тээвэрлэхтэй холбогдсон хэм хэмжээг ангилал зүйн болон экологийн адил төстэй байдлыг харгалзан (1) бор шувууны баг, (2) галуу, нугас болон ус намгийн бусад шувууд, (3) тагтаа, (4) өдрийн махчин болон ууль, (5) тогоруу, (6) тахианы багийн шувууд гэсэн 6 үндсэн бүлгээр авч үзсэн байна.

Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаа. Хоёр нутагтан, мөлхөгчдөд тавих тусгай шаардлага. Хүний тусламж, оролцоо зайлшгүй шаардлагатай болсон хоёр нутагтан, мөлхөгч амьтдыг эмчлэх, асрах, тоо толгойг өсгөн олшруулах, энэ үйл ажиллагаанд оролцох төрийн ба төрийн бус байгууллага, иргэдийн хэм хэмжээг энэхүү стандартаар тодорхойлсон байна. Тухайлбал, уг стандартад хуурай газрын хүйтэн цуст нугаламт амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд тэдний амьдрах байр оромж, түүний экологийн нөхцөл ямар байх, энэ бүлэг амьтдыг тэжээх, асрах, харьцах, тээвэрлэхэд ямар хэм хэмжээ баримтлах тухай асуудлуудыг анги тус бүрээр авч үзжээ.

4.6. ЗЭРЛЭГ АМЬТНЫ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ҮНДСЭН

ОЙЛГОЛТ

Зэрлэг амьтан асрах, хамгаалах цогц үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг бол хүний тусламж шаардлагатай болсон тэдгээр амьтдад үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ юм. Амьтан асрах, хамгаалахад чиглэсэн эмнэлгийн бүх төрлийн үйлчилгээг гагцхүү малын эмч л гардан гүйцэтгэж, холбогдох заавар зөвлөмжөөр ханган, гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлэн цэгнэх учиртай. Өөрөөр хэлбэл, хүний тусламж шаардлагатай болсон аль нэг

амьтанд чухам яг ямар үйлчилгээ хэрэгтэйг оношлон тогтоох, түүнийг хаана, ямар аргаар эмчлэх, хэрхэн асарч тордох, үр дүн нь ямар болсон, байгальд нь буцаан тавьж болох эсэхийг зөвхөн мал, амьтны эмч л бие даан шийдвэрлэнэ.

Аврах, асрах хэрэгцээ бүхий амьтдад үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ гэдэг бол тухайн амьтанд анхан шатны үзлэг хийх, оношлох, мэдээ алдуулах, анхан шатны тусламж үзүүлэх, боловсруулсан төлөвлөгөө, аргачлалын дагуу эмчлэх, физиологи, биохимийн үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд амьтныг зориудаар амь хороон унтуулах, элдэв шалтгаанаар үхсэн амьтны хүүр, сэг зэмийг устгалд оруулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, хорио цээр тогтоох, тусгаарлах зэрэг олон төрлийн үйл ажиллагааг хамарсан нэн нарийн нийлмэл үйл явц юм. Эмнэлгийн үйлчилгээ нь хэдийгээр амьтан аврах, асран хамгаалах чиглэлээр ажиллаж буй мал, амьтны эмч мэргэжилтний хийж гүйцэтгэх үндсэн үүрэгт ажил боловч амьтан аврах, асран хамгаалах салбарт ажиллаж буй амьтан маллагчид болон үйлчилгээний бусад ажиллагсад энэ талын ойлголт, мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай. Ийм ч учраас энэхүү бүтээлд зэрлэг амьтанд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээний зарим асуудлыг дээр дурьдсан ажилтнуудад зориулан нэн ерөнхий байдлаар тоймлон авч үзэв.

Ирсэн амьтанд нэн тэргүүнд эмнэлгийн ерөнхий үзлэг хийнэ. Энэ ажиллагаа анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх юм уу эмчилж эдгэрүүлээд байгальд буцааж тавих боломж байгаа эсэх, эс бөгөөс амьтан хамгаалах шаардлагад нийцсэн аргаар унтуулах шаардлагатай эсэхийг тогтооно.

Анхан шатны үзлэг

Энэ бол аврах, асрах шаардлагатай болсон амьтдад үзүүлэх эмнэлгийн хамгийн анхан шатны үйлчилгээ юм. Энэ үйлчилгээг ихэвчлэн эмч мэргэжилтэн үзүүлнэ. Амьтны эмч анхан шатны үзлэг хийж урьдчилсан оношилгоо тогтоохын тулд тухайн зэрлэг амьтдын тухай зохих мэдээлэлтэй байх нь илүү үр дүнтэй. Үүний тулд эмч, мэргэжилтэн нь хүний туслалцаа шаардлагатай болсон амьтан байгаа газарт тодорхой хугацаанд очих, эсвэл мал эмнэлэгт өвчтөнийг тээвэрлэж аваачих, холбогдох мэдээллийг аль болох дэлгэрэнгүй өгөх гэх мэтээр харилцаатай байж өвчтөний ерөнхий нөхцөл байдалтай танилцах боломжийг бүрдүүлнэ.

Зэрлэг амьтанд анхан шатны үзлэг хийх, тусламж үзүүлэх нь амьтанд их хэмжээний хямрал үүсгэдэг. Амьтны төрөл зүйл, биеийн хэмжээ, нас, хүйс, зан төрхийн онцлогоос хамаарч амьтны гаргах хариу үйлдэл нь асрамжлагч ба үзлэг хийж буй мэргэжилтэнд эрсдэл учруулах магадлал өндөр тул анхан шатны тусламж үзүүлэхдээ амьтнаа аль болохоор хямралд оруулахаас сэргийлэх, булчин сулруулах ба тайвшруулах эм тариа ашиглах, том хэмжээний буюу аюултай амьтантай ганцаар ажиллахгүй байх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Тусламж шаардлагатай амьтантай аль болохоор богино хугацаанд харьцах, аюулгүй байдлыг хангах үүднээс алчуур даавуунд ороох, нүдийг боох, тариа тарих зэргээр тайвшруулах нөхцлийг хангана. Зөвөөрлөх хайрцаг сав, даавуу зэргийг урьдчилан бэлтгэсэн байна. Том махчин амьтан, галзуу, боом болон бусад халдварт өвчний шинж, тэмдэг илэрч байгаа, хорт могой, сарьсан багваахай зэрэг өндөр эрсдэлтэй амьтанд зөвхөн мал, амьтны эмч мэргэжилтэн хүрч ажиллах юм уу эсвэл түүний өгсөн заавар, зөвлөмжийн дагуу холбогдох бусад ажил мэргэжлийн хүмүүс оролцон ажиллана. Эмчилгээ шаардлагатай амьтдын жинг мэдэх нь эмийн тун тогтооход хэрэгтэйг анхаарна уу.

Шаардлагатай хэмээн үзэж буй амьтанд анхан шатны үзлэгийг малын эмч бусад ажиллагсадтай хамтран хийж, тухайн амьтны төрөл зүйл, нас хүйс, эрүүл мэндийн төлөв байдал зэрэг мэдээллийг баримтжуулна. Амьтан хүлээн авсан тухай бүртгэл хийж зураг авч, анхан шатны үзлэгийг дараах чиглэлээр шат дараалан явуулна. Үүнд:

1. Нүд нь хараатай эсэх
2. Хамрын сүвэнд нь цус, салс байгаа эсэх
3. Амьсгалын онцлог (амаар, хамраар, чанга дуугаар), нэг минут дахь амьсгалын тоо
4. Чихэнд цус, паразит хачиг байгаа эсэх. Сонсгол шалгах.
5. Зогсолт, хэвтэлт хэвийн байгаа эсэх
6. Биеийн бүрэлдэхүүн хэсгүүд бүрэн бүтэн, хэвийн өсөлттэй эсэх
7. Амьтан хэвийн хөдөлж чадах эсэх
8. Амьтны биед эктопаразит байгаа эсэх
9. Амьтанд эндопаразит байгаа эсэх
10. Амьтны үс, өдөн бүрхүүл, хайрс нь бүтэн бөгөөд эрүүл байгаа эсэх
11. Амьтны биед ямар нэгэн шарх, сорви, гэмтэл байгаа эсэх. Шархтай тохиолдолд шинэ хуучныг цусны бүлэгнэлт өнгө зэрэг дээр тулгуурлан тогтоох.
12. Амьтны бөгсөн бие цэвэр эсэх, муухай үнэр бий эсэх
13. Амьтны зан төрхийн байдал (сэргэлэн цовоо, сул дорой г.м)
14. Биеийн халууныг хэмжих, гипотерм, гипертермид орсон эсэх
15. Усны дутагдалд орсон үгүйг тогтоох (арьс таталтын арга, салст бүрхүүлийн байдал)
16. Зүрх судасны үйл ажиллагаа (зүрхний цохилт), цус багадалтын шинж тэмдэг байгаа эсэх (хамар, ам, нүдний салст бүрхэвчийн өнгө)
17. Хивэгч амьтан дээр хивэлт хэвийн явагдаж буйг тогтоох
18. Цусны дээж авах (цусны түрхэц, бүхэл цус ба EDTA дахь цус). Цусны дээж хадгалах горим нь -20 хэм, -70 хэм, шингэн азотын орчинд
19. Ялгадасны дээж авах зэргийг нэн түрүүнд анхаарч үзлэг хийнэ.

Шийдвэр гаргах нь

Анхан шатны үзлэгийн үр дүнд мал, амьтны эмч юм уу мэргэжлийн ажилтан дараах шийдвэрийн аль нэгийг бие даан гаргана. Үүнд:

1. Тухайн амьтанд эмнэлгийн анхан шатны шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлсний дараа цаашид бие даан амьдрах боломжтой хэмээн үзээд байгальд болон хашаанд нь буцаан тавих
2. Анхан шатны үзлэгээр доор дурдсан нөхцөлүүдээс аль нэг нь, эсвэл хэд хэд нь илэрч байгаа амьтныг асран хамгаалах шаардлагатай гэж үзнэ. Үүнд:
 - Хүндээр өвчилсөн амьтан (үзлэгийн үед ямар нэг халдварт өвчин туссан эсэхэд онцгой анхаарах)
 - Хөнгөнөөс дээш зэргийн гэмтэл, бэртэлтэй амьтан
 - Хаягдсан, төөрсөн, бие даах чадваргүй нялх төл амьтан
 - Ган, зуд, үер, аянга цахилгаан, түймэр болон байгалийн бусад гэнэтийн бэрхшээлд өртөж хүний тусламж дэмжлэг зайлшгүй шаардлагатай болсон амьтан
 - Идэш тэжээл, унд усны хомсдолын улмаас турж эцэн, хүч тамир нь барагдсан амьтан.

3. Анхан шатны үзлэгээр дараах нөхцөлүүдийн нэг нь, эсвэл хэд хэд нь илэрч буй амьтныг зориудаар унтуулж, амь хорооно. Үүнд:
- Нас ахиж хэт хөгширсний улмаас цаашид амьдрах боломжгүй болсон
 - Мэдрэлийн тогтолцооны гэмтлийн улмаас хөдөлгөөний эрхтнүүд хэвийн хөдөлгөөн хийх чадвараа (гүйх, авирах, мөлхөх, үсрэх, нисэх эсвэл усанд сэлэх г.м) бүрэн алдсан
 - Мэдрэлийн тогтолцооны гэмтлийн улмаас орчноо мэдрэх (харах, сонсох, үнэрлэх, амтлах, мэдрэх) чадвараа бүрэн алдсан
 - Өнчирсний улмаас нөхөн сэргэх чадвар нь алдагдаж, бие даан амьдрах чадваргүй болсон.

4.7. ЗЭРЛЭГ АМЬТДАД ҮЗҮҮЛЭХ ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Янз бүрийн шалтгаан, нөхцлийн улмаас байгалийн зэрлэг амьтад бэртэж гэмтэх юм уу өвчлөх нь нилээд элбэг. Эдгээрээс түгээмэл тохиолдох зарим хэлбэрүүдийг дор тоймлон авч үзэв.

Гэмтэл бэртэл. Арьс зүсэгдэх, үс ноос, өд сөд нь зулгарах, мөлхөгчдийн сүүл тасрах гэх зэрэг хөнгөн гэмтэл бэртэлтэй амьтдад газар дээр нь эмнэлгийн анхан шатны үйлчилгээ үзүүлж, байгальд нь суллан явуулна. Хүнд ба хүндэвтэр гэмтэлтэй үед эмч мэргэжилтэн нь тухайн амьтныг цаашид эмчлэх эсэхийг шийдвэрлэнэ. Бага зэргийн бэртэл гэмтлийг эмчлэхэд зориулсан гадаргуу ариутгах үхжлийн эсрэг бэлдмэл, тампон, хөвөн, самбай, хайч, хямсаа зэргийг бэлтгэсэн байна.

Цус алдалт. Цус алдалт нь амьтныг цочроож (шок) улмаар үхэлд хүргэх өндөр эрсдэлтэй тул аль болох богино хугацаанд арга хэмжээ авах ёстой. Цус алдалтыг артери, вен ба хялгасан судасны гэж ангилах бөгөөд артерийн цус алдалт нь тод улаан өнгөтэй, шахалттайгаар хүчтэй олгойдож гардгаараа онцлог. Харин вений цус нь хар хүрэн өнгөтэй урсаж гарна. Хялгасан судасны цус нь ягаан өнгөтэй, шүүрэх байдлаар аажим урсаж гарах бөгөөд цус алдалтын хамгийн түгээмэл хэлбэр болно. Дотуур цус алдалтын үед амьтдад цустай ханиалгах, цусаар бөөлжих, амьсгаа нь хүндрэх зэрэг шинж тэмдэг илэрнэ. Дотоод цус алдалтыг зогсоож чадахгүй бол амьтан эдгэрэх магадлал тун бага байна. Цус алдалтын цэгийн дээд талд нь шууд даралт үзүүлэх аргаар зогсоож болно. Хүчтэй цус алдалтын үед даралттай боолт тавина. Боолт нь цусаар нэвчин шүүрэх тохиолдолд боолтоо авалгүйгээр дээр нь дахин шинэ боолт тавина. Цус алдалт зогсоох боломжгүй тохиолдолд тухайн амьтныг унтуулах эсвэл мал эмнэлэг рүү хүргэх шийдвэр гаргана.

Шарх. Хөнгөн буюу өнгөц шархыг шингэн антисептик (бетадин г.м)-ээр цэвэрлэнэ. Шархыг шалбархай, ил шарх (зүсэлт), нүхэн шарх (амьтанд хазуулсан ор, гаднын биетээр хатгуулсан г.м) зэргээр төрлүүдэд хувааж болох бөгөөд аливаа амьтны шархаар дамжин халдвар биед орох нь асуудал дагуулдаг тул амьтны биед үүссэн шархны төрөл, тэдгээрийн онцлог, тусламж эмчилгээний талаар тодорхой мэдлэгтэй байх шаардлагатай. Үүнд:

- Хөхрөлт - энэ бол далд шарх тул арьсан доогуур цус хурсан байх ба эмчлэх шаардлагагүй.

- Шалбархай - энэ бол ил шарх тул арьсны гаднах давхарга болон цусны судас зэрэг нь ил гарсан байна. Шархыг ариутгаж цэвэрлээд амьтнаа суллаж болно.
- Зүсэлт - Ямар нэг хурц иртэй зүйлээр үүссэн ил шарх бөгөөд энэ тохиолдолд ихэнхдээ арьс, зөөлөн эд болон булчин зүсэгдсэн байна. Ийм шархыг сайтар ариутгаж, гүн биш бол тухайн амьтныг буцаан тавьж болно.
- Урагдсан шарх - амьтны шүд, хумсаар үүсгэгдсэн ил шарх бөгөөд арьс болон арьсан доорх эд гэмтсэн байна. Шархыг сайтар ариутгана. Шаардлагатай гэж үзвэл 1-2 хоног хүний асрамжид байлгаад амьтнаа суллаж болно.
- Цоорхой шарх - арьс ба зөөлөн эд хурц шовх үзүүртэй зүйлээр нүхлэгдсэнээс эрхтэн гэмтсэн байж болно. Ийм шархыг сайтар ариутгах, шарх гүн тохиолдолд 1-3 хоног хүний асрамжид байлгаж эмчилнэ.
- Уранхай шарх - арьс ба зөөлөн эд нь хэсэгчлэн буюу бүтэн салсан байна. Энэ тохиолдолд шархыг сайтар ариутгаж, урагдсан арьсыг байранд нь буцаан тавьж даралттай боолтоор даруулан, 1-3 хоног асран эмчлээд суллан тавина.
- Гаднын биет зүйл нэвтрэн орсон ил шарх - Эмч, эмнэлгийн ажилтны заавраар эмчилнэ.

Яс хугаралт, булгаралт ба суналт. Яс хугаралт нь ил (яс нь арьснаас ил гарсан), далд буюу битүү (арьс нь гэмтээгүй) гэсэн хэлбэрээр тохиолдоно. Тухайн амьтны хөдөлгөөн, хөндүүрлэж буй биеийн хэсэг зэргийг ажиглаж, аль нэгэн мөчөө ашиглахгүй байх, хөндүүрлэж байгаа эсэх, мөчний хэлбэр, хэмжээ хэвийн бус, хавдсан, мултарсан зэрэгт анхаарна.

Тухайн амьтны талаар гаргах шийдвэр нь хугаралт хэдэн яснаас тогтсон, байршил, хугарсан цаг хугацаа, ил буюу хаалттай байдал зэргээс хамаарна. Ил хугаралд гаднын халдвар орсон байх магадлал өндөр тул хүнд бэртэлд хамаарна. Ийм бэртлийн үед анхан шатандаа даралт үүсгэгдэхгүйгээр боолт хийнэ.

Булгаралт, суналттай үеийн шинж тэмдэг нь далд хугаралттай төстэй байна. Амьтанд стресс үзүүлэхгүйгээр бэртлийг газар авахгүй байдлаар тогтоож, бэхэлнэ. Дээрх тохиолдлуудыг малын эмч үзэж оношлоод цаашид эмчлэх эсвэл зориудаар унтуулах шийдвэрийн аль нэгийг гаргана. Эмчлэх тохиолдолд доод талын хугацаа 6 долоо хоног бөгөөд энэ хугацааны төгсгөлд байгальд бие даан амьдрах баталгаа тэр бүр байхгүй гэдгийг санах хэрэгтэй.

Хэвлийн хөндийн гэмтэл. Ихэвчлэн механик нөлөөлөл (автомашинд мөргүүлэх, цохиулах, амьтанд өшиглүүлэх, мөргүүлэх, хад чулуунд цохиулах, хөл алдан өнхрөх г.м)-ийн улмаас амьтад хэвлийн хөндийн бэртэл, гэмтэлд өртдөг. Ийм төрлийн гэмтлийн үед амьтан цочролд орох, өвдөх, бөөлжих, хавагнах, хөхрөх, гэдэс цухуйж гарах зэрэг шинж тэмдэгтэй байна. Ийм төрлийн гэмтлийн эмчлэгдэх магадлал таруу тул амьтныг унтуулах нь олонтаа тохиолдоно.

Цээжний хөндийн гэмтэл. Энэ төрлийн гэмтэл нь хөнгөнөөс хүнд, амь насанд аюул учруулах хэмжээнийх хүртэл байна. Шинж тэмдэг нь өвдөлт, амьсгал хүндрэх, ойр ойрхон амьсгалах, амьсгаадах, гэмтлийн хэсэгтээ бэмбийж хавдах, өнгө хувирах зэрэг болно. Амьсгалын замын хүнд хэлбэрийн хүндрэлтэй амьтны толгой урагш сунаж амьсгаадна. Ийм төрлийн гэмтлийн эмчлэгдэх магадлал муу байдаг тул тухайн амьтныг унтуулах нь олонтаа тохиолдоно.

Толгой ба нугасны гэмтэл. Толгой нугасны гэмтэл нь хүнд бэртэлд орно. Ухаан алдах, хэвийн бус зан төрх гаргах, хамар чихнээс цус, тунгалаг шингэн гарах, хүүхэн харааны хэмжээ тэгш бус байх зэрэг шинж тэмдгүүд илэрнэ. Хэрэв амьтан ухаангүй байвал хажуугаар нь байрлуулж, амьсгалын замыг чөлөөтэй болгоно. Амнаас нь шингэн гарах тул толгой нь хүзүү, цээжнээс арай доогуур байх ёстой. Нуруу нугасны гэмтлийн хамгийн нийтлэг шалтгаан бол зам тээврийн осол байдаг. Ийм төрлийн гэмтэлд сэжиглэсэн тохиолдолд амьтанд тун болгоомжтой хүрнэ. Шинж тэмдгүүд нь нурууны сулрал, хойд хөл нь унжиж, сулрах, өвдөлт, хэсэгчилсэн ба бүтэн саажилт зэрэг хэлбэрээр илэрнэ. Ийм төрлийн гэмтлийн эмчлэгдэх магадлал муу байдаг тул үзлэгийн дараа амьтан унтуулах шийдвэрийг мэргэжилтэн нар гаргана.

Нүдний гэмтэл. Нүд нь маш мэдрэмтгий тул алив байдлаар гэмтсэн тохиолдолд амьтандаа сөргөөр нөлөөлнө. Гаднын объект, утаа, шарх нь нүдний гэмтлийн нийтлэг шалтгаан. Нүдэнд гаднын биет орсноор нүднээс шингэн гарах, улайх зэрэг шинж тэмдэг ажиглагдана. Тус биетийг зайлуулах шаардлагатай тул нүдийг нээж цэвэр усаар угаана. Угаагдахгүй бол өөр арга хэрэглэх боловч гаднын биет нь нүд рүү нэвтрэн орсон тохиолдолд оролдохгүй байх нь зөв. Утаанаас үүдэлтэй нүдний гэмтлийг ус буюу физиологийн шингэнээр угаах байдлаар түргэн тусламж үзүүлнэ. Нүдний шарх нь гаднын биет, утаа зэргээс болж цочрохоос ч илүү хүнд өвчлөлийг үүсгэнэ. Шархтай нүдэнд цус, цуст шингэн ялгарна. Малын эмч үзлэг хийсний дараа эмчлэх юм уу унтуулах шийдвэрийн аль нэгийг гаргана. Хөнгөн гэмтлийн үед анхан шатны тусламж үзүүлсний дараа амьтнаа суллаж тавина.

Түлэгдэлт. Амьтны түлэгдэлтийг үнэлэхдээ түлэгдэлтийн гүн (өнгөц, хэсэгчилсэн зузаан, бүрэн зузаан), цар хүрээ (биеийн түлэгдсэн хувь), байршлыг харгалзан үзэх шаардлагатай. Түлэгдсэн амьтны түлэгдэлтийн хэмжээ хөнгөн бол анхан шатны тусламж үзүүлж, эмчилнэ. Анхан шатны тусламж нь хүйтэн усаар шавших, нойтон даавуугаар жин (компресс) тавих зэрэг болно. Түлэгдсэн амьтныг түлэгдэлтээс гадна, цочрол, өвдөлт, шингэн алдалтыг нь хамт эмчлэх шаардлагатай байдаг. Биеийнх нь 50%-аас дээш хэсэг түлэгдсэн амьтныг унтуулах шаардлагатай.

Амьтныг тордож эмчлэх нь

Стресс. Энэ бол зэрлэг амьтдын үхэл, өвчлөлд хүргэдэг хамгийн нийтлэг хүчин зүйлүүдийн нэг юм. Стрессийн шинж тэмдэг, жишээ нь хөхтөн амьтдад дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Амьтан дайрах эсвэл зугтахыг оролдоно
- Амьдралын идэвх буурах эсвэл унжийг идэвхгүй болно
- Шүдээ хавирна
- Урд мөч, мөр, цээж, хойд мөчөө долооно.

Стрессийг тайлах үндсэн арга нь тухайн амьтныг тайвшруулж харанхуй, нам гүм, дулаан орчинд тодорхой хугацаанд байлгах явдал юм. Жижиг ба дунд зэргийн хөхтөн амьтдыг уутанд байрлуулж тайвшруулахыг зөвлөдөг.

Цочрол (шок). Энэ нь цусны эргэлтийн тогтолцооны уналтаас үүдэлтэй бөгөөд стресс, цусны алдагдал, шингэний алдагдал, цусны даралт буурах, зүрхний үйл ажиллагааны доголдлоос үүсдэг. Хүнд гэмтсэн амьтад цочролд ордог. Цочролын шинж

тэмдгүүд нь судасны лугшилт ба амьсгалах нь хурдсах, гипотерм (биеийн температур буурч амьтан чичрэх), буйл нь цагаан эсвэл цайвар өнгөтэй болох зэргээр илэрнэ. Тэгэхдээ цочролын эдгээр шинж тэмдгүүд нь үргэлж илэрхий байдаггүй, шоконд орсон амьтан ихэвчлэн нам гүм, бие нь хөрсөн байдгийг анхаарах ёстой. Цочролыг эмчлэхийн тулд эхлээд стрессийг багасгах (амьтны нүдийг боох), цус алдах шинж тэмдгийг зогсоох, дараа нь амьтныг дулаан, чимээгүй орчинд оруулна. Цочролд орсон амьтанд шингэн өгч болохгүй, зөвхөн дулаацуулсны дараа л бүлээн шингэн бага багаар өгнө.

Гипотерм (биеийн температурын бууралт). Биеийн температур буурснаас гипотерм үүсдэг. Гипотермийн шинж тэмдэгт арьс нь хөрөх, идэвхгүй байдалд орох, зүрхний цохилт удаашрах зэрэг орно. Ийм амьтныг дулаацуулах шаардлагатай бөгөөд үүний тулд дулаан уутанд хийх юм уу халуун устай лонх, сав, халаагуур хэрэглэнэ. Гипотермд орсон үсэн бүрхүүл хөгжиж амжаагүй үр зулзага, ангаахай, дэгдээхэйг ойролцоогоор 32 хэмийн, үс болон өдөн бүрхүүлтэй залуу амьтныг 28 хэмийн, бие гүйцсэн амьтныг 28 хэмийн орчинд тус тус байлгана. Дулааны эх үүсвэрийг амьтан байршуулсан байр оромж, тор савны гадна талд байрлуулснаар амьтан нь өөрөө ойртох буюу холдоно. Саван дотор байршуулах тохиолдолд заавал тусгаарлагч жийргэвч ашиглана. Хэт халаахаас сэргийлж тогтмол хянах хэрэгтэй. Бүлээцэж, бээрэнгэ нь гарсан амьтанд шингэн өгнө.

Шингэний дутагдалд орох. Биеэс их хэмжээний шингэн алдагдсанаар шингэний дутагдалд орно. Энэ тохиолдолд амьтны бүхий л эд, эрхтний тогтолцооны хэвийн үйл ажиллагаа доголдож амь насанд нь аюул учирч болзошгүй юм. Шингэний дутагдалд орсон эсэхийг амьтны арьсыг татан үзэж хэр хурдан хэвийн байдалдаа орж байгаагаар нь шалгана. Шингэний алдагдалтай амьтны арьс майхан байдалтай буцаж буухгүй, арьс нь уян хатан бус болсон байна. Нүд нь хуурайшиж, гархилсан шинжтэй, нуух нь хуурай байх зэрэг нь шингэн алдагдалтай байгааг харуулна. Шингэнийг нөхөхийн тулд жижиг хавтгай саванд усыг бага багаар хийж шимэн уулгах нь зохимжтой. Өөрөө ууж чадахгүй байгаа жижиг амьтанд норгож чийглэсэн зүйлсийг аманд нь хүргэх байдлаар ус уулгана. Амьтны хоолой руу ус хийж болохгүй. Жижиг амьтдыг бодвол том амьтад ус уухгүйгээр илүү удаан тэсвэрлэнэ.

Гипертерм буюу биеийн температур нэмэгдэх эмгэг. Биеийн температур нэмэгдсэнээр бөөрний үйл ажиллагааны дутагдалд орох, шоконд орох, комад орох, үхэлд хүргэх аюултай.

Гипертермийн шинж тэмдэгт дараах зүйлс орно. Үүнд:

- Амьсгал хурдсах
- Шүлс их хэмжээгээр ялгарах
- Урд мөч, мөр, цээж, хойд мөчөө долоох (зарим тохиолдолд шүлс эдгээр хэсэгт хатаж наалдсан байна)
- Салст бүрхүүлд нь цус хурсан
- Тахикарди буюу зүрхний цохилт түргэсэх
- Суулгах
- Шингэн алдах зэрэг шинж тэмдгүүд илэрнэ.

Сэрүүн агаарт байлгах юм уу нойтон даавуу, ус зэргийг ашиглан амьтны биеийн температурыг аажмаар бууруулж, сэрүүн чимээгүй орчинд байрлуулна.

Булчингийн эмгэг буюу доройтол (миопати). Амьтан барих явцад их биеийн булчингийн эсвэл зүрхний булчингийн доройтолд орох явдал ялангуяа, өндөр хөгжилтэй шувуу, хөхтөн зэрэг амьтдад гардаг. Бүх нас, хүйсийн амьтад мэдрэмтгий байдаг. Миопатид орсноор гэнэтийн үхэлд хүргэж болзошгүй боловч зарим тохиолдолд биеийн байдал зэргээс шалтгаалан баригдсанаас хойш хэдэн долоо хоногийн дараа ч үхэх тохиолдол бий. Миопатийн үед амьтан толгой, хүзүүгээ унжуулах, хүндээр амьсгалах, чичрэх, хөдөлгөөнгүй болох, хөдөлгөөний уялдаа алдагдах, саажих, унах зэрэг шинж тэмдэг илэрнэ. Барьсан амьтныг стрессээс сэргийлэх нь миопати зэрэг бусад эмгэгээс хамгаалах үндсэн арга болно. Иймд эмчилгээ эхлэхийн өмнө барьсан амьтныг тайвшруулах арга хэмжээ авах нь илүү булчингийн эмгэгийг эмчлэхэд нэн үр дүнтэй.

Тархи хөдлөх (доргих). Хэрэв амьтан тархины доргилт авсан байх магадлалтай (барих явцад тор, хатуу гадаргуу руу мөргөх г.м) бол харанхуй орчинд байрлуулж, 2-4 цагийн дараа биеийн байдлыг шалгаж, хэвийн байдлаар хөдлөх, зогсох чадвартай байгаа эсэхийг тогтооно. Хэвийн байдалд ороогүй бол 24 цаг тайван байлгана.

Паразитын нөлөөлөл. Паразитын халдварлал нь анхан шатны тусламж хүргэх хэмжээний асуудал биш боловч амьтны нөхөн сэргэх чадварт ихээхэн саад учруулдаг. Паразит хорхой буюу гельминтийн халдварлал нь амьтныг эцээж тураана. Мөн олон зүйл паразитууд хүнд халдварлах аюултай. Бүүрэг, бөөс, хачиг зэрэг эктопаразитуудыг шавж устгах инсектицидын тусламжтайгаар устгана. Хачиг, хос далавчтаны өт авгалдай (гуурын авгалдай)-г хямсаагаар авч цэвэрлэж болно.

Халдварт өвчин. Хүнд, гоц халдварт, эмчлэх боломжгүй халдварт өвчнөөр халдварласан нь тогтоогдвол тухайн амьтныг унтуулна. Энэ нь тухайн амьтанд чиглэсэн хүмүүнлэг үйлдлээс гадна, тухайн нутгийн зэрлэг амьтдыг мөн эрсдлээс хамгаалсан онцгой арга хэмжээ юм. Халдварт өвчинтэй амьтны хүүр, сэгийг газрын гүнд булшлах буюу шатаах замаар устгана.

Автозамын осол. Замын осолд ангилал зүйн ямар ч бүлгийн, аль ч насны бүхий л амьтад өртдөг. Гэмтэл нь цочрол, хугарал, дотоод цус алдалт зэрэг байна. Осол гэмтлийн зэргийг тодорхойлсны үндсэн дээр анхан шатны тусламжийг ямар түвшинд үзүүлэх, аль эсвэл эмчилгээнд өгөх, унтуулах зэргийг шийдвэрлэнэ. Ихэнх тохиолдолд анхан шатны тусламж үзүүлээд буцаан тавьдаг боловч хүнд гэмтэлтэй амьтныг унтуулна.

Махчдын дайралтад өртөх. Махчин амьтдын дайралтад өртсөн амьтад ихэвчлэн янз бүрийн шархтай байдаг. Ил шарх нь зөвхөн механик гэмтлээс гадна, халдвар үүсгэгч нэвтэрсэн байх магадлал тун өндөр. Ил шархыг ариутгаж гаднын нөлөөнөөс хамгаалж бооно.

Хордлого. Амьтад хорыг залгих, амьсгалах болон биеийн гадаргуугаар шингээх байдлаар авах боломжтой. Мөн зэрлэг амьтад төрөл бүрийн хоронд хордож үхсэн амьтдыг идэж хордох нь олонтаа тохиолдоно. Тухайн амьтан хордлоготой болохыг доорх шинж тэмдгүүд илэрхийлнэ. Үүнд:

- Бөөлжих
- Шүлсээ гоожуулах
- Булчингийн чичирхийлэл
- Уялдаагүй хөдөлгөөн

- Таталт
- Саажилт
- Кома
- Үхэл.

Тухайн амьтанд хордлогын шинж илэрсэн тохиолдолд малын эмч эмчилгээ хийх эсэхийг шийдвэрлэнэ.

4.8. АМЬТНЫ МАЛЛАГАА, АСАРГААНЫ ҮЕД АНХААРАХ ЗҮЙЛСИЙН ТУХАЙ

Амьтны маллагаа, асаргаа гэдэг бол нэг талаас амьтан аврах, асран хамгаалал үйл ажиллагаанд оролцогч эмч, мэргэжлийн ажилтан, амьтан маллагч болон үйлчилгээний бусад ажилтан, ажиллагсад, нөгөө талаас хүний тусламж шаардлагатай болсон амьтны хооронд өрнөж буй бүх төрлийн харилцан үйлчлэлийг багтаасан нэн өргөн хүрээтэй ухагдахуун юм. Маллагаа, асаргааны мөн чанар нь тухайн амьтанд өвдөлт, зовлон шаналлыг аль болох бага мэдрүүлэх, улмаар уг амьтныг богино хугацаанд илаарьшуулан эдгээж, тэнхрүүлээд байгальдаа бие даан амьдрах чадвартай болоход нь тусламж дэмжлэг үзүүлэхэд оршино. Иймд тусламж шаардлагатай болсон амьтны маллагаа, асаргаа гэдэг нь тухайн амьтныг хээрээс анх олж, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх тэр мөчөөс эхлэх бөгөөд хэрэв тухайн амьтны амийг хороож устгалд оруулахааргүй бол эмчлэн илаарьшуулж, тэнхрүүлээд цаашид төрөлх байгалийн орчиндоо бие даан амьдрах нөхцөл хангагдах хүртэл үргэлжлэх үйл явц юм.

Зан төлөвийн хариу үйлдлээ харуулах хангалттай орон зайг амьтдад бэлтгэж өгөх ёстой. Өөрөөр хэлбэл, хүний асрамжид орсон амьтад хэвийн амьдарч, зан төрхөө чөлөөтэй илэрхийлэх боломж олгохуйц тийм орон байрны орчныг бий болгох ёстой. Амьдрах орчин таатай биш байх нь амьтдын зан төрх, физиологи, биохимийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, эдгэрэн илаарьших, дасан зохицох үйл явцыг удаашруулах эсвэл бүр үр дүнгүй болгох аюултай.

Үүрэг, хариуцлага. Амьтан тэжээх болон арчлах ажил төвийн дарга болон түүний мэргэжилтнүүдийн хариуцлагад хамаарна. Эдгээр хүмүүсийн шийдвэргүйгээр амьтан тэжээх, услах болон бусад арчилгаа хийгдэхгүй. Тухайн амьтны шаардлагад нийцсэн орчин бүрдүүлсэн бөгөөд зүй ёсны арчилгаа хийх боломжтой амьтныг л хүлээн авч үйлчилгээ үзүүлнэ. Амьтныг хөндлөнгийн хүн арчлахыг хориглоно.

Байнгын арчилгаа, маллагаа шаардахгүй амьтдад тавих тэжээл, усны чанар, хэмжээг малын эмчтэй зөвлөн шийднэ. Байнгын эмчилгээ шаардлагатай тохиолдолд жишээ нь, арьс, үсэн бүрхүүл, өдөн бүрхүүлийг тордох, хумс тайрах болон бусад шаардлагатай тордолт, арчилгааг эмчийн заавраар хийнэ. Нялх залуу болон зан төрхийн өөрчлөлтөд орсон амьтанд илүү тордлого шаардагдана.

Амьтдын эрүүл мэндийн талаар. Амьтан аврах, асран хамгаалах үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээд нь амьтны эрүүл мэнд, тав тухыг хангахад баримтлах журам, заавар боловсруулж, дагаж мөрдөнө. Зааварт микробиологийн хяналт, амьтны эрүүл мэндэд хямрал үүссэн үед ажиллах горим, шинээр ирсэн амьтныг бүртгэх, үзлэгт хамруулах тухай тодорхой тусгасан байна.

Аврах, асран хамгаалах байранд байгаа амьтны эрүүл мэнд, асаргаа маллагааны явц, үр дүнг мэргэжлийн ажилтан, амьтан маллагч нар өдөр бүр тогтмол хянаж, бүртгэл, тэмдэглэл хөтөлж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

Болзошгүй эрсдэлээс сэргийлэх, хамгаалах үүднээс ажилчдын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг хангасан байна. Амьтан аврах, асран хамгаалах аливаа байгууламжид зөвшөөрөлгүй хүн орохыг хориглоно.

Тодорхой шалтгааны улмаас удаан хугацаагаар эмчлэх шаардлагатай тохиолдолд зүйлийн онцлогоос хамаарч дараах зүйлийг онцгой анхаарах ёстой. Үүнд:

- Гадаад, дотоод шимэгчтэй тэмцэх (шимэгч хорхой, хачиг, гуур, бөөс г.м)
- Болзошгүй бүх халдварт өвчний эсрэг урьдчилан сэргийлэх тарилга хийх.

Эмнэлгийн үйлчилгээ, тарилга хийх ажлыг малын эмч эсвэл түүний зааварчилгаагаар зохих дадлага эзэмшсэн маллагч хийнэ. Аврах үйл ажиллагаанд орсон амьтан өвчтэй эсвэл өвчтэй байж болох хардлага байгаа бол эмчид яаралтай үзүүлнэ.

Малын эмч авран хамгаалах үйл ажиллагаанд байгаа амьтдыг байнга үзэж аливаа өвчний илрэл, гадна, дотор шимэгчид, зан төрхийн өөрчлөлт зэргийг цаг алдалгүй мэдэж, шаардлагатай эмчилгээ хийнэ. Тэрээр амьтны тэжээл, арчилгаа, байр савны талаар удирдлагад зохих зөвлөгөө өгнө.

Хорио цээр, тусгаарлах болон дасан зохицох үе. Хорио цээр (карантин) гэдэг нь хүний асрамжид шинээр болон дахин ирсэн амьтдыг тодорхой хугацаанд бусад 1 амьтдаас тусгаарлан байлгах үйл явц юм. Шинээр ирсэн амьтдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, ямарваа нэгэн өвчин тархах аюулаас хамгаалахад хорио цээр чухал үүрэгтэй. Хорио цээрийн үргэлжлэх хугацаа нь тухайн амьтны эрүүл мэндийн байдлаас шалтгаалж харилцан адилгүй байх ба үүнийг гагцхүү малын эмч, мэргэжилтний шийдвэр, заавар зөвлөмжийн дагуу тухайн орчинд хэсэгчлэн зохион байгуулна.

Хорио цээр, тусгаарлалт явуулах зорилго нь (а) халдварт өвчний эрсдлээс бусад амьтдыг хамгаалах, (б) зоонозын халдвараас хүнийг хамгаалах, (в) хүний хараа хяналт, асаргаанд орж буй амьтдын дасан зохицох чадварыг дээшлүүлэх зэрэг болно. Үзлэг, оношилгооны үр дүнд халдварт өвчтэй болох нь тогтоогдсон амьтдыг хорио цээрийн арга хэмжээнд хамруулна.

Тусгаарлалт нь бусад амьтан болон хүн ямар нэг өвчний халдвар авах эрсдлийг бууруулах ач холбогдолтой. Эрсдлийн бүлэгт хамаарах магадлалтай амьтдыг заавал тусгаарлах шаардлагатай. Мөн үзлэгээр халдварт өвчтэй болох нь бүрэн гүйцэд тогтоогдоогүй ч сэжигтэй хэмээн үзсэн амьтныг зохих хугацаагаар тусгаарлана.

Шинээр ирж байгаа амьтныг хүлээн авахдаа хаанаас гаралтай болохоос хамаарч тусгаарлах, түүнчлэн дасахад тохиромжтой тайван орчинд байлгана.

Дасан зохицох үе гэдэг бол тээвэрлэлтийн явцад тухайн амьтанд үүссэн мэдрэлийн хямралыг засаж тайвшруулах, амьдралын шинэ орчин нөхцөл, цаашлаад тэднийг асарч халамжилж буй үйл ажиллагаанд дасан зохицоход маш чухал үүрэгтэй зурвас хугацаа юм. Шинээр ирсэн амьтан харьцангуй эрүүл, сэргэлэн цовоо байсан ч гэсэн дасгах хугацааг заавал дамжуулах шаардлагатай. Харин дасан зохицох үеийн үргэлжлэх хугацаа нь тухайн амьтанд стресс хэр үргэлжилсэн (ер нь стрессийн түвшин нь ихэвчлэн зөөвөрлөлт ямар зайд, хир хугацаанд үргэлжилсэнээр тодорхойлогддог), цочролын түвшин, тэдний нас, эрүүл мэндийн байдал, амьдрах орчны нөхцлийн өөрчлөлт гэх зэрэг олон хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй байна.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг хэрхэн гүйцэтгэх вэ? Өвчтэй ч онош тодорхой бус зэрлэг амьтдын байр, хэрэглэгдэхүүн, ялгадас, хоолны үлдэгдэл зэргийг Мал эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн заавар (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны А/67 тоот тушаал)-ын дагуу ариутган халдваргүйжүүлнэ. Боом, ям,

хулганы яр, дуут хавдар, зогсоо, үхрийн мялзан, шүлхий зэрэг өвчний үед зэрлэг амьтдын арьс, шир, үс ноос, эвэр туурайг авч ашиглахыг хориглох бөгөөд шууд устгана. Боомын сэжигтэйгээр үхсэн зэрлэг амьтны хүүрийг задлахыг хатуу хориглоно.

Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх үндсэн арга. Тухайн нян, вирусийн тэсвэрт чанар, онцлог, халдваргүйжүүлэлт хийх объектын шинж байдлаас шалтгаалан харилцан адилгүй аргаар ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийнэ. Мал, амьтны эмнэлгийн байгууллагаас хэрэгжүүлэх халдваргүйжүүлэлтийн арга хэмжээ нь үндсэн зорилгын хувьд хүн эмнэлэгтэй ижил төсөөтэй боловч технологийн бага зэргийн ялгаатайгаар доорх хэд хэдэн аргыг хэрэглэнэ. Үүнд:

Механик цэвэрлэгээ. Энэ нь халдваргүйжүүлэлтийн өмнөх бэлтгэл үе бөгөөд амьтны хэвтэр, хашаа хороо, тэжээлийн хог хаягдал, хашаа, байр, оромжийн шал, хана, тааз, орох, гарах хаалга зэрэгт наалдсан болон бусад хэлбэрээр бохирдсон өвчин үүсгэгчийг механик аргаар цэвэрлэснээр эмгэг төрүүлэгчдэд халдваргүйжүүлэгч бодисын үзүүлэх үйлчилгээ, нөлөөг сайжруулах ач холбогдолтой.

Химийн арга. Аливаа нян, вирусээр бохирлогдсон объектыг химийн янз бүрийн бодис, бэлдмэлүүдийг тохирох хэмжээ, хувиар бэлтгэж, тодорхой хугацаагаар үйлчлүүлж халдварыг аюулгүй болгох арга юм. Химийн халдваргүйжүүлэлтийг ихэвчлэн уусмал байдлаар хийхийн зэрэгцээ мананцаржуулах эсвэл нунтаг хэлбэрийг ч бас ашиглана. Химийн аргыг амьтны хашаа байр, хэвтэр бууц, дэвсгэр, өвс тэжээл, газрын хөрс, бэлчээр, багаж хэрэгсэл, хог хаягдлыг халдваргүйжүүлэхэд өргөн хэрэглэнэ. Химийн бодисоор хийх халдваргүйжүүлэлтийг уг үйл ажиллагаанд хэрэглэх бодис, урвалжаас шалтгаалан шүлтийн, хүчлийн, хлорт нэгдлийн, фенолын, хүнд металлын, формальдегидийн халдваргүйжүүлэлт гэх мэтээр ангилна.

Хэдийгээр халдваргүйжүүлэлтэд дээр дурдсан олон төрлийн бодис, бэлдмэлийг ашиглах боломжтой ч амьтны байр оромж, өрөө тасалгааны шал, хаалганы бариул, ширээ, сандал зэрэг бүх гадаргууг 250-500 мг/л хлор агуулсан хлорын бодис эсвэл 100 мг/л хлорын давхар ислийг агуулсан халдваргүйтгэлийн бодисыг түгээмэл ашиглаж ариутгана. Хлор агуулсан халдваргүйжүүлэгч уусмалаар арчиж 15-30 минутын турш халдваргүйтгэнэ. Угаалгын өрөөний шал, ханыг 15-30 минутын турш 500 мг/л хлор байхаар тооцож бэлдсэн халдваргүйтгэлийн уусмалаар шүрших эсвэл арчина. Бохирдуулагч ихтэй цус, бөөлжис, ялгас зэрэг биологийн шингэнийг халдваргүйжүүлэхдээ халдваргүйжүүлэх бодисын тунг зохих хэмжээгээр нэмэгдүүлж болно. Халдваргүйжүүлэх бодисын уусмал бэлтгэхдээ аюулгүй байдлыг хангах үүднээс бээлий, хормогч, нүдний шил болон зааварт тусгагдсан бусад хэрэгслийг ашиглана. Өвчтэй, сэжигтэй амьтан байгаа байр, хашааны үүдэнд халдваргүйжүүлэх уусмал бүхий дэвсгэр эсвэл хөл онгоц байрлуулсан байна. Хүйтний улиралд халдваргүйжүүлэх уусмал дээр хоолны давс 10%-аар тооцож нэмнэ. Амьтантай ажилласны дараа гараа сайн савандаж угаах ба гарын ариутгалд 0.5% иодын уусмал, 70% спиртийг ашиглана. Уусмалаар 1-3 минутаар 2 удаа арчих, мөн хлор, устөрөгчийн хэт исэл агуулсан нэг удаагийн гар ариутгагч бодис хэрэглэж, өөрөөр нь хатаана.

Физикийн арга. Энэ нь нарны гэрэл, галын дөл, буцалсан ус, усны уур, хэт ягаан туяа, хатаалт, өндөр нам температур, өндөр давтамжит цахилгаан гүйдэл, хэт богино долгион зэрэг физик хүчин зүйлийг ашиглаж явуулах арга юм. Амьтан аврах, асран хамгаалах байр, оромжийн ариутгалыг хэт ягаан туяагаар халдваргүйжүүлэх бол хүчин чадал нь 1.5 ватт/м²-аас багагүй, өндөр нь 1.8-2.2 м, хугацаа доод тал нь 30 минут байна.

Биологийн арга. Энэ арга нь байгалийн юмс үзэгдлийн өөрийн дотоод чанарыг ашиглан халдварт өвчин үүсгэгчийг гадаад орчны хүрээлэл дотор устгахыг хэлнэ. Тухайлбал, аливаа өвчин үүсгэгчийн эсрэг үйлчлэх антигонист бичил биетнүүд болон байгалийн үзэгдлийг ашиглаж болно. Үүнд биотермийн, фитонцидийн зэргийг дурьдаж болно.

Ариутгал халдваргүйжүүлэлтэд ашиглах бодис, урвалж. Халдваргүйжүүлэлтэд Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн дараах төрлийн химийн бодис, бэлдмэлийг ашиглана.

Хлорлог бодис:

- Хлорамин хуурай ба уусмалаар 0.2-10%
- Хлорын шохой хуурай ба уусмалаар 3-10%
- Гипохлорид кальц хуурай ба уусмалаар 3-7%
- Гипохлорид натри хуурай ба уусмалаар 0.1-2%
- Жавелион уусмалаар 0.015-0.5%

Спирт:

- Этилийн спирт уусмалаар 6-96%
- Изопропилийн спирт 60%

Иодлог бодис:

- Иод форм
- Иодинал уусмал (Химодин 0.1%, кали иод 0.9%)
- Поливидон иодын уусмал 10%
- Иодинат, тамедин

Альдигед:

- Формалин уусмалаар 5-10%
- Глютаральдегид 2%
- Салидекс 2%

Фенолийн бүлгийн бодисууд:

- Фенол, Тимол, Крезол, Хлорфенол, Гексахлорфен зэрэг.

Бусад бодис:

- Устөрөгчийн хэт исэл 1 -6%
- Виркон (Персульфит кали) 2%
- Идэмхий натри, идэмхий кали
- Килса, түүхий шохой.

Ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажилтан хүн нэг бүрийн хэрэглэх халдвар хамгааллын хувцас болон хөдөлмөр аюулгүй байдал хангах хувцасны тухай.

Халдвар, хамгааллын хувцас хэрэглэх нь халдвартай болон халдварын сэжигтэй эмгэгт материал, амьтантай харьцах, лабораторид ажиллах үед малын эмч, шинжээч, туслах ажилтныг халдварт өртөх эрсдэлээс хамгаалах өндөр ач холбогдолтой.

Хүн нэг бүрийн халдвар хамгааллын хувцасны иж бүрдэлд дор дурьдсан зүйлс багтах ба эдгээрийг ойролцоогоор 20х25 см хэмжээтэй гялгар уутанд нэгтгэн багцалж урьдчилан бэлдсэн байна. Багц тус бүр 0.5-0.7 кг жинтэй байна. Халдвар хамгааллын

хувцасны иж бүрдэл нь амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагааны үед зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэг удаа 2 цагийн турш өмсөж хэрэглэх зориулалттай бөгөөд дараах зүйлүүдээс бүрдсэн байна. Үүнд:

- Амны хаалт (маск) N-95 эсвэл амьсгалын хошуувч. Энэ нь амьсгалын замаар халдвар авахаас хамгаална.
- Арьс хамгаалах зориулалттай нэг удаа ашиглах өмд, цамц, гутал. Эдгээрийг комбинзонтой хослуулан хэрэглэнэ. Комбинзон нь ажиллагч хүний биеийн арьс, ажлын хувцсыг биологийн бохирдлоос хамгаална. Комбинзоныг усанд тэсвэртэй материалаар хийсэн байна. Комбинзоны дотуур нэг удаа ашиглах өмд, цамцыг өмсөнө.
- Дотор талд өмсдөг винил бээлий (4 мм)
- Гадна талд өмсдөг нитрил бээлий (4-11 мм). Энэ 2 төрлийн бээлийг дэс дараагаар нь давхарлан өмсөнө. Энэ 2 төрлийн бээлийг хатгалтад тэсвэртэй тусгай технологийн дагуу үйлдвэрлэсэн байдаг.
- Гутлын гадуур өмсдөг нэг удаагийн углааш. Комбинзон өмссөний дараа гутлын гадуур углаашийг давхар углаж өмсөнө.
- Ус үл шингээгч хормогч. Үүнийг комбинзон дээрээ өмсөх бөгөөд комбинзоныг гаднын элдэв бохирдлоос хамгаалах үүрэгтэй.
- Хамгаалалт бүхий нүдний шил. Энэ нь үсэрсэн эмгэгт материал, шингэн зэргээс нүд, нүүрийг хамгаална. Нүдний шил нь нүдний тойронд нягт сууж яг таарсан байх ёстой. Ердийн нүдний шилийг хамгаалалтын шилний оронд хэрэглэхийг хориглоно. Хамгаалалтын шилийг нүдний харааны шилэн дээр давхар зүүж болно.
- Гар ариутгах зориулалт бүхий изопропилын спирт шингээсэн тампон юм уу цаасан алчуур. Гадна талын бээлийг тайлахын өмнө эдгээрээр арчиж бохирдлоос цэвэрлэнэ.
- Хатуу гадаргуутай хэсгийг арчиж, халдваргүйжүүлэх зориулалт бүхий нойтон цаасан алчуур. Эмгэгт материал, шингэнээр бохирдсон байж болох арьс, хувцсыг тайлсны дараа дотор талын бээлийг халдваргүйжүүлж цэвэрлэхэд ашиглана.
- Хог хаягдал хийх уут. Ашигласан халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг энэ уутанд хийж устгах арга хэмжээ авна.
- Халдвар хамгааллын хувцасны багцыг ашиглах зааварчилгаа.

Халдвар хамгааллын хувцсыг өмсөх дараалал

Юуны өмнө тухайн ажилтан нь өөрт тохирсон хэмжээний хувцсыг сонгоно. Халдвар хамгааллын хувцас нь өмсөхөд чөлөөтэй, ямар нэгэн байдлаар хөдөлгөөнийг хязгаарлахгүй байвал зохино. Халдвар хамгааллын хувцсыг дараах дарааллаар өмсөнө. Үүнд:

- 1) Эхлээд комбинзоноо өмсөж, цахилгааныг нь татна.
- 2) Гутлын углаашийг углана.
- 3) Амьсгалын хошуувч зүүнэ.
- 4) Нүдний шил зүүнэ.
- 5) Амьсгалын хошуувч, нүдний шилээ зүүсний дараа комбинзоны малгайг татаж толгойдоо углана.

- 6) Хормогчоо зүүнэ. Үүний тулд хормогчийг уутнаас нь гаргаж хүзүүндээ углаж бүчийг нь ар нуруундаа уяж зангидна.
- 7) Бээлийг өмсөнө. Эхлээд цагаан буюу тунгалаг бээлийг өмсөөд дараа нь бараан өнгөгэй бээлийг давхарлаж өмсөнө.

Халдвар хамгааллын хувцсыг тайлах дараалал

- 1) Хормогчоо тайлж хог хаягдлын уутанд хийнэ.
- 2) Гадна бээлийг нойтон цаасан алчуураар арчиж, хэрэглэсэн цаасан алчуураа хаягдлын уутанд хийнэ.
- 3) Гутлын углашийн дээд ирмэг талаас барьж тайлаад хаягдлын уутанд хийнэ.
- 4) Гадна талын бээлийг тайлаад хаягдлын уутанд хийнэ.
- 5) Комбинзоныг юүдэн талаас эхлэн дотрыг нь гадагш эргүүлж доош хуйлж тайлах бөгөөд хаягдлын уутанд хийнэ.
- 6) Нүдний шилээ чангалагч уяанаас дээшээ татаж тайлаад хаягдлын уутанд хийнэ.
- 7) Амьсгалын хошуувчийн дээд талын уяаг эхлээд мулталж тайлаад дараа нь (доод талын уяаг толгой дээгүүрээ мулталж тайлан хаягдлын уутанд хийнэ.
- 8) Дотор талын бээлийг тайлаад хаягдлын уутанд хийнэ.
- 9) Гараа халдваргүйжүүлэх зориулалт бүхий нойтон цаасан алчуураар арчиж хэрэглэсэн алчуураа хаягдлын уутанд хийнэ.
- 10) Хаягдлын уутныхаа амыг нь хааж зангидаж уяна. Гараа угаана.

Халдвар хамгааллын хувцас өмсөх үед анхаарах зүйлс

- Халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Дахин юм уу угааж хэрэглэхийг хориглоно.
- Халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг хэрэглэхтэй холбоотой зааварчилгааг урьдчилан өгөх ба эрүүл мэндийн хувьд тохирохгүй хүнд хэрэглэхийг хориглоно.
- Халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг хэрэглэж байгаа үедээ амьсгалын хошуувч, нүдний шил зэргийг тайлахыг хориглоно.
- Халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл урагдах юм уу бохирдвол нэн даруй солино. Ажил завсарлаж, дараа нь дахин ажиллахаар бол шинэ хувцас өмсөнө.
- Халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг өмсөх, тайлах газрыг урьдчилан тогтоосон байвал зохино.

Халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг устгах, халдваргүй болгох

- Халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг тайлахдаа халдварын аюултай бүсээс гарсан байна.
- Хэрэглэсэн халдвар хамгааллын хувцас, хэрэгслийг шатаах юм уу автоклавдаж устгана.

Гар угаах

- Гараа усаар норгож савандана. Цоргоны ус хэрэглээгүй тохиолдолд савтай уснаас хүнээр гар дээрээ хийлгүүлнэ.
- Савандсаны дараа гараа хөөсөртөл 20 секунд үрж угаана.
- Гараа усаар сайтар булхаж зайлна.
- Гараа агаарт хатаах юм уу алчуураар арчина.

4.9. АМЬТАН ХАМГААЛАХ БАЙРАНД ӨВЧИН ТАРХАХААС СЭРГИЙЛЖ, ХАМГААЛАХ НЬ

Мэргэжлийн ажилтан, амьтан маллагч нь цэвэр хувцаслаж аль болохоор олон удаа хувцсаа сольж, тогтмол угааж цэвэрлэнэ. Ажлын гутал нь ариутгах боломжтой байх бөгөөд байнга цэвэрлэнэ.

Амьтны өрөө цэвэрлэх, дээж авах, задалгаа хийх үед нэг удаагийн бээлий, маск хэрэглэнэ. Ажлын байр нь гар угаах ба ариутгах нөхцлийг хангасан байна.

Ажиллагсдыг цайлах, хооллох, тамхи татах зориулалтын байр нь амьтны гаралтай хог хаягдалгүй, цэвэр ариун нөхцлийг хангасан байна.

Амьтан маллагчид, ажиллагсдад зооноз өвчний талаар сургалт явуулж, хувийн ариун цэвэр сахих дүрмийг тогтооно. Ажиллагсад татран ба галзуугийн (хөхтөн амьтадтай ажилладаг бол) вакцин заавал хийлгэсэн байна. Жирэмсэн ажилтан нар эмчийн зөвлөгөө авч ажиллана. Зэрлэг амьтдыг хамгаалах байранд ялангуяа, өвчтэй амьтдын байранд хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, дархлаа суларсан хүмүүс нэвтрэхийг хориглоно. Махчид, сарьсан далавчтан зэрэг галзуу өвчин дамжуулагч амьтдыг асран хамгаалагч нар нь сургалтад хамрагдаж зохих мэдлэг, чадвар эзэмшсэн байна.

Задалгааны өрөөнд ажлын халат, мэс заслын маск, бээлийтэй (зарим тохиолдолд нүдний хамгаалалттай) ажиллах бөгөөд хэрэглэсэн багаж, ширээ савыг ариутгаж, гарсан хогийг зохих дүрэм журмын дагуу устгалд оруулна.

Амьтны гаралтай дээж, сорьцыг хоол хүнсний зориулалтаас тусдаа хөлдөөгч юм уу хөргөгчид хадгална.

Эмч, мэргэжлийн ажилтан зэрлэг амьтны сэг зэмийн устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг удирдан зохион байгуулна.

4.10. АМЬТНЫ АМЬ ХОРООХ ТУХАЙД

Дараах нөхцлүүдийн нэг нь, эсвэл хэд хэд нь илэрч буй амьтныг зориудаар унтуулж, амь хорооно. Үүнд:

- а. Нас ахиж хэт хөгширсний улмаас цаашид амьдрах боломжгүй болсон
- б. Мэдрэлийн тогтолцооны гэмтлийн улмаас хөдөлгөөний эрхтнүүд хэвийн хөдөлгөөн хийх чадвараа (гүйх, авирах, мөлхөх, үсрэх, нисэх эсвэл усанд сэлэх г.м) бүрэн алдсан
- в. Мэдрэлийн тогтолцооны гэмтлийн улмаас орчноо мэдрэх (харах, сонсох, үнэрлэх, амтлах, мэдрэх) чадвараа бүрэн алдсан
- г. Өнчирсний улмаас нөхөн сэргэх чадвар нь алдагдаж, бие даан амьдрах чадваргүй болсон.

Мэргэжлийн ажилтан нь мэргэжлийн тусгай бэлтгэл хийж, зориудаар амьтны амь хороох энэрэнгүй аргын талаар зохих мэдлэг, чадвар эзэмшсэн байна. Амьтны амийг зориудаар хороон унтуулах үед баримтлах үндсэн зарчим:

- Амьтны амь хороох аргууд нь амьтанд их хэмжээний өвдөлт, шаналал хямралыг авчрах ёсгүй.
- Цогцсыг устгахаас өмнө үхлийг баталгаажуулах ёстой. Барбитурат эм хэрэглэх аргыг зөвхөн малын их эмч хүн хийх ёстой.
- Хэрэв барбитуратын тунг зүрх эсвэл цээжний хөндийд хийхээр бол амьтанд бүрэн мэдээ алдуулах шаардлагатай.

Мэдрэмжээ алдаж, сэргэх чадваргүй болсон амьтныг ихэнхдээ эмийн аргаар унтуулна. Эмийн арга хэрэглэх боломжгүй тохиолдолд амьтанд хамгийн бага өвдөлт, шаналал үүсгэдэг дараах аргуудыг хэрэглэнэ. Үүнд:

- Буугаар дух буюу дагз орчмын хэсэгт тархийг онилж буудах. Энэ аргыг ихэвчлэн дундаас дээш биетэй хөхтөн амьтдад хэрэглэнэ.
- Нугаслах аргаар үхүүлэх бөгөөд үүнийг зөвхөн дадлага, туршлагатай мэргэшсэн хүнээр гүйцэтгүүлнэ. Нугаслахын өмнө амьтнаа муужруулж, хариу урвал үзүүлэхгүй болсон цагт хөдөлгөөнгүй бэхэлсний дараа аман хүзүү, дагзны нүхээр хутгаар хатгаж нугасыг тасална.
- Мэдрэмжээ алдаж, сэргэх чадваргүй болсон тохиолдолд цусыг юүлнэ.
- Хоёр нутагтан, мөлхөгч амьтдыг хөлдөөж болно.

Амьтны амь хороох дараах аргуудыг хэрэглэхийг хатуу хориглоно. Үүнд:

- а. Урьдчилан мэдээ алдуулалгүйгээр тархины бус хэсэгт цахилгаанаар үйлчлэх
- б. Амьсгал боох (живүүлэх, боомилох, цээж шахах г.м)
- в. Амьдаар нь шатаах
- г. Гэр ахуйн бүтээгдэхүүнээр хордуулах
- д. Ухаан алдуулалгүйгээр толгойг цавчих, мэдрэмжээ алдаж, сэргэх чадваргүй болсноос бусад тохиолдолд цус юүлэх
- е. Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдэж, зөвшөөрөөгүй эм, бэлдмэл хэрэглэх
- ё. Агаарын эмболизмын арга ашиглах.

Зориудаар амийг хороон, унтуулсан амьтдын сэг зэмийг нь журмын дагуу устгалд оруулна. Барбитуратын тунг хэтрүүлэн унтуулсан амьтдын сэг зэмийг бусад амьтанд өгч болохгүй. Үхсэнийг баталгаажуулахаас өмнө тухайн амьтны цогцсыг устгахыг хориглоно.

4.11. МЭДЭЭ АЛДУУЛАЛТ

Зэрлэг амьтдад эмчилгээний зорилгоор мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм хэрэглэн мэдээ алдуулах үйл ажиллагааг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмын дагуу явуулна.

4.12. УСТГАЛ

Зориуд устгаж унтуулсан эсвэл үхсэн амьтны хүүр, сэг зэм, халдвартай материалыг сайтар битүүмжилж, зөөвөрлөхдөө ариун цэврийг чанд мөрдөж булшлах газарт хүргэсний дараа ашигласан машин техникээ цэвэрлэн ариутгана.

Булшлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ орон нутгийн төрийн захиргаа, хууль, онцгой байдлын болон мал, хүн эмнэлгийн мэргэжлийн байгууллага, байгаль орчны албадтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр устгах арга, булшлах газрыг сонгох ба устгах, булшлах, халдваргүйжүүлэх арга хэмжээг хамтран авч хэрэгжүүлнэ. Булшлах газрыг сонгохдоо хөрсний ус, нуур, голын эргээс хол зайтай, улсын болон орон нутгийн чанартай авто болон төмөр зам, нутгийн шүтлэгтэй уул, овооноос зайдуу, мал, хүний суурьшил сийрэг, үерийн усанд автахааргүй, өндөрлөг, хуурай хөрстэй, зонхилох салхины чиглэлийн эсрэг талд байрлах зэрэг шалгуурыг харгалзана.

Булшлах үйл ажиллагаанд дараах үндсэн 2 аргыг дангаар буюу хослуулан хэрэглэнэ. Үүнд:

а. Шатааж хөрсөнд булшлах. Гоц халдварт ба зарим халдварт өвчтэй амьтдыг энэ аргаар булшлах бөгөөд шатаах нүхээ бэлдэж ёроолд нь сүрэл дэвсэж, нүхний дунд хэсэг хүртэл устгах зүйлсээ байршуулаад шатаах хэрэгслээр дүүргэж шатаана. Устгалын явцад гарсан үнс, бусад үлдэгдлийг нүхэнд булна. Өвлийн улиралд шатамхай бензин, дизелийн түлш, керосин, мод зэрэг шатамхай бодис, материал ашиглаж болно.

б. Хөрсөнд булшлах. Гоц халдварт ба зарим халдварт өвчтэй, онош тодорхойгүй шалтгаанаар хорогдсон, зориудаар устгасан амьтдыг энэ аргаар булшлах бөгөөд нүхний гүн нь 250-300 см байна. Нүхний ёроолд 25-28%-аас дээш идэвхт хлор бүхий хлорын шохой эсвэл гипохлорт кальцийг хуурайгаар нь 2-3 см зузаантай дэвсэж чийглэх юм уу формальдегидийн 4-10%-ийн уусмалаар шүршинэ. Нүхэнд булшлах зүйлсийг үелүүлэн байршуулж, үе тус бүрийг халдваргүйжүүлэх бодисоор хучих буюу шүршинэ. Нүхийг 50 см-ээс доошгүй зузаан хөрсөөр дүүргэж сайтар чигжинэ. Эцэст нь газрын гадаргаас дээш 50 см өндөр шороо овоолж анхааруулсан тэмдэг байрлуулна.

Булах ажлыг гүйцэтгэж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг сайтар хангах, хүн амьтан, шувуунд халдвар дамжихаас сэргийлэн булшлах ажлыг богино хугацаанд түргэн шуурхай гүйцэтгэх, байгаль орчинд ямар нэгэн хор, аюулгүй байх нөхцлийг урьдчилан тооцсон байвал зохино.

4.13. АЮУЛТАЙ АМЬТАНТАЙ ХАРЬЦАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Зэрлэг амьтан адуулахад хүнд элдэв эрсдэл, аюул учруулахгүй байх нөхцлийг хангасан байх ёстой. Биеийн хэмжээ, хүч чадал, ялгаруулах хор, өөрийгөө хамгаалах хэрэгсэл (хурц соёо, эвэр, туурай, хорт шүд г.м), зан төрх нь хүнд эрсдэл үүсгэхээр бол аюултай гэж үзнэ. Ийм нөхцөлд амьтан бүрд зориулсан аюулгүй ажиллагааны арга хэмжээг хангаж мөрдөнө. Сахин хэрэгжүүлэх аюулгүй ажиллагааны зааврыг удирдах хүмүүс хариуцан боловсруулж, ажиллагсад зааж сургана.

Аюултай амьтдыг барих багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж (тор, бариултай тор, унтуулах багаж, буу, хамгаалах зааварчилгаа г.м)-ийг шаардлагатай хэмжээгээр урьдчилан бэлдэж, бэлэн байлгана. Аюултай амьтантай харьцах заавар, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө гаргасан байна. Төлөвлөгөөг холбогдох байгууллагатай зөвшилцсөн байна. Хор ялгаруулах амьтан адуулах нөхцөлд тухайн чиглэлээр мэргэшсэн эмчийн оролцоотойгоор аюулын үед дагаж мөрдөх арга хэмжээг төлөвлөсөн байна. Хорны эсрэг үйлчлэлтэй бодис бэлдмэлийг бэлэн байлгах шаардлагатай.

БҮЛЭГ ТАВ. ГОВИЙН БҮСИЙН НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ АРГАЧЛАЛ

5.1. БАРИХ, ЗӨӨВӨРЛӨХ АРГАЧЛАЛ

Монгол оронд нийтдээ 142 зүйл, дэд зүйлийн зэрлэг хөхтөн амьтад тархсан бөгөөд эдгээрийг дотор нь шавьж идэштний баг, гар далавчтны баг, туулай хэлбэртний баг, мэрэгчдийн баг, мах идэштний баг, туруутны баг, туурайтны баг, тавхайтны баг гэсэн 8 багт хамаарна. Эдгээрээс говийн бүсэд тархсан нэн ховор, ховор зүйл амьтдаас мэрэгчдийн багт Гозоорой зурам, Сухайн чичүүл, Давжаа алагдаага, Соотон алагдаага, Элсний тажигдаахай, Зүүн гарын даахай, мах идэшний багаас Цөөвөр чоно, Мазаалай баавгай, Эрээн хүрнэ, Ирвэс, Шилүүс, Цоохондой, туруутны багаас Хар сүүлт зээр, Монгол бөхөн, Янгир, Аргаль, Туурайтны багаас Хулан адуу, Тахь адуу, Тавхайтнаас Хавтгай гэсэн амьтад орж байна.

Дээр дурьдсан нэн ховор, ховор амьтдаас “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-д байршуулах боломжтой амьтдыг сонгохдоо Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслийн зорилтот амьтан болоод говийн гайхамшигт 6 зүйл болоод арчилгаа маллагаа даах байдал, дасан зохицох чадварыг үндэслэн өвсөн тэжээлт зүйлүүдийг судлах хамгаалах төвд байршуулах нь боломжтой гэж үзлээ. Энэ утгаараа эхний ээлжинд Хар сүүлт зээр, Монгол бөхөн, Янгир, Аргаль, Хулан адуу, Тахь адуу, Хавтгай, Халиун буга гэсэн зүйлийг сонгон авлаа.

Монгол орны хөхтөн амьтдын дотор туруутан, туурайтан, тавхайтан амьтдын зүйл харьцангуй цөөн тоотой бөгөөд тэдгээрийн ихэнх нь ховор, нэн ховор ховордож болзошгүй амьтад байдаг онцлогтой. Энэ багт өвсөн болон холимог идэштэй дараах 13 зүйлийн хөхтөн амьтад багтана.

Аливаа эрсдэл учирсан туруутан, туурайтан, тавхайтан амьтдыг барих, зөөвөрлөх, тэдэнтэй харьцахад олон талын болгоомжлол шаардахаас гадна, энэ ажил төдийлөн амаргүй юм. Тухайлбал, тэдгээрийг барихад хүн хүч, техник тоног төхөөрөмж, зардал чирэгдэл ихтэйгээс гадна, аюулгүй ажиллах хэрэгтэй болдог. Хэдийгээр ядарч туйлдсан, өвдсөн, гэмтсэн боловч эдгээр тураг амьтад нь зэрлэг догшин зан төрхөө хадгалсаар байдгийг юуны өмнө байнга анхаарч байх ёстой. Тэдгээрийг барихад хамгийн тохиромжтой арга нь унтуулагч буу хэрэглэх арга бөгөөд бас тороор барьж болно. Унтуулсны дараа эсвэл торонд оруулсны дараах богино хугацаанд амжиж барих, аюулгүй байдлыг хангаж нүдийг хаах, уяа аргамжаа хийх, хөдөлгөөнийг хязгаарлах, зөөврийн чингэлэгт байршуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх нь чухал. Унтуулагч буу хэрэглэх тохиолдолд буудагч нь буу эзэмших эрхтэй, туршлагатай, тайвшруулагч сумны тунг тохируулах чадвартай байх зэрэг олон шалгуурыг хангасан байх учиртай.

Түүнээс гадна, эвэр, туруу томтой, биеийн жин ихтэй буга, бор гөрөөс, аргаль, янгир, бөхөн, зээр зэрэг туруутан амьтдад мөргүүлэх, тийрүүлэхээс сэргийлэх, хулан, тахь, хавтгай зэрэг том туурай, тавхайтай урт хөлийн амьтад өшиглөх, тийрэх, хазах зэргээр олон янзын зан төрхтэйг анхаарч болгоомжтой харьцахыг эрхэмлэнэ. Түүнчлэн эдгээр амьтадтай харьцахдаа халдварт өвчнөөс болгоомжлох, вакцин хийх зэргээр элдэв халдвар дамжихаас сэргийлэх хэрэгтэй.

Тураг амьтдыг зөөвөрлөж хамгаалах төвийн байранд авчрах нь мөн л амаргүй, ихээхэн нягт нямбай, анхаарал болгоомжтой байхыг шаардсан ажил юм. Тухайлбал, тэдгээрийг зөөвөрлөх сав, машин техник тоног төхөөрөмж шаардлагатай. Эдгээрийг зөөвөрлөхөд өөрийнх нь хэмжээнд тохирсон том хэмжээний модон чингэлэг хэрэгтэй

болно. Хулан зэрэг туурайтныг модоор хийсэн зөөврийн чингэлэг саванд байрлуулж, машины тэвшинд хөдөлгөөнгүй суурилуулах хэрэгтэй. Аргаль, янгир, бөхөн, зээр, буга, зэрэг амьтдыг биеийн хэмжээнд нь тохирсон, доторлогоо бүхий модон чингэлэг ашиглаж зөөвөрлөх бөгөөд чингэлгийн шал нь өвсөн дэвсгэртэй, хаалга нь бэхэлгээ түгжээ сайтай, гэрэл багатай эсвэл нүдний хаалттай байх зэрэг олон шаардлага тавигдана. Энэ тухай тусгай шаардлагад тодорхой заасан байгаа тул энэ бүх шаардлагыг мөрдөх нь зүйтэй.

Амьтны тухай хууль, Засгийн газрын тогтоол, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын хавсралт, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай конвенцын хавсралт Монгол Улсын Улаан ном, Улаан данс зэрэг ховор амьтан хамгааллын баримт, бичгүүдэд бүртгэлтэй амьтдыг байгаль орчны төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр барих, асрах, суллах үйл ажиллагааг явуулна.

Хүснэгт 5.1. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-д байршуулах

амьтны тоо, зардлын тооцоо

№	Зүйлийн нэр	тоо	Хүйсийн харьцаа		Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих** Зөвшөөрлийн хураамжийн хэмжээ /мян.төгрөгөөр/		Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих Зөвшөөрлийн хураамжийн дүн /мян.төгрөгөөр/	Амьтан барих газрыг тогтоох, барилт хийх, тээвэрлэж авчирах төслийн зардлын дүн /мян.төгрөгөөр/	Нийт дүн
			Эр	Эм	Эр	Эм			
1	Хар сүүлт зээр	8	2	6	340.0	400.0	3080.0	15000.0	18080.0
2	Монгол бөхөн	8	2	6	400.0	400.0	3200.0	20000.0	23200.0
3	Янгир	8	2	6	540.0	620.0	4800.0	15000.0	19800.0
4	Аргаль	6	1	5	2200.0	2600.0	15200.0	15000.0	30200.0
5	Хулан адуу	6	1	5	1940.0	2200.0	12940.0	20000.0	32940.0
6	Тахь адуу	6	1	5	2200.0	2600.0	15200.0	20000.0	35200.0
7	Хавтгай	6	1	5	3800.0	4260.0	25100.0	5000.0	30100.0
8	Халиун буга	6	1	5	1320.0	1500.0	8820.0	25000.0	33820.0
Нийт							88340.0	135000.0	223340.0

**Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар агнах, барих

5.2. ХАШААНЫ ХИЙЦ, БҮТЭЦ, ТОНОГЛОХ АРГАЧЛАЛ

Аливаа эрсдэлд орсон туруутан, туурайтан, тавхайтан амьтдыг том хэмжээний багтаамж бүхий өндөр ханатай, хашаанд байрлуулан асрах бөгөөд хашаа нь хэвтэр, усан сан, тохиромжтой субстрат зэрэг тухайн төрөл зүйлийн амьтны нөхцөл байдалд тохирсон амьдрах орчны элементүүдийг агуулсан байх нь зүйтэй. Ерөнхий том хашаа нь дотроо торон тасалгаа бүхий жижиг хэсгүүдтэй байх нь тохиромжтой. Хашаа нь амьтан гэмтээхээс урьдчилан сэргийлэх, бусад зэрлэг амьтан, гэрийн мал амьтан, хортон шавжийг оруулахгүй байхаар бүтээгдсэн байвал зохино. Хашааны хийц, бүтэц нь өвдсөн, гэмтсэн, шархадсан, өнчирсөн, ядарч туйлдсан зэрэг олон янзын эрсдэлд орсон амьтдыг байгалийн зэрлэг зан төрхийг нь алдагдуулахгүйгээр богино хугацаанд дасган, гаршуулан тэжээхэд чиглэгдсэн байх учиртай.

Хашаа

Амьтан судлах хамгаалах төв нь ажилчид, судлаачид, зочид, жуулчдын аюулгүй байдал, хамгаалалтыг хангадаг бөгөөд бат бөх, харагдац сайтай байх нь чухал үзүүлэлт юм. Тиймээс хашаагаа төлөвлөхдөө амьтан болон зочдын аюулгүй байдлыг хангах нь нэн тэргүүний асуудал юм.

Хашаа нь ирсэн зочид жуулчид амьтныг ойроос харахыг хүсэлд нийцсэн байх ёстой. Харин тэд хашааны торны бүтэц амьтдыг ойроос мэдрэх, зураг авахийг хүсдэг. Иймд тод, тасалдалгүй харагдах боломжийг олгодог.

Аливаа амьтан судлах хамгаалах төвийн зэрлэг ан амьтдын байгууламж бүр өөр өөр шаардлага, хамгаалалтыг зохих түвшинд байлгахын тулд хашаа барих шаардлагатай байдаг. Тиймээс бид шаардлагатай стандартад нийцсэн янз бүрийн хувилбар, шийдлийг сонгох нь чухал юм.

Тус төв нь дараах хашааны 2 хэлбэртэй. Үүнд:


- Хязгаарлалтын хашаа
- Хамгаалалтын хашаа

Хязгаарлалтын хашаа

Бид хязгаарлалтын хашааг 2,2 м өндөртэй шон хоорондын зай 4 м хийхээр төлөвлөсөн бөгөөд зэрлэг амьтан харайх, хашааг цэвэрлэх боломж бүрдүүлэх, хүн хашлага руу авирах, хашаа руу орох боломж байхгүй гэдгийг баталгаажуулсан.

Хязгаарлалтын хашааг үндсэн хашааны хойд хэсэгт залгуулан барих бөгөөд тухайн хашаанд шинээр ирсэн амьтдыг тусгаарлах, биологи, зан төрхийн судалгаа хийх, нөөц амьтдыг тусгаарлах, үржлийн үед хөөгдсөн залуу бодгалиудыг тусгаарлах, үржлийн үеийн тэмцэлдээнээс сэргийлэх үүднээс зарим эр бодгалиудыг тусгаарлах, махчдын довтолгооноос хамгаалах, судлаач, зочид, жуулчид багатай улиралд амьтдыг бэлчээх, хашаа хороог цэвэрлэх ариутгах үед суллах, байгальд буцааж тавихдаа зөөлөн арга хэрэглэх зэрэг олон зориулалтаар ашиглана.

Хязгаарлалтын хашаа нь 50 га газрыг хамрах бөгөөд хашаанд байгалийн бүрдэл хад чулуу, сайр, мод бут, уст цэг зэргийг оруулах нь ач холбогдолтой.



Зураг 5.1. Хязгаарлалтын хашааны план зураг

Хашааны нийт урт 10000 м байна. Хашаанд шаардлагатай материалын зардлыг дараагийн бүлэгт орууллаа.

Хашааны ерөнхий план зургийг оруулсан ба торон хашааг бат бэх барьж хашаан дээгүүр болон доогуур хүн болон махчин амьтан нэвтрэхээс зайлсхийсэн болно.



Зураг 5.2. Торон хашааны дээгүүр өргөст тор татах ба хашааны ёроолоор төмөр тор байрлуулна.

Хамгаалалтын хашаа.

Хамгаалалтын хашаа нь Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төвийн үндсэн хашаа бөгөөд энэ хашаанд амьтны байр, ажилчдын байр, аж ахуй, тэжээл нөөцлөх агуулах, авто зогсоол, явган зам зэрэг объектууд багтана. Хашааг бат бэх байдал, аюул, эрсдлээс хамгаалах зориулалтаар бусад олон улсад ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын стандартын дагуу хийхээр төлөвлөв.

Энэ хашаа нь нийт 6 га талбайг хамран орших ба цаашид өргөжин тэлэх боломжтой байхаар тооцов.



Зураг 5.3. Төвийн ерөнхий харагдах байдал (дээрээс)


“Төвийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” –ийн үндсэн хашаа нь 322м урт, 199м өргөн буюу нийт 6.4 га нутаг дэвсгэрийг хамарна.

Энд зэрлэг амьтан байрлуулах 4 байр, оффисийн байр, харуулын байр гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Байрлалын хувьд уламжлалт буюу хойд талаараа амьтад байрших байрууд, урд хэсэгтээ угтах хаалга, оффисийн байр, зочидыг угтах машин болон хүн цуглах талбай байрлана.




Зураг 5.4. Төвийн ерөнхий харагдах байдал (урдаас)


Хашааг дагуулан говийн бүсийн модлог ургамал болох элдэв навчит улиас, жигд, хайлаас модыг хослуулан тарихаар төлөвлөсөн.



Зураг 5.5. Төвийн ерөнхий харагдах байдал (баруун талаас)



Зураг 5.6. Төвийн ерөнхий харагдах байдал (хойноос)



Зураг 5.7. Төвийн ерөнхий харагдах байдал (зүүнээс)



Зураг 5.8. Амьтны хашааны гадна талаас харсан байдал

Нэг зүйл амьтны хамгаалалын хашаа нь 40м х 37м буюу 0.15 га –г эзэлнэ. Энэхүү хашаанд тогтмол тэжээл, усалгааны горимд 6-8 бодгалиуд байхад тохиромжтой бөгөөд үржил, төлөлтийн үед зарим бодгалиудыг том хашаанд шилжүүлэн байршуулна.



Зураг 5.9. Амьтны хашааны гадна талаас харсан байдал

Хашаа нь газраас доош 30см суурьтай, газрын гадаргаас дээш 80 см цементээр цутгасан, түүнээс дээш 150 см хоорондоо хөндөлгүй тууш төмөр торон хашаатай, үүний дээр 140 хэмийн дотогш налуу нарийн торон хашаа үргэлжилнэ. Нийт хашааны өндөр 280см болно.



Зураг 5.10. Амьтны хашаан дотроос харсан байдал

Хашааны бүтцийн ажлын план зургийг доорхи зургаар үзүүлээ.

5.3. БАЙР ОРОМЖИЙН ХИЙЦ, БҮТЭЦ, ТОНОГЛОХ АРГАЧЛАЛ

Амьтны байр оромжийн хийц, бүтэц

Амьтан хамгаалах байранд амьдралын хэв маяг, зан төрхийн хувьд хоорондоо нийцэлтэй зүйлийг ойролцоо хашаанд байрлуулж, эхний хэд хоногт тэдний харилцаанд байнгын хяналт тавьж ажиглалт хийх, байгаль дээр хамтын бүлгэмдэл үүсгэдэг амьтдыг боломжтой бол ижил төрлийн зохих нас, хүйсийн амьтадтай нь хамт байлгахыг эрхэмлэх зэргээр амьтад хоорондын зан төрхийн харилцааг тооцсон байх нь хашаа байрны орон зайг хэмнэх сайн талтайг анхаарахад илүүдэхгүй.

Хашаан доторх идэш тэжээлийн болон усны сав зэрэг бүх хэрэгсэл нь эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан, амьтнаас хүнд болон бусад амьтад халдварт өвчин дамжихгүй байх бүх талын нөхцлийг бүрдүүлсэн байх нь чухал.

Зэрлэг амьтныг асрах явцад ойр ойрхон давталттай юм уу эсвэл удаан үргэлжилсэн стресс нь тэдгээр амьтдын өсөлтийн хурдыг бууруулж, турах, хэвийн бус зан төрх (жишээ нь, өөрийгөө хазах, гэмтээх г.м)-ийг үүсгэх, асаргааны үр дүнг бууруулах, хорогдох эрсдлийг нэмэгдүүлдэг сөрөг талтай. Стрессийн илүү нарийн шинж тэмдгүүд нь байнгын давтамжтай байдаг бөгөөд үүний үр дүнд стрессээс үүдэлтэй хэвшмэл сөрөг зан төрхүүд үүсэж болдгийг анхаарах хэрэгтэй.

Нэг байранд 2 зүйл ховор амьтан байрших ба байрны хооронд ханаар, гадаа талбайг тороор хязгаарлаж өгнө. Энэхүү байр нь урагш харсан хаалга хаалганы дээгүүр үргэлжин 3 цонхтой байх бөгөөд нарны тусгалыг байранд оруулснаар элдэв өвчин үржих, байрны дулааныг нарны энергээр хангахад чиглэсэн. Мөн дээрээ салхивч гаргасан нь байрны доторх агаарын сэлэлтийг хийх үүрэгтэй.



Зураг 5.12. Амьтан хамгаалах байр




Зураг 5.13. Амьтан хамгаалах байрны зүүн урд талаас



Зураг 5.14. Амьтан хамгаалах байрны зүүн талаас

Байрны хойд талд үргэлж торон ханатай саравч хийсэн бөгөөд энд тухайн зүйл амьтны идэш тэжээл, усыг хадгалах шинээр ирсэн бодгалиудыг тусгаарлах зэргээр ашиглана.




Зураг 5.15. Амьтан хамгаалах байрны зүүн хойноос



Зураг 5.16. Амьтан хамгаалах байрны хойд талаас



Зураг 5.17. Амьтан хамгаалах байрны баруун хойд талаас



Зураг 5.18. Амьтан хамгаалах байрны баруун талаас



Зураг 5.19. Амьтан хамгаалах байрны хойно байрлах тэжээлийн хадгалах хэсэг



Зураг 5.20. Амьтан хамгаалах байрны дотор талд амьтан тусгаарлах өрөө, эмчлэх өрөөний байрлал



Зураг 5.21. Амьтан хамгаалах байрны дотор тал

5.4. ТЭЖЭЭХ УСЛАХ, ТОРДОХ АРГАЧЛАЛ

Амьтан хамгаалах амьтдын идэш тэжээлийг тухайн амьтны эрсдлийн байдал тарга хүч, нас хүйс зэрэгт нь тохируулж өгөх бөгөөд энэ талаарх мэдээлэл дутмаг бол биологич, малын эмч нарын зөвлөгөөг авч өөрсдийн тодорхой удирдамж боловсруулж авах хэрэгтэй. Гадаад орны адил төрлийн үйл ажиллагааг явуулж буй мэргэжлийн байгууллага, ажилтнуудтай холбоо харилцаатай ажиллах тэжээх аргуудад сайн суралцах нь чухал юм.

Амьтан маллагч, мэргэжилтнүүд тухайн зүйл амьтны идэш тэжээлийн талаар сургалтад сууж, судлаачид болон бусад туршлагатай хүмүүсээс зөвлөгөө авч, тодорхой туршлага хуримтлуулсан байх нь зүйтэй.

Хамгалах төвд буй амьтны идэш тэжээл нь хоол боловсруулах хэвийн үйл ажиллагаанд зохицсон, байгальд тавьсны дараа түүнийгээ таньж олоход нь сургасан, эрүүлжүүлэх наад захын хэрэгцээг хангасан, байгаль дээр иддэг тэжээлтэй нь аль болох төсөөтэй байвал зохино.

Хүснэгт 5.2. Амьтны тэжээлийн норм

№	Амьтны нэр	Хугацаа	Амьтны тоо /толгойгоор /	Багсармал тэжээл /тонн/		Өвс /тонн/		Давс, хужир /тонн/	
				Хоногийн тэжээлийн норм /кг/	Хэмжээ, тонн	Хоногийн тэжээлийн норм /кг/	Хэмжээ, тонн	Хоногийн тэжээлийн норм /кг/	Хэмжээ, тонн
1	Аргаль хонь	365	6	0,5	1,095	2,5	5,475	0,01	0,0219
2	Янгир ямаа	365	6	0,2	0,438	1	2,19	0,01	0,0219
3	Хулан адуу	365	6	1	2,19	4,8	10,512	0,03	0,0657
4	Хавтгай	365	6	2	4,38	9	19,71	0,03	0,0657
5	Халиун буга	365	6	0,1	0,219	1,26	2,7594	0,01	0,0219
6	Тахь адуу	365	6	0,1	0,219	4,8	10,512	0,03	0,0657
7	Монгол бөхөн	365	8	0,1	0,292	0,6	1,752	0,01	0,0292
8	Хар сүүлт	365	8	0,1	0,292	1,3	3,796	0,01	0,0292
9	Нийт тэжээлийн хэрэгцээ				9,125		56,7064	0,14	0,3212
10	Эхний жил зардал	25209820			9417000		15150420		642400
11	2 дахь жил зардал	32772766			12242100		19695546		835120

- Мал аж ахуйн хүрээлэнгээс гаргасан амьтны тэжээлийн норм

Ихэнх амьтад зориудын орчинд удаан байх үед витамин, эрдсүүдийн дутагдалд ордгийг урьдчилан тооцож нэмэлт витамин эрдэс өгч байж зөв тэжээл болно. Гэвч нэмэлт зүйлийг буруу хэмжээгээр хийвэл идэш тэжээлтэй холбоотой бэрхшээл ч үүсэж болохыг анхаарах ёстой.

Амьтныг байгальд суллахын өмнө тэдгээрийн тэжээлийн орцонд нь байгальд чөлөөлөн тавьсны дараа тэдний амьдрах орчинд элбэг тохиолдох бүтээгдэхүүнийг боломжтой хэмжээгээр нэмж өгч байх ёстой.

Бохирдол, өвчин дамжихаас зайлсхийхийн тулд ан амьтан, хүний хоол бэлтгэх газар, багаж хэрэгслийг тусад нь байлгах хэрэгтэй.



Зураг 5.23. Амьтан услах онгоц

Амьтан услах усны онгоцонд тавигдах шаардлага нь 1. Амьтанд элдэв харшлах бодис хийж байгаагүй материалаар хийгдсэн байх, 2. Мал амьтныг өдөрт ундаалах усны хэмжээг агуулах багтаамжтай байх, 3. Онгоц доторхийг цэвэрлэж ариутгах боломжтой байх, 4. Онгоцны усыг өдөртөө сольж хуучин усыг асгах хүйс цорготой байх, 5. Амьтны амыг ураг элдэв сэртэн, үзүүргүй байх, 6. Тухайн амьтны өндрөөс шалтгаалан газраас дээш өндрийг тохируулж болохоор байх зэрэг болно.

Хүснэгт 5.3. Амьтан судлах хамгаалах төвийн амьтны усалгаанд өдөр болон жилд хэрэглэх усны хэмжээ, амьтан услах онгоцны зардал

№	Зүйлийн нэр	Бодг алийн тоо	Нэг бодгаль хэрэглэх өдрийн усны норм*** /литр/	Өдөрт хэрэглэх усны норм л/хоног	Жилд хэрэглэх усны хэмжээ /тонн/	Шаардлага тай 100л усны онгоцны уртын хэмжээ /метр/	1м урттай усны онгоцны үнэлгээ /төгрөг/	Нийт үнэлгээ /төгрөг/
1	Хар сүүлт зээр	8	3.5	28	10.2	2	100000	200000
2	Монгол бөхөн	8	3.5	28	10.2	2	100000	200000
3	Янгир	8	3.5	28	10.2	2	100000	200000
4	Аргаль	6	3.5	21	7.7	2	100000	200000
5	Хулан адуу	6	35	210	76.7	2	100000	200000
6	Тахь адуу	6	35	210	76.7	2	100000	200000

7	Хавтгай	6	60	360	131.4	4	100000	400000
8	Халиун буга	6	30	180	65.7	2	100000	200000
9	Хязгаарлалтын хашаа					4	100000	400000
Нийт дүн		54	174	1065	388.8	22		2200000

*** Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зарцуулах усны норм батлах тухай БОНХАЖ-ын сайдын тушаалын 11-р хавсралт

5.5. АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ БАЙРНЫ АРИУТГАЛ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ

АРГАЧЛАЛ

Хөхтөн амьтдыг судлах, хамгаалахдаа амьтдын оромж, байрыг цэвэрлэх, ариутгах хугацааг тодорхой заасан төлөвлөгөөтэй байна. Энэ төлөвлөгөөнд амьтдын байр, оромж, хашаа зэргийг сар тутамд их цэвэрлэгээ, ариутгал заавал хийхээр тусгах ёстой бөгөөд энэ үед амьтдыг байрнаас нь түр зайчуулан байршуулах нөхцөл боломжоор бүрэн хангагдсан байвал зохино.

Хөхтөн амьтдын байр, хашаа, хэвтэр, холбогдох бусад газрууд, түүний ойр орчмын хог хаягдал, амьтдаас үүсэлтэй бохирдол зэргийг графикт хугацааны дагуу тогтмол цэвэрлэж байх бөгөөд энэ нь амьтад болон түүнийг маллаж буй иргэдийн ариун цэвэр, аюулгүй байдлыг хангахад ч бас чухал ач холбогдолтой. Тухайлбал, том амьтдын хашааг 7 хоногт 1 удаа заавал цэвэрлэж, элс хөрсөн дэвсгэр нойтон бохирдсон нарийн өвс, солом, зэгс зэрэг дэвсгэрийг солино. Амьтны байрны (тор, байшин, хашаа г.м) цэвэрлэх ариутгах боломжгүй гадаргууг элэгдэж бохирдсон үед шинэчилнэ. Харин асаргаанд буй амьтад байнга хүрэлцэж байдаг хатуу гадаргууг өдөр бүр цэвэрлэнэ. Бусад гадаргууг цэвэрлэгээний графикт заасан хугацаанд цэвэрлэх боломжтой.

Асаргаанд буй хөхтөн амьтны идэш тэжээлийн тавцан, тэжээл болон ус уудаг газруудыг 7 хоногт 1-ээс доошгүй ариутгах нь зүйтэй. Амьтны тэжээл иддэг газар тавцан зэргийг олон амьтан ээлжлэн ашигладаг тохиолдолд дараагийн амьтны тэжээлийг өгөхөөс өмнө заавал ариутгана. Амьтны байранд хэрэглэх хогийн сав нь зориулалтын таглаа битүүмжлэлтэй байх бөгөөд байнга ариутгана. Асаргаанд буй хөхтөн амьтдын байр, оромж, тор, хашаа зэргийг цэвэрлэсэн, ариутгасан тухай журнал хөтөлнө. Журналын бүтэц дараах хэлбэртэй байна.

Хүснэгт 5.4. Амьтны байрны цэвэрлэгээний журналын загвар

№	Цэвэрлэсэн хугацаа	Амьтантай байр	Байрны дугаар	Амьтны нэр	Цэвэрлэсэн хүний гарын үсэг
1					
2					

5.6. ГОВИЙН БҮСИЙН НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВИЙН ОФИССЫН БАЙРНЫ ТӨЛӨВЛӨЛТ

“Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилга нь нарны эх үүсвэр бүхий цахилгаан энергийн хангамжтай, эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн мэдээллийн төв бүхий байрыг барих нь тус газрын материаллаг баазыг олон улсын түвшинд хүрэхүйц чанаржуулж, удаан хугацааны судалгаа хийх, олон зочид, жуулчдыг татах түшиц төв болохоор төлөвлөгдөж байна.



Зураг 5.24. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилга

Оффисийн барилга нь 19.9м х18.9м харьцаатай, 2 давхар бөгөөд 1-р давхарт граш, агуулах, мэдээллийн төв, хурлын танхим, лаборатори, номын өрөө, тусгаарлах зоо, гал тогоо, эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөө, өргөн коридороос тогтоно. 2-р давхарт өргөн коридори, лабораторын 2 өрөө, дарга болон ажилчдын 4 өрөө, эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө, орчныг ажиглах терассанаас бүрдэнэ. Барилга нь орчин үеийн хэв маягтай, байгалийн дулааныг ашиглах наран тал руугаа харсан том цонхтой байхаар төлөвлөгдсөн. Барилгын 2 давхарыг тойрсон террас нь ажилчид, судлаачид, зочид, жуулчид эргэн тойрныг ажиглах боломжийг олгоно.



Зураг 5.25. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (баруун хойно)



Зураг 5.26. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (хойноос)



Зураг 5.27. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (зүүн хойноос)




Зураг 5.28. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (зүүн өмнөөс)



Зураг 5.29. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн оффисийн барилгын харагдах байдал (өмнөөс)


Говийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв Судалгаа, офисийн барилга 1-р давхарын план байгуулалт
2022.11.25





Өрөөний тодорхойлолт

Орны Тайлбар	Өрөөний нэр	Талбар м ²	Шэл төрөл
1	Хоолоо	42	Баримтлал
2	Лаборатор	17	Баримтлал
3	Агуулгах	70	Баримтлал
Нийт талбар 129 м ²			
4	Нөмийн өрөөн	20	Паркет
5	Газал хоолоо	15.5	Паркет
6	Хүдсний өрөөн	41	Паркет
7	Мэргэжилтний тус	29	Паркет
8	Тусгаарлах зор	6.4	Чулуу
9	ОО-ийн	3.4	Чулуу
10	ОО-ийн	2.7	Чулуу
11	ОО-ийн хамгаалах бар	2.7	Чулуу
12	Усанг ороох өрөөн	7	Чулуу
Нийт талбар 195 м ²			

Хэсэглэл А-А



Хэсэглэл Б-Б



Улаанбаатар хот, Хэнтийн дүүрэг, 11-р хороо				Б-1
Говийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв				
Замраг	Т.Ариунзaya	Төрийн байгуулалт	Масштаб	1:100
Харилцагч	Т.Мөнхтөгвийн	Т-309	Өгөгдөлтэй байгуулагч	Б.Эрдэнэ
Гүйцэтгэгч	Б.Эрдэнэ	41 сая.р	А3	1
Сайжигч	С.Цэцэг	10 сая.р	Т.Ариунзaya	2022.11.25

Зураг 5.30. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-ийн офисийн барилгын 1 давхарын план зураг

5.7. АМЬТАН СУДЛАХ ХАМГААЛАХ ТӨВД БУЙ ХӨХТӨН АМЬТАДТАЙ

ХАРЬЦАХ АРГАЧЛАЛ

Хөхтөн амьтад нь түүхэн хөгжлийн явцад олон янзын амьдрах орчныг эзэмшин тархсан өндөр хөгжилтэй бүлэг амьтад билээ. Хөхтөн амьтад нь амьдрах орчин, идэш тэжээлийн онцлог, бусад амьтадтай харилцах чадвар, мэдрэлийн систем, мэдрэхүйн эрхтний нарийн хөгжил зэрэг олон хүчин зүйлээс хамааран олон янзын зан төрхтэй болон хөгжсөөр иржээ. Тухайлбал, довтлох, зугтах, нуугдах, түрэмгийлэх зэрэг олон янзын зан төрхтэй бөгөөд эдгээр шинжид тохируулан харьцах шаардлагатай.

Орчин үед хүний үйл ажиллагааны шууд ба дам нөлөөгөөр Монгол орны хөхтөн амьтдын тархац, байршил, амьдрах орчин өөрчлөгдсөөр байна. Түүгээр ч барахгүй хөхтөн амьтад хүний нөлөө, хууль бус агнуурын улмаас гэмтэх, шархдах, өнчрөхийн зэрэгцээ байгалийн ган, зуд, түймэр зэрэг гэнэтийн гамшигт үзэгдлийн нөлөөгөөр эрсдэлд орох нь нэмэгдсээр байна. Эдгээр амьтдыг аврах, асран хамгаалах үйл ажиллагааг зохих шаардлагын дагуу эрхлэхийн тулд тухайн амьтны зан төрхийн онцлогийг сайн мэдэж харьцах нь чухал. Асаргаанд буй гэмтсэн, өвдсөн, шархадсан амьтад стресс ихтэй байдаг тул дараах журмыг баримтлан харьцана. Үүнд:

Амьтан маллагч болон мал амьтны эмч нар хөхтөн амьтантай харьцах дүрмийг баримтлан ажиллах шаардлагатай бөгөөд тухайн амьтны зан төрхөд тохируулан харьцах аргыг эзэмшсэн байхыг шаардана. Тухайлбал, шавьж идэштэн, сарьсан багваахай, мэрэгч амьтад нь хурц жижиг шүдтэй тул хазуулахаас болгоомжилно. Эдгээр амьтад нян, вирусийн халдвар тарааж болзошгүйг анхаарна. Мах идэшт амьтад хүчирхэг хурц, бахим шүдтэй, хазах, довтлох, ярдаглах зан төрхтэй тул хувийн хамгаалах хэрэгсэлтэйгээр харьцах зайлшгүй шаардлагатай бөгөөд махчин амьтдын эмчилгээ, тордлогыг хийх үедээ зориулалтын ширэн хошуувч өмсүүлэх, нүдийг далдлах, зориулалтын зузаан бээлий, нүдний шил, зузаан хувцас ашиглах зэргээр болгоомжтой харьцах нь чухал.

Түүнээс гадна, тухайн амьтдын зан төрх харилцан адилгүй байдаг тул тэдгээрийг урьдчилан сайн судалж мэдэх, энэ талаар зохих туршлага, дадлага эзэмшсэн байх шаардлагатай. Тухайлбал, шархтай махчин амьтад илүү стресстэй байх тул шууд довтлох аюултай, эвэр, туруу томтой биеийн жин ихтэй хулан, тахь, хавтгай, хандгай, цаа буга, бор гөрөөс, аргаль, янгир, бөхөн, зээр зэрэг туруут амьтад догшин зантай, хөдөлгөөн хурдан байх тул мөргөх, тийрэх, цоройх, цовхрох зэрэг олон янз зан төрхтэйг анхаарч болгоомжтой харьцана.

Эдгээр тураг амьтдын эмчилгээ үйлчилгээ, тордлогыг тусгай зориулалтын хөдөлгөөнийг хязгаарласан өрөө, хашаанд оруулж хийхээс гадна, асаргаа эмчилгээнд буй хөхтөн амьтадтай харьцахдаа тэдгээрийн нүдийг шир, даавуу савхи зэрэг материалаар далдлан боох, зориулалтын уут толгойд нь углах зэрэг аргыг хэрэглэнэ. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд тураг амьтад болон махчин амьтадтай харьцахдаа малын эмчийн зөвлөгөөний дагуу түр тайвшруулах эм эмнэлгийн хэрэгсэл ч ашиглах шаардлага үүсэж болно. Тухайлбал, тураг хөхтнүүд баавгай, ирвэс, мазаалай, чоно, үнэг, дорго, элбэнх, нохой зээх зэрэг том махчид болон жижиг махчдад мэс засал хийх, шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагаанд унтуулга хэрэглэнэ. Унтуулгыг малын эмчийн заавраар хийх бөгөөд унтуулгад улсын бүртгэлд бүртгэлтэй, амьтанд хэрэглэхээр зөвшөөрөгдсөн бодис реактивыг хэрэглэх нь зүйтэй. Унтуулах, мансууруулах, тайвшруулах үйлчилгээ бүхий бодисыг тухайн амьтны биеийн жин, тэнхрэлт, өвчин, шархны байдал зэрэг олон хүчин зүйлийг урьдчилан тооцож хэрэглэнэ.

5.8. АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВД БУЙ ХӨХТӨН АМЬТДЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ

Төвд буй хөхтөн амьтдын бүртгэлийг амьтны зүйл нэг бүрээр хөтөлж, тэнхрэл эдгэрлийн явцын тухай тэмдэглэл хийж байх нь дараа дараагийн үйл ажиллагаанд туршлага болох сайн талтай. Бүртгэлийн журналд ямар зүйлийн амьтанд ямар асаргаа, эмчилгээ хийсэн, биеийн байдал, сайжирсан эсвэл муудсан гэх зэргээр амьтны асаргааны хугацаан дахь түүхийг товч тодорхой бичнэ. Бүртгэлийг тодорхой хөтөлснөөр шинээр ирсэн амьтдын асаргаа, эмчилгээнд анхаарах үйл ажиллагаа дээр эргэлзэж, цаг алдахгүйгээр шуурхай хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

5.9. АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВД БУЙ ХӨХТӨН АМЬТДЫГ ТЭМДЭГЛЭХ АРГАЧЛАЛ

Амьтан судлах, хамгаалах төвд буй хөхтөн амьтдыг тэмдэглэх нь тэдгээрийн биеийн байдлыг хянах, эмчилгээ тордлогоо идэш тэжээлд үр дүнг амьтан бүрээр үнэлэхэд чухал ач холбогдолтой. Тэмдэглэгээнд дараах зүйлийг анхаарна. Үүнд; амьтанд хийх тэмдэглэгээ нь тухайн амьтны эрүүл мэндэд харшлахгүй, тэдгээрийн идэш тэжээлээ идэх, ус уух зэрэг амьдралын нэн чухал үйл ажиллагаанд саад учруулахгүй байвал зохино. Жишээ нь, шавьж идэштэн, мэрэгчид, огдой зэрэг жижиг амьтдын хумсыг зориулалтын будгаар будаж тэмдэглэнэ. Сарьсан багваахайг нөхөн сэргээж, эрүүлжүүлээд тавих тохиолдолд зориулалтын бөгж зүүх нь цаашдын ажиглалт судалгаанд чухал үүрэгтэй.

Харин тарвага, хэрэм зэрэг дунд зэргийн биетэй мэрэгчдэд микрочип зэргийг хэрэглэх боломжтой. Ирвэс, шилүүс, баавгай, үнэг, чоно, дорго, элбэнх, нохой зээх зэрэг том махчид, суусрын овгийн жижиг махчид зэрэг амьтдыг чихний ээмгээр тэмдэглэх боломжтой. Том биетэй туруутан, туурайтан, тавхайтнуудад чихэнд өнгөт ээмэг, дугаартай ээмэг зүүх, өнгийн хүзүүвч зүүж тэмдэглэж бүртгэлжүүлэх боломжтой. Бусад зан төрхийн судалгааны зорилгоор олон төрлийн тохиолол хүлээн авах дамжуулагчуудыг ашиглаж болно.

Гэхдээ эдгээр тэмдэглэгээг мал эмнэлгийн зааврын дагуу ариутгасан зориулалтын багаж төхөөрөмжөөр мэргэжилтэн, мал амьтны эмч хийнэ. Ингэж тэмдэглэгээ хийх нь эдгээр амьтдыг суллан тавьсны дараа тэдгээр тэмдэглэгээнд үндэслэн мониторинг судалгаа хийх боломж бүрдүүлдэг сайн талтай юм.

5.10. АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ ТӨВӨӨС БАЙГАЛЬД ТАВИХ АРГАЧЛАЛ

Нэн ховор, ховор амьтдыг авран хамгаалж, тэнхрүүлж, тодорхой тоо толгойд хүргэсний дараа хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх, инбридингээс урьдчилан сэргийлэх, сүрэг сэлбэх, залуу бодгалиудыг байгалийн амьдрах орчинд нь буцааж эсэн мэнд тавихад бидний эцсийн зорилго оршино. Иймээс зориудын орчинд асарч тэнхрүүлсэн амьтдыг стандартад заасан шаардлагын дагуу хоёрдогч эрсдэлд оруулахгүйгээр байгальд буцаан тавих нь амьтныг судлах, хамгаалах үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь юм.

Судалгаа, хамгааллын ажлын үр дүнд тодорхой тооны тогтвортой сүрэг үүсгэж амжилттай гаршуулснаар ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй байгууллага, тухайн зүйл амьтан үгүй болсон газруудад сэргээн нутагшуулах үйл ажиллагаа явуулах, байгальд суллан тавьж популяцийг сэргээх хэрэгтэй. Гэхдээ байгаль орчны төлөв байдал, улирлын нөхцөл, тухайн үеийн цаг агаар, цаг хугацаа зэрэг хүчин зүйлүүд нь тухайн амьтны

цаашид идээшин амьдрах нөхцлийг аль болох бүрдүүлсэн үед л байгальд тавих учиртай. Тухайлбал, төл амьтдыг байгаль дулаарч тогтворжсон, цаг агаарын тохиромжтой үед тавих, өвсөн тэжээлт амьтдыг өвс ургамал дэлгэрсэн үед тавих гэх мэтээр уг амьтан идэш тэжээлээ олж амьдрах нөхцлийг харгалзан үзэх ёстой.

Нөгөө талаас тухайн амьтдын зэрлэг зан төрхийн төлөв байдлыг ч анхаарч үзэх учиртай. Амьтныг суллахын өмнө эдгээр амьтдыг мэргэжилтэн, эмч болон туршлагатай маллагч нар уг амьтны биеийн байдал, зан төрх, цаашид биеэ даан амьдрах чадвар зэргийг олон талаас нь бодитой үнэлсэн байх шаардлагатай. Жишээ нь, тухайн амьтны шарх, өвчин болон гэмтэл бүрэн эдгэрсэн эсэх, нас хүйсдээ зохицсон жинтэй байгаа эсэх, байгалийн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг таних, барих, хэрэглэх чадварууд нь хадгалагдаж байгаа эсэх, тухайн амьтанд махчин амьтад болон гэрийн малаас зугтах, зай барих зэрэг зэрлэг зан төрх бий эсэх, байгалийн хатуу ширүүн нөхцөлд шилжилт хөдөлгөөн хийх чадвартай эсэх, асаргааны газарт байх үеийн өнгө, үнэр, дуу чимээ зэрэгт татагдахааргүй чадвартай эсэх, байгалийн нөхцөлд ойролцоо амьдарч буй ижил төстэй зүйлүүдээ таньж, тэдэнтэй зохих ёсоор харилцах чадвар нь хадгалагдаж байгаа эсэх, хүнээс зай барих байгалийн зан төрх зэрэг нь амархан сэргэх чадвартай эсэх, байгальд амьд үлдэхийн тулд өөрөө хийдэг нүх ухах, овоохой, нуувч барих, биеэ далдлах зан төрхүүд нь хадгалагдаж байгаа эсэх зэргээр зэрлэг зан төрхийн талаас нь сайтар үнэлсэн байх хэрэгтэй.

Түүнчлэн нүүдлийн зүйлүүдийн хувьд тухайн амьтны нүүдэл хийх хугацаа нь суллах хугацаатай давхцаж байгаа эсэхийг мэргэжлийн байгууллага хүмүүстэй зөвлөлдөж нягтлан тогтоосны дараа байгалийн амьдрах орчинд нь суллахыг анхаарах хэрэгтэй юм. Хэрэв суллагдаж буй амьтны нүүдлийн хугацаа өнгөрсөн тохиолдолд дараагийн нүүдлийн хугацааг хүлээх хэрэгтэй болдгийг анхаарч энэ бүх хугацааг бүхэлд нь тооцож байж нүүдлийн сүрэгт нь нийлүүлэхийг хичээх хэрэгтэй болно. Үүнээс үзэхэд, асаргаа дууссан амьтныг дуртай үедээ байгальд суллан тавьж болдоггүйг анхааралдаа авах учиртай. Энэ жишээ нь Монгол орны уудам газар нутагт жилийн 4 улирлаар тархац байршлаа сэлгэн нутаглаж байдаг цагаан зээр, хар сүүлт зээр, монгол бөхөн, хулан, хавтгай зэрэг ховор амьтдын хувьд тохиолдож болзошгүйг анхаарвал зохино.

Амьтныг байгалийн амьдрах орчинд нь суллан тавихдаа анх барьсан газарт нь тавихыг урьдал болгох хэрэгтэй. Хэрэв анх барьсан газар нь тодорхойгүй тохиолдолд түүнтэй аль болох төстэй орчныг сонгож тавих зарчим баримтална. Харин тэрхүү шинээр сонгосон орчин нь хоргодох газар, ус, идэш тэжээлийн нөөц сайтай, махчин амьтдын болон зам харгуй багатай, дэд бүтэцгүй, хүн малын нөлөөгүй, ойрын үед газар тариалан, бүтээн байгуулалтад өртөхгүй нь баталгаажсан зэрэг нөхцлийг хангасан байвал зохино. Энэ тохиолдолд уг амьтанд хамгийн зохимжтой орчин сонгохыг амьтан маллагчийн байгаль, амьтны тухай ажиглалт, туршлагад тулгуурлах нь чухал. Гэхдээ авран хамгаалсан амьтдыг тэдгээрийн гарал үүслээс бусад орчинд суллах нь экологийн харилцан үйлчлэлийн урьдчилан төсөөлөөгүй эрсдэлд хүргэж болзошгүйг анхаарах нь зүйтэй. Тухайлбал, байгаль дахь зэрлэг амьтдын популяцид өвчин, паразит тархах, генетикийн хувьд ялгаатай байгалийн зэрлэг популяци руу удамшлын өвчин халдварлах болон генетикийн бусад үр дагаврууд гарч болзошгүй, тухайн сонгосон орчинд амьдарч буй байгалийн зэрлэг популяцийн тогтвортой социаль бүтцэд нөлөөлж болзошгүй зэрэг онолын хувьд анхаарах ёстой асуудлууд байдгийг тооцох хэрэгтэй юм.

Нөгөө талаас аажим буюу «зөөлөн» суллах хувилбарыг илүүд үзэх хэрэгтэй. Зөөлөн гэдэг нь хамгаалах төвд байх хугацаанд нь амьтныг түр хугацаанд томхон

тасалгаанд байн байн суллаж турших замаар дасгалжуулах арга юм. Урт хугацааны асрамж, социаль бүлэг шаардлагатай эсвэл өнчин амьтдад огцом суллах буюу "хатуу" хувилбар нь зохимжгүй хэмээн үздэг олон улсын чиг хандлага бий. Хатуу гэдэг нь туршиж дасгалгүйгээр шууд байгальд тавихыг ойлгоно. Хэрэв социаль амьдралтай зүйлүүдийг бүлэг болгон суллах гэж байгаа бол тухайн бүлгийн бүх бодгалиуд ижил эсвэл хөрш зэргэлдээх байршлаас гарал үүсэлтэйг харгалзан нэг дор суллаж болно.

Мөн тухайн амьтны шилжилт хөдөлгөөн хийх чадварт нь үндэслэн гарал үүсэл бүхий газраас нь тодорхой зайн хязгаар дотор нь суллаж болно. Жишээ нь: урт хөлийн туруут амьтдыг байршил нутгаас нь нэлээд хол зайд суллах боломжтой гэсэн үг.

Асаргаанаас гарсан амьтныг газрын ойрыг бодож анх барьсан газраас нь эрс ялгаатай орчинд тавих, экологийн нөхцөл нь мэдэгдэхүйц бэрхшээл учруулах, тэдний цаашдаа амьдрах боломжийг бууруулахаар байгаа тохиолдолд аз туршин суллах нь уг амьтанд дахин эрсдэл учруулахыг анхаарах хэрэгтэй.

5.11. ШААРДЛАГАТАЙ ҮЕД АМЬТНЫ АМЬ ХОРООХ АРГАЧЛАЛ

Зэрлэг хөхтөн амьтдыг судлах хамгаалах үйл ажиллагаа явуулж буй байгууллага нь зайлшгүй шаардлагатай тохиолдолд зарим амьтны амийг хороох үйл ажиллагаа явуулж болдог олон улсын жишиг бий. Түүгээр ч барахгүй зарим орны амьтан асрах байгууллагад амьтны ам хороох үйлдлийг яаралтай зохион байгуулах талаар зохих арга хэмжээг авахгүй байсны улмаас хуулийн хариуцлага хүлээдэг жишээ ч улс орнуудад байдаг ажээ. Гэхдээ амьтны амийг зориудаар хорооход тодорхой шалгуур үзүүлэлтийг мөрддөг байна. Тухайлбал, нэг талаас тухайн амьтанд асаргаа эмчилгээ хийсэн ч цаашдаа байгальд байснаасаа илүү сайн эдгэрч сайжрахгүй нь эмч мэргэжилтнүүдийн зөвлөгөөнөөр актаар тодорхойлогдсон байх, амьд үлдэх магадлал муутай, зовуурь шаналгаа ихтэй, засаршгүй хүнд гэмтэлтэй, эдгэршгүй өвчтэй зэрэг нь мэргэжилтний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн амьтан улсын болон олон улсын түвшинд ховор, ховордсон амьтны жагсаалт конвенцод бүртгэгдээгүй байх зэрэг эрх зүйн чиглэлтэй шалгуурыг хангасан байна.

Нөгөө талаас гэмтэл, өвчний улмаас эсвэл мэс заслын явцад нөхөн сэргэх чадвараа бүрэн алдсан, мөч, далавч, тавхай, сүүл зэрэг гүйх, авирах, мөлхөх, үсрэх зэрэг үүрэг бүхий эрхтнүүдийн гэмтэл нь уг амьтныг байгальд бие даан амьдрах чадварыг мэдэгдэхүйц бууруулсан, нүд, чих, хамар зэрэг эрхтнүүд гэмтэх, ажиллагаагүй болсноос үүдэн харах, сонсох, мэдрэх, үнэрлэх зэрэг орчноо мэдрэх чадварууд сэргэхгүйгээр муудсан зэрэг тухайн амьтны өөрийнх нь биеийн байдалтай нь холбоотой шалгууруудыг хангасан байх ёстой.

Эхээс өнчрөн хоцорсон бөгөөд цаашдаа амьдрах чадваргүй нь эмч, мэргэжилтний зөвлөгөөнөөр магадлагдсан, онц ноцтой халдварт өвчтэй нь тодорхой оношлогдсон төл амьтдын амийг ч зохих журмын дагуу хороож сэг зэмийг устгана. Ийм амьтдын сэг зэм, амь хороох үеийн мэдээ алдуулах уусмал зэрэг нь тухайн нутгийн хүн, амьтдад эрсдэл учруулах тул шатаах эсвэл газрын гүнд булж устгах аргыг хэрэглэнэ. Хэрэв эдгээр аргыг хэрэглэхгүй сэг зэмийг ил хаясан тохиолдолд барбитуратын дозыг хэтрүүлэх аргаар амийг нь хороосон амьтны сэгийг бусад махчин амьтад идэж хордох аюултайг анхаарвал зохино. Том амьтдын амийг хороох зарим тохиолдолд калибр буу хэрэглэх нь маш богино хугацаанд тархийг шууд гэмтээдэг тул амьтанд зовуурь үүсгэдэггүй сайн талтай. Гэхдээ галт зэвсэг ашиглахдаа Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуулийн шаардлагыг бүрэн хангасан байхыг анхаарах ёстой.

5.12. ГОВИЙН НЭН ХОВОР, ХОВОР ХӨХТӨН АМЬТДЫН БИОЛОГИЙН ОНЦЛОГ, ТЭДГЭЭРИЙГ СУДЛАХ, АВРАН ХАМГААЛАХ АРГАЧЛАЛ

Монгол орны говийн бүсийн нэн ховор, ховор амьтдын жагсаалтад давжаа алагдаахай (*Allactaga elater*), гозоорой зурам (*Spermophilus alaschanicus*), соотон алагдаага (*Euchoreutes naso*), элсний тажигдаахай (*Salpingotus kozlovi*), зүүнгарын даахай (*Stylodipus sungorus*), сухайн чичүүл (*Meriones tamariscinus*), шилүүс мий (*Lynx lynx*), цоохор ирвэс (*Uncia uncia*), эрээн хүрнэ (*Vormela peregusna*), мазаалай баавгай (*Ursus arctos gobiensis*), тахь адуу (*Equus ferus przewalskii*), хулан адуу (*Equus hemionus*), хавтгай тэмээ (*Camelus ferus*), аргаль хонь (*Ovis ammon*), янгир ямаа (*Capra sibirica*), монгол бөхөн (*Saiga borealis*), хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) гэсэн 17 зүйл хөхтөн амьтан бүртгэгдсэн. Эдгээр нэн ховор, ховор амьтдаас туруутан, туурайтан, тавхайтны багын 8 зүйл өвсөн тэжээлт хөхтөн амьтныг “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-д гаршуулан тэжээх, тэдгээрийг судлах, олон нийтийн экологийн боловсрол олгох, аялагч жуулчдын урсгалыг татах зэрэг олон талын ач холбогдолтой.

Эдгээр амьтдын биологи, зан төрхийн онцлог болон хамгаалах үеийн байр оромж, идэш тэжээл, арчилгаа тордлогын онцлог анхаарах зүйлсийн талаар доор товчхон оруулав.

ТАХЬ АДУУ (*EQUUS FERUS PRZEWALSKII*)

Монгол Улсын Улаан номд бүртгэлтэй, нэн ховор, унаган зүйл. Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуураар олон улсын болон бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” зүйл хэмээн үнэлэгджээ. Биеийн урт 220-280 см, мундаа орчмын өндөр 115-146 орчим см, хялгастай сүүлний урт 92-110 см, чихний урт 14-18 см, биеийн жин 275-325 кг хүрнэ. Ороо нийллэг 5-р сараас 7-р сарын эцэс хүртэл үргэлжилнэ. Гүү хээлээ 327-357 орчим хоног тээж, 5-р сарын дунд үеэс 7-р сарын эх хүртэлх хугацаанд унагална.

Хамгаалах байранд тэжээсэн тохиолдолд томоохон зайтай, металл хийцийн шон бүхий торон өндөр хашаанд байрлуулна. Хэвтрийг сайн хуурайлж ариутгах бөгөөд идэш тэжээл, усан хангамжийг онцгойлон анхаарч сайн тордох шаардлагатай. Тахийн хашаа нь томоохон талбайтай байх тул хөрс, элсэн дэвсгэртэй байх ба хэвтрийн хэсэгт нь өвс дэвсэх нь тохиромжтой.

Тахийг намар бэлтгэсэн нарийн өвсөөр тэжээнэ. Зуны улиралд төрөл бүрийн шинэ ургацын өвсөөр тэжээх бөгөөд асаргааны үед зориулалтын нэмэлт тэжээл өгч тордоно. Уургаар баяжуулсан багсармал тэжээл, ус, витамин зэргийг хангалттай хэмжээгээр өгч болно.

Зориудын байранд хоорондоо тохирох бодгалиудыг хамтад нь байлгавал стресс багатай, тайван байдгийг анхаарах хэрэгтэй. Учир нь сүргийн амьдралтай амьтдыг ганц нэгээр нь байлгах үед тайван бус болно.

Иймд нэг хашаанд 1 азарга, 5 гүүг хамт байлгах хамгийн тохиромжтой сүрэг бүрдэлт юм. Сүргийн азаргыг 4-5 жил тутамд сольж байх нь үр дүнтэй. Тахийн унагыг 3 нас хүрэхэд сүргээс салгаж бусад газарт шилжүүлэн нутагшуулах боломжтой болно.

ХУЛАН АДУУ (*EQUUS HEMIONUS*)

Монгол Улсын Улаан номд бүртгэлтэй, ховор зүйл. Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуураар олон улсын хэмжээнд “эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” зүйл хэмээн үнэлэгджээ. Биеийн урт 200-210 см, мундаа

орчмын өндөр 110-140 см, чихний урт 17.5-26 см, биеийн жин 200-300 кг хүрнэ. Ороо нийллэг 7-р сараас 8-р сарын эцэс хүртэл үргэлжилнэ. Гүү хээлээ 340 - 342 хоног орчим тээж, 5-р сарын дунд үеэс 7-р сарын эх хүртэлх хугацаанд төллөг унага төрүүлнэ. Байдас 3-4 настай, үрээ 4-5 нас хүрч байж үржилд орно.

Хамгаалах тохиолдолд томоохон зайтай, металл хийцийн шон бүхий өндөр торон хашаанд байрлуулна. Өвдсөн, гэмтсэн, мөчдийн хугаралтай зэрэг шалтгаан бүхий амьтдыг тус тусад нь хашаалж, дахин эрсдэхээс хамгаална. Эрсдэлд орсон амьтдын хэвтрийг сайн хуурайлж ариутгах бөгөөд идэш тэжээл, усан хангамжийг онцгойлон анхаарч, сайн тордох шаардлагатай. Хулангийн хашаа нь томоохон талбайтай байх тул хөрс, элсэн дэвсгэртэй байх ба хэвтрийн хэсэгт нь өвс дэвсэнэ.

Зориудын орчинд асран хамгаалах тохиолдолд намар бэлтгэсэн нарийн өвсөөр тэжээнэ. Зуны улиралд асарвал төрөл бүрийн шинэ ургацын өвсөөр тэжээх бөгөөд асаргааны үед зориулалтын нэмэлт тэжээл өгч тордоно. Уургаар баяжуулсан багсармал тэжээл, ус, витамин зэргийг хангалттай хэмжээгээр өгч тордоно. Хулан сүргийн амьдралтай тул зориудын байранд хоорондоо тохирох бодгалиудыг хамтад нь байлгавал стресс багатай, тайван байдгийг анхаарах хэрэгтэй.

ХАВТГАЙ ТЭМЭЭ (*CAMELUS FERUS*)

Монгол Улсын Улаан номд бүртгэлтэй, нэн ховор зүйл. Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуураар олон улсын хэмжээнд “устаж байгаа”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” зүйл хэмээн үнэлэгджээ. Биеийн урт 225-245 см, өндөр нь 180-198 см, сүүлний урт 55-75 см, чихний урт 17-26 см, биеийн жин 450-690 кг хүрнэ.

Ороо нийллэг 1-р сараас 2-р сарын эцэс хүртэл үргэлжилж, ингэ хээлээ 408-430 хоног тээдэг онцлогтой. Ингэ жил өнжиж байж 3-4 сард төллөж, нэг ботго гаргана. Ингэ 3-4 настайдаа, буур 5 нас хүрч үржилд орно.

Зориудын орчинд асран тэжээх тохиолдолд зай ихтэй хашаанд тохирох бодгалиудын хамт байрлуулах нь тайван байх нөхцөлийн нэг болно. Барих зөөвөрлөхөд зориулалтын тоног төхөөрөмж, машин техник шаардлагатай. Сүргээр амьдардаг тул ганц нэгээр хашаанд байхад тогтворгүй. Идэш тэжээлд нь шаваг, бударгана, харгана, хармаг зэрэг говийн ургамлууд зонхилно. Харин зориуд арчлан тэжээх үед нэмэлт сайн тэжээл, усаар хангаж тордох нь чухал.

Хавтгай тэмээг гаршуулах нутагшуулах ажлыг Эхийн гол болон Захуйн усны хавтгай нутагшуулах төвүүдэд хийж байсан бөгөөд Манай төвөөс 20 км зайд байрлана.

Захуйн усны хавтгай тэмээ нутагшуулах төвөөс 1 буур, 5 ингэ авч гаршуулан тэжээх боломжтой.

АРГАЛЬ ХОНЬ (*OVIS AMMON*)

Монгол Улсын Улаан номд бүртгэлтэй, ховор зүйл. Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуураар олон улсын хэмжээнд “эмзэг”, бүс нутгийн хэмжээнд “устаж болзошгүй” зүйл хэмээн үнэлэгджээ. Биеийн урт 140-150 см, сэрвээний өндөр 120-125 см, угалз болон эм хонь хоёулаа эвэртэй. Угалзын эврийн урт 58-150 см, зарим нь 170 см хүрнэ. Түүний эврийн угийн бүдүүн нь 40-44 см эм хонины эвэр 25-35 см урт, мушгиа багатай. Угалзын биеийн жин 200 кг, хонины жин 60-70 кг хүрнэ. Ороо нийллэгт 10-р сард орно. Хээлээ 150 орчим хоног тээж, хавар төллөнө. Жилд нэг төллөх ба

ихэвчлэн нэг, хааяа ихэрлэх бөгөөд 2-3 настайдаа бэлэг боловсорч үржилд орно. Сүргээр амьдарна.

Аргалийг өндөр торон болон модон хашаанд байрлуулна. Аргалийг хоорондоо тохирох байдлаар нь ангилж, хэд хэдээр нь нэг тасалгаанд байлгаж болно. Тухайлбал нэг үеийн төлүүд хамт байх боломжтой ба хөхүүл төлүүд эхтэйгээ хамт байна. Эсвэл дан төлүүдийг хамтад нь байлгавал байр хашааны багтаамжийг оновчтой ашиглахад хэрэгтэй юм. Аргаль нь сүргийн амьдралтай тул ганц нэгээр нь хашаанд байрлуулахад тогтворгүйтэх, стресс ихтэй байх тул хоорондоо аюулгүй бодгалиудыг аль болох хамтад нь байлгавал зохимжтой.

Харин өвдсөн, гэмтсэн, мөчдийн хугаралтай зэрэг шалтгаан бүхий амьтдыг тус тусад нь хашаалахгүй бол бусад амьтад нь мөргөх, орон зайг нь түрэмгийлэх зэргээр нэгнээ гэмтээх эрсдэлтэйг анхаарах хэрэгтэй. Эрсдэлд орсон амьтдын хэвтрийг сайн хуурайлж ариутгах бөгөөд идэш тэжээл, усан хангамжийг онцгойлон анхаарч сайн тордох шаардлагатай. Аргалийн хашаа нь томоохон талбайтай, хөрс, элсэн дэвсгэртэй байх ба хэвтрийн хэсэгт нь өвс дэвсэнэ.

Зориудын орчинд асарч хамгаалах, нөхөн сэргээх үед элдэв зүйлийн өвслөг ургамлаар тэжээх бөгөөд үет ургамал голдуу иднэ. Өвлийн улиралд сөөглөг ургамлын мөчир өгч болох ба нэмэлт хүчит тэжээл, усаар сайн хангаж тордоно. Зудтай өвөл ядарсан үедээ угалз эврээ даахгүй хэвтээд турж үхэх тохиолдол байдаг. Арчилгаа тордлогоо нэлээд шаардах бөгөөд зориудын орчинд тэжээхэд эмзэг амьтан тул онцгойлон анхаарах шаардлагатай.

“Товийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-д 1 эр, 5 эм бодгалийг байршуулах нь тохиромжтой.

ЯНГИР ЯМАА (*CAPRA SIBIRICA*)

Монгол Улсын Улаан номд бүртгэгдсэн, ховор зүйл туруутны нэг юм. Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуураар олон улсын хэмжээнд “анхааралд өртөхөөргүй”, бүс нутгийн хэмжээнд “ховордож болзошгүй” зүйл хэмээн үнэлэгджээ. Биеийн урт 130-165 см, сэрвээний өндөр 70-110 см, сүүлний урт 10-18 см, чихний урт 14-16 см, тэх ба ямаа хоёулаа эвэртэй, тэхийн эврийн урт 74-140 см. ямааных 16-38 см. Тэхийн биеийн жин 45-150 кг, ямааных 29-90 кг хүрнэ.

Ороо нийллэг 11-р сарын сүүлч 12-р сарын эхээр болж, хээлээ 140-175 хоног тээх бөгөөд 4-р сарын сүүлчээр 1 ишиг гаргана. Янгир 2-3 настайгаас эхлэн үржилд орно. Сүргээр амьдрах зан төрхтэй. Идэш тэжээлд нь элдэв өвслөг ургамал гол үүрэгтэй.

Янгирыг өндөр торон, модон хашаанд байрлуулан тэжээнэ. Янгирын бодгалиудыг хоорондоо тохирох байдлаар нь ангилж, хэд хэдээр нь нэг тасалгаанд байлгаж болно. Тухайлбал, нэг үеийн төлүүд хамт байх боломжтой ба хөхүүл төлүүд эхтэйгээ хамт байж болно. Эсвэл дан төлүүдийг хамтад нь байлгавал байр хашааны багтаамжийг оновчтой ашиглахад дөхөм болно. Харин өвдсөн, гэмтсэн, мөчдийн хугаралтай зэрэг шалтгаан бүхий амьтдыг тус тусад нь хашаалахгүй бол бусад амьтад нь мөргөх, орон зайг нь түрэмгийлэх зэргээр нэмж гэмтээх эрсдэлтэйг анхаарах хэрэгтэй. Амьтдын хэвтрийг сайн хуурайлж ариутгах бөгөөд идэш тэжээл, усан хангамжийг онцгойлон анхаарч сайн тордох шаардлагатай.

Янгирын хашаа нь томоохон талбайтай, хөрс, элсэн дэвсгэртэй байх ба хэвтрийн хэсэгт нь өвс дэвсэнэ. Янгир сүргийн амьдралтай, бөгөөд ганц нэгээр нь хашаанд

байрлуулахад тогтворгүйтэх, стресс ихтэй байх тул хоорондоо аюулгүй бодгалиудыг аль болох хамтад нь байлгавал зохино.

Зориудын орчинд асрах тохиолдолд нарийн өвс, хүчит тэжээл, нэмэлт тэжээлүүдээр тэжээж, усаар сайн хангах хэрэгтэй. Зориудын орчинд асрах үед арчилгаа тордлогоо ихээхэн шаардах эмзэг зүйлийн нэг юм.

“Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-д 2 эр, 6 эм бодгалийг байршуулах нь тохиромжтой.

МОНГОЛ БӨХӨН (*SAIGA BOREALIS*)

Монгол Улсын Улаан номд бүртгэлтэй, нэн ховор, унаган зүйл туруутны нэг. Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуураар олон улсын хэмжээнд “устаж болзошгүй”, бүс нутгийн хэмжээнд “устаж байгаа” зүйл хэмээн үнэлэгджээ. Биеийн урт 110-140 см, сэрвээний өндөр 63-80 см, сүүлний урт 8-13 см, чихний урт 7-11 см, биеийн жин 23-40 кг хүрнэ.

Ороо нийллэг 12-р сарын дундуур болж, хээлээ 150 хоног тээх бөгөөд 6-7 сард 1-2 янзага төрүүлнэ. Сүргээр амьдрах зан төрхийн онцлогтой. Гэвч олноор сүрэглэхгүй, нэг ооно 30 хүртэл тооны шаргачин хураана.

Бөхөнг тохирсон өндөртэй торон болон модон хашаанд байрлуулна. Бодгалиудыг хоорондоо тохирох байдлаар нь ангилж, хэд хэдээр нь нэг тасалгаанд байлгаж болно. Тухайлбал, нэг үеийн төлүүд хамт байх боломжтой ба хөхүүл төлүүд эхтэйгээ хамт байна. Эсвэл дан төлүүдийг хамтад нь байлгавал байр хашааны багтаамжийг оновчтой ашиглахад дөхөмтэй болно. Харин өвдсөн, гэмтсэн, мөчдийн хугаралтай зэрэг шалтгаан бүхий амьтдыг тус тусад нь хашаалахгүй бол бусад амьтад нь мөргөх, орон зайг нь түрэмгийлэх зэргээр нэмж гэмтээх эрсдэлтэйг анхаарах хэрэгтэй. Эрсдэлд орсон амьтдын хэвтрийг сайн хуурайлж ариутгах бөгөөд идэш тэжээл усан хангамжийг онцгойлон анхаарч сайн тордох шаардлагатай. Бөхөнгийн хашаа нь томоохон талбайтай, хөрс, элсэн дэвсгэртэй байх ба хэвтрийн хэсэгт нь өвс дэвсэнэ. Бөхөн сүргийн амьдралтай бөгөөд ганц нэгээр нь хашаанд байрлуулахад тогтворгүйтэх, стресс ихтэй байх тул аль болох хамтад нь байлгавал зохино.

Зориудын орчинд асрах тохиолдолд өвс тэжээл, хэвтрээр нь сайн хангаж, арчлахыг шаардана. Нэмэлт тэжээл, усаар сайн хангахгүй нөхцөлд арчилгаа авахдаа муу маллахад эмзэг өвөрмөц амьтан тул анхаарал халамж их шаардана. Элдэв өвчин паразит хорхойтой байж болзошгүй тул болгоомжтой харьцаж арчлах хэрэгтэй.

Бөхөн нутагшуулсан туршлага. ШУА-ийн судлаачид Говийн Их Дархан цаазат газрын мэргэжилтнүүдтэй хамтран 1985-1989 онд Монгол орны нэн ховор хөхтөн амьтан болох Монгол бөхөнг Алтайн өвөр говьд нутагшуулах ажлыг гүйцэтгэж байжээ. Судлаачид Шаргын говийн Далан түрүү, Бургасны амны Төхөм, Дугуйн тал, Бага Дарвийн бэл зэрэг нутгаас 3 хүртэл хоногийн настай, 100 гаруй янзага барьж Алтайн өвөр говийн Сухайт, Тэгш, Баянбулагт бөхөн түр тэжээх цэг байгуулан тэжээсэн байна. Янзагыг зөөвөрлөхдөө бүрхүүл бүхий ачааны машины тэвш эсвэл задгай тэвш дээр өвс, ноос тэгшлэн ачаад уг ачаан дээрээ ууттай янзагыг хоорондоо зайтай ачин хүний хяналтын дор хол газар руу 1-2 хоног тээвэрлэн түр цэгт аваачиж байжээ.

Нялх янзагыг гэрийн ямаанд хөхүүлэн бойжуулаад 1985-1989 онд Захуй, Баянбулаг хавьд 3-24 сарын настай 54 толгой бөхөнг суллан тавьж байжээ. Энэ судалгаа нь бөхөнг нялх үед нь барьж гаршуулах, нутагшуулах бүрэн боломжтой болохыг анх нотолсон байдаг.

Нялх янзагыг гэтэн гараар барьж, барьсан янзагыг жижиг нүхтэй торонд байрлуулж, торны дотуур олсоор хэц татаж хөшиг юм уу зөөлөн эд тохон тасалгаа хийж байрлуулах нь хатуу хана мөргөхөөс сэргийлнэ. Янзагыг өдөрт 3 удаа ямаанд цадтал нь хөхүүлэх ба 5 жилд нэг ч янзага харангадаагүй, хоол боловсруулах эрхтний хямрал гараагүй нь ямааны сүү тохирч байсныг гэрчилж байжээ. Арчлахдаа дотроо ус, өвстэй уужим хашаанд байлгасан бөгөөд 7-р сарын сүүлчээс янзага өвсөнд орж эх ямаатай хамт бэлчиж байжээ. Харин 1985-1987 онд барьсан янзагануудад шөвөг яр гарч үхэх, шилүүс, бүргэд довтлох зэрэг бэрхшээл олон байснаас туршилт амжилт олоогүй боловч ихээхэн туршлага хуримтлагдсан нь чухал ач холбогдолтой юм.

ХАР СҮҮЛТ ЗЭЭР (*GAZELLA SUBGUTTUROSA*)

Монгол Улсын Улаан номд бүртгэлтэй, ховор зүйлийн нэг. Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансны ангилал, шалгуураар олон улсын болон бүс нутгийн хэмжээнд “эмзэг” зүйл хэмээн үнэлэгджээ. Биеийн урт 110-116 см, сэрвээний өндөр 64-75 см, сүүлний урт 16-20 см, чихний урт 8-13 см, биеийн жин 18-30 кг орчим.

Ороо нийллэг 12-р сараас 1-р сарын хооронд болж, хээлээ 180 хоног тээх бөгөөд 5-6 сард голдуу нэг янзага төрүүлнэ. 2-3 настайдаа үржилд орно. Сүргээр амьдрах онцлогтой бөгөөд өвөл, намар олноороо сүрэглэнэ.

Хар сүүлт зээрийг өндөр торон болон модон хашаанд байрлуулан асарна. Бодгалиудын хоорондоо тохирох байдлаар нь ангилж, хэд хэдээр нь өөр өөр тасалгаанд байлгаж болно. Тухайлбал, нэг үеийн төлүүд хамт байх боломжтой ба хөхүүл төлүүд эхтэйгээ хамт байна. Эсвэл дан төлүүдийг хамтад нь байлгавал байр хашааны багтаамжийг оновчтой ашиглахад дөхөмтэй. Харин өвдсөн, гэмтсэн, мөчдийн хугаралтай зэрэг шалтгаан бүхий амьтдыг тус тусад нь хашаалахгүй бол бусад амьтад нь мөргөж орон зайг нь түрэмгийлэх зэргээр нэмж гэмтээх эрсдэлтэйг анхаарах хэрэгтэй. Эрсдэлд орсон амьтдын хэвтрийг сайн хуурайлж ариутгах бөгөөд идэш тэжээл, усан хангамжийг онцгойлон анхаарч сайн тордох шаардлагатай. Зээрийн хашаа нь томоохон талбайтай, хөрс, элсэн дэвсгэртэй байх ба хэвтрийн хэсэгт нь өвс дэвсэнэ. Зээр сүргийн амьдралтай бөгөөд ганц нэгээр нь хашаанд байрлуулахад тогтворгүйтэх, стресс ихтэй байх тул аль болох хамтад нь байлгавал зохино.

Зориудын орчинд асрах тохиолдолд хашаанд байрлуулж, ус өвсөөр сайн хангаж тордвол тордлогоо авах боломжтой. Сүргийн амьдралтай тул ганц нэгээр байхдаа стресс ихтэй, тайван байж чаддаггүйг анхаарах хэрэгтэй. Эмчилгээ тордлогоо авах боломжтой.

“Товийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-д 2 эр, 6 эм бодгалийг байршуулах нь тохиромжтой.

5.13. ХӨХТӨН АМЬТДЫН ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ

“Товийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв”-д амьтдыг байршуулахдаа анхан шатны үзлэгийг малын эмч юм уу мэргэжлийн ажилтан үйлдэж амьтны төрөл зүйл, нас хүйс, эрүүл мэндийн төлөв байдал зэрэг мэдээллийг баримтжуулна. Амьтан хүлээн авсан тухай бүртгэл хөтөлж, гэрэл зургаар баримтжуулсны дараа анхан шатны үзлэг хийж оношлох, цаашид авах арга хэмжээг шийдвэрлэнэ.

Анхан шатны үзлэгээр тухайн зүйл хөхтөн амьтанд гаж зан төрх илэрч байгаа эсэх, алхаа гишгээ нь өөрчлөгдсөн эсэх, диарей, шингэн алдалт, тураал, хоолны дуршилгүй болсон эсэх, шүлсээ гоожуулах, эмгэг цангах байдал, үсэн бүрхүүлийн алдалт, гэмтэл зэргийг тогтооно. Мөн хөхтөн амьтдын тодорхой овог, төрлийн онцлог халдварт эпизоот

ба зооноз өвчнүүдийн сорил явуулж, лабораторийн шинжилгээ хийнэ. Тухайлбал: Салаа туурайтан (*Artiodactyla*)-д бруцеллэз, сүрьеэ, иж сүрьеэ (*paratuberculosis*), шүлхий, боом, пастереллэз гэх мэт өвчний сорил тавина.

Амьтдын хорио цээр

Хөхтөн амьтдыг карантлах буюу хорио цээр тогтоож, тусгаарлах нь шинээр ирсэн амьтанд клиник шинж тэмдэг илрээгүй, далд үедээ буй өвчин байгаа эсэхийг тогтоох зорилготой. Зөвхөн шинээр ирсэн амьтад төдийгүй байгальд нь эргүүлэн тавихаар төлөвлөж буй амьтдыг мөн бусдаас тусгаарлаж карантинна.

Карантины үргэлжлэх хугацаа бүх зүйл хөхтөн амьтдын хувьд доод тал нь 30 хоног байх ба үргэлжлүүлэх эсэхийг малын эмч тогтооно. Буга (*Cervidae*) болон тугалмайтан (*Bovidae*)- ны овгийн зүйлүүд дээр бруцеллэз ба сүрьеэ өвчний шинжилгээг хийнэ. Эдгээрийг карантинд 93 хоног байлгах шаардлагатай бөгөөд энэ хугацаанд туберкулины сорилыг 2 удаа явуулна. Бруцеллэзын сорил нь 30 хоногийн дотор нэг удаа хийгдэнэ. Бүлгээр хамтад нь байршуулсан амьтдын хувьд карантины хугацаанд халдварт өвчний сорилоор эерэг гарсан амьтныг бусдаас ялган тусгаарлана.

Карантинд тусгаарлагдсан бүх амьтдын ялгас, дэвсгэр, тэжээлийн үлдэгдэл зэргийг тухай бүрд нь цэвэрлэж, ариутгана. Мөн асаргаанд хэрэглэсэн багаж, хэрэглэгдэхүүнийг ариутгана.

Төвийн бүх ажилчид гоц халдварт зарим өвчний вакцинжуулалтад хамрагдсан байх хувийн ариун цэврийг чанд сахиж, хамгаалалтын хувцас, бээлий, маск ашиглах бөгөөд гутлаа халдваргүйжүүлэх ваннаар дамжуулна.

Төвд байсан амьтдыг байгальд буцаан тавихын өмнө тухайн нутагт тэмдэглэгдсэн эпизоот ба зооноз өвчнөөс сэргийлсэн вакцинжуулалтыг хийх шаардлагатай. Салаа туурайтан амьтдын хувьд шүлхий, бог малын мялзан өвчин, боом зэрэг болно. Дээрх өвчний эсрэг вакцинууд нь зэрлэг амьтанд хэрхэн үйлчилж байгаа талаар судлагдаагүй, зөвхөн малд зориулсан тул карантинд байх хугацаанд нь аль болохоор эрт вакцинжуулалт хийх нь зохистой. Ялангуяа амьд вакцин хэрэглэх нь зарим тохиолдолд амьд вирусийг байгальд тараах аюултайг анхаарах хэрэгтэй. Тийм учраас амьд болон үхүүлсэн хоёр төрлийн вакцинаас үхүүлснийг сонгоно.

Экто болон эндопаразитын халдварлалт бүртгэгдсэн тохиолдолд буцаан тавихаас өмнө паразитын эсрэг эм, туулгалт хийнэ. Хөхтөн амьтад дээр ялангуяа хамууны хачиг, гуур, бэлчээрийн хачиг, бүүрэг зэргийн эсрэг эмчилгээ хийнэ.

Зарим бүлгийн хөхтөн амьтдад хийх тусгай үзлэг, шинжилгээ

Хөхтөн амьтдад хийх тусгай үзлэг, шинжилгээнд дараах чиглэлийн үзлэг, оношилгоо нэн тэргүүнд анхаарах шаардлагатай бөгөөд зөвхөн эмч, мэргэжлийн ажилтны шийдвэр, заавар зөвлөмжийн дагуу гүйцэтгэнэ.

Туруутан (*Artiodactyla*). Карантин 30-аас доошгүй хоног байна. Бруцеллэз сүрьеэгийн сорил тавина. Дараах чиглэлээр үзлэг, шинжилгээ хийж, эмчилнэ. Үүнд:

1. Ялгасны шинжилгээг хөвүүлэх, тунадасжуулах, шууд (эндопаразитын) аргаар
2. Уушгины нематодын шинжилгээ - Берманы аргаар
3. Иж сүрьеэ болон салмонеллын шинжилгээг баасны өсгөврийн аргаар
4. Цусны түрхцэд цусны паразитын шинжилгээ
5. Цусны стандарт шинжилгээ

6. Гематокритын шинжилгээ
7. Боломжтой бол шээсний шинжилгээ
8. Бруцеллёзын шинжилгээг цусны ийлдэс дээр
9. Бог малын мялзан (PPR), хөх хэлтэх (bluetongue), лептоспироз, анаплазмозын серологийн шинжилгээ
10. Сүрьеэгийн серологийн шинжилгээ (ELISA, Gamma-interferon г.м). Туберкулины сорил боломжтой.
11. Эктопаразитын шинжилгээ (хамуу, гуурын авгалдай, хамрын гуур, алагхүрд, хачиг г.м)
12. Ийлдэс, эд эсийн дээжийг -80 хэмийн хөлдөөгчид хадгалах
13. Боломжит вакцинжуулалт: боом, пастереллэз, ботулизм, мялзан, бог малын мялзан, шүлхий, галзуу, хөх хэлтэх, үхрийн вируст диарей, ямааны годрон, иж сүрьеэ, лептоспироз.
14. Экто ба эндопаразит, паразит хорхойн туулгалтыг авермектины бүлгийн эмээр (ивермектин, дорамектин г.м)
15. Риккетсийн халдвар гарсан тохиолдолд эмийн эмчилгээ хийнэ.

Туурайман (*Perissodactyla*). Карантин 30-аас доошгүй хоног байна. Энэ хугацаанд доорх үзлэг, шинжилгээг хийж, шаардлагатай эмчилгээг хийнэ. Үүнд:

1. Ялгадасны шинжилгээг хөвүүлэх, тунадасжуулах, шууд (эндопаразитын) аргаар
2. Уушгины нематодын шинжилгээ - Берманы аргаар
3. Цусны түрхцэд цусны паразитын (бабезиоз) шинжилгээ
4. Адууны ям өвчний шинжилгээ (хавсарга бэхжүүлэх арга)
5. Адууны нийлүүлгийн өвчний шинжилгээ (хавсарга бэхжүүлэх арга, ICT)
6. Адууны халдварт цус багадалт (Коггинсын болон иммунодиффузын аргаар)
7. Адууны вируст артерит (ийлдэс саармагжуулах арга)
8. Дээрх 5, 6, 7, 8 дугаарт дурьдсан өвчнүүд эерэг гарсан амьтныг унтуулна.
9. Гематокрит дахь цусанд трипаносомын (*Trypanosoma evansi*) шинжилгээ
10. Цусны стандарт шинжилгээ
11. Боломжтой бол шээсний шинжилгээ
12. Эктопаразитын шинжилгээ
13. Ийлдэс, эд эсийн дээжийг -80 хэмийн хөлдөөгчид хадгалах
14. Боломжит вакцинжуулалт: боом, сахуу, галзуу, адууны томуу, ботулизм, зогсоо.
15. Экто ба эндопаразит, паразит хорхойн туулгалтыг тохирох эмээр хийнэ.

БҮЛЭГ ЗУРГАА. “ГОВИЙН БҮСИЙН НЭН ХОВОР, ХОВОР АМЬТАН СУДЛАХ, ХАМГААЛАХ” ТӨВ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ТООЦОО

- 6.1. Төслийн санхүү хөрөнгө оруулалтын тооцоо**
 - 6.1.1. Төслийн анхны хөрөнгө оруулалт
 - 6.1.2. Барилга байгууламж, дэд бүтцийн зардал
 - 6.1.3. Машин техник, тоног төхөөрөмжийн зардал
 - 6.1.4. Тавилга эд хогшлын зардал
 - 6.1.5. Эргэлтийн хөрөнгийн зардал
- 6.2. Төслийн төсөвт өртгийн тооцоолол**
 - 6.2.1. Ажиллагсдын цалин хөлсний зардал
 - 6.2.2. Байгалийн нөөц ашигласны зардал
 - 6.2.3. Тэжээлийн зардал
 - 6.2.4. Шатахууны зардал
 - 6.2.5. Эм урвалж, ариутгалын зардал
 - 6.2.6. Хөдөлмөр хамгааллын зардал
 - 6.2.7. Үндсэн хөрөнгийн элэгдэл, засварын зардал
 - 6.2.8. Түлш,эрчим хүчний зардал
 - 6.2.9. Бусад зардал
- 6.3. Төслийн санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ**
 - 6.3.1. Төслийн орлогын тооцоолол
 - 6.3.2. Төслийн орлого үр дүнгийн тайлан
 - 6.3.3. Төслийн Экологи эдийн засгийн үнэлгээ
 - 6.3.4. Төслийн дотоод өгөөж/IRR/, нөхөн төлөгдөх тооцоолол/PP/
- 6.4. Эрсдэлийн шинжилгээ**
 - 6.4.1. Үйл ажиллагааны болон бусад эрсдэлийн дүгнэлт
 - 6.4.2. Хугарлын цэгийн шинжилгээ

Барилга байгууламж , тоног төхөөрөмжийн зардал:	1,368,207,528
Эргэлтийн хөрөнгийн зардал:	813,483,181
НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: (813,483,181+1,368,207,528) =	2,181,690,709
Үйл ажиллагааны зардал:	144,083,360
ТӨСЛИЙН НИЙТ САНХҮҮЖИЛТ: (2,181,690,709+144,083,360) =	2,325,774,069

6.1. ТӨСЛИЙН САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО

6.1.1. Төслийн анхны хөрөнгө оруулалт

Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв байгуулахад ашиглагдах ан амьтны байр, хамгаалалалтын болон хязгаарлалтын хашаа, ажилчдын ажлын байр, харуул хамгаалалтын байр, гүний худаг, машины зогсоол болон явган хүний зам, ариун цэврийн байр, машин техник, тоног төхөөрөмж, цахилгаан үүсгүүр, болон гэрэлтүүлэг, ажлын байрны тавилга эд хогшил зэрэг биет хөрөнгийн үнэлгээ болон дээрх хөрөнгийг ашиглалтанд оруулахад шаардагдах эргэлтийн хөрөнгийн үнэлгээг хөрөнгө оруулалтын тооцоонд орууллаа.

Хүснэгт 6.1. Төслийн анхны хөрөнгө оруулалт

Д/д	Үзүүлэлт	Тоо	Балансын үнэ сая,төг
1	Ажилчдын офиссийн барилга	1	234603385.8
2	Ан амьтны байр	4	330881100.1
3	Гүний худаг	1	70000000
4	Ойн хамгаалах зурвасны зардал	1	13000000
5	Нарны хавтан /багц 5000w/	1	17100000
6	Ачааны машин	1	30000000
7	Суудлын тэрэг	1	122000000
8	Тоног төхөөрөмж/1-6/	1	37144150
9	Ddish TV	1	3000000
10	Гадна хашаа /ш/	200	76620264
11	Дотор тусгаарлах хашаа /ш/	309	118378307.9
12	Хашааны суурь фундам/м3/	402.3	69785733.92
13	Хязгаарлалтын хашаа/50га/	3000	70216000
14	Явган зам /м2/	400	68345637.93
15	Машины зогсоол /м2/	200	17115738.5
16	Ажиглалтын байр м2	1	5250300.344
17	Гадна Ариун цэврийн байр /м3/	1	4506910
18	Тавилга эд хогшил	1	34240000
19	Тэжээлийн болон усны ёонкс	12	3120000
20	Цахилгаан генератор/ DE142AS/	1	42900000
21	Тээврийн зардал	1	672933181
22	Ан амьтан барих зардал	1	135000000
23	Төслийн бэлтгэл ажлын зардал	1	5550000
Дүн			2181690709

Төслийн анхны хөрөнгө оруулалтын нийтдээ: **2181690709 төгрөг бөгөөд үүнээс 62.7% буюу 1368207528** төгрөгийн зардал нь биет хөрөнгө , **37.3%** нь буюу **813483181** төгрөг нь эргэлтийн хөрөнгийн зардал байна. Төслийн анхны хөрөнгө оруулалтын зардлын дүнг Улаанбаатар хотын барилгын захын үнэ ханш барилгын ажлын үнэлгээ ашиглаж тооцоолсон болно.

6.1.2. Барилга байгууламж, дэд бүтцийн зардал

Барилга байгууламжийн зардал ан амьтны 4 байр, ажилчдын офиссийн байр болон хамгаалалтын хашаа, болон хязгаарлалтын хашаа, бусад барилга байгууламжийн зардлыг багтаасан.

Хүснэгт 6.2. Амьтны байр

№	Орцын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ/төг/	Орцын хэмжээ	Нийт зардал /төг/
1	Тоосго	ш	350	45226	15829100
2	Цемент	кг	330	22414.7	7396851
3	Элс	кг	18.9	46625.7	881225.73
4	Хайрга	кг	10.3	94501	973360.3
5	Арматур	м	1879	322	605038
6	Дээврийн мод	ш	654	22000	14388000
7	Дээврийн төмөр	м2	12000	261.64	3139680
8	Хаалга/3м/	ш	1	1200000	1200000
9	Хаалга/2м/	ш	6	220000	1320000
10	Хаалга/1м/	ш	1	150000	150000
11	Цонх	ш	7	70000	490000
12	Хадаас	кг	5000	100	500000
13	Бусад				5000000
14	Ажлын хөлс				30847020
Дүн					82720275.03

Тусгаарлах өрөө ,Эмчлэх өрөө ,Тэжээл саравч, Коридор, бусад өрөө гэсэн зохион байгуулалттай 100.78 м2 байрыг тоосгоор барихад гарах зардлын тооцоолол бөгөөд ижил хэмжээний 4 байрыг барихад **330881100.1** төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай.

Хүснэгт 6.3. Оффисийн барилга байгууламж

№	Орцын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ/төг/	Орцын хэмжээ	Нийт зардал /төг/
1	Тоосго	ш	350	72236.3	25282716.7
2	Цемент	кг	330	34573.6	11409293.2
3	Элс	кг	18.9	71917.9	1359249.1
4	Хайрга	кг	10.3	145763.3	1501362.3
5	Арматур	м	1879	493.9	928054.6
6	Дээврийн мод	ш	22000	1940.25	42685500.0
7	Дээврийн төмөр	м2	12000	261.64	3139680.0
8	Паркетин шал	м2	60000	341	20460000.0
9	Керамзит бетон/6.3x1.2/	ш	135000	103	13905000.0
10	Эрдэс хөвөн хавтан/10мм/	м2	35000	388.05	13581750.0
11	Чулуун хөвөн хавтан/10мм/	м2	30000	318	9540000.0

12	Өнгөлгөөний чулуун хавтан/ 3см/	м2	78000	385.4	30061200.0
13	Замаск/20 кг/	кг	30000	40	1200000.0
14	Обой/хулдаасан/	боодол	18000	119.52	2151360.0
15	Ялуу	м	20000	20	400000.0
16	Модон рек	м3	350000	15	5250000.0
17	Хар цаас /боодол/	боодол/10м/	24000	38.8	931200.0
18	Хаалга/м/	ш	190000	18	3420000.0
19	Цонх	ш	15	70000	1050000.0
20	Хадаас	кг	5000	100	500000.0
21	Бусад				15000000.0
22	Ажлын хөлс				30847020.0
Дүн					234603385.8

Төслийн ажилчдын оффисийн барилга нь 2 давхар тоосгон материалаар баригдах бөгөөд 1 давхар нь 243 м2, 2 давхар нь 341.3 м2 талбайтай ажилчдын ажлын өрөө, гал тогоо, террас, лаборатори зэрэг зохион байгуулалттай. Ажилчдын 3 өрөөг зочдын өрөө болгон ашиглах боломжтойгоор тохижуулж төслийн тооцоолол хийсэн.

Хүснэгт 6.4. Амьтны хамгаалалтын хашаа

д/д	Шаардлагатай зүйлс	Тоо ширхэг/м/	Нэгж үнэ/төг/	Нийт үнэ
1	Хашааны турба шон /100мм/	6.5	32000	208000
2	6мм төмөр тор/м/	1.16	4722	5477.52
3	Арматур/20мм/	32.2	1879	60503.8
4	Лист төмөр/50х50х3.5мм/ м	13	7240	94120
5	Ажиллах хүч /төг/	1	15000	15000
Нийт				383101.32

Хамгаалалтын хашаа нь нийт 6.4 га газар буюу 199м х 322м харьцаатай бетонон суурьтай, төмөр уголник дээр 20мм- ийн цул төмрөөр гагнаж, дээд хэсгийг 30см тороор торлосон байдлаар хийгдсэн 4м урттай 1 хашааны төсөвт өртөг нь **383101.32** төгрөг болж байна. Явган болон машин орох хаалга зэргийг хасаад тооцоход нийтгдээ 509 ш хашаа гадна болон дотно талд шаардагдана. Нийт хашааны суурь оруулаагүй өртөг нь **194998572** төгрөг болсон.

Хүснэгт 6.5. Хашааны суурийн өртөг

№	Орцын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ/төг/	Орцын хэмжээ	Нийт зардал /төг/
1	Цемент	кг	330	115470.4	38105242.6
2	Элс	кг	18.9	240194.6	4539677.8
3	Хайрга	кг	10.3	486826.6	5014313.6
4	Ажлын хөлс		55000	402.3	22126500
Нийт					69785733.9

Барилгын зургийн дагуу гадна болон дотор талын хамгаалалтын хашааны суурийг тусад нь тооцсон бөгөөд нийтдээ 402.3 м³ бетон цутгалтын ажил шаардагдана. Бетоныг 240мм өргөн 110см өндөртэй цутгаж хийх бөгөөд материалыг тээвэрлэх зардлыг тусад нь тооцож хөрөнгө оруулалтын зардлын эргэлтийн хөрөнгө хэсэгт оруулсан.

Хүснэгт 6.6. Хязгаарлалтын хашаа

№	Материалын нэр	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Нийт зардал
1	Хашааны шон /2.5м/х1мм	27040	750	20280000
2	Тор /6смх2мх30м/	74360	100	7436000
3	Тор бэхлэгч	2000	9000	18000000
4	Ёроолын/ тор1.3мм/1.6ммх1мх18м	58500	166.7	9750000
6	Өргөст тор/1 Боодол200мх2.3мм/	200000	45	9000000
7	Хашаа барих ажлын хөлс	5000	750	3750000
9	Явган хаалга	200000	4	800000
10	Машины хаалга	400000	3	1200000
Нийт				70216000

Хязгаарлалтын хашааг 2,2м өндөртэй шон хоорондын зай 4м хийхээр төлөвлөж 50 га газар буюу нийтдээ 3 км урттай газарт 750 ширхэг хашаа шаардагдах бөгөөд **70,261,000** төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдана.

Хүснэгт 6.7. Явган зам

№	Орцын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ/төг/	Орцын хэмжээ	Нийт зардал /төг/
1	Цемент	кг	330	13284	4383720
2	Элс	кг	18.9	33210	627669
3	Хайрга	ш	10.3	79704	820951.2
4	Боржуур /50х20х8/	ш	3500	2774.11	9709397.73
5	Явган замын хавтан /20х10/	ш	450	6642.00	2988900
6	Ажлын хөлс	м ²	15000	3321	49815000
Нийт					68345637.93

Барилгын зурагт тусгаснаар явган хүний зам нь аялагчид, зочид , сонирхогчид ан амьтан сонирхоход зориулж 6 м өргөн, 322 м урт 1935 м² талбай, 4 м өргөн 156 м урт 624 м² талбай, 2,2 м өргөн, 194,09 м урт 427 м² талбай мөн нийтийн 335 м² талбай нийтдээ **3321 м²** явган хүний зам барихаар төлөвлөж **68345637.93** төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэнэ.

Хүснэгт 6.8. Авто зогсоол

№	Орцын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ/төг/	Орцын хэмжээ	Нийт зардал /төг/
1	Цемент	кг	330	6690	2207700

2	Элс	кг	18.9	6690	126441
3	Хайрга	ш	10.3	33450	344535
4	Боржуур	ш	26500	115.6	3064062.5
5	Байгалийн боржин чулуу/20х20/	ш	800	1672.5	1338000
6	Ажлын хөлс	М2	15000	669	10035000
Нийт					17115738.5

Авто зогсоолыг 669 м2 талбайд байгалийн 20 х20 см боржин чулуугаар хийх бөгөөд тооцоололд замын боржуур, зуурмаг, ажлын хөлсийг оруулж тооцоход **49384260** төгрөг шаардагдана. Авто зогсоолын хашлага нь нэг бүр нь 62 кг жинтэй 116 ш боржуур байх бөгөөд авто зогсоолд шаардагдах бусад материалын хамт тээврийн зардалд тусад нь тооцоолол хийсэн.

Хүснэгт 6.9. Жорлон /Ариун цэврийн байр/

№	Орцын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ/төг/	Орцын хэмжээ	Нийт зардал /төг/
1	Агааржуулах хоолой	м	60000	10	600000
2	Модон материал/ 4м/	ш	22000	160	3520000
3	Цемент	кг	330	150	49500
4	Хайрга	кг	10.3	1500	15450
5	Элс	кг	18.3	1200	21960
6	Суултуур	ш	75000	4	300000
Бүгд					4506910

Говийн нөхцөлд тохирсон эко жорлон барих технологийн дагуу гадна аялагчдад зориулсан жорлон,хогийн цэг байгуулахад 4,5 сая төгрөг шаардагдана.

Хүснэгт 6.10. Харуулын буюу ажиглалтын байр.

№	Орцын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ/төг/	Орцын хэмжээ	Нийт зардал /төг/
1	Тоосго	ш	350	5805.6	2031944.4
2	Цемент	кг	330	574	189420
3	Элс	кг	18.9	1791	33849.9
4	Хайрга	кг	10.3	2420	24926
5	Арматур	м	1879	40	75160
6	Дээврийн мод	ш	22000	25	550000
7	Дээврийн төмөр	м2	12000	7.5	90000
8	Хаалга/1м/	ш	1	220000	220000
9	Цонх	ш	3	45000	135000
10	Хадаас	кг	5000	10	50000
11	Бусад				850000
12	Ажлын хөлс				1000000
Бүгд					5250300.34

Харуулын байр нь 3 х 2.5м хэмжээтэй тоосгон хийцтэй бөгөөд 5.25 сая төгрөгийн төсөвт өртөгтэй байна.

Хүснэгт 6.11. Хамгаалалтын ойн зурвас

№	Ургуулах модны тоо	1 модыг тарьж ургуулах зардал	Нийт
1	325	40,000	13,000,000

Нийтдээ 325 м газарт хамгаалалтын хашааны дагуу 1.5-2м зайтай бэлдсэн нүхэнд бортгонд бэлдсэн тарьцуудыг сонгож тарихаар төсөвт тусгалаа. Тоорой, Жигд, Хайлаас, Заг болон бусад говийн бүсэд ургах боломжтой бортоготой тарьцуудын дундаж үнээр тооцсон бөгөөд тарилтын зардлыг хамтад нь тооцсон.

6.1.3. Машин техник, тоног төхөөрөмжийн зардал

Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төвд амьтан авран хамгаалахад шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үлгэрчилсэн зааврын дагуу тооцож шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо хийсэн.

Хүснэгт 6.12. Тээврийн хэрэгсэл болон түүнтэй холбоотой багаж хэрэгсэл /тоног төхөрөмж 1/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Зориулалт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Бага оврын ачааны машин (Pickup trucks)	Амьтан тээвэрлэх	1	122000000	122000000
2	Богино долгионы радио станц болон өсгөгч (mobile trans receiver, repeater)	Холбоо барих, мэдээлэл дамжуулах	6	50000	300000
3	Онцгой тохиолдолд хэрэглэх багаж хэрэгслийн багц (car emergency kit)	Алслагдсан зайд, зэлүүд газарт үүсэх аливаа эрсдэлийг багасгах	1	1000000	1000000
4	Өндөр өргөгч (Hi-lift jack)	Автомашин, хүнд даацтай зүйлийг өргөх	1	270000	270000
5	Либотка (power winch)	Автомашин, хүнд даацтай зүйлийг гацаанаас гаргах, эрсдэлээс гарах	1	1550000	1550000
6	Хүрз, сүх, хөрөө	Учирч болох эрсдэлийг багасгах	1	120000	120000
Нийт					125240000

Бага өврийн тээврийн хэрэгслэлийг төсөл хэрэгжүүлэгчид өөрсдийн сонголтоор авч болох бөгөөд стандарт шаардлагын дагуу тоногдсон Land 76 (Pickup trucks) машиныг сонгож үнэлгээ хийсэн. Үүнээс гадна амьтан хамгаалах төвийн үйл ажиллагаанд шаардлагатай тухайлбал хадлан тэжээл, түлш болон амьтан зөөвөрлөх зориулалттай ачааны бага оврын машиныг хөрөнгө оруулалтын тооцоонд оруулж өгсөн.

Хүснэгт 6.13. Амьтан барихтай холбоотой багаж хэрэгсэл /тоног төхөөрөмж 2/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Зориулалт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Нойрсуулах, тайвшруулах багаж хэрэгсэл					
1	Хийн даралтат буу (tranquilizer gun)	Холын зайд байх амьтныг буудаж тайвшруулах, нойрсуулах	1	600000	600000
2	Хийн даралтат буунд хэрэглэх хийн баллон (CO ² cartridge)	Хийн буунд хэрэглэнэ	1	250000	250000
3	Хүний амьсгалын хүчээр үлээгч гуурсан хоолой (Blowgun)	Ойрын зайд хэрэглэх ба хашигдсан амьтныг буудаж барих, нойрсуулах	1	100000	100000
4	Нойрсуулагч, тайвшруулагч тариуртай сум (tranquilizer dart)	Том амьтдыг барих, нойрсуулах шингэн тариа (хийн буу, гуурсан хоолойг сумлах)	1	300000	300000
Зөөврийн тор, амьд баригч, зөөвөрлөх хэрэгсэл, номхруулагч, зайд баригч					
1	Зэрлэг амьтан зөөвөрлөх торон хайрцаг	Зөөвөрлөх амьтныг хийж тусгаарлах	1	185000	185000
2	Торон хайрцаг халхлах бүтээлэг	Амьтанд стресс үүсэх нөхцөлийг багасгах, харагдах орчныг хязгаарлах	1	50000	50000
3	Зэрлэг амьтан зөөвөрлөх хатууруулсан хуванцар хайрцаг	Зөөвөрлөх амьтныг хийж тусгаарлах	1	160000	160000
4	Жижиг амьтан барих зориулалттай амьд баригч	Амьтныг амьдаар нь барих	1	120000	120000
5	Дамнуурга	Нойрсуулсан, тайвшруулсан амьтныг зөөвөрлөх	1	150000	150000
6	Урт бариултай уургалагч (catch pole)	Уургын ишний уртаар амьтнаас зай барих, хянах	1	70000	70000
7	Иштэй тор (hand net)	Шувуу, жижиг амьтан барих, хөдөлгөөнийг хязгаарлах	1	70000	70000
8	Радио долгионоор амьтан мөрдөгч ' (Wildlife radio telemetry)	Зэрлэг амьтныг мөрдөх судалгаанд хэрэглэнэ.	1	260000	260000
Нийт					2315000

Ан амьтан барихтай холбоотой зарим тоног төхөөрөмжийн үнэлгээг Амазон сайтны мэдээлэлд тулгуурлан хийсэн. Тоног төхөөрөмжийн үнэлгээ нь аль улсын ямар төрлийн багаж гэдгээс хамаарч өөр байж болно.

Хүснэгт 6.14. Мэс засал болон үзлэгийн багаж хэрэгсэл /тоног төхөөрөмж 3/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Зориулалт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Үзлэгийн өрөөнд хэрэглэгдэх тоног төхөөрөмж, багаж					

1	Үзлэгийн өрөөний тавилга	Үзлэгтэй холбоотой эмийн сан, багаж хэрэгсэл, ариутгалын бүтээгдэхүүн хадгалах	1	1000000	1000000
2	Үзлэгийн ор	Амьтныг хэвтүүлж үзлэг, эмчилгээ хийх	1	350000	350000
3	Гэрэлтүүлэг	Орчныг гэрэлтүүлэх, ариутгах	1	25000	25000
4	Эмчийн үзлэгийн багаж хэрэгслүүд	Эмчийн хэрэглэгдэхүүн (эмчид хариуцуулан өгөх эсвэл зөвхөн тухайн өрөөнд хэрэглэх)	1	5000000	5000000
Мэс заслын өрөө, мэс заслын дараах өрөөний тоног төхөөрөмж, багаж					
1	Мэс заслын ор	Мэс ажилбар хийх	1	3000000	3000000
2	Ариутгалын гэрэл, гэрэлтүүлэг	Гэрэлтүүлэх, ариутгах	1	30000	30000
3	Өрөөний тавилга	Мэс ажилбарын үед хэрэглэгдэх багаж, ариутгалын бодис, бүтээгдэхүүн хадгалах	1	600000	600000
4	Мэс заслын багаж хэрэгслүүд	Мэс ажилбарт хэрэглэх	1	3000000	3000000
Суурин тор, амьтны байр					
1	Угсарч давхарладаг битүү ханатай, төмөр сараалжин хаалгатай тор	Мэс засал, эмчилгээнд орсон амьтныг байрлуулах, хөдөлгөөн хорих	1	800000	800000
2	Амьтны ялгас хадгалах ба хамаа тосгуур	Ялгасыг тусгаарлах, цэвэрлэх	2	20000	40000
3	Идүүр	Амьтан хооллох	3	30000	90000
4	Гадаа болон дотор байрлалтай амьтан хоргодох торон байр	Амьтныг тэнхрүүлэх, зэрлэг нөхцөлд буцаан дасгах, тусгаарлах, байгалийн температурт нь дасгах	3	150000	450000
Нийт					14385000

Үзлэгтэй холбоотой эмийн сан, багаж хэрэгсэл, ариутгалын бүтээгдэхүүн хадгалах, эмчид хариуцуулан өгөх эсвэл зөвхөн тухайн өрөөнд хэрэглэх, Мэс ажилбарын үед хэрэглэгдэх багаж, ариутгалын бодис, бүтээгдэхүүн хадгалах, Амьтныг тэнхрүүлэх, зэрлэг нөхцөлд буцаан дасгах, тусгаарлах, байгалийн температурт нь дасгах багаж хэрэгслэлүүдийн зах зээлийн үнэлгээнд суурилан тооцсон.

Хүснэгт 6.15. Харуул хамгаалалт,ажилчдын, тэжээл боловсруулах өрөөний багаж хэрэгсэл /тоног төхөөрөмж 4/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Зориулалт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
---	------------------------	-----------	------------	-------------	----------

Техник, харуул хамгаалалтын өрөө					
1	Богино долгионы суурин станц, өсгөгч	Байгууллагын дотоод холбоо, явуулын ангитай холбоо барих	1	50000	50000
2	Ахуйн тавилга (ширээ, сандал, шүүгээ)	Харуул хамгаалалтын хэрэгцээнд	1	600000	600000
3	Хяналтын камерын систем	Гадна талбай, гадна талын амьтдын хоргодох байр, дотор талын амьтдын хоргодох байр зэргийг хянах, аюулгүй байдлыг хангах	1	2500000	2500000
Ажилчдын байрны эд зүйлс					
1	Эмнэлгийн багаж хэрэгсэл, ариутгах төхөөрөмжүүд	Ариутгах, халдваргүйжүүлэх	1	500000	500000
2	Ахуйн тавилга	Ахуйн хэрэгцээнд	1	3000000	3000000
Амьтны идэш тэжээл боловсруулах өрөө					
1	Хоол бэлтгэлийн ширээ, тавилга	Амьтны идэш бэлтгэх	1	500000	500000
2	Хөргөгч, хөлдөөгч бүхий байр, тасалгаа	Амьтны идэш тэжээл хадгалах	1	3000000	3000000
Нийт					10150000

Байгууллагын дотоод холбоо, явуулын ангитай холбоо барих, Гадна талбай, гадна талын амьтдын хоргодох байр, дотор талын амьтдын хоргодох байр зэргийг хянах, аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж, хоол бэлтгэлийн ширээ, тавилга, Хөргөгч, хөлдөөгч зэрэг шаардлагатай хэрэгслэлүүдийн үнэлгээг хөрөнгө оруулалтын үнэлгээ хийлээ.

Хүснэгт 6.16. Амьтан маллагчийн хамгаалах багаж хэрэгсэл /тоног төхөөрөмж 5/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Зориулалт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Амьтан маллагчийн хамгаалах хэрэгсэл					
1	Явуулын эмийн сан, шаардлагатай мэс заслын хэрэгсэл, эмчийн багажууд	Тусламж шаардлагатай амьтанд хэрэглэх	1	800000	800000
2	Ажлын гутал, хувцас, хэрэгсэл	ХАБЭА-н шаардлага хангах, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах	6	350000	2100000
3	Ариутгалын бээлий (нэг удаагийн)	Амьтантай харьцахад хэрэглэх	200x5	10900	54500
4	Байршил тогтоогч төхөөрөмж (GPS)	Байршил тогтоох	2	89000	178000
5	Үүрэн холбооны төхөөрөмж буюу гар утас	Холбоо барих	4	600000	2400000
6	Богино долгионы гар станц	Холбоо барих	4	50000	200000

7	Дохионы буу болон гал (Flare giih or stick)	Алслагдсан зайд, зэлүүд газарт үүсэх аливаа эрсдэлийг багасгах	1	500000	500000
8	Гар ажиллагаатай өргөгч	Амьтан зөөвөрлөх	1	500000	500000
Нийт					6732500

Явуулын эмийн сан, шаардлагатай мэс заслын хэрэгсэл, эмчийн багажууд, байршил тогтоогч төхөөрөмж, Үүрэн холбооны төхөөрөмж буюу гар утас, баг, бээлий зэрэг хэрэгслэлүүдийн үнэлгээ нь **6732500** төгрөг болж байна. Ажилчдын тоо болон ажлын байрны нөхцлөөс шалтгаалан тоног төхөөрөмжийн үнэлгээг өөрчилж болно.

6.1.4. Тавилга эд хогшлын зардал

Амьтан хамгаалах төвийн хувьд малын эмч, амьтан маллагч, биологич, гэрээт ажилтнууд ажиллах бөгөөд тэдгээрийн ажлын өрөө, гал тогооны өрөө, тэжээлийн байр болон аялагчдын амарч хоноглох өрөөний дотоод тохижилтонд ашиглагдах эд хогшлын тооцооллыг энэ хэсэгт багтаасан.

Хүснэгт 6.17. Дотоод тохижилтын эд хогшил

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ/төг/	Орцын хэмжээ	Нийт зардал /төг/
1	Ажлын ширээ	ш	300000	4	1200000
2	Сандал	ш	25000	30	750000
3	Унтлагын ор	ш	330000	16	5280000
4	Жижиг ширээ	ш	110000	4	440000
5	Цайны аяга	ш	8000	50	400000
6	Хоолны таваг	ш	95000	60	5700000
7	Гал тогооны ком	ш	150000	3	450000
8	Цагаан хэрэглэл	хос	95000	32	3040000
9	Тогоо	ш	250000	2	500000
10	Будаа агшаагч	ш	180000	2	360000
11	Шарах шүүгээ	ш	450000	1	450000
12	Хоолны суулга ком	хос	150000	2	300000
13	Мах ногооны вандан	ш	35000	4	140000
14	Хувцасны шкаф	ш	150000	6	900000
15	Гутлын тавиур	ш	65000	6	390000
16	Хөнжил	ш	90000	16	1440000
17	Гудас	ш	70000	16	1120000
18	Орны бүтээлэг	ш	50000	16	800000
19	Хөшиг	ш	180000	8	1440000
20	Хөшиг тогтоогч	ш	80000	8	640000
21	Нам даралтын зуух /ком/	ш	4500000	1	4500000
22	Бусад				4000000
23	Нийт				34240000

Аялагчид, амьтан сонирхогчид болон ажилчид ажлын зориулалтаар ашиглах ширээ сандал, болон гал тогооны хэрэгслэлүүд, болон хөшиг, орны цагаан хэрэглэл гэх мэт эд хогшлын зах зээлийн үнэлгээнд тулгуурлан тооцоо хийсэн.

6.1.4. Эргэлтийн хөрөнгийн зардал

Хөрөнгө оруулалтын зардлын эргэлтийн хөрөнгөтэй холбоотой хэсэг нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой шаардагдах мөнгөн зардлуудыг хамруулна. Эргэлтийн хөрөнгийн зардалд урьдчилж шаардагдах зардал, тээврийн зардал, амьтан барих зардлуудыг багтааж тооцсон.

Хүснэгт 6.18. Төслийн бэлтгэл ажлын зардал

№	Урьдчилсан ажлынтөрөл	Ажлын давтамж тоо	Нэгжийн зардал	Нийт зардал
1	Албан томилолт	2	600,000	1,200,000
2	Барилгын ажлын зураг төсөл /засварлах/	1	2,000,000	2,000,000
3	Орон нутгийн нөхцөл байдлын судалгаа	2	1000,000	2,000,000
4	Бусад урьдчилсан зардал	1	350,000	350,000
Нийт				5,550,000

Төсөл хэрэгжихээс өмнө орон нутгийн удирдлагын зүгээс урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийн дагуу төсөл хэрэгжүүлэх газрын байршил болон бусад үйл ажиллагааны нөхцөл байдлыг судлах, урьдчилсан нөхцлийг хангуулахад гарах зардал юм. Төслийн хөрөнгө оруулалтын эргэлтийн шинж чанартай зардалд оруулан тооцно.

Хүснэгт 6.19. Барилгын материалын тээврийн зардал

№	Материалын нэр	Хэмжээ тн	Зай км	Бүгд тн/км	1 тн/км-ийн үнэ.төг	Бүгд зардал
1	Тоосго	1113.5	1030	1146871.3	450	516092104
2	Цемент	125.0	1030	128705.1	450	57917299
3	Арматур	2.1	1030	2176.123344	450	979256
4	Хашаа	23.7	1030	24462.4382	450	11008097
5	Тавилга, тоног төрхөөрөмж	30.0	1030	30900	450	13905000
6	Элс	401.6	40	16065.16925	450	7229326
7	Хайрга	844.2	40	33766.5955	450	15194968
8	Боржуур	22.6	1030	23245.8125	450	10460616
9	Боржин хавтангууд	26.6	1030	27414.48	450	12336516
10	Бусад материал	60	1030	61800	450	27810000
Дүн						672933181

Төслийн нийт хөрөнгө оруулалтын зардлын 37.3% буюу гуравны нэгийг тээврийн зардал эзэлж байна. Тээврийн зардлын хувьд хайрга, элснээс бусад тоосго, цемент, болон бусад барилгын материалыг УБ хотоос татахаар төлөвлөн. Мөн 1 тн/км-ыг 450 төгрөг байхаар тооцоолсон. Элс болон хайргыг орон нутгаас нь 40 км дотор татахаар, Улаанбаатар хотоос ан амьтан хамгаалах төв хоорондын зайг аймгийн төв орохгүйгээр явахаар тооцсон.

Хүснэгт 6.20. Амьтан барих зардал

Д/д	Үзүүлэлт	Тоо	Үнэ	Бүгд үнэ
1	Хар сүүлт зээр	8	15000000	15000000
2	Монгол бөхөн	8	20000000	20000000
3	Янгир	8	15000000	15000000
4	Аргаль	6	15000000	15000000
5	Хулан адуу	6	20000000	20000000
6	Тахь адуу	6	20000000	20000000
7	Хавтгай	6	5000000	5000000
8	Халиун буга	6	25000000	25000000
Дүн				135000000

Ан амьтан барих ажил нь төслийн ажлыг эхлүүлэх хамгийн чухал ажил учраас төслийн эргэлийн хөрөнгийн хэсэгт урьдчилж тусгах шаардлагатай юм. Мөн төслийн жил бүрийн үйл ажиллагааны зардлын тооцоололд орохоор төлөвлөж байгаа юм.

6.2. ТӨСЛИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ТООЦООЛОЛ

Төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах шаардлагын дагуу төслийн төсөвт өртөгт уг төслийг хэрэгжүүлж үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зардлууд болох тогтмол болон хувьсах зардлын тооцооллыг оруулдаг. Үүнд: ажиллагсдын цалин хөлсний зардал, байгалийн нөөц ашигласны зардал, тэжээлийн зардал, шатахууны зардал, эм урвалж, ариутгалын зардал, хөдөлмөр хамгааллын зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл, засварын зардал, түлш, эрчим хүчний зардал, бусад зардал зэргийн тооцоолол хийлээ.

Хүснэгт 6.21. Ажиллагсдын цалин хөлсний зардал

№	Албан тушаал	Орон тоо	Ажиллах хугацаа /сараар/	Цалин, мян.төг	
				Сарын цалин мян.төг	Жилийн цалингийн фонд, мян.төг
1	Төвийн эрхлэгч	1	12	1300	15600000
2	Малын эмч	1	12	1100	13200000
3	Биологич	1	12	1200	14400000
4	Малчин	3	12	800	28800000
5	Улирлын ажилчин	10	2	900	18000000
Дүн		16		23150	90000000

НДШ 12.5%				11250000
Дүн				101250000

Төслийг хэрэгжүүлэхэд төвийн эрхлэгчээс гадна малын эмч, биологич, малчин гэсэн үндсэн 6 ажилтантай байх ба хадлан тэжээл, амьтан барих зэрэг ажлуудын үед түр ажилчдыг гэрээгээр ажиллуулах зохион байгуулалттай байхаар тооцооллоо. Үндсэн цалин болон нийгмийн даатгалын зардлын нийт хэмжээ **101250000** төгрөг байна. Энэ зардлын хувьд ажилчдын тоо, сарын цалингийн хэмжээг хэрхэн тогтоохоос хамаарч өөрчлөгдөж болно.

Хүснэгт 6.22. Байгалийн нөөц ашигласны зардал

№	Зүйлийн нэр	Хүйс	Тоо	Төлбөрийн хэмжээ	Нийт төлбөр
1	Аргаль	Эр	1	2200	2200
		Эм	5	2600	13000
2	Янгир	Эр	2	540	1080
		Эм	6	620	3720
3	Хулан адуу	Эр	1	1940	1940
		Эм	5	2200	11000
4	Хавтгай	Эр	1	3800	3800
		Эм	5	4260	21300
5	Халиун буга	Эр	1	1320	1320
		Эм	5	1500	7500
6	Тахь адуу	Эр	1	2200	2200
		Эм	5	2600	13000
7	Монгол бөхөн	Эр	2	400	800
		Эм	6	400	2400
8	Хар сүүлт зээр	Эр	2	340	680
		Эм	6	400	2400
Нийт төлбөр			54		88340

Байгаль орчны яамны 2011 оны бүртгэлтэй амьтдыг байгаль орчны төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр барих, асрах, суллах, ашиглах журмын дагуу нийтдээ 8 зүйлийн 54 амьтан барьж үйл ажиллагааг явуулна. Мөн ан амьтан ашигласны төлбөрийг жил бүр төлөхөөр тооцооллоо.

Хүснэгт 6.23. Амьтны тэжээлийн зардал

№	Амьтны нэр	Ху гац аа	Амьтны тоо /толгойгоор/	Багсармал тэжээл /тонн/		Өвс /тонн/		Давс, хужир /тонн/	
				Хоногийн тэжээлийн норм /кг/	Хэмжээ, тонн	Хоногийн тэжээлийн норм /кг/	Хэмжээ, тонн	Хоногийн тэжээлийн норм /кг/	Хэмжээ, тонн
1	Аргаль	365	6	0.5	1.095	2.5	5.475	0.01	0.0219
2	Янгир	365	8	0.2	0.584	1	2.92	0.01	0.0292
3	Хулан адуу	365	6	1	2.19	4.8	10.512	0.03	0.0657

4	Хавтгай	365	6	2	4.38	9	19.71	0.03	0.0657
5	Тахь адуу	365	6	1	2.19	4.8	10.512	0.01	0.0219
6	Халиун буга	365	6	0.2	0.438	1.16	2.5404	0.01	0.0219
7	Монгол бөхөн	365	8	0.1	0.292	0.6	1.752	0.01	0.0292
8	Хар сүүлт зээр	365	8	0.1	0.292	1.3	3.796	0.01	0.0292
9	Нийт тэжээлийн хэрэгцээ				11.461		57.2174	0.12	0.2847
10	Эхний жил зардал	25136820			9417000		15150420		569400
11	2 дахь жил зардал	32677866			12242100		19695546		740220

Ан амьтны тэжээлийн зардлын тооцооллыг багсармал болон байгалийн хуурай өвсөөр тэжээхээр тооцоолсон. Зэрлэг амьтны хоногийн тэжээлийн хэрэгцээг Монгол улсын МААЭШХ-ийн эрдэмтэдийн судалгаанд үндэслэн тооцооллоо.

Хүснэгт 6.24. Шатахууны зардал

№		Явах зай км	Шатахуун		Үнэ л/төг	Бүгд үнэ
			Нэгж л/км	Бүгд л		
1	Тэжээл бэлдэх	1000	20	200	3900	780000
2	Ачаа тээвэрлэх	1000	25	250	3900	975000
3	Гэмтсэн амьтан хайх	2000	20	100	3900	390000
4	Цахилгаан генератор			250	3900	975000
5	Бусад	2000	6	30	3900	117000
Бүгд						3237000
1	Тосолгооны материал 10%					323700
Дүн						3560700

Шатахууны зардлыг ан амьтны тэжээл бэлдэх, ажилчдын болон хоол хүнс тээвэрлэх, зэрэгт үйл ажиллагаанаас гадна, цахилгаан эх үүсвэр ашиглахтай гарах дизель түлш, мөн тослох материалын зардлыг тооцов.

Хүснэгт 6.25. Эм урвалж, ариутгалын зардал

Д/д	Үзүүлэлт	Тоо	Үнэ	Бүгд үнэ
				мян.төг
1	Паразитын эсрэг эм бэлдмэл	1	200000	200000
2	Антибиотек	1	100000	100000
3	Вакцин/мялзан, галзуу/	25	30000	750000
4	Туулга	25	8000	200000
5	Ариутгалын бодис/кг/	25	5000	125000
6	Бусад материал	1	500000	500000
Дүн				1875000

Баруун алтай бүсийн зэрлэг ан амьтанд элбэг тохиолддог халдварт болон халдваргүй өвчний бүртгэгдсэн байдалтай уялдуулан шаардлагатай ам урвалжийн зардлыг тооцоолол хийлээ. Тухайлбал хамуу- Scabies, Эргүү-Ценуро зэрэг өвчний үед хэрэглэх парзитын эсрэг эм бэлдмэл, антибиотек зэрэг эм, вакцины үнийн судалгаанд түшиглэн тооцооллоо.

Хүснэгт 6.26. Хөдөлмөр хамгааллын зардал

№	Материалын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд зардал
1	Ажлын хувцас/ш/	12	80000	960000
2	Ажлын гутал /хос/	12	60000	720000
3	Маск /боодол/	6	10000	60000
4	Малгай /ш/	6	80000	480000
5	Бээлий/хос/	500	4000	2000000
6	Резинен бээлий /хос/	100	10000	1000000
7	Халаад/ш/	12	35000	420000
8	Бусад			350000
Бүгд				5990000

Ажилчид болон түр ажилчид өмсөж хэрэглэх шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас хунарын зардлыг үйл ажиллагааны төсөвт өртөгт багтаав. Эилийн хэрэгцээг бусад төвүүдийн жишиг тооцололд үндэслэв.

Хүснэгт 6.27. Үндсэн хөрөнгийн элэгдэл, засварын зардал

Д/д	Үзүүлэлт	Тоо	Балансын үнэ сая,төг	Элэгдэл байгуулах хугацаа	Элэгдэл засварын зардал мян.төг
1	Ажилчдын офиссийн барилга	1	234603385.8	40	5865084.645
2	Ан амьтны байр	4	330881100.1	40	8272027.503
3	Гүний худаг	1	70000000	15	4666666.667
5	Нарны хавтан /багц 5000w/	1	17100000	10	1710000
6	Ачааны машин	1	30000000	10	3000000
7	Суудлын тэрэг	1	122000000	10	12200000
8	Тоног төхөөрөмж/1-6/		37144150	10	3714415
9	Ddish TV	1	3000000	5	600000
10	Гадна хашаа /м/	200	76620264	40	1915506.6
11	Дотор тусгаарлах хашаа /м/	309	118378307.9	40	2959457.697
12	Хашааны суурь фундам/м3/	402.3	69785733.92	40	1744643.348
13	Хязгаарлалтын хашаа/50га/	3000	70216000	10	7021600
16	Ажиглалтын байр м2	1	5250300.344	20	262515.0172
17	Гадна ариун цэврийн байр /м3/	1	4506910	20	225345.5
18	Тавилга эд хогшил	1	29740000	10	2974000
19	Тэжээлийн болон усны ёонкс	12	3120000	20	156000

20	Цахилгаан генератор/ DE142AS/	1	42900000	10	4290000
Дүн			1265246152		57287261.98

Төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хөрөнгө, тоног төхөөрөмжүүдийн элэгдлийн зардлыг хөрөнгийн анхны өртгөөс ашиглах хугацаанд үндэслэн шулуун шугамын аргаар байгууллаа.

Хүснэгт 6.28. Хоол, хүнсний зардал

№	Материалын нэр	Хэмжих нэгж /кг/	Нэгжийн үнэ	Нийт зардал
1	Мах	100	7500	750000
2	Гурил	75	2300	172500
3	Будаа	75	3800	285000
4	Лууван	20	2000	40000
5	Манжин	20	2500	50000
6	Төмс	50	2000	100000
7	Байцаа	20	2500	50000
8	Сонгино	10	3000	30000
9	Давс	5	1000	5000
Бүгд				1482500

Хоол хүнсний зардал нь ажилчдын болон аялагчдын хоол хүнсний зардлыг тооцооллоо.

Хүснэгт 6.29. Бусад зардал

№	Зардлын төрөл	Нийт зардал
1	Хог хаягдлын зардал	1200000
2	Газрын төлбөр	500000
3	Түлээ, нүүрс	2000000
4	Бусад зардал	1000000
5	Нийт зардал	4700000

Төслийн тооцоололд оффисийн барилга байгууламжийн нам даралттай зуухаар халаахаар төлөвлөсөн бөгөөд халаалтыг нарны зай хураагуураар шийдэхгүй юм. Мөн газар ашигласны төлбөрийг хуулийн дагуу төлөх бөгөөд бусад нэмэгдэл зардлуудыг энэ тооцоололд үйл ажиллагааны зардлын 3% байхаар тооцож орууллаа.

6.3. ТӨСЛИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ

6.3.1. Төслийн орлогын тооцоолол

Говийн ховор, нэн ховор ан амьтныг судлах, хамгаалах төв нь орон нутагт шууд орлого оруулах зорилготой гэхээс илүү нийгмийн, экологи эдийн засгийн үр ашигтай байхаар төлөвлөж байгуулах юм. Энэ бүс нутаг нь “Ээж хайрхан” ууланд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой учраас ан амьтан хамгаалах төвийн үйл ажиллагааг аялал жуулчлалын нэг хэсэг болгож ашиглах нь эдийн засгийн хувьд орон

нутагт ач холбогдолтой байна. Төслийн орлогыг **эдийн засийн шууд орлого, экологи эдийн засгийн орлого буюу шууд бус орлого** гэж 2 ангилан тооцооллоо.

Хүснэгт 6.30. Төслийн шууд орлогын тооцоолол

№	Орлогын төрөл	Нэгжийн үнэ	Эхний жил		Хоёр дахь жил		Гурав дахь жил		Дундаж	
			Бүтээгдэхүүний тоо	Орлого	Бүтээгдэхүүний тоо	Орлого	Бүтээгдэхүүний тоо	Орлого	Бүтээгдэхүүний тоо	Орлого
1	Аялал жуулчлалын орлого шууд орлого	-	-	232160000	-	238200000	-	245000000	-	238453333
	а. Дотоод	10000	5000	50000000	5500	55000000	6000	60000000	5500	55000000
	б. Гадаад	20000	300	6000000	320	6400000	350	7000000	323	6466666,7
	в. Багцын орлого	300000	50	15000000	50	15000000	50	15000000	50	15000000
	г. Буудлын орлого	150000	200	30000000	200	30000000	200	30000000	200	30000000
	д. Хоолны үйлчилгээний орлого	8000	270	2160000	350	2800000	500	4000000	373,3333	2986666,7
	е. Кино зураг авалт, бичлэг хийх	6000000	2	12000000	2	12000000	2	12000000	2	12000000
	ё. Зөвлөх үйлчилгээ, сургалт	3000000	3	9000000	3	9000000	3	9000000	3	9000000
ж. Ахисан түвшиний оюутны судалгааны ажил гүйцэтгүүлэх зардал	36000000	3	108000000	3	108000000	3	108000000	3	108000000	

Төслийн шууд орлогын хүрээнд гадаадын болон дотоодын аялагчдад нэн ховор ан амьтныг үзүүлэх, ан амьтныг видео контент бэлдэх, кино зураг авалтанд ашиглуулах, оюутан судлаачдыг туршилт судалгаа хийхэд ашиглуулах, мөн аялагчдад хоолоор үйлчлэх, буудал амралтын журмаар 2-3 өрөөг ашиглуулах гэх мэтээр орлого олох, орон нутгийг ажлын байраар хангахад туслах давхар зорилготой байж болно. Төслийн орлогыг эхний жилийн орлогоос дараагийн жилийн орлого хамгийн багадаа 10% өсөхөөр тооцоолж дундаж орлогыг 2 жилийн орлогын дундаж байхаар тооцоолсон. Шууд орлого дунджаар **238453333 төгрөг** байна.

6.3.2. Төслийн орлого үр дүнгийн тайлан

Хүснэгт 6.31. Төслийн үйл ажиллагааны нэгдсэн зардлын тооцоолол

№	Зардлын төрөл	Эхний жилийн зардлын дүн	Хоёрдох жилийн зардлын дүн	Дундаж зардлын дүн
1	Ан амьтан ашигласны зардал	88340	114842	101591
2	Ан амьтан барих зардал	0	67500000	33750000
3	Шатахуун	3560700	3560700	3560700
4	Тэжээл	25136820	32677866	28907343

5	Хөдөлмөр хамгаалал	5990000	5990000	5990000
6	Цалин хөлс / НДШ/	101250000	111375000	106312500
7	Хоолны материалын зардал	1482500	1556625	1519562.5
8	Эм урвалжийн зардал	1875000	2437500	2156250
9	Газрын төлбөр	500000	500000	500000
10	Түлш бусад зардал	4200000	4200000	4200000
11	Элэгдэл засварын зардал	57737262	57737262	57737262
Нийт зардал		201820622	287649795	244735208

Төслийн зардлын хувьд ан амьтан барих зардлыг эхний жилийн зардлыг эргэлтийн хөрөнгийн хэрэгцээнд оруулан тооцооллоо. Дараагийн жилээс эхлэн 50% иар хорогдуулан тооцооллоо.

Хүснэгт 6.32. Төслийн орлого үр дүнгийн тайлан /шууд орлогоор тооцсон/

1	Нийт орлого	30160000	33176000	31668000
2	Ан амьтан ашигласны зардал	88340	114842	101591
3	Ан амьтан барих зардал	0	67500000	33750000
4	Шатахуун	3560700	3560700	3560700
5	Тэжээл	25136820	32677866	28907343
6	Хөдөлмөр хамгаалал	5990000	5990000	5990000
7	Цалин хөлс / НДШ/	101250000	111375000	106312500
8	Хоолны материалын зардал	1482500	1556625	1519562.5
9	Эм урвалжийн зардал	1875000	2437500	2156250
10	Газрын төлбөр	500000	500000	500000
11	Түлш бусад зардал	4200000	4200000	4200000
12	Элэгдэл засварын зардал	57737261.98	57737261.98	57737261.98
13	Нийт зардал	201820622	287649795	244735208.5
14	ТТӨА	-171660622	-254473795	-213067208.5
15	ТАХ	0		
16	Цэвэр ашиг	-171660622	-254473795	-213067208.5

Төслийн хувьд эдийн засгийн шууд орлогоор тооцвол жилдээ 213067208 төгрөгийн алдагдалтай ажиллах тооцоо гарч байна. Экологи эдийн засгийн орлогыг оруулан тооцвол ашгийн үзүүлэлт дараах байдлаар тооцоологдож байна.

6.3.3. Төслийн Экологи эдийн засгийн үнэлгээ

Төслийн хувьд цэвэр эдийн засгийн хувьд үр ашигтай гэхээс илүү экологи эдийн засгийн хувьд үр ашигтай байх зорилгоор тооцоолол хийсэн. Экологи эдийн засгийн орлогын хувьд а. Ховор, нэн ховор амьтныг өгсөх б. Ховор нэн ховор амьтныг аврах гэсэн 2 үндсэн үйл ажиллагаанд үндэслэн тооцоолсон.

Хүснэгт 6.33. Төслийн орлого үр дүнгийн тайлан /шууд орлогоор тооцсон/

Орлогын төрөл	Тоо	Нэгжийн үнэ	Эхний жилийн орлого	Хоёрдох жилийн орлого	Дундаж орлого
Аялал жуулчлалын орлого шууд орлого			232160000	238200000	238453333
а. Дотоод	5500	10000	50000000	55000000	55000000
б. Гадаад	323	20000	6000000	6400000	6466666,67
в. Багцын орлого	50	300000	15000000	15000000	15000000
г. Буудлын орлого	200	150000	30000000	30000000	30000000
д. Хоолныүйлчилгээний орлого	373	8000	2160000	2800000	2986666,67
е. Кино зураг авалт, бичлэг хийх	2	6000000	12000000	12000000	12000000
ё. Зөвлөх үйлчилгээ, сургалт	3	3000000	9000000	9000000	9000000
ж. Ахисан түвшиний оюутны судалгааны ажил гүйцэтгүүлэх зардал	3	36000000	108000000	108000000	108000000
Шууд бус орлого/өсгөх/ ЭЭЗҮ			160250000	176275000	176275000
Аргаль	2	12000000	24000000	26400000	26400000
Янгир	2	2900000	5800000	6380000	6380000
Хулан адуу	2	10350000	20700000	22770000	22770000
Хавтгай	1	20200000	20200000	22220000	22220000
Халиун буга	3	7050000	21150000	23265000	23265000
Тахь адуу	4	13000000	52000000	57200000	57200000
Монгол бөхөн	4	2100000	8400000	9240000	9240000
Хар сүүлт зээр	4	2000000	8000000	8800000	8800000
Шууд бус орлого/эмчилж байгальд тавих/ ЭЭЗҮ			89600000	98560000	98560000
Аргаль	1	12000000	12000000	13200000	13200000
Янгир	2	2900000	5800000	6380000	6380000
Хулан адуу	1	10350000	10350000	11385000	11385000
Хавтгай	1	20200000	20200000	22220000	22220000
Халиун буга	1	7050000	7050000	7755000	7755000
Тахь адуу	2	13000000	26000000	28600000	28600000
Монгол бөхөн	2	2100000	4200000	4620000	4620000
Хар сүүлт зээр	2	2000000	4000000	4400000	4400000
Нийт шууд бус орлого			249850000	274835000	274835000
Нийт орлого=шууд орлого+шууд бус орлого			482010000	513035000	513288333

Төслийн эхний жилийн экологийн үнэлгээний орлого нь **249850000 төгрөг** байна. Шууд бус болон шууд орлогын нийт дүн **482010000 төгрөг** болж байна. Төслийн экологи

эдийн засгийн үнэлгээг Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээнд үндэслэн тооцооллоо.

Хүснэгт 6.34. Төслийн орлого үр дүнгийн тайлан /экологи эдийн засгийн орлогоор тооцсон/

№	Орлогын төрөл	Эхний жилийн орлого	Хоёрдох жилийн орлого	Дундаж орлого
1	Аялал жуулчлалын орлого шууд орлого	232160000	238200000	238453333,3
2	Шууд бус орлого/өсгөх/ ЭЭЗҮ	160250000	176275000	176275000
3	Шууд бус орлого/эмчилж байгальд тавих/ ЭЭЗҮ	89600000	98560000	98560000
4	Нийт орлого=шууд орлого+шууд бус орлого	482010000	513035000	513288333,3
5	Нийт зардал	201820622	287649795	244735208,5
6	ТТӨА	280189378	225385205	268553124,9
7	Тах	3033937,802	22538520,5	26855312,49
8	Цэвэр ашиг	277155440,2	202846684,5	241697812,4

Төслийн экологи эдийн засгийн үнэлгээгээр тооцсон орлого үр дүнгийн тайлангийн хувьд жилд дунджаар 241.7 сая төгрөгийн ашигтай байх тооцоолол гарч байна.

6.3.4. Төслийн дотоод өгөөж/IRR/, нөхөн төлөгдөх тооцоолол/PP/

Төслийн урьдчилсан техник эдийн засгийн үнэлгээний шаардлагын дагуу төслийн нөхөн төлөгдөх хугацаа /PP/, олон улсын төслүүдэд шаардагддаг элэгдлийн өмнөх хүү татвар төлөхийн өмнөх ашиг /EBIDTA/, төслийн хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь /IE/ зэрэг үзүүлэлтүүдийг тооцсон.

Хүснэгт 6.35. Төслийн PP8-, EBIDTA, IE /экологи эдийн засгийн орлогоор тооцсон/

№	Үзүүлэлт	Эхний жил (мян.төг)	2 дахь жил (мян.төг)	Дундаж (мян.төг)
1	Борлуулалтын орлого	482010000,0	513035000,0	513288333,3
2	Жилийн нийт зардал	201820622,0	287649795,0	244735208,5
3	Татварын өмнөх ашиг	280189378,0	225385205,0	268553124,9
4	Орлогын татвар	3033937,8	0,0	0,0
6	Татварын дараах цэвэр ашиг	277155440,2	225385205,0	268553124,9

№	Үзүүлэлт	Эхний жил (мян.төг)	2 дахь жил (мян.төг)	Дундаж (мян.төг)
1	Татварын өмнөх ашиг (EBIT)	280189378,0	225385205,0	252787291,5
2	Элэгдлийн зардал (Deprecation)	57737262	57737262	57737262,0
3	EBITDA	337926640,0	283122467,0	310524553,5
4	Цэвэр ашиг (NP)	277155440,2	202846684,5	241697812,4
5	Хөрөнгө оруулалт (мян.төг)	2181690709		

6	Хөрөнгө оруулалтын нөхөн төлөгдөх хугацаа (EBIDTA)	6,5	7,7	7,0
7	Хөрөнгө оруулалтын нөхөн төлөгдөх хугацаа (NP)	7,9	10,8	9,0
8	Хөрөнгө оруулалтын өгөөж (EBITDA) %	15,5	13,0	14,2
9	Хөрөнгө оруулалтын өгөөж (NP) %	12,7	9,3	11,1

Төслийн экологи эдийн засаг болон шууд орлогын нэгдсэн үнэлгээгээр тооцсон нөхөн төлөгдөх дундаж хугацаа 7. жил, EBIDTA-аар тооцсон хөрөнгө оруулалтын өгөөж нь 14.2 % байна.

6.4. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

6.4.1. Үйл ажиллагааны болон бусад эрсдэлийн дүгнэлт

Говийн ховор, нэн ховор ан амьтныг хамгаалах төвийн үйл ажиллагаа явуулах үед дараах эрсдэлүүд учирч болох бөгөөд эрсдэлийг хэрхэн даван туулах талаар төслийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх шаардлагатай.

➤ Амьтны /малын /гоц халдварт өвчин

Хэдийгээр энэ төрлийн эрсдэлд учирч болох талтай ч ан амьтныг байнгын суурин маллагаанд байлгах учраас энэхүү эрсдэлийн хувьд учирч болох тохиолдол бага байх боломжтой. Нөгөө талаас эрсдэлээс сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг байнга хийх, вакцинжуулалтанд хамруулах зэргээр сэргийлж болно.

➤ Байгаль,цаг уурын бэрхшээл

Гал түймэр, үер ус, ган зудны эрсдэлийг хамруулан ойлгож болно. Ан амьтан суурин маллагаанд хамрагдах тул байгаль орчноос шалтгаалан бий болох эрсдэл харьцангуй багатай.

➤ Тэжээлийн хүрэлцээ, хангамж доройтох.

Суурин байранд байгаа ан амьтны хувьд байгалиас иддэг тэжээлийн хувьд эрдэс дутагдах мэт эрсдэл гарч магадгүй юм. Энэ эрсдэлээс хамгаалахын тулд Тус төв өөрийн эзэмшлийн хязгаарлалтын 50 га газарт шаардлагатай тэжээлийн ургамлыг тариалах замаар өөрийн хэрэгцээг хангах боломжтой.

➤ Ажиллагсадын мэдлэг, ур чадвар дутагдах:

Тус төв нь шаардлагатай ажилчдыг сонгон авахдаа өөрсдийн боловсруулсан шалгуурын дагуу тухайн салбарт ажиллаж ирсэн туршлагыг харгалзах хэрэгтэй.

➤ Бүтээгдэхүүний үнэ буурах:

Сүүлийн жилүүдэд ЗГ-ын зүгээс аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж байна. Мөн дотоодын аялагчдын тоо . Цаашдаа ч өсөх хандлага байгаа учраас аялал жуулчлалын орлогын эрсдэлийг бууруулж байна.

➤ Тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж

Төсөл хэрэгжүүлэгчийн байгууламж нь үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай техник хэрэгсэл, барилга байгууламжаар бүхрэн хангагдсан. Тодорхой хугацааны дараа үйл ажиллагааны өсөлттэй уялдан үүсэж болох бэрхшээлийг дотоодын нөөц болоцоогоор цаг тухайд шийдэх бүрэн боломжтой.

Төслийг хэрэгжүүлэх явцад дээр дурдсанаас бусад бэрхшээл үүсэж болох ч түүнийг тухай бүрд нь шийдээд байх боломжтой гэж үзэж байна.

6.4.1. Хугарлын цэгийн шинжилгээ

Хүснэгт 6.36. Эрсдлийн хугарлын цэгийн шинжилгээ

№	Зардлын төрөл	Эхний жилийн зардлын дүн	Хоёрдох жилийн зардлын дүн	Дундаж зардлын дүн
1	Ан амьтан ашигласны зардал	88340	114842	101591
2	Ан амьтан барих зардал	0	67500000	33750000
3	Шатахуун	3560700	3560700	3560700
4	Тэжээл	25136820	32677866	28907343
5	Хөдөлмөр хамгаалал	5990000	5990000	5990000
6	Цалин хөлс / НДШ/	101250000	111375000	106312500
7	Хоолны материалын зардал	1482500	1556625	1519562,5
8	Эм урвалжийн зардал	1875000	2437500	2156250
9	Газрын төлбөр	500000	500000	500000
10	Түлш бусад зардал	4200000	4200000	4200000
11	Элэгдэл засварын зардал	57737261,98	57737261,98	57737261,98
12	Нийт зардал	201820622	287649795	244735208,5
№	Орлого ба Зардал	Эхний жилийн зардлын дүн	Хоёрдох жилийн зардлын дүн	Дундаж зардлын дүн
1	Тогтмол зардал /FC/	57737261,98	125237262	91487261,98
2	Хувьсах зардал /VC/	144083360	162412533	153247946,5
3	Шууд орлого /R/	232160000	238200000	238453333
4	Экологийн эдийн засгийн орлого	249850000	274835000	274835000
5	Нийт орлого	482010000	513035000	513288333
	Хугарлын цэг/БЕОР/	0,66		
	Хугарлын цэг/БЕОР/	0,55		
	Хугарлын цэг/БЕОР/	0,17		

Төслийн хугарлын цэгийн шинжилгээгээр төслийн шууд орлогоор тооцсон хугарлын цэгийг тооцоход төслийн орлогоо 66% иар өсгөх үед орлого болон зарлага тэнцэнэ. Экологийн үнэлгээгээр тооцсон хугарлын цэгийн тооцоогоор орлого 66% өсгөхөд төслийн орлого зарлага тэнцэнэ. Мөн төслийн хугарлын цэгийн үед орлого 17 % иар буурахад төслийн орлого болон зардал тэнцэхээр үр дүн гарч байна. Уг төслийн хувьд эдийн засгийн шууд орлого буюу аялал жуулчлал болон бусад үйл ажиллагааны орлогыг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн ан амьтны өсгөх,эмчлэх үйл ажиллагааны орлогыг тодорхой хувиар бууруулсан ч экологи эдийн засгийн үр ашиг алдагдахгүй учраас төслийн нийгмийн болон экологийн үр ашиг өндөр байна.

ДҮГНЭЛТ

1. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах газрыг говийн амьтдын тархалтын түүхэн нутаг болох Улаан шалын хоолойн зүүн зах Бөөнцагаан нуурын орчим байгуулах хамгийн боломжтой.
2. Тус төвд Хар сүүлт зээр, Хавтгай тэмээ, Монгол бөхөн, Янир ямаа, Аргаль хонь, Хулан адуу, Тахь адуу, Халиун буга зэрэг 8 зүйлийг зориудын аргаар буюу үржүүлгийн төвд үржүүлж өсгөх бүрэн боломжтой.
3. Төвийг байгуулснаар нэн ховор, ховор амьтдын талаархи судалгааны ажил сайжирч олон улсад эргэлтэнд орсноор илүү олон судалгааны төсөл хөтөлбөр хэрэгжих суурь болно.
4. Нэн ховор, ховор зүйл амьтны тоо толгойг өсгөж, тогтвортой популяцийг бий болгон хэмжээг ихэсгэн хамгаалснаар нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенциор хүлээсэн үүрэг, үндэсний хөтөлбөр, бодлогын томоохон зорилтоо биелүүлнэ.
5. Говь-Алтай аймгийн нэг томоохон байгалийн аялал жуулчлалын үзмэр болж гадаад дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
6. Тус төвийг дагаж аялал жуулчлалын баазууд хөгжих, орон нутгийн хөгжлийг түргэсгэнэ.
7. Монгол улсын болон орон нутгийн иргэд, оюутан, сурагчдын экологийн боловсрол олгох нэг томоохон түшиц газар болно.
8. Орон нутагт ажлын байр нэмэгдэнэ.
9. Дээрх бүхний үр дүнд говь, цөл, түүний биологийн олон янз байдлыг хайрлан хамгаалах ажил өргөжин тэлнэ.
10. Төслийн нийт санхүүжилт 2,325,774,069 төгрөг байна.
11. Төсөл хэрэгжсэнээр жилд дунджаар 244735208 төгрөгний зардал гарч байна.
12. Төслийг амжиттай хэрэгүүлсэн тохиолдолд жилд олох шууд орлого 238453333 төгрөг, шуд бус орлого 274835000 төгрөг нийт орлого 513288333 төгрөг байхаар дундажлан тооцоолов.
13. Төслийн экологи эдийн засаг болон шууд орлогын нэгдсэн үнэлгээгээр тооцсон нөхөн төлөгдөх дундаж хугацаа 7 жил байна.

ЗӨВЛӨМЖ

“Товийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах” төв байгуулах ажлыг гүйцэтгэхэд дараах зүйлсийг анхааран ажилахыг зөвлөж байна. Үүнд:

1. Монгол улсын болон олон улсын хууль, дүрэм, гэрээ, конвенцийг дагаж мөрдөх
2. Төв байгуулах газар нь ямар зүйл ховор амьтдын түүхэн тархац нутгийн хүрээнд хамарч байгааг харгалзах
3. Төвд байршуулах амьтдын амьдрах орчны үнэлгээ хийж, амьдрах орчны сонголтыг урьдчилан тодорхойлох
 - 3.1. Уур амьсгал, физик, хими, газарзүйн болон бусад хүчин зүйлийг тодорхойлох
 - 3.2. Тархацыг хязгаарлагч хүчин зүйлийн хамаарлыг тодорхойлох (амьдрах орчин идэш тэжээлийн өрсөлдөөн, махчин, өвчин, шимэгч гэх мэт)
 - 3.3. Амьдрах орчны тохиромжтой байдлыг тодорхойлох (тохиромжтой амьдрах орчин, идэш тэжээлийн хангамж сайн, хоргодох газар ихтэй, өвчний голомтоос ангид гэх мэт)
 - 3.4. Амьтны боломжит амьдрах орчныг үнэлэх (амьдрах орчны даац, орон зайн хэмжээ, амьдрах орчны өөрчлөлт, хязгаарлагдмал амьдрах орчин гэх мэт)
4. Байршуулах зүйлүүдийн популяцийн үнэлгээ хийх
 - 4.1. Тохиромжтой газар нутагт тухайн зүйл амьтны амьдрах чадвартай хамгийн бага популяцийн хэмжээг тодорхойлох
 - 4.2. Амьтны амьдрах чадвартай хамгийн бага популяцийн тоо толгойн өсөлтийн дотоод чадавхийг тодорхойлох (популяцийн насны бүтэц, хүйсийн харьцаа, үхэл хорогдол, төрөлтийн дундаж эрчим, үр төлөрхөг байдал, мэнд үлдэлт гэх мэт)
 - 4.3. Түүхэн хугацаанд буюу сүүлийн 50-100 жилд тухайн амьтны популяцийн тоо толгойн хэлбэлзлийн чиг хандлага ямар байсныг тодорхойлох
5. Тухайн байршуулах зүйлүүдийн тоо толгой буурсан шалтгааныг тодорхойлох
 - 5.1. Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн төлөв байдлыг тодорхойлж сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх
 - 5.2. Нутгийн иргэдийн хандлагыг тодорхойлон сэргээн нутагшуулалт амжилтанд хүрэх бололцоотой эсэхийг дүгнэх
6. Амьтныг судлах, хамгалах төвд байршуулахад хүний үйл ажиллагаа хэрхэн нөлөөлөх аюул занал байгаа эсэх, дарамтын түвшинг үнэлэх
7. Төвд байршуулах амьтныг барих, популяцийг сонгох, сэргээн нутагшуулах амьтныг барих, тээвэрлэх тухайн газрын популяцийн эрүүл байдал, популяцийн тоо толгойн өсөлтийн дотоод чадавхийг үнэлэх
 - 7.1. Амьтны амьдрах орчны даац зохицох байдал болон учирч болох эрсдлийг үнэлэх
 - 7.2. Амьтны тор хашаанд бодгалиудын амьдрах орчны нийцэл, ялгааг тодорхойлох
 - 7.3. Амьдрах орчны дасан зохицох байдал болон барих тээвэрлэх, сэргээн нутагшуулах үед учирч болох эрсдлийг үнэлэх, бууруулах арга хэмжээ авах, технологийг боловсронгуй болгох

8. Төвд байршуулах зүйлүүдийг барилт хэвийн өсөлт үржлийг алдагдуулахгүйгээр тогтоогдсон нөөцийн 25-30 хувийг барих шаардлагатай гэж үзэх
9. Төвд байршуулан нутагшуулах үндэслэл, төлөвлөгөө, арга зүй, технологийг нэгтгэсэн судалгааны тайлан, үр дүнг шинжлэх ухааны байгууллагаар хэлэцүүлэн дүгнэлт гаргах
10. Амьтныг байршуулах байр сав, тээвэрлэхэд тавигдах шаардлагыг боловсруулах
11. Бүх зүйл дээр үржүүлгийн хөтөлбөрийг боловсруулах
12. Байнгын хяналт, үзлэг, мониторинг, популяцийн мэдээллийг боловсруулан судалгааны эргэлтэнд оруулах
13. Төвийн байгаль хамгааллын менежментийн төлөвлөгөө, бизнесийн болон хүний нөөцийн төлөвлөгөө боловсруулах
14. Төвийн амьтдын тэжээл, усны норм, стандартад нийцүүлэн төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх
15. Эрсдлийн төлөвлөгөө боловсруулах
16. Мал эмнэлэг ариун цэврийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, сахин ажиллах
17. Бодгалиудыг байгальд суллан тавих, мониторинг хийх хөтөлбөр боловсруулах
18. Амьтныг нутагшуулах мэргэжлийн байгууллага нь олон улсын байгаль хамгаалах холбооноос боловсруулсан сэргээн нутагшуулах аргачлалыг баримтлах
19. Байгальд сэргээн нутагшуулсан популяцийн тоо толгойн өсөлт, популяцийн дотоод өрсөлдөөн, амьдрах орчны сонголт, махчлал зэрэг экологи, биологийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж мэдээллийн сан бүрдүүлэх
20. Төвийн байршуулах, нутагшуулах төслийн үйл ажиллагаанд 3 жил тутамд судалгаа шинжилгээний, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулах
21. Төслийн үр дүнг ашиглан бизнесийн үйл ажиллагаа явуулах тохиолдолд 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэх
22. “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах” төвийн явцын жил бүрийн тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад хүргүүлэх зэрэг зөвлөмжийг хүргүүлж байна.

УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

БОАЖЯамны Төрийн нарийн бичгийн дарга болон Сайнс тэч гэйт ХХК амьтны мэргэжлийн байгууллагын хооронд байгуулсан гэрээний дагуу Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь төслийн зорилтот нутаг болох Зармангийн говь болон Улаан шалын хоолойд “Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг төсөл хэрэгжих орон нутагт танилцуулах, санал авах уулзалт, хэлэлцүүлэгийг 2023 оны 2 сарын 13-18 хооронд Баянхонгор, Говь-Алтай аймгуудад зохион байгууллаа.

2023 оны 2 сарын 15 өдөр Говь-Алтай аймгийн БОАЖГ-т “Захуй, Зармангын говьд говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг орон нутагт танилцуулах, санал авах уулзалт, хэлэлцүүлэгийг хийлээ. Тус хэлэлцүүлэгт БОАЖГ-ийн дарга Г. Болдбаатар, хэлтэсийн дарга Д. Батмагнай, амьтны асуудал харицсан мэргэжилтэн Г. Олонбаатар, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн Т. Лодой, байгаль орчны хяналтын улсын байцаагч Г. Билэгсайхан, аймгийн ЗДТГ-ийн Хөгжлийн бодлогийн газрын мэргэжилтэн Б. Цэрэнбал, Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг ангах нь төслийн зохицуулагч Э. Цэцэгмаа, төслийн зөвлөх А. Баясгалан нар оролцлоо. Сайнс тэч гэйт ХХК-ийн мэргэжилтэн С. Цогт “Захуй, Зармангын говьд говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв” байгуулах төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, үндэслэл боловсруулах төслийг танилцууллаа.

Энэ уулзалтанд аймгийн зүгээс маш идэвхитэй оролцсон бөгөөд асуулт хариулт санал зөвлөгөөг олныг хэллээ. Гарсан саналуудыг дурьдвал:

1. Усны асуудлыг яаж шийдэх вэ?
2. 2016 оноос ховор, нэн ховор амьтныг судлах хамгаалах төв байгуулах асуудал яригдаж эхэлсэн үүнийгээ ENSURE төслийг ажилд оруулж одоо ажил хэрэг болж байгаад талархаж байна.
3. Гол нь амьтны хүрээлэн шиг судлах хамгаалах төв байгуулж байгаа нь сайн байна. Дурьдсан 8 зүйл амьтан өсөх үржүүлэх боломжтой.
4. Ээж хайрхан уул бол манай аймгийн аялал жуулчлалын гол маршрут энд аялал жуулчлал хөгжүүлэхэд энэ төвийг үүрэг их байгааг дурьдсан.
5. Хөрөнгө оруулалтыг яаж шийдэх талаар асуудал хөндөгдсөн.
6. Байнга зарлага гарч байна. Хөрөнгө оруулалт, тогтмол зардал гээд энийг яаж нөхөх вэ?
7. Орлого яаж олох вэ? орлогыг нэмэгдүүлэх талаар боломжуудыг нэмэх шаардлагатай байна. Анхны оруулсан хөрөнгө оруулалтыг 20 жилд нөхнө гэсэн байна. Үүнийг яаж ойртуулах вэ?
8. Орлого олохгүй бол энэ төслийг эхлүүлэх хэцүү бараг эхлүүлэхгүй амьтад нь байгаль дээрээ байх нь дээр болох гээд байна.
9. Барилга байшингийн төсвөө байшин бүр дээр гаргамаар байна.
10. Шууд орлогыг хэт багаар тооцон байна. Жишээ нь жилд 500 дотоодын жуулчин ирнэ гэснийг 5000 дотоодын аялагч ирнэ гэж өөдрөгөөр харж тооцоо гаргах хэрэгтэй.

11. Орлогын тооцоог хэд хэдэн хувилбартай тооцож болно.
12. Тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглүүлж орлогоо нэмэгдүүлэх
13. Эхний 3 жилд зарлага, орлогыг тэнцвэржүүлэх бодлого барьж ажиллах 20 жилд зарлагаа нөхнө гэдэг хэт хол байна. Усан цахилгаан станцын том төслүүд ингэж олон жилд зардалаа нөхдөг.
14. Бусад төслийг харахад кофе шоп, хоолноос их орлого олдог. Энэ дээр анхаар.
15. Зөвхөн амьтан судлах хамгаалах бус асран хамгаалах тал дээр анхаарал хандуулах, ихэнхи олон улсын төслүүд бэртсэн гэмтсэн амьтдыг асран хамгаалахад илүү анхаарч энд хөрөнгө оруулалт хийдэг.
16. Цахилгаан дулааны асуудлыг яаж шийдэх вэ?
17. Аймгийн бусад бодлогын баримт бичгүүдтэй уялуулах шаардлагатай. Тухайлбал аялал жуулчлал хөгжүүлэх тайлантай танилцаж уялдуулах шаардлагатай.
18. Энэ төслийг ажил болгомоор байна. Төслийн газрын сонголт, амьтны сонголт, төслийн амьтны байр, офиссын байрны загвар сайн болжээ.
19. Хашааны бат бэх байдлыг сайн анхаарах хэрэгтэй.
20. Энэ оны 2-р улиралдаа багтаад дуусгаад цааш авч хөөцөлдөө.
21. Төслийг барьж байгуулсаны дараа хэн цааш авч явах вэ? компани уу? Төрийн бус байгууллага уу? Энийг шийдвэрлэх шаардлагатай.
22. Жилд ирэх гадаад дотоодын жуулчдын тоон судалгааг сайн гаргах шаардлагатай.
23. Ээж хайрханд пассив хаус барихаар яригдаж байгаа тэнд ирэх жуулчдын тоог хэд гэж авч үзсэн бол тэр судалгааг харах, тэнд олон хувилбартай тооцоо хийсэн байснаас санаа авах
24. Цаашид төвийг хэн авч явахаа тодорхой болгох.
25. Энэ төслийг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлдэг KFW төсөлд хандах хэрэгтэй. Ховд аймгийн Алтай суманд KFW төслийн хүрээнд 3 хүнд зориулж 3 давхар байшин бариулахаар 4 тэрбум төгрөг төсөвлөснийг манай байгууллагаас санал өгч зогсоосон байгаа, тэр мөнгийг нааш татаж энэ төслөө санхүүжүүлэх талаар санал гаргаж ярилцая.
26. Энэ төслөө эхлүүлэх ажлын хэсэг байгуулж ажилдаа яаравчлан орох хэрэгтэй байна.
27. Барилгын материалаа Улаанбаатараас татан авах нь зөв.
28. Гадаадын их сургуулиудаас судлаач оюутны ажиллах бололцоог хангаж, тэдгээрээс судалгааны зардлын мөнгө авч орлогоо нэмэгдүүлэх, Говийн их дархан газрын Б хэсэгт ирж буй ахисан түвшиний гадаад оюутнаас 10000 доллар авдаг юм байна. Ийм бололцоог судлах хэрэгтэй.

Уулзалт хэлэлцүүлэгийн төгсгөлд энэ ажил чухал ач холбогдолтой ажил болсон байна. Энэ төслийг хэрэгжүүлэхэд аймаг бэлэн байгаагаа мэдэгдэж ажлын хэсэг байгуулж ажиллах, энэ төслөө авч KFW, GIZ төслүүдээс санхүүжилт хүсэхээ илэрхийлж төслийг таатай хүлээн авч, дэмжиж байгаагаа илэрхийлсэн.

Төслийн тайлан хэлэлцүүлэх ажил 2 аймагт амжилттай явагдаж дэмжигдсэн бөгөөд хэлэлцүүлэгийн үер гаргасан санал зөвлөмжийг тайландаа тусган тайлангаа засварлан хүргүүлж байна.


АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. С. Гомбобаатар нар, Биологийн олон янз байдлын тухай конвенц, конвенцыг хэрэгжүүлэх Үндэсний тавдугаар тайлан. Улаанбаатар хот. 2014 он
2. Б. Чимэддорж, С. Пүрэвсүрэн, Х. Тэрбиш., Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг Олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн лавлах. Улаанбаатар хот. 2019 он
3. E. L. Clark., Ж. Мөнхбат., E.M. Monks.,С. Дуламцэрэн., J.E.M. Baillie., Н. Батсайхан., Л.Я. Боркин., Р. Самьяа., М. Stubbe (Эмхэтгэгчид, редакторууд) 2006. Монгол орны хөхтөн амьтны улаан данс. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
4. Gombobaatar S. And Monks E. M. (compilers), Seidler R., Sumiya D., Tseveenmyadag N., sBayarkhuu S., Baillie J. E. M., Boldbaatar Sh., Uuganbayar Ch., (editors) 2011. Regional Red List Series Vol.7. Birds. Zoological Society of London, National University of Mongolia and Ornithological Society.
5. Даш. Д. Физик- газар зүйн мужлалын шинэчилсэн хувилбар. Монгол орны ландшафт-экологийн зарим асуудлууд. УБ. 2000.
6. Ерөнхий редактор: Ц. Шийрэвдамба Монгол Улсын улаан ном 2014.
7. Ерөнхий редактор: Д. Дожотов Монгол улсын үндэсний атлас 2022
8. Ерөнхий редактор: Б. Чимэддорж Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах аргачлал 2022 он
9. Мөнхбаяр Х. Тэрбиш Х, Мөнхбаатар М. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчид. Улаанбаатар. 2009.
10. Х. Тэрбиш., Х. Мөнхбаяр., E. L. Clark., Ж. Мөнхбат., E.M. Monks., М. Мөнхбаатар., J.E.M. Baillie., Н. Батсайхан., Л.Я. Боркин., Р. Самьяа., Д.В. Семенов. (Эмхэтгэгчид, редакторууд) 2006. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
11. Нямбаяр, Б нар Монгол дахь Шувуудад чухал газруудын лавлах:Байгаль хамгааллын түшиц нутаг. УБ. 2009 он
12. Undarmaa. J, other ,Rangeland ecosystem of Mongolia 2018.
13. УЦУОСМХ. Уур амьсгалын норм: цаг уурын станц (1981-2010), харуул (1986-2015). 2017 он
14. УЦУОСМХ. Уур амьсгалын шинэчилсэн стандарт норм (1991-2020). 2021 он


ХАВСРАЛТ



Зураг 1. Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төв байгуулах газрын байршил



Зураг 2. Говийн бүсийн нэн ховор, ховор амьтан судлах, хамгаалах төвийн харагдах байдал




Зураг 3. Төвийн харагдах байдал (Уул, жалга судгийн байдал)



Зураг 4. Төв байгуулах газрын хэв шинж (төвөөс зүүн урагш)



Зураг 5. Төв байгуулах газрын ургамалжилын байдал (зүүнээс төв рүү)



Зураг 6. Төв байгуулах газрын ургамалжил (урдаас төв рүү)



Зураг 7. Төв байгуулах газрын ерөнхий төрх (төвөөс зүүн рүү)



Зураг 8. Төв байгуулах газрын ерөнхий төрх (төвөөс баруун зүг Эж хайрхан уулын зүг)



Зураг 9. Төв байгуулах газрын ерөнхий төрх (төвөөс Баянтоорой тосгон зүг)



Зураг 10. Төв байгуулах газрын ерөнхий төрх (хязгаарлалтын хашааны төв хэсгийн өндөрлөг)



Зураг 11. Цагаан бургасны баянбүрд



Зураг 12. Цагаан бургасны баянбүрдийн эх



Зураг 13. Цагаан бургасны баянбүрдийн мазалайн байр



Зураг 14. Цагаан бургасны баянбүрдийн мазалайн байрны нүүр хэсэг



Зураг 15. Мазалайн байрны ажиглах хэсэг



Зураг 16. Цагаан бургасны баянбүрдийн офиссын байр



Зураг 17. Говь-Алтай аймгийн БОАЖГ-т зохиогдсон уулзалт хэлэлцүүлэг (2022-02-15)



Зураг 18. Уулзалт хэлэлцүүлэгийн үеийн асуулт хариулт, санал, зөвлөгөө өгч байх үе